МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ *3*
ЗУРГИЙН ЖАГСААЛТ *4*
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ *5*
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ *6*
УДИРТГАЛ *7*
НЭГ.АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ *9*
1.1.Асуудлын мөн чанар, цар хүрээ 9
1.1.1.Төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал 9
1.1.2.Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин 85
1.1.3.Төрийн, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын дүгнэлт, санал, зөвлөмж 105
1.1.4.Тулгамдаж буй асуудлууд 122
1.1.5.Шүүхийн практикийн тойм судалгаа 126
1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд 130
1.3.Асуудал үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл 131
ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО *138*
ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ *139*
3.1.Асуудлыг зохицуулах хувилбарууд 139
3.1.1.“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах 139
3.1.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх 140
3.1.3.Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх 140
3.1.4.Төрөөс санхүүгийн интервенц хийх 141
3.1.5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх. 141
3.1.6.Захиргааны шийдвэр гаргах 143
3.1.7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах 144
3.2.Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг тал 145
3.3.Хамгийн үр дүнтэй байж болох зохицуулалтын хувилбар 146
ДӨРӨВ.ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ *148*
4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хууль 148
4.2.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө 148
ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ *150*
5.1.Олон улсын эрх зүйн зохицуулалт 150

5.2.Гадаад улсын хууль тогтоомж.....152
ЗУРГАА.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....155
ДОЛОО.АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....160
ХАВСРАЛТ № 1.....164
ХАВСРАЛТ № 2.....175
ХАВСРАЛТ № 3.....183
ХАВСРАЛТ № 4.....194

ТОВЧИЛСОН ҮГ

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МУНУХЭЗБтХ	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ӨУтХ	Өрийн удирдлагын тухай хууль
ТБОНӨХБАҮХАтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТБЗ	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл
ТТБтХ	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТХХТтХ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ХБТТУтХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шат 10

Зураг 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл 13

Зураг 3.Санхүүжилтийн задаргаа /эзлэх хувиар/..... 27

Зураг 4.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар
/эзлэх хувиар, тэрбум.төг/ 28

Зураг 5.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн мөчлөг 34

Зураг 6.Төлөвлөлтийн бэлтгэл шат ба тулгамдсан асуудал 39

Зураг 7.Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд
урьдчилсан үнэлгээ хийх цаглавар 43

Зураг 8.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн цаглавар 44

Зураг 9.Хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл 45

Зураг 10.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл 45

Зураг 11.Мега төслийн онцлог, төрөл 49

Зураг 12.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн цаглавар 53

Зураг 13.Гэрээний дүн, зардлын хэмжээ, дундаж үзүүлэлт
/тэрбум.төг, эзлэх хувиар/ 55

Зураг 14.Гэрээний нийт болон бусад зардлын ангилал /эзлэх хувиар/ 55

Зураг 15.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт
болон нэмэлт санхүүжилт /тэрбум.төг/..... 74

Зураг 16.Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн хөгжил 80

Зураг 17.Төсвийн хөрөнгө оруулалтын хууль зүйн зохицуулалтын шатлал 86

Зураг 18.ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын
удирдлагын үнэлгээний үр ашгийн үзүүлэлт” /2016, 2023 он/ 113

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, оролцогчид 11

Хүснэгт 2.Гадаад зээл, тусламжийн дүн /тэрбум.төг/..... 31

Хүснэгт 3.Төсвийн хөрөнгө оруулалт ба концесс /тэрбум.төг/..... 32

Хүснэгт 4.ТЭЗҮ-ийн агуулгын харьцуулалт..... 38

Хүснэгт 5.Төсвийн хөрөнгө оруулалтын цаглавар..... 41

Хүснэгт 6.Төслийн бэлэн байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт 44

Хүснэгт 7.Төсвийн хөрөнгө оруулалтын
төслийн ангилал /хөрөнгө оруулалтын хэмжээгээр/ 46

Хүснэгт 8.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн
төслийн тоо /төсөвт өртгөөр/ 50

Хүснэгт 9.Захиалагч болон зохиогчийн хяналтын уялдаа холбоо 61

Хүснэгт 10.Авто зам, гүүрийн ажлын техник, технологийн
хяналтын зардлын хэмжээ /эзлэх хувиар/ 62

Хүснэгт 11.Барилгын норм, норматив боловсруулах сангийн
орлого төвлөрүүлэлт, зарцуулалт /тэрбум.төг/ 65

Хүснэгт 12.Фидикийн гэрээний төрөл..... 67

Хүснэгт 13.Фидикийн гэрээний жишээ..... 67

Хүснэгт 14.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр,
тэдгээрийн хууль зүйн зохицуулалт 87

Хүснэгт 15.Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтын
талаарх нарийвчилсан зохицуулалт 90

Хүснэгт 16.ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын
удирдлагын үнэлгээ /2016, 2023 он/..... 112

Хүснэгт 17.Төсвийн хөрөнгө оруулалтын талаарх
хэлэлцүүлгийн нэгдсэн мэдээлэл..... 117

Хүснэгт 18.Зохицуулалтын хувилбаруудын эерэг
болон сөрөг талын харьцуулалт..... 145

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.Төсвийн хөрөнгө оруулалт /эх үүсвэрээр, тэрбум.төг/ 25

График 2.Төсвийн хөрөнгө оруулалт ба ДНБ /эзлэх хувиар/ 26

График 3.Төсвийн нийт хөрөнгө оруулалт /эзлэх хувиар, тэрбум.төг/ 27

График 4.Төсвийн хөрөнгө оруулалт эдийн засгийн ангиллаар /эзлэх хувиар/ 28

График 5.Гадаад зээл, тусламжийн дүн /салбараар, тэрбум.төг/ 31

График 6.Хөгжлийн түнш байгууллагын зээл, тусламж /тэрбум.төг/ 32

График 7.Концессын эргэн төлөлт /тэрбум.төг/ 32

График 8.Санхүүжилт аваагүй төслийн тоо 40

График 9.Гэрээ байгуулагдаагүй болон зураг төсөлгүй батлагдсан төслийн тоо 40

График 10. 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төслийн тоо 51

График 11.Төслийн хэрэгжилтийн дундаж хугацаа /жилээр/ 69

График 12.Таваас дээш жил үргэлжилж байгаа төслийн тоо, нийт төслийн тоонд эзлэх хувь 70

График 13.Олон жил үргэлжилж байгаа төслийн тоо, 2025 оны төсвийн хууль 70

График 14.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл /эзлэх хувиар/ 72

График 15.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл /улирлаар, эзлэх хувиар/ 73

График 16.Нэмэлт санхүүжилт үүссэн шалтгаан нөхцөл /эзлэх хувиар/ 75

График 17.Цахим системээр олгосон санхүүжилтийн тоо 81

График 18.Тулгамдаж байгаа нийтлэг асуудал 119

УДИРТГАЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, дүн шинжилгээ хийх тандан судалгаа (цаашид “Тандан судалгаа” гэх)-г Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын [1] хүрээнд боловсруулж, дараах үе шатаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Асуудалд дүн шинжилгээ хийх;
2.Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3.Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тодорхойлж, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулах;
4.Хуулийн зохицуулалтын хувилбар, түүний үр нөлөөг үнэлэх;
5.Олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;
6.Зөвлөмж боловсруулах.

Тандан судалгааг боловсруулахдаа:

- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин;
- Улсын хэмжээнд төсвийн эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалт (2016 - 2024 он), хэрэгжилт, үр дүн, тулгамдаж буй асуудал, түүнд хийсэн анализ дүгнэлт[2];
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үйл ажиллагаанд Монгол Улсын эрх бүхий байгууллага, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагаас өгсөн дүгнэлт, санал, зөвлөмж;
- Төсвийн хөрөнгө оруулалтын үе шат, түүнд оролцогч байгууллага, тэдгээрийн чиг үүрэг, бүрэн эрх зэргийг хамруулан судлав.

Энэхүү тандан судалгааны зорилго нь төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг сонгох, цаашид төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах буюу тодруулбал, төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмч хөрөнгийн ашиглалтыг илүү үр өгөөжтэй, үр ашигтай болгоход чиглэсэн зохицуулалтын хувилбарыг тодорхойлоход оршино.

Үүнээс гадна, хуулийн ажлын хэсгээс Тандан судалгааны хүрээнд дараах бие даасан судалгааны ажлуудыг гүйцэтгэн хавсралтаар оруулав. Үүнд:

[1] https://legalinfo.mn/mn/detail?lawId=207333&showType=1
[2] Энэхүү тандан судалгааны тайланд тусгасан тоон мэдээлэл нь хуулийн төслийн боловсруулалтын явцад өөрчлөгдөх магадлалтай.

1) Олон улсын харьцуулсан судалгаа

Төсвийн хөрөнгө оруулалтын талаарх олон улсын чиг хандлага, сайн туршлага, гадаад орнуудын төсвийн хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн зохицуулалтын судалгааг боловсруулж, *харьцуулсан судалгааны тайланг* тандан судалгааны тайланд хамт оруулаа.

2) Шүүхийн практикийн тойм судалгаа

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хамаарах хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгааг гүйцэтгэж, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд голлон үүсдэг асуудлыг тодорхойлох, шүүхийн шийдвэр, дүгнэлтийг судлах, эдгээр асуудлыг шийдвэрлэх арга замыг тогтоох зорилгоор *шүүхийн практикийн тойм судалгааг* боловсруулж, мөн энэхүү тайланд оруулав.

3) Олон нийтийн хэлэлцүүлэг, судалгаа

Судалгааны ажлын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны оролцогчид болох төрийн байгууллагууд буюу яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хувийн хэвшил буюу гүйцэтгэгч болон зураг төсөл зохиогч, захиалагч, захиалагчийн техник, технологийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, иргэний нийгмийн байгууллагын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авч, тайланд нэгтгэв.

НЭГ.АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1.Асуудлын мөн чанар, цар хүрээ

1.1.1.Төсвийн хөрөнгө оруулалтын өнөөгийн нөхцөл байдал

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын түүхэн замнал нь Монгол Улсын анхны Сангийн яам буюу Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам байгуулагдсан цаг үеэс эхлэлтэй бөгөөд 110 гаруй жилийн түүхтэй. Монгол Улсад хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсвийн эх үүсвэртэй хөрөнгө оруулалтуудын хувьд улсын төсөв, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, ТХХТ, ОНХС, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, сан болон санхүүгийн бусад эх үүсвэр зэргээс бүрдэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар авто зам, эрчим хүч, инженерийн дэд бүтэц зэрэг нийтийн зориулалттай дэд бүтэц, бүтээн байгуулалтууд, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, музей, соёлын төв, захиргааны байр зэрэг төрийн үйлчилгээний барилга байгууламжуудыг барьж байгуулах төслийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэхээс гадна эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

1.1.1.1.Төсвийн хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Хөрөнгө оруулалт гэдэг нь ямар нэгэн хөрөнгийг ирээдүйд үр ашгаа өгөх хэлбэрт шилжүүлж, өгөөж авах зорилгоор бэлэн мөнгө, хувьцаа, бонд, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөд байршуулах үйл ажиллагаа юм. Эдийн засгийн онолоор тухайн улсын нэг жилд үйлдвэрлэсэн нийт баялаг буюу ДНБ-ийг зардлын ангиллаар тооцоолох нэг бүрэлдэхүүн нь хөрөнгө оруулалт байдаг. Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн хөгжлийн нэг гол хүчин зүйл юм. Үр өгөөжтэй төсөлд хөрөнгө оруулахын хэрээр үйлдвэрлэл нэмэгдэж, ДНБ өсөн улмаар эдийн засгийн өсөлтийг тэлдэг тул хөрөнгө оруулалт ба эдийн засгийн өсөлт харилцан эерэг хамааралтай гэж үздэг.

Төсвийн хөрөнгө оруулалтын хувьд хувийн хөрөнгө оруулалтаас ялгаатай байдал нь эдийн засаг, нийгмийн дэд бүтэц, үйлчилгээг хангахад чиглэсэн урт хугацаанд ашиглах нийтийн буюу төрийн болон орон нутгийн өмчийг бий болгодогт оршино. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь урт хугацааны хөгжил, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эдийн засгийн тэргүүлэх чиглэлд нөөцийг оновчтой хуваарилж, үр ашигтай, хэмнэлттэй байхад чиглэгддэг.

Хууль зүйн хувьд төсвийн хөрөнгө оруулалт гэдгийг “улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг ойлгоно гэж” Төсвийн тухай хуулийн 4.1.24-т тодорхойлсон байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг бэхжүүлснээр дараах 3 чиглэлд эерэг үр дүн гарна гэж үздэг:

1. Урт хугацааны хөгжлийн бодлого, зорилт хэрэгжинэ. Үүнд: улс, орон нутаг, салбарын урт хугацааны бодлого, зорилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дунд болон богино хугацааны зорилго, зорилтуудын дийлэнх нь хөрөнгө оруулалтаас хамааралтай байдаг.
2. Төсөв, санхүүгийн удирдлагын хэрэгжилт хангагдана. Төсвийн санхүүгийн нэгдмэл хариуцлага, нөөцийн оновчтой хуваарилалт, төрийн үр ашигтай үйлчилгээний зорилтыг мөн л хөрөнгө оруулалтын оролцоотой хангана гэж үздэг.
3. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд ахиц, дэвшил гарна. Хөрөнгө оруулалтын удирдлагын зөв тогтолцоо нь төслийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар гүйцэтгэлийг сайжруулдаг.

Дэлхийн банкнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад заавал байх 8 үе шатыг дараах байдлаар тодорхойлсон.[3]

Зураг 1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шат



Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын дээрх 8 үе шат нь дараах агуулгатай:

- Хөрөнгө оруулалтын стратеги, бодлого: Энэ үе шатанд стратегийн хөрөнгө оруулалтын удирдамж, төслийн үзэл баримтлал боловсруулж, урьдчилсан шалгалт хийдэг. Төслийн үзэл баримтлал нь Засгийн газрын стратегийн зорилт, эдийн засгийн ангилалд нийцсэн байх наад захын шалгуурыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд салбарын шийдвэр гаргагчдад

[3] Kim, Jay-Hyung, Jonas Arp Fallov, and Simon Groom. 2020. Public Investment Management Reference Guide. International Development in Practice. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1529-4. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO

чиглүүлэх стратегийн өргөн хүрээний удирдамж боловсруулж, урьдчилсан шалгалт хийх үе шат юм.

- Төслийн албан ёсны үнэлгээ: Энэхүү төсөл бэлтгэх үе шатанд зураг төсөл, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг багтаасан урьдчилсан үнэлгээ болон ТЭЗҮ гэсэн хоёр судалгааг хийнэ. Эдгээр нь төслийн техникийн хүчин чадал, цар хүрээнд нийцсэн аргачлалаар тодорхойлогдоно.
- Төслийн хөндлөнгийн үнэлгээ: Энэ үе шатанд Сангийн яам, Төлөвлөлтийн яам эсхүл, бие даасан агентлаг төслийн эрэлтийг хэтрүүлэн тооцсон эсэх, зардлыг дутуу тооцсон эсэхийг хянана.
- Төслийн сонголт ба төлөвлөлт: Энэ үе шатанд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтыг төсвийн мөчлөгтэй холбох, төслийн зохистой байдал, тэргүүлэх ач холбогдол, ирээдүйд гарах зардал, санхүүжилтийг нягтлан шалгана.
- Төслийн хэрэгжилт: Энэ үе шатанд төслийн зохион байгуулалт, зохицуулалт, худалдан авалт, төлөвлөлт, ажлын хуваарь хийх зэргээр төслийг хэрэгжүүлэх бөгөөд хяналтын систем, төслийн нийт зардлыг удирдана.
- Явцын тохируулга, сайжруулалт: Төслийн хэрэгжилтийг харгалзан гүйцэтгээгүй төслийг зогсоох, эсхүл төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах зэргээр тохируулга, сайжруулалт хийнэ.
- Хөрөнгийн удирдлага: Шинэ барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлтгэх, төлөвлөсөн үйлчилгээг тогтвортой хүргэх, үндсэн хөрөнгөд бүртгэх, засвар үйлчилгээ хийх зэргээр хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- Төслийн хяналт, тайлагналт: Энэхүү үе шатанд төсөл дууссаны дараа тогтоосон хугацаанд төсөвт заасны дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянаж, төслийн үр дүнг зураг төсөлтэй харьцуулан үнэлэх замаар гүйцэтгэлийн дараах хяналт, тайлагналтыг хийдэг.

Хүснэгт 1.Хөрөнгө оруулалтын эх үүсвэр, оролцогчид

Эх үүсвэр	Төслийн үе шат */оролцогчид/*					
	Төлөвлөлт	Худалдан авах ажиллагаа	Хэрэгжилт, гүйцэтгэл	Санхүүжилт	Хяналт, тайлагналт	Өмч бүртгэл, ашиглалт
Улсын төсөв	- Батлах: УИХ - Боловсруулах: Засгийн газар /Сангийн яам, ТЕЗ нар/ - Санал гаргах: /ТЕЗ, аймаг, нийслэл, агентлаг/	ТЕЗ, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Аймаг, нийслэлийн Худалдан авах ажиллагааны алба	Захиалагч, Захиалагчийн хяналт, Зохиогчийн хяналт, Гүйцэтгэгч	Захиалагч, Сангийн яам	Захиалагч	Захиалагч
Гадаад зээл, тусламж	- Батлах: УИХ - Боловсруулах: Засгийн газар /Сангийн яам, ТЕЗ нар/	ТЕЗ, Захиалагч, Санхүүжүүлэгч байгууллага, Төрийн худалдан авах	Захиалагч, Захиалагчийн хяналт, Санхүүжүүлэгч	Захиалагч, Санхүүжүүлэгч байгууллага, Сангийн яам	Захиалагч, Санхүүжүүлэгч байгууллага	Захиалагч

	- Санал гаргах: ТЕЗ, аймаг, нийслэл, агентлаг	ажиллагааны газар, Аймаг, нийслэлийн Худалдан авах ажиллагааны алба	байгууллагын хяналт, Захиалагчийн хяналт, Зохиогчийн хяналт, Гүйцэтгэгч			
Орон нутгийн төсөв, ОНХС	- Батлах: аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл - Боловсруулах: аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагч, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч - Санал гаргах: орон нутгийн агентлаг	Захиалагч, Аймаг, нийслэлийн Худалдан авах ажиллагааны алба	Захиалагч, Захиалагчийн хяналт, Зохиогчийн хяналт, Гүйцэтгэгч	Захиалагч, Сангийн яам	Захиалагч	Захиалагч
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүжилт	- Батлах: Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл - Боловсруулах: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	Захиалагч, Аймаг, нийслэлийн Худалдан авах ажиллагааны алба	Захиалагч, Захиалагчийн хяналт, Зохиогчийн хяналт, Гүйцэтгэгч	Захиалагч, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд	Захиалагч	Захиалагч
ТХХТ-ийн санхүүжилт	- Батлах: Засгийн газар, аймаг, нийслэлийн ИТХ - Боловсруулах: Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засаг дарга -Дүгнэлт гаргах: Сангийн яам -Санал гаргах: Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил	Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга	Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хувийн хэвшлийн түншлэгч, аймаг, нийслэлийн Засаг дарга	Сангийн яам, аймаг, нийслэл	Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга	Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн Засаг дарга

Дүгнэлт:


1. Дэлхийн банкнаас төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 8 үе шатыг хэрэгжүүлсэн байхыг улс орнуудад зөвлөдөг бөгөөд Монгол Улсын хувьд Төсвийн тухай хууль, холбогдох журам, цахим системд шинэчлэл хийж, уг 8 үе шатыг нэвтрүүлж эхэлсэн ч цаашид улам сайжруулах шаардлагатай байна.
2. Улсын хэмжээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогчид нь эх үүсвэрээс хамааран ялгаатай байх бөгөөд төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, тайлагналтын нэгдсэн тогтолцоо хангалтгүй байна.

1.1.1.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт

Аливаа улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь төсвийн хөрөнгө оруулалтын зорилго, чиглэлийг тодорхойлох үндэс суурь болдог. Монгол Улсын Үндсэн хуульд 2019.11.14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д *“... Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна ...”* гэж заасан.

ХБТТУтХ-аар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн суурь зохицуулалтыг тусгасан бөгөөд уг хуулийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж, Төсвийн тухай хуулийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх” гэж заасан. *Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны зорилго, зорилтыг хангахад чиглэгдэх шаардлагатайг илтгэж байна.*

Зураг 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл



Монгол Улсын урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын талаар дараах зорилтуудыг тусгасан байна. Үүнд:

Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор[4] батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Эдийн засгийн

[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15406

тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, ... эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, ... хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болох" зорилт дэвшүүлсэн.

- 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.6-д "Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна", *4.1.21-т "Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.",* 5.2.11-д "Улсын нэгдсэн төсвийг урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, батлах тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ." гэж тусгасан.

Дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

- УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор [5] батлагдсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын 3 дахь хэсгийн бүсүүдийн хөгжлийн зорилго, зорилтод "Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, ТХХТ-ийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна." гэж, 5.2-т "*бүс нутгийн тэргүүлэх чиглэл, байгаль газар зүйн нөхцөл, нөөц, байршлын давуу талтай уялдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, ТХХТ-ийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна*." гэж тусгасан.
- УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор[6] батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-оор боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот, хөдөө, ногоон хөгжил болон төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд *Монгол Улсын хөгжлийн 20 багц төслийг хэрэгжүүлэхээр* заасан.

Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг

- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор[7] батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д "... Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, ... эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, ... хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно." гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэ хүрээнд 4.1.2-т "*төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болгоно*." гэж хүрэх үр дүнг тусгасан.

[5] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140840005441
[6] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431
[7] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15584

- Түүнчлэн, уг тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” батлагдсан ба 150 төслийг гадаад зээл, тусламж, улсын төсөв, холимог эх үүсвэр, Хөгжлийн банк, ТХХТ-ийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр заасан.
- УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор[8] батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.2.2-т “Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дараалыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, ... хиймэл оюун ухааныг ашиглана.”, 3.2.2.14-т “*Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө*.”, 4.4.2.15-д “Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, үр өгөөжийг дээшлүүлнэ.” гэж тусгасан.

Богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг

- УИХ-ын тогтоолоор тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлдэг. Тухайлбал; УИХ-ын 2024.10.08-ны өдрийн 35 дугаар тогтоолоор[9] “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-г баталсан. Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 1.3.2.8-д “*Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дараалыг оновчтой тодорхойлж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох оролцогчдын хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, хиймэл оюун ухааныг ашиглана ...* ” хэмээн тусгажээ.

Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого төлөвлөлт дараах хандлага чиглэлээр хөгжих шаардлагатай болж байна. Үүнд:

1.Байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжсэн байх;
2.Гамшигт тэсвэртэй байх;
3.Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн байх;
4.Жендерийн мэдрэмжтэй байх;
5.Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилах.

Дээрх чиглэлээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон олон улсын гэрээнд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Ногоон хөгжил” хэсгийн зорилго 6-д “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган

[8] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311
[9] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142247261431

үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.” гэж заасан. Төсвийн хөрөнгө оруулалтад байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүч ашиглах шаардлага тулгамдаж байна. Түүнчлэн, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Амар тайван, аюулгүй нийгэм” хэсгийн зорилго 7-д “гамшгийн эрсдэлийг бууруулах”, “гамшигт тэсвэртэй дэд бүтцийг бий болгоно” гэж заасан.

Монгол Улс “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай” НҮБ-ын суурь конвенцыг[10] 1993 онд, уг конвенцын Парисын хэлэлцээрийг[11] 2016 онд соёрхон баталсан. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор[12] баталсан. Монгол Улс үндэсний хүлэмжийн хийн ялгарлаа нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.89 сая CO2-той дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах зорилт дэвшүүлсэн.

Засгийн газар, Жендерийн үндэсний хорооны 2022.10.05-ны өдрийн 2 дугаар тогтоолоор “Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-г батлсан. Уг төлөвлөгөөний зорилт 3.3-т “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх түвшинд нэвтрүүлнэ” хэмээн зааж, үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаар Сангийн яамыг тодорхойлсон.

Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт нь жендерийн онцлог хэрэгцээг хангах, олон салбар дахь жендерийн ялгаатай байдлыг бууруулах зорилготой. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн туршилтын шатанд Сангийн яамнаас 2021-2024 онд төсвийн төсөл боловсруулах удирдамжид жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар тусгаж төсвийн захирагч нарт хүргүүлжээ. Туршилтын хугацаанд жендерийн мэдрэмжтэй бодлогыг үндэсний хөгжил, салбарын бодлого, төсөвтэй илүү уялдуулах шаардлагатай гэж дүгнэсэн.[13]

Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөх талаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан. Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 02 дугаар албан даалгаварт хиймэл оюун ухаан, өндөр технологийн шилжилт, ногоон хөгжлийн шилжилт хийх чиглэлээр ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосон.

[10] https://legalinfo.mn/mn/detail?lawId=10695
[11] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12109
[12] https://legalinfo.mn/mn/detail?lawId=210340&showType=1
[13] “Монгол Улсын жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлт сургамж, дараагийн алхам” бодлогын танилцуулга

Дүгнэлт: Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхой заасан байна. Тухайлбал:

1. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлнэ;
2. Төсвийн хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэхэд зарцуулах ба санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилна гэжээ.

1.1.1.3.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн тухай

Нийгмийн шинжтэй буюу төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай бүтээн байгуулалтын төслийг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт дараах эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд: улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаад зээл, тусламж, ТХХТ/концесс, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөв, Засгийн газрын тусгай сан болон санхүүгийн бусад эх үүсвэр хамаарна.

Төсвийн хөрөнгө оруулалт дээрх эх үүсвэрээр хэрэгждэг тул тэдгээрийг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбогдох харилцааг хэд хэдэн хууль, эрх зүйн актаар зохицуулдаг ба тэдгээрийн хоорондын уялдаа холбоо сул, нэгдсэн зохицуулалт хангалтгүй байна. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт, тайлагналтын харилцааг журмаар зохицуулдаг нь хариуцлагын тогтолцоог сулруулж, эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Нэгдсэн төсвийн нийт зардалд тусгагдаг хөрөнгийн зардлын талаар:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Төсвийн тухай хуулийн 8.4-т зааснаар Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх бөгөөд УИХ жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батална.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн асуудлыг Төсвийн тухай хуулиар зохицуулдаг. Төсвийн тухай хуулийн 33.2.6-д зааснаар “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/ тусгаж батална. Үүний дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар баталдаг.[14] Мөн

[14] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333387179651&showType=1

Төсвийн тухай хуулийн 27, 29, 29[1] дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг тодорхойлсон.

2.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт: Төсвийн тухай хуулийн 8.5-д зааснаар аймаг, нийслэлийн ИТХ, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор, сум, дүүргийн ИТХ, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Зөвлөл тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор батална. Төсвийн тухай хуулийн 68.1-д орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална хэмээн хуульчилсан. Өөрөөр хэлбэл, орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/ батлах учиртай.

Түүнчлэн, 2024.06.05-ны өдөр Төсвийн тухай хуулийн 68.2, 68.3-т дараах өөрчлөлт орсон. Үүнд:

-68.2.Төсвийн төслийг ИТХ, Зөвлөлөөр хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

-68.3.ИТХ, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ. Эдгээр өөрчлөлтийг 2025.06.01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тусгасан.

Орон нутгийн төсвөөр 21 аймаг, нийслэл болон сум, дүүрэгт хөрөнгө оруулалт хийдэг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын талаар жишээ болгон Өвөрхангай аймаг болон Нийслэлийн төсвийн талаар товч танилцуулъя.

2.1.Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт: Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2024.12.18-ны өдрийн 02/12 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны төсвийг баталсан.[15] Уг тогтоолын 2 дугаар хавсралтаар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засварын 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан бөгөөд төсөл, арга хэмжээний нэр, хэрэгжиж эхлэх, дуусах хугацаа, төсөвт өртөг, 2025 онд санхүүжих дүнг тусгажээ. Ингэхдээ шилжих хөрөнгө оруулалт, дараа нь шинэ хөрөнгө оруулалт гэсэн дарааллыг баримталжээ. 2025 онд шилжих болон шинэ 26 төсөлд 5,624.3 сая төгрөгийн төсөв тусгаснаас 2025 онд 4,301.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2024 оны 02/12 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 4 дүгээр

[1515] https://uvurkhangai.gov.mn//upload/files/cc2b6fee2ff64a69ef4259a1639cca04.pdf

хавсралтаар аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан. Тодруулбал, Өвөрхангай аймаг орон нутгийн төсөв, аймгийн замын сангийн хөрөнгө болон аймгийн ОНХС гэсэн 3 эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийж байна.

2.2.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт: Нийслэлийн ИТХ-ын 2024.12.25-ны өдрийн 24/33 дугаар тогтоолоор нийслэлийн 2025 оны төсвийг баталсан.[16] Уг тогтоолын 2 дугаар хавсралтаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 3 дугаар хавсралтаар нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 4 дүгээр хавсралтаар нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 5 дугаар хавсралтаар нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 6 дугаар хавсралтаар нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалтыг, 7 дугаар хавсралтаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг, 8 дугаар хавсралтаар нийслэлийн ОНХС-гийн хөрөнгөөр 2024-2025 онд дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталжээ. Тодруулбал, нийслэлд нийслэлийн төсөв, замын сангийн хөрөнгө, нийслэлийн үнэт цаасны хөрөнгө, нийслэлийн ОНХС гэсэн 4 эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийж байна.

Нийслэл, Өвөрхангай аймгийн жишээнээс үзэхэд орон нутагт улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, аймгийн замын сан, үнэт цаасны хөрөнгө зэрэг эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийж байна. Иймд эдгээр эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн хэрэгцээ, шаардлага, уялдаа холбоо, хяналт, ил тод байдал, эдийн засгийн үр ашгийг хангах шаардлагатай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт: “Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэнэ” гэж Төсвийн тухай хуулийн 4.1.28-д тодорхойлсон. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан Төсвийн тухай хуулийн 59.1-д зааснаар Ашигт малтмалын тухай хуулийн 47^3 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10 хувь, дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувиас бүрддэг. Орон нутгийн

[16] https://ulaanbaatar.mn/files/mn/budget-info/file/6zo7blojzwq/67720114e90d11380022174d.pdf

хөгжлийн нэгдсэн сангаас болон улсын төсвөөс олгох шилжүүлгийг ОНХС-д Төсвийн тухай хуульд зааснаар хуваарилдаг.

Төсвийн тухай хуулийн 60.2-т ОНХС-гийн эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал;
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 100 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь;
- Малын тоо толгойн албан татварын орлого;
- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж;
- Энэ хуулийн 59.8-д заасан хуваарилалт.

Төсвийн тухай хуулийн 60.3-т зааснаар ОНХС-гийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно. Үүнд:

- Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ;
- Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
- Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;
- Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
- Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
- Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг орон нутаг тухайн жилийн төсөвтэй хамт батлан хэрэгжүүлж байна.

4.Гадаад зээл, тусламжаар хэрэгжих хөрөнгө оруулалт: Төсвийн тухай хуулийн 11.1.8-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зээл, тусламжийн санхүүжилт, зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж, 32.2.8-д “гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/-ыг төсвийн төслийн

танилцуулгад тусгана” гэж тус тус заасны дагуу гадаад зээл, тусламжаар хэрэгжих төслийн төсвийн төлөвлөлтийг Сангийн сайдын багцад тусгадаг. Мөн хуулийн 8.6.3-т заасан төсвийн хуваарийн дагуу төслүүдийн төсвийг төлөвлөж, батлан мөрдүүлж, түүнд өөрчлөлт оруулдаг.

5.ТХХТ-ээр хэрэгжих хөрөнгө оруулалт: Концессын хуулийг анх 2010 онд батлан хэрэгжүүлж байсан ч уг хуулийн дагуу амжилттай концессын төсөл хэрэгжих боломжгүй, үр нөлөө нь төсөвт эрсдэл үзүүлж байсан тул 2022 онд Концессын хуулийг хүчингүй болгож, ТХХТ-ийн тухай хуулийг шинээр баталсан.

ТХХТтХ-аар нийгмийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрийг төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлэх боломж бүрдсэн. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төслийг санхүүжилтийн зохион байгуулалт, төлбөрийн нөхцөл, онцлогоос хамааруулан дараах 2 үндсэн төрөлд ангилж үздэг. Үүнд:

1) Хэрэглэгч төлөх төсөл

Хувийн хэвшлийн этгээд нь төслийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлсний дараа хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж, орлогоосоо зардлаа нөхөн төлж ашиг хүртдэг. Төрийн зүгээс санхүүгийн үүрэг шууд хүлээхгүй байх тохиолдол элбэг бөгөөд төр зөвхөн зөвшөөрөл олгох, зохицуулалт хийх, хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлдэг. Энэхүү төрлийн төслийн жишээнд авто замын хураамж, нийтийн тээвэр, цахилгаан хангамж, усан хангамж, хог хаягдлын менежмент зэрэг орлого бүрдүүлэх боломжтой дэд бүтцийн үйлчилгээ багтана.

2) Засгийн газар төлөх төсөл

Хувийн хэвшлийн этгээд нь төслийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж, дараа нь Засгийн газраас гэрээний нөхцөл, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн тогтоосон хэмжээгээр төлбөр авах байдлаар хөрөнгө оруулалтаа нөхдөг. Төсвөөс урт хугацаанд санхүүгийн үүрэг хүлээх энэхүү арга нь орлого шууд бүрдүүлэх боломжгүй, нийгмийн шинж чанартай үйлчилгээний салбарт (жишээлбэл, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн захиргааны байгууллагын барилга, цэвэрлэх байгууламж гэх мэт) өргөнөөр ашиглагддаг.

Түүнчлэн, Засгийн газраас төлөх ТХХТ төсөл нь төсөв, өрийн удирдлагад шууд болон шууд бус урт хугацааны нөлөө үзүүлдэг бөгөөд төслийг эхлүүлэх, хэрэгжүүлэх шийдвэр гаргахад төсвийн хүрээний баримт бичиг, өрийн удирдлагын бодлого, хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан, урьдчилсан үнэлгээ, нөлөөллийн судалгаанд үндэслэх нь чухал байдаг. Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлд ТХХТ-ийн талаар зохицуулсан бөгөөд 30.3-т “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний төсвөөс санхүүжүүлэх төлбөрийн үүрэг нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.” хэмээн хуульчилсан.

ТХХТтХ-д зааснаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг тухайн салбарын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн авах, төслийн саналд хийсэн урьдчилсан үнэлгээг хянаж баталгаажуулах, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн бүрэн шинжилгээг хянаж, дүгнэлт гаргах, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл өгөх, Засгийн газар төслийн бүрэн шинжилгээ хийгдсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Нэгдсэн төсвийн нийт зардалд тусгагддаггүй эх үүсвэрийн талаар:

1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаас: Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нийтийн зориулалттай, нийтээрээ ашиглах төсөлд хөрөнгө оруулалт хийдэг. Жишээ дурдахад, “Эрдэнэт” ТӨҮГ сургууль, цэцэрлэг, дотуур байрны 819 нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажилд 50.0 тэрбум төгрөг зарцуулахаар болсон байна.[17] “Эрдэнэт” ТӨҮГ боловсролын байгууллагын нүхэн жорлонг сайжруулах болсон нь УИХ-ын 2020 оны 39 дүгээр тогтоолтой[18] холбоотой бөгөөд уг тогтоолын 1.5-д “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасан. УИХ-ын шийдвэртэй тул дээрх хөрөнгө оруулалтын мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.[19]

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудасны мэдээллээр[20] тус байгууллага нь нийт 21 төрийн өмчит аж ахуйн тооцоотой хуулийн этгээд (ТӨҮГ, ХК, ХХК)-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч байна. Тухайлбал, “МИАТ” ТӨХК, “Монголын төмөр зам” ХХК, “Монгол шуудан” ХК, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ зэрэг.

Дээрхтэй адилаар Засгийн газраас хувьцаа эзэмшигчээр тогтоосон шийдвэрийн дагуу Сангийн яам, Эрчим хүчний яам болон бусад төрийн захиргааны байгууллагууд төрийн өмчит хуулийн этгээд (аж ахуйн тооцоотой)-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлдэг. Хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч буюу төрийн захиргааны байгууллагууд нь үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, төрийн өмчит хуулийн этгээдийн дүрэм, холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг мөрдөн ажилладаг. Эдгээрээс төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны төсөв, хөрөнгө оруулалт, эдийн засгийн үйл ажиллагаанд баримталдаг суурь хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль байна. Төрийн болон орон

[17] https://www.parliament.mn/nn/15846/
[18] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15773
[19] “Эрдэнэт” үйлдвэрийн хөрөнгө оруулалтын мэдээлэл 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем publicinvestment.gov.mn-д орсон.
[20] https://pcsp.gov.mn/?page_id=1822

нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуульд зааснаар төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурал нь төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, түүний зардлыг төсөвлөн баталдаг.

Төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг хөрөнгө оруулалтын зарим хэсэг нь нийтийн хэрэгцээнд ашиглагдах боломжтой бол, зарим хэсэг нь дотоод үйл ажиллагаанд хэрэглэгддэг. Гэхдээ төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлдэг хөрөнгө оруулалтын талаарх нэгдсэн мэдээлэл Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын алинд ч байхгүй. Учир нь төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг өөр өөр байгууллага хэрэгжүүлэхийн сацуу төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл нэгтгэгдэх, тухайн мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байх тухай хууль зүйн зохицуулалт байхгүй болно.

Түүнчлэн, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчийн эрхийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлдэг. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг хөрөнгө оруулалтын мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй бус бөгөөд нэгдсэн тайлан, мэдээллийг төрийн өмчит хуулийн этгээдтэй адил ямар ч байгууллага хариуцан гаргадаггүй байна.

ОУВС-гийн 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл - техникийн туслалцааны тайлан”-гаар “төрийн өмчит томоохон компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг Эдийн засаг, хөгжлийн яам болон Сангийн яамаар хянуулж, хэлэлцүүлэх журам тогтоож, төрийн өмчит компанийн удирдлага, хяналтыг сайжруулах. Төрийн өмчит компанийн санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг олон нийтэд нээлттэй, ил тод нийтлэх;” гэсэн зөвлөмж өгсөн. Тодруулбал, “Төрөөс төрийн болон орон нутгийн өмчит компани, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг системтэйгээр хянадаггүй, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, санхүүгийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланг нийтэлдэггүй, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй, санхүүгийн удирдлагын зохицуулалт бүрэн тогтоогдоогүй нь төсөвт эрсдэлтэй тул хөрөнгө оруулалт, санхүүгийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланг бэлтгэх, төсвийн эрсдэлд дүн шинжилгээ хийх шаардлагатай” болохыг анхааруулсан.

2.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаас: Хувийн хэвшлийн компаниуд мөн нийтийн зориулалттай төсөлд хөрөнгө оруулалт хийдэг. Тухайлбал, “Монголын Алт” компани Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 11.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 960 хүүхдийн сургуулийг 2022 онд барьж ашиглалтад оруулсан. Түүнчлэн, “Монголын Алт” компани Өмнөговь аймгийн Гурвантэс суманд 320 хүүхдийн сургууль, 120 хүүхдийн дотуур байр, хүүхэд, залуучуудын соёл, спортын төв, Дорноговь аймгийн

Даланжаргалан суманд 120 хүүхдийн цэцэрлэг зэрэг бүтээн байгуулалтыг өөрсдийн хөрөнгөөр хийсэн байдаг.[21]

“MCS” компани “Борх” нарны цахилгаан станц, “Цэнгэг” эрчим хүч хуримтлуурын системийг 2021-2022 онд, Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн засвар, тохижилтыг 2019-2020 онд 300 сая төгрөгөөр гүйцэтгэсэн зэрэг төслийг хэрэгжүүлсэн байдаг.[22]

Хувийн хэвшлийн бусад компаниуд өөрсдийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлдэг ч энэ талаарх нэгдсэн тоон мэдээлэл мөн дутагдалтай.

3.Хувийн хэвшлийн зарим сан: Засгийн газрын бус сангууд хөрөнгө оруулалт хийдэг. Жишээ дурдвал, “Оюу толгой” компанийн “Говийн Оюу хөгжлийг дэмжих сан” эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр тогтвортой хөгжилд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд “Оюу толгой” компаниас жил бүр 5 сая ам.долларын санхүүжилт олгоно гэсэн мэдээлэл олдов.[23]

4.Хөгжлийн сан: Хөгжлийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн мэдлийн шинэ сан бол Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн[24] 9.1.3, 10.1.3-т заасан Хөгжлийн сан болно. Үндэсний баялгийн сангийн тухай хуульд зааснаар Хөгжлийн сан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эдийн засаг, нийгмийн үр өгөөж бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх, сангийн үйл ажиллагааны удирдлагыг хэрэгжүүлэх, Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан Хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ-д өргөн мэдүүлэх, УИХ Хөгжлийн сангаар санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг хэлэлцэн батлахаар зохицуулжээ.

Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Үндэсний баялгийн сан” хэсэг, зорилтыг хэрэгжүүлэх II үе шат (2031-2040), *4.6-д “Мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх болсноор нийгмийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, улмаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чадавхыг бүрдүүлсэн байна.”* гэж, урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Үндэсний баялгийн сан” хэсэг, *4.6.6-д “Хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбарууд болох зам тээвэр, эрчим хүч, усны менежмент, харилцаа холбоо зэрэг салбаруудыг дэмжиж, цаашлаад уул уурхай*

[21] https://www.mak.mn/news
[22] https://mcs.mn/mn/srproject/
[23] https://goviinoyu.mn/uil-ajillagaa
[24] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140188869101

дагасан дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэн дотогшоо чиглэсэн хөрөнгө оруулалт хийнэ. Томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг сангийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ." гэж заажээ. Түүнчлэн, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгасан.

Хөгжлийн сангаар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэхэд давхардал үүсэх эрсдэлтэй тул ямар эх үүсвэрээр ямар төсөл хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай.


Дүгнэлт:

1. Монгол Улсад улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаад зээл, тусламж, ТХХТ, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, сан, хувийн хэвшил болон бусад эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын олон эх үүсвэртэй.
2. Хөрөнгө оруулалтын эдгээр эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийн талаарх нэгдсэн мэдээлэлгүйн улмаас зарим төсөл давхардах, бүрэн хүчин чадлаар ажиллах боломжгүйд хүрэх, төслийн үр өгөөж буурах зэрэг тохиолдол гарах, мөн зарим хөрөнгө оруулалтууд давхардах, зөрчилдөх эрсдэл үүсэх магадлалтай.
3. Хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрээр төсөл хэрэгжүүлдэг ч эдгээрийн мэдээлэл, ялангуяа төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын мэдээллийг нэгтгэн гаргах, улмаар төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд оновчтой ашиглах шаардлагатай

1.1.1.4.Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэл

Монгол Улсад 2016-2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 22.8 их наяд, гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр 16.4 их наяд, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 22.1 их наяд төгрөг буюу нийт 61.4 их наяд төгрөгийн эх үүсвэр тус тус хөрөнгө оруулалтаар батлагдаж, хэрэгжсэн байна.


График 1.Төсвийн хөрөнгө оруулалт /эх үүсвэрээр, тэрбум.төг/



2025 онд 9.9 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийснээс 3.2 их наяд төгрөг нь улсын төсвөөс, 2.0 их наяд төгрөг нь гадаад зээл, тусламжаар, 4.7 их

наяд төгрөг нь орон нутгийн төсвөөс хэрэгжсэн. 2026 онд 11.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөснөөс 3.3 их наяд төгрөг нь улсын төсвөөс, 1.6 их наяд төгрөг нь гадаад зээл, тусламжаар, 6.3 их наяд төгрөг нь орон нутгийн төсвөөс хэрэгжинэ.

График 2.Төсвийн хөрөнгө оруулалт ба ДНБ /эзлэх хувиар/



Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардлын хөрөнгийн зардлын хувьд төсвийн нийт зардлын дунджаар 22 хувь, ДНБ-ий дунджаар 7.5 хувь байгаа нь хөгжиж буй орны хувьд хангалттай үзүүлэлт боловч гол асуудал нь үр ашгийн үзүүлэлт чухал хэвээр байна.

ОУВС-гийн судалгаанд хөгжиж буй орнууд ДНБ-ийхээ 1 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн хөрөнгө оруулалт хийснээр ДНБ урт хугацаанд 1-ээс дээш хувийн өгөөж бий болгодог гэж дурддаг.[25] Аливаа улсын хөрөнгө оруулалт нь шингээх чадвартаа нийцсэн байвал эдийн засаг, нийгмийн өсөлт бий болгож, харин шингээх чадвараас хэтэрвэл нөөцийн хомсдолыг үүсгэн инфляцыг өдөөж, хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулдаг гэж үздэг.

Төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх зохистой хэмжээ нь тухайн улсын эдийн засгийн хөгжлийн түвшин, хөгжлийн зорилт, төсөв, санхүүгийн чадавх, өрийн дарамт зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Гэхдээ олон улсын жишиг, судалгаанаас үзэхэд дараах нийтлэг чиг хандлага байна:

- *Хөгжиж буй орнуудын хувьд:* Төсвийн хөрөнгө оруулалт ДНБ-ий 4-8 орчим хувь байх нь зохистой гэж үздэг. Хэт бага байвал дэд бүтэц, нийгмийн салбарын хөгжил удааширч, хэт өндөр байвал төсөвт дарамт учруулж болзошгүй.
- *Хөгжсөн орнуудын хувьд:* ДНБ-ий 2-4 орчим хувь байхад хангалттай гэж үздэг. Эдгээр оронд дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн тул хөрөнгө оруулалтын хэрэгцээ харьцангуй бага байдаг.

[25] IMF, “Well Spent How Strong Infrastructure Governance Can End Waste In Public Investment”, 2020, pg 20

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх нийтийн зориулалттай барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлдэг. Сүүлийн жилүүдэд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг тэргүүлэх чиглэл болгож, энэ хүрээнд 2024-2025 онд боомт, олон улсын чанартай авто зам, эрчим хүчний хөрөнгө оруулалтыг түлхүү хэрэгжүүлж байна.


График 3.Төсвийн нийт хөрөнгө оруулалт /эзлэх хувиар, тэрбум.төг/



Монгол Улсын хөрөнгө оруулалтад төсвийн хөрөнгө оруулалт /улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж/-ын эзлэх хувь 2016-2018 онд 15.4-өөс 5.7 хувь болон буурч, 2019-2021 онд 10 хувь байсан бол 2023-2025 онд 8-аас 10 хувь болж өссөн.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2025 онд нийт 19.5 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд давхардсан тоогоор 10,169 төсөл, арга хэмжээнд 16.8 их наяд төгрөгийн санхүүжилт олгон хэрэгжүүлжээ. 2016-2024 оны 16.8 их наяд төгрөгийн санхүүжилтийн 85 орчим хувь нь барилга байгууламж, 9-10 хувь нь НӨАТ, 5-6 хувь нь бусад зардалд зарцуулагдсан байна.

Зураг 3.Санхүүжилтийн задаргаа /эзлэх хувиар/



Төсвийн хөрөнгө оруулалтыг Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын[26] дагуу зардлын эдийн засгийн ангиллаар барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж болон ТЭЗҮ, зураг төсөл гэж ангилдаг бөгөөд өмнөх онуудад хэрэгжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн ангиллаар авч үзвэл дийлэнх хэсэг нь барилга байгууламж, бүтээн байгуулалтын чиглэлд хэрэгжсэн байна.

График 4.Төсвийн хөрөнгө оруулалт эдийн засгийн ангиллаар /эзлэх хувиар/




Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын дунджаар 82.7 хувийг барилга байгууламж, 10 хувийг тоног төхөөрөмж, 5.4 хувийг их засвар, 1.9 хувийг ТЭЗҮ-д зарцуулдаг.

Төсвийн хөрөнгө оруулалт - салбараар: Монгол Улсын хувьд хөгжиж буй орон учраас эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага өндөр хэвээр байгаа тул өмнөх жилүүдэд мөн л эрчим хүч, зам тээвэр, эрүүл мэнд, боловсрол, суурь дэд бүтцийн салбарт ихэнх хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

[26] https://mof.gov.mn/files/uploads/legacy/2021

Зураг 4.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар/эзлэх хувиар, тэрбум.төг/



2012–2019 онд гурван ээлжийн сургалтаас хоёр ээлжид шилжих, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд боловсролын салбар улсын төсвийн хөрөнгө оруулалтын хамгийн өндөр жинтэй салбаруудын нэг байсан. 2020–2022 онд хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй саарсан боловч 2023 оноос дахин өсөж, 2024 онд 723.1 тэрбум төгрөг, 2025 онд 446.4 тэрбум төгрөг, 2026 онд 506.8 тэрбум төгрөгөөр батлагдсан нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэг, дотуур байрны бүтээн байгуулалтыг эрчимжүүлж байгааг харуулж байна.

Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт 2020 оноос хойш тогтвортой өндөр түвшинд хадгалагдаж, инженерийн шугам сүлжээ, хот байгуулалт, ус хангамж, ариутгах татуургын төслүүдэд чиглэн нэмэгдсэн. Тухайлбал, 2024 онд 530.0 тэрбум төгрөг буюу тухайн хугацааны хамгийн өндөр санхүүжилт батлагдсан бол 2025 онд 334.8 тэрбум төгрөг, 2026 онд 216.6 тэрбум төгрөг тус тус батлагдсан байна.

Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тогтвортой үргэлжилж, эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, оношилгоо, тоног төхөөрөмжийн шинэчлэлд чиглэж байна. Тухайлбал, 2024 онд 282.6 тэрбум төгрөг, 2025 онд 145.9 тэрбум төгрөг, 2026 онд 223.7 тэрбум төгрөг батлагдсан.

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт 2023 оноос эрчимтэй өсөж, Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон эрчим хүчний шинэчлэлийн бодлоготой уялдан нэмэгдэж байна. Тухайлбал, 2024 онд 226.0 тэрбум төгрөг, 2025 онд 229.4 тэрбум төгрөг, 2026 онд 312.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан бол 2027 онд 1,061.0 тэрбум төгрөг болж огцом өсөхөөр төлөвлөгдсөн нь эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах болон түгээх дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бодлогыг илэрхийлж байна.

Гадаад зээл, тусламж: Монгол Улс 1990 онд эдийн засгийн тогтолцоог сольж, ардчилсан нийгэм, зах зээлийн эдийн засагт шилжсэн түүхэн шилжилт нь улсын эдийн засгийн бүтэц, удирдлагын тогтолцоог цогцоор нь өөрчлөх шаардлагыг бий болгож, үүний үр дүнд эдийн засгийн хүндрэл, сорилттой тулгарсан. Ийм нөхцөл байдалд гадаадын хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл нь Монгол Улсын эдийн засгийг сэргээх, шинэ нөхцөлд дасан зохицох, бүтцийн шинэчлэл хийхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэр хангалтгүй, төсөв санхүүгийн хомсдол их байсан тул гадаад зээл, тусламжийн эх үүсвэр нэн шаардлагатай болсон.

Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улс олон улсын санхүүгийн болон хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэж, тэдгээрээс нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрийг татах үйл ажиллагааг эхлүүлсэн.

1990-ээд оны эхэн үе нь эдийн засгийн шилжилтийн хамгийн хүнд үе байсан бөгөөд 1990–1999 онуудад Монгол Улс олон улсын байгууллага болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд нийт 1.3 тэрбум ам.долларын гадаад нэн хөнгөлөлттэй болон хөнгөлөлттэй зээлийг авч, эдгээр зээл нь эдийн засгийн бүтцийн шинэчлэл, төрийн байгууллагын зохион байгуулалтын өөрчлөлт, банк, санхүүгийн салбарын шинэ тогтолцоог бий болгох, чадавхжуулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэнд, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь дэд бүтцийг бий болгох, эдийн засгийн уналтын сөрөг үр дагаврыг бууруулах, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх зэрэг олон чиглэлд зарцуулагдсан байна.

Үүний дараа 2000 оноос эхлэн Монгол Улсын эдийн засгийн өсөлт харьцангуй тогтворжиж, шинэ дэд бүтэц бий болгох, үндэсний эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх шаардлага өсөн нэмэгдсэнтэй холбоотойгоор гадаад зээл нь өмнөх арван жилтэй харьцуулахад илүү хөрөнгө оруулалтын шинжтэй, урт хугацааны хөгжлийн бодлогын чиглэлд чиглэх болсон бөгөөд энэ үед нийт 1.5 тэрбум ам.долларын зээлийг дулааны цахилгаан станцын шинэчлэл, авто болон төмөр зам барих, орон нутгийн хөгжил, орон сууц, нийтийн аж ахуй болон агаарын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор авч ашигласан.

Харин 2010-аад оны эхэн үеэс эхлэн Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой болж, гадаад зээлийн нөхцөл хосолмол хэлбэртэй буюу хөнгөлөлттэй болон арилжааны нөхцөл хосолсон хэлбэрт шилжиж, сүүлийн 15 жилийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотын хүн амын өсөлт, төвлөрөл нэмэгдсэнтэй уялдан хотын суурьшлын бүсийг тэлэх, зам тээвэр, инженерийн дэд бүтэц, нийтийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүссэн бөгөөд эдгээр төсөл, хөтөлбөр нь улсын төсвийн шууд хөрөнгө оруулалтаар санхүүжих

боломжгүй, өндөр өртөг бүхий хөрөнгө оруулалтын төсөл байсан тул гадаадын хөнгөлөлттэй зээлийг үндсэн эх үүсвэр болгон ашигласан.

Ийнхүү Монгол Улсын Засгийн газар 1991 оноос хойш хөгжлийн түнш улс болон олон улсын байгууллагаас нийт 27.9 их наяд төгрөгийн гадаад зээл, тусламжийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор авч ашигласан бөгөөд энэ хүрээнд нийт 392 төсөл хэрэгжүүлсний 296 нь амжилттай хэрэгжиж дууссан, харин 96 төсөл нь одоогоор үргэлжлэн хэрэгжиж байна.


Сүүлийн жилүүдэд гадаад зээл, тусламжийн дүн нэмэгдэх хандлагатай байна.[27]

Хүснэгт 2.Гадаад зээл, тусламжийн дүн /тэрбум.төг/

Ангилал	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026
Зээл	835.9	1,096.3	1,196.3	1,265.1	1,384.0	1,224.5	2,209.0	1,542.4	1,235.3
Тусламж	110.0	146.0	150.3	150.3	298.5	570.5	558.0	417.0	365.0
Нийт	945.9	1,242.3	1,346.6	1,415.4	1,682.5	1,795.0	2,767.0	1,959.4	1,600.3

Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн төсвийг төлөвлөхөд Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслийг түлхүү санхүүжүүлэх зарчим баримталдаг.


График 5.Гадаад зээл, тусламжийн дүн /салбараар, тэрбум.төг/



2019-2026 оны гадаад зээл, тусламжийн тал орчим хувийг Азийн Хөгжлийн банк болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын санхүүжилт, үлдсэн хувийг Дэлхийн банк болон бусад хөгжлийн түнш улсын санхүүжилт эзэлж байна.[28]

[27] https://iltod.mof.gov.mn/
[28] Иргэдийн төсөв, https://iltod.mof.gov.mn/

График 6.Хөгжлийн түнш байгууллагын зээл, тусламж /тэрбум.төг/




Концесс: УИХ-аас 2010 онд баталсан Концессын тухай хуулийн дагуу[29] концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслийн эргэн төлөлтийг 2016 оноос улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж эхэлсэн бөгөөд үүнд 1.6 их наяд төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 3.Төсвийн хөрөнгө оруулалт ба концесс /тэрбум.төг/

	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
УТХО	977.6	602.1	683.3	1,553.4	1,330.9	1,418.9	1,393.8	2,686.0	3,828.5	2,914.9
Концесс	70.7	177.7	82.9	144.7	323.5	266.3	303.6	279.6	25.0	107.1
Нийт дүн	1,048.3	779.9	766.2	1,698.1	1,654.4	1,685.2	1,697.4	2,965.6	3,853.5	3,022.1

График 7.Концессын эргэн төлөлт /тэрбум.төг/



[29] ТХХТтХ 2022 онд батлагдаж, 2023.12.31-ний өдрөөс хүчин төгөлдөр болсноор Концессын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсон.

Концессын тухай хууль хэрэгжсэнээс хойш концессын “Барих-Шилжүүлэх”, “Барих- Ашиглах-шилжүүлэх” гэсэн хоёр төрлөөр нийт 60 гэрээ байгуулсан. Эдгээр гэрээний нийт үнийн дүн 8.9 тэрбум ам.доллар буюу 31.2 их наяд төгрөг ба энэ нь Монгол Улсын 2022 оны ДНБ-ий 60 орчим хувьтай тэнцэж байсан. Тодруулбал; концессоос үүсэх санхүүгийн үүрэг өндөр байгааг илэрхийлнэ. Мөн “Барих-Шилжүүлэх” төслийн эргэн төлөлтийг төсөл хэрэгжиж дууссаны дараагаас шууд төлөхөөр тусгасан нь улсын төсөвт ихээхэн ачаалал, дарамт үүсгэж байсан тул Концессын тухай хуулийг хүчингүй болгож, УИХ-аас ТХХТтХ-ийг 2022 онд баталж, 2023.12.31-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Концессын бүх гэрээг “бүрэн хэрэгжсэн” гэж тооцоход концессын гэрээний нийт үнийн дүнгийн ДНБ-д эзлэх хувь (60) нь хөгжиж буй эдийн засагтай улс (5.5 хувь), Азийн хөгжиж буй эдийн засагтай улсын дундаж (10.8 хувь)-аас хэт өндөр байсан.[30]

Дүгнэлт:

1. Сангийн яам улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаад зээл, тусламж, концессын санхүүжилтээр хэрэгжсэн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн талаарх тоон мэдээллийг гаргадаг. Харин санхүүгийн бусад эх үүсвэрээр хэрэгжсэн төслийн талаарх нэгдсэн тоон мэдээлэл гаргадаггүй буюу дутагдалтай байна.
2. 2016-2026 онд улсын төсвөөр 22.8 их наяд төгрөг, гадаад зээл, тусламжаар 16.4 их наяд төгрөг, орон нутгийн төсөв, ОНХС-гаар 22.1 их наяд төгрөг буюу нийт 61.4 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт тус тус батлагдаж, хэрэгжсэн байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2025 онд нийт 19.5 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, давхардсан тоогоор 10,169 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж, 16.8 их наяд төгрөгийн санхүүжилт олгожээ.

[30] ТХХТтХ-ийн тандан судалгаа, судлаачийн тооцоолол

1.1.1.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үе шат

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл нь төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалт гэсэн 5 үе шатаар хэрэгждэг бөгөөд эдгээр 5 процессын үе шат тус бүрийн талаар тодорхой авч үзье.

Зураг 5.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн мөчлөг



1.1.1.5.1.Төслийн төлөвлөлт

Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхэд төлөвлөлтийн үе шат чухал нөлөөтэй бөгөөд төлөвлөлтөд бэлтгэл үе шат үндсэн бүрэлдэхүүн хэсэг болдог. Төлөвлөлтийн шатанд бэлтгэл ажил болох газрын асуудал, зураг төсөл, төсөв, ТЭЗҮ зэрэг ажлууд хамаардаг.

1.Төслийн бэлтгэл үе шат: Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно” гээд 13.3.3-т “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ” гэж заасан. Өөрөөр хэлбэл; төсөл, арга хэмжээний бэлтгэл үе шатанд

ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн, зардал төсвийг магадлалаар баталгаажсан, холбогдох зөвшөөрөл гарсан байх шаардлагатай. Төсвийн тухай хуульд эдгээр шаардлагын талаар нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй буюу ямар төсөлд ТЭЗҮ, ямар төсөлд зураг төсөл заавал хийгдэх талаар тодорхой зохицуулаагүй болно.

1.1.ТЭЗҮ, зураг төслийн талаар холбогдох хуульд тусгасан байдал: Төсвийн хөрөнгө оруулалтыг төсөвт тусгах эхний шаардлага нь өмнө дурдсанаар ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөл, төсвөө батлуулсан байх юм. Эдгээр шаардлагад хамаарах ТЭЗҮ, зураг төсөл, төсөв гэх ойлголтыг хууль тогтоомжид хэрхэн тодорхойлсныг авч үзье.

1. Барилгын тухай хуульд[31] “ТЭЗҮ” гэж тусгасан боловч уг ойлголтод нэр томьёоны тайлбар хийгээгүй. Уг хуулийн 4.1.30-д “зураг төсөл” гэж “барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, ТЭЗҮ, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг хэлнэ.”
2. Эрчим хүчний тухай хуульд[32] “ТЭЗҮ”, “зураг төсөл” гэж тусгасан ч тэдгээр ойлголтод нэр томьёоны тайлбар хийгээгүй. Эрчим хүчний тухай хуулийн 3.1.32-т “магадлал” гэж “эрчим хүчний барилга байгууламж, түүнд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, техник, технологи, нэгдсэн төсөв нь норм, дүрэм, стандартын шаардлага хангасан талаар мэргэшсэн шинжээчийн дүгнэлт гаргах ажиллагааг хэлнэ.”
3. Авто замын тухай хуульд[33] “ТЭЗҮ” гэж тусгасан боловч уг ойлголтод нэр томьёоны тайлбар хийгээгүй. Уг хуулийн 4.1.18-д "зураг төсөл" гэж “авто зам, замын байгууламжийг барих, засварлах, шинэчлэхэд шаардагдах хайгуул, геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, байгаль орчны судалгаа, нарийвчилсан зураг, техникийн шаардлага, өртгийн тооцооны нэгдсэн баримт бичгийг ойлгоно.” гэж тодорхойлжээ.

Төсвийн тухай хуулийн 24.6, 28.6, 29.4-т “зураг төсөв” гэж, 29[1].2.2-т “зураг төсөл” гэж ялгаатай хуульчилжээ.

Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Авто замын тухай хуульд “зураг төсөл” гэж, Төсвийн тухай хуульд “зураг төсөв”, “зураг төсөл” гэж тусгасан хэдий ч төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд нийтлэг байдлаар хэрэглэгддэг.

[31] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11705
[32] https://legalinfo.mn/mn/detail?lawId=60
[33] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12656

Зураг төсөл гэдэг нь ТЭЗҮ болон төсвийн аль алиныг багтаасан ойлголт байхаар Барилгын тухай хууль, Авто замын тухай хуульд заажээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах хүрээнд 2016 оноос дараа онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсвийг боловсруулахад нийт 438.9 тэрбум төгрөг зарцуулсан боловч зураг төсөл, төсөв хийгдсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэггүй, төсөвт тусгадаггүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй төслийн зураг төслийг гүйцэтгэснээс болж “хэрэгцээгүй цаас” болон хувирч, төсвийн үргүй зардал гарах эрсдэлийг бий болгодог байна.

Мөн, зураг төсөл батлагдсаны дараа зарим ТЕЗ зураг төсөл, ажлын даалгаварт дур мэдэн өөрчлөлт оруулдаг. Үүнээс шалтгаалан барилгын ажил гацах, зогсох эрсдэл үүсдэг байна. Зураг төсөл боловсруулахад гарсан алдаанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо сул бөгөөд зураг төслийн магадлал чанаргүй хийгдэж байгааг сайжруулах, үнэн зөв хийх хэрэгтэй байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Төсвийн тухай хуулийн 29[1].2.2-т барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх гэсэн заалтыг Сангийн яамнаас боловсруулан 2022 онд батлуулсан боловч хэрэгжилтэд асуудал гарч байна. Тухайлбал, зарим төслийн шинж чанар, түвэгшлийн түвшин, техникийн шийдлийн онцлогоос хамааран харилцан адилгүй байгаагаас зураг төсөл, төсвийг нарийвчлан боловсруулах, эсхүл техник, технологийн хувьд нарийн, иж бүрэн төлөвлөлт шаарддаг ч, гүйцэтгэлийн хувьд стандартад суурилсан, олон улсын туршлагад тулгуурласан, инженерчлэлийн ажлын явцад тухай бүр зураг төслийг боловсруулах тохиолдол гардаг байна.

Монгол Улсын хууль тогтоомжид “зураг төсөл” нь “ТЭЗҮ” гэх ойлголтоос өргөн хүрээтэй ойлголт байхаар тусгажээ. “Зураг төсөл” гэх ойлголтод нэр томьёоны тайлбар хийсэн бөгөөд “ТЭЗҮ”-ийн талаар нэр томьёоны тайлбар байхгүй.

1.2.ТЭЗҮ-ийн талаарх ойлголт: ТЭЗҮ гэх ойлголтын нэр томьёоны тодорхойлолт хуульд байхгүй тул ТЭЗҮ-ийн талаар тодруулъя. ТЭЗҮ нь төсөл амжилттай хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлж, төслийн нийгмийн ач холбогдол, тогтвортой байдлын талаар шийдвэр гаргах үндэслэл болдог судалгаа бөгөөд төслийн үнэлгээний үе шатанд хийгддэг.

ТЭЗҮ нь техникийн болон эдийн засгийн судалгааг багтаана. Техникийн судалгааны хүрээнд зардлын тооцоо, эрэлтийн нарийвчилсан таамаглал, төслийн урьдчилсан техникийн, эсхүл инженерийн зураг төслийг бүрдүүлсэн байна.

ТЭЗҮ-ийн эдийн засгийн судалгаа нь төслийн нийгэмд үзүүлэх үр өгөөжийг судалж, зах зээлийн болон нийгэм, байгаль орчны нөлөөллийг шинжилдэг. Энэ хүрээнд одоогийн нөхцөл байдал болон техникийн хувьд боломжтой хэд хэдэн

хувилбарын нийт зардал, үр ашгийн харьцуулалт хийж хамгийн үр өгөөжтэй хувилбарыг тодорхойлно.

ТЭЗҮ-ийг дараах төсөлд зайлшгүй боловсруулах шаардлагатай гэж үздэг. Үүнд:

1. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан төсөл: Хөрөнгө оруулалтын хэмжээ их байх тусам эрсдэл нэмэгдэх магадлал их юм;
2. Шинэ технологи, инновац нэвтрүүлэх төсөл: Шинэ технологийн эрсдэл, зах зээлд хэрхэн нөлөөлөхийг урьдчилан тооцоолох шаардлагатай. Жишээлбэл, сэргээгдэх эрчим хүчний төсөл, биотехнологийн үйлдвэрлэл, хиймэл оюун ухаан ашигласан үйлчилгээ гэх мэт;
3. Төрийн болон нийтийн ач холбогдолтой төсөл: Төсвийн хөрөнгө оруулалттай бөгөөд нийгэмд шууд нөлөө үзүүлэх төсөлд ТЭЗҮ хийж, үр ашгийг нь тогтооно;
4. Байгаль орчинд нөлөөлөх төсөл: Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөх зорилго бүхий төсөл хамаарна;
5. Олон улсын зээл, тусламж шаардлагатай төсөл: Олон улсын байгууллага, банк, санхүүгийн байгууллагаас зээл, тусламж олгох төсөлд ТЭЗҮ хийлгэхийг шаарддаг;
6. Хувийн хэвшлийн томоохон төсөл: Хувийн хэвшлийн компаниуд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ТЭЗҮ-д үндэслэдэг.

ТЭЗҮ дараах ач холбогдолтой. Үүнд:

- Төсөл хэрэгжих боломжийг үнэлэх;
- Хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах;
- Төслийн үр ашгийг нэмэгдүүлэх;
- Санхүүгийн шийдвэр гаргахад туслах;
- Төслийн төлөвлөлт, удирдлагыг сайжруулах;
- Олон нийтийн дэмжлэгийг авах.

ТЭЗҮ-ийн тайлангийн дэлгэрэнгүй агуулга нь төслийн шинж чанар, салбарын онцлогоос хамааран ялгаатай байх боловч Дэлхийн банкнаас ТЭЗҮ-ийн тохиромжтой ерөнхий бүтцийг гаргасан.[34] Харин Вьетнам Улсын Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуульд ТЭЗҮ-ийн тайланд заавал тусгах асуудлыг тодорхойлсон байна.[35] Түүнчлэн, Казахстан Улсын “Улсын хөрөнгө оруулалтын төслийн саналыг боловсруулах, тохируулах, шалгах, төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хянах,

[34] Kim, Jay-Hyung, Jonas Arp Fallov, and Simon Groom. 2020. *Public Investment Management Reference Guide*. International Development in Practice. Washington, DC: World Bank.
[35] Law on Public Investment (2024). http//english.luatvietnam.vn/dau-tu/law-on-public-investment-no-58-2l

сонгох, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, төсвийн зээл олгох үндэслэлийг тодорхойлох журам”-д төслийн ТЭЗҮ-ийн бүтцийг тусгасан.[36]

Хүснэгт 4.ТЭЗҮ-ийн агуулгын харьцуулалт

Дэлхийн банк	Вьетнам Улс	Казахстан Улс
Хураангуй	Хөрөнгө оруулалтын хэрэгцээ	Хураангуй
Одоогийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;	Төсөл нь холбогдох ерөнхий төлөвлөгөөнд нийцэж байгаа талаарх үнэлгээ;	“Маркетинг” хэсэг (тухайн бүс нутагт төслийн өнөөгийн болон хэтийн төлөвийн эрэлт, эсхүл төслийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээг тусгах);
Төслийн хувилбаруудын шинжилгээ;	Төслийн зорилго, үр дүнд дүн шинжилгээ хийж, боломжит хүрээг тогтоох;	“Техник болон технологи” хэсэг (төсөл хэрэгжүүлэх техник, технологийн шийдлийн дүн шинжилгээ, тэдгээрийн давуу болон сул тал, сонгосон хувилбарын үндэслэлийг тусгах);
Зах зээлийн үнэлгээ ба эрэлтийн шинжилгээ;	Хөрөнгө оруулалтын үе шатыг тогтоох, хөрөнгө оруулалтын хэлбэрийг сонгох;	“Байгаль орчин” хэсэг (байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ);
Техникийн судалгаа, төслийн зардлын хураангуй;	Байгалийн нөхцөл, техник, эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтын байршлыг сонгох;	“Зохион байгуулалт” хэсэг (төслийн зохион байгуулалтын төлөвлөгөө);
Төслийн орон зайн төлөвлөлт;	Төслийн удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө;	“Санхүү, эдийн засаг” хэсэг (төслийн зардал, санхүүжилтийн төлөвлөгөө, санхүүгийн шинжилгээ, эдийн засгийн шинжилгээ зэргийг тусгах);
Санхүүгийн шинжилгээ;	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах шийдэл;	“Нийгэм” хэсэг (төслийг мэргэшсэн хүний нөөцөөр хангах боломжийн дүн шинжилгээ);
Эдийн засгийн шинжилгээ;	Нөхөн олговор, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ерөнхий төлөвлөгөө;	“Эрсдэлийн шинжилгээ” хэсэг;
Эрсдэлийн шинжилгээ ба удирдлага;	Төсөл хэрэгжүүлэх хуваарь, хөрөнгө оруулалт хийх үндсэн хуваарь;	Ерөнхий дүгнэлт;
Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ;	Нийт хөрөнгө оруулалт, хөрөнгийн эх үүсвэрийн бүтэц, хөрөнгө төвлөрүүлэх төлөвлөгөөг тодорхойлох;	ТЭЗҮ-ийн хавсралтууд.
Хэрэгжилт, үйл ажиллагааны зохицуулалт;	Төсөл хэрэгжүүлэх явцад гарах холбогдох зардлыг тодорхойлох;	
Төсөл хэрэгжих боломжийн талаарх дүгнэлт.	Төсөл эзэмшигчийг тодорхойлох, төсөл хэрэгжүүлэх удирдлагын зохион байгуулалтын хэлбэрт дүн шинжилгээ хийх, сонгох, төсөл хэрэгжүүлэх явцад оролцогч талуудын харилцаа, үүрэг хариуцлага, төслийн үйл ажиллагааны удирдлагын зохион байгуулалт;	
	Нийгэм-эдийн засгийн үр ашиг, нөлөөлөл, үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдал, хөрөнгийн нөхөх чадвар зэрэг хөрөнгө оруулалтын үр ашгийн шинжилгээ.	

[36] Правила разработки или корректировки, проведения необходимых экспертиз инвестиционного предложения государственного инвестиционного проекта, а также планирования, рассмотрения, отбора, мониторинга и оценки реализации бюджетных инвестиций и определения целесообразности бюджетного кредитования. https://adilet.zan.kz/rus/docs/V1400009938

Дэлхийн банкнаас Монгол Улсад ТЭЗҮ ямар байхыг тогтоосон стандарт байхгүй тул стандарт бүтэцтэй болох, түүнд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээг багтаах талаар зөвлөсөн байна.[37]

ТЭЗҮ-ийг ямар төсөлд заавал боловсруулах, ТЭЗҮ ямар агуулгатай байх талаар Монгол Улсын хууль тогтоомжид тусгаагүй болно. Харин бусад улсын хууль тогтоомжид ТЭЗҮ-ийн талаар зохицуулсан байна. Иймд Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу ТЭЗҮ-д баримтлах нийтлэг стандарттай болох шаардлагатай.

1.3.Бэлтгэл үе шатанд тулгардаг асуудал: Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн талаарх судалгаагаар төлөвлөлтийн бэлтгэл шатанд тулгардаг асуудлыг дараах байдлаар тодорхойлсон.

Зураг 6.Төлөвлөлтийн бэлтгэл шат ба тулгамдсан асуудал



Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн бэлтгэл шатанд дараах асуудал тулгамдаж байна. Үүнд:


1. Зураг төсөл, төсөв, ТЭЗҮ-ийн талаар нэгдсэн ойлголт, тодорхойлолт, зохицуулалт байхгүй;
2. Зураг төсөл, төсөв, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг аль байгууллагын зөвшөөрлөөр, хэн боловсруулах нь тодорхой бус;
3. Зураг төсөл, төсөв, ТЭЗҮ боловсруулах шалгуур үзүүлэлт, цаглавар байхгүй;
4. Зураг төсөл, төсөв, ТЭЗҮ-ийг санхүүжүүлэх эх үүсвэр, төслийн төсөвт өртгөөс үл хамааран захиалагчийн шийдвэрээр хэрэгжүүлдэг нь санхүүжилтийн үр ашгийг сулруулах, ашиглагдахгүй байх магадлалыг нэмэгдүүлдэг.

[37] Дэлхийн банк, 2025, “Монгол улсын төрийн санхүүгийн үнэлгээ“

Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулахын тулд зураг төслийн магадлалд үндэслэн барилгын материалын үнийн өсөлт болон бусад үндэслэл *(зураг төсөлд өөрчлөлт орох, нэмэлт ажил бий болох гэх мэт)*-ээр бий болсон нэмэлт санхүүжилтийг төсөвт тусган шийдвэрлэсэн байдаг.


Монгол Улсын 2018-2025 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан боловч төсвийн жилд багтаан гэрээ байгуулж чадаагүй төсөл, арга хэмжээний шалтгааныг судлан үзэхэд дийлэнх нь бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй атал төсөвт тусгагдсан явдал байв. 2010-2025 оны төсөвт тусгагдсан боловч санхүүжилт аваагүй нийт 1,379 төсөл, арга хэмжээ байна.

График 8.Санхүүжилт аваагүй төслийн тоо



2020, 2022, 2024 онд төсөвт тусгагдсан хэдий ч санхүүжилтээ аваагүй төслийн тоо нэмэгдэж 210, 184, 244-т хүрсэн. 2018-2024 онд төсөвт батлагдсан боловч нийт 310 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдаагүй болно.

График 9.Гэрээ байгуулагдаагүй болон зураг төсөлгүй батлагдсан төслийн тоо



Шинээр хэрэгжүүлэхээр 2018-2025 онд батлагдсан төсөл, арга хэмжээний дунджаар 11.3 хувьд гэрээ байгуулаагүй бөгөөд дийлэнх буюу 7.1 хувь нь зураг төсөл, төсөвгүй батлагдсан байна. Тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөв бэлэн байсан эсэх нь дараагийн үе шат болох худалдан авах ажиллагааны үе шатанд шууд нөлөөлж байна.

Тухайн жилийн төсөвт тусгагдсан боловч зарим төсөлд гэрээ байгуулагдахгүй байгаа нь төслийн төлөвлөлтийн бэлтгэл үе шатны ажил хангалтгүй байгаатай холбоотой. Гэрээ байгуулагдаагүй төслийн нэлээд нь зураг төсөлгүй байгаа нь үүнийг нотолно.

Төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн үр өгөөжийг бууруулдаг 2 гол асуудал байна. Эхнийх нь, төслийн бэлтгэл ажил зохих ёсоор хийгдээгүй байхад төсөл, арга хэмжээг төсөвт тусгадаг. Удаах нь, төслийн бэлтгэл ажлыг хэрхэн хийх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, ТЭЗҮ, зураг төслийн талаар нэгдсэн тайлбар тодорхойлолт тусгагдаагүй явдал болно.

2.Төслийн төлөвлөлтийн цаглавар: Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд Төсвийн тухай хуулийн 8.4 дэх хэсэгт заасан төсвийн цаглаврыг мөрдөхийн зэрэгцээ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор[38] батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар[39] батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлалууд", Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалд[40] нарийвчлан заасан хугацааг баримтлан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн систем (PIMIS)-ээр төлөвлөж байна.

Хүснэгт 5.Төсвийн хөрөнгө оруулалтын цаглавар

	Үйл ажиллагаа	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
Аймаг/ Нийслэл	Төслийн санал үүсгэн урьдчилсан үнэлгээ хийж, ТЕЗ-д илгээх	15											
ТЕЗ	Урьдчилсан үнэлгээ хийж Сангийн яаманд илгээх	01.16 – 02.15											
Сангийн яам	Төслийн урьдчилсан үнэлгээ хийж, эх үүсвэрийг батлах		02.16 – 03.15										

[38] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760272322161&showType=1
[39] https://publicinvestment.gov.mn/law/1000?url=/api/file/downloadFile/admin/
[40] https://publicinvestment.gov.mn/law/1080?url=/api/file/downloadFile/pimis/

Иргэдээс санал авах – Publicinvestment гар утасны аппликейшн				1 - 31	*Хэрэгжиж буй төсөлд сэтгэгдэл бичих, санал хүсэлт ирүүлэх боломжтой.*									
Сум/Дүүрэг	Төслийн бэлэн байдлын үнэлгээг хийж, эрэмбэлэн сонгож аймаг, нийслэлд хүргүүлэх	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах сайжруулах боломжтой.*		1 - 30	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах, сайжруулах боломжтой.*									
Аймаг/ Нийслэл	Төслийн бэлэн байдлын үнэлгээг хийж, эрэмбэлэн сонгож ТЕЗ-д хүргүүлэх	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах, сайжруулах боломжтой.*				5.1 – 6.25	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах сайжруулах боломжтой.*							
ТЕЗ	Төслийн бэлэн байдлын үнэлгээг хийж, эрэмбэлэн сонгож Сангийн яаманд хүргүүлэх	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах, сайжруулах боломжтой.*					6.26 – 7.25	*Төсөл үүсгэх, үнэлгээ хийх, боловсруулах, сайжруулах боломжтой.*						
Сангийн яам	Үнэлгээг хянаж, шаардлагатай тохиолдолд засварлан эрэмбэлж, Засгийн газарт өргөн барих							7.26 – 8.25						
УИХ	Ирэх оны төсвийн төсөл батлах											**15**		

Дээрх хүснэгтээс харахад төслийн урьдчилсан үнэлгээ 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор, иргэдийн санал авах ажиллагаа 03 дугаар сард, төслийн бэлэн байдлын үнэлгээ 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 25-ны дотор хийгдэнэ. Сангийн яам төсвийн төслийг 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газарт өргөн барих, УИХ төсвийг 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батална. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн төлөвлөлтийн шатанд хийгдэх урьдчилсан болон бэлэн байдлын үнэлгээний талаар танилцуулъя.


Анхаарах зүйл: УАГ, ТТБЗ, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын санал зөвлөмж, санал асуулгаар төлөвлөлтийн шатанд нэлээд асуудал байгаа нь тогтоогдсон. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төслийг төсөвт тусгадаг, эрэмбэ дараалал баримталдаггүй, төлөвлөх, сонгох үйл явцад ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдалтай, улсын хөгжлийн бодлогод нийцдэггүй хэмээн үзжээ.

2.1.Урьдчилсан үнэлгээ: Төсвийн тухай хуулийн 2022.04.22-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээний талаар 27^1 дүгээр зүйл нэмэгдсэн бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд аргачлалын дагуу урьдчилсан үнэлгээ хийхээр болсон. Сангийн сайдын 2023.07.04-ний өдрийн 137 дугаар тушаалаар “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал” батлагдсан. ТЕЗ урьдчилсан үнэлгээнд оруулах төслийн саналаа Сангийн яаманд хүргүүлэх, Сангийн яам урьдчилсан үнэлгээний аргачлалын дагуу нэгдсэн шалгуур

үзүүлэлтээр үнэлгээ өгч, тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлохоор Төсвийн тухай хуулийн 27[1].2, 27[1].3 дахь хэсэгт заасан.

“Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-ыг 2024 оноос мөрдөж байна.

Зураг 7.Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд урьдчилсан үнэлгээ хийх цаглавар



Урьдчилсан үнэлгээний зорилго нь төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг урьдчилан тодорхойлох, үнэлэх бөгөөд төсвийн хариуцлагатай, тогтвортой удирдлагын суурь болдог. Санхүүжилтийн тогтвортой эх үүсвэргүйгээр төсөл хэрэгжих боломжгүй болох, эсхүл хэрэгжилтийн явцад санхүүгийн дутагдал, зогсолт, хугацаа хэтрэлт, зардлын өсөлт зэргээс шалтгаалан төсвийн үр ашиг буурах, иргэдийн итгэл алдагдах эрсдэл өндөр байдаг. Иймд төсөвт тусгахын өмнө төсөл бүрийн санхүүжилтийн урьдчилсан эх үүсвэрийг тодорхойлох, нягтлан шалгах, үнэлэх үйл ажиллагааг заавал хэрэгжүүлэх шаардлагатай.

Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатны төсөлд албан ёсны урьдчилсан үнэлгээ хийх үе шатыг нэвтрүүлэх зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар урьдчилсан үнэлгээ хийх аргачлалыг батлуулж, урьдчилсан үнэлгээг цахим системээр хэрэгжүүлж байгаа боловч төсөл бүрийн хувьд санхүүжилтийн боломжит эх үүсвэрийг тогтоох, тэдгээрийн хэрэгжилтийн нөхцөл, эрсдэл, хууль, эрх зүйн зохицуулалтад нийцэж буй эсэхийг үнэлэх асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай.


Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд 2024 оноос урьдчилсан үнэлгээ хийж эхэлсэн нь Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатанд нийцнэ. Цаашид урьдчилсан үнэлгээний үр дүнг бэлэн байдлын үнэлгээтэй уялдуулах, нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

2.2.Бэлэн байдлын үнэлгээ: Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам”-аар 2019 оноос төслүүдийг үнэлж, эрэмбэлж эхэлсэн. Сангийн сайдын дээрх тушаалын хавсралтуудаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, сонгох, аргачлал”-ыг тус тус баталсан. 2018 онд батлагдсан уг журмын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг 2 үе шат бүхий 16 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг байсан.

Төсвийн тухай хуулийн 2023 оны нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалаар уг журам, аргачлалд нэмэлт, өөрчлөлт оруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг 1 үе шат бүхий 10 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг болсон. Дээрх үнэлгээ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаврын дагуу хийгдэх бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шат цахим системээр 03 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 25 хүртэл явагддаг.

Зураг 8.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлтийн цаглавар



Төлөвлөлтийн үе шатанд сум, дүүрэг, аймаг, нийслэл, ТЕЗ болон Сангийн яам гэсэн 4 түвшинд дараах 10 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийдэг.


Хүснэгт 6.Төслийн бэлэн байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	ТЕЗ			Сангийн яам		
		Оноо	Жин	Дүн	Оноо	Жин	Дүн
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх;	5	1.5	7.5	5	1.5	7.5
2	Олон нийтийн санал авсан эсэх;	5	2	10	5	2	10
3	Эдийн засаг, нийгмийн ач холбогдол тооцсон эсэх;	5	3	15	5	3	15
4	Төслийн хүчин чадлын ашиглалт;	5	1.5	7.5	5	1.5	7.5
5	Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай, тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх;	5	2	10	5	2	10
6	Төслийн нийт зардлыг бүрэн тооцсон эсэх;	5	3	15	5	3	15
7	Төсөлтэй холбоотой ашиглалтын хугацааны зардал, түүнийг санхүүжүүлэх санал;	5	1	5	5	1	5
8	Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл;	5		5	5	1	5
9	Төслийн зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн эсэх;	5		12.5	5	2.5	12.5
10	Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт эсэх.	5		12.5	5	2.5	12.5
	Дүн:			100.0			100.0

Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатны 3 дахь нь төсөлд хөндлөнгийн үнэлгээ хийх юм. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн бэлэн байдлын үнэлгээг Дэлхийн банкны төслийн хөндлөнгийн үнэлгээтэй уялдуулах, нийцүүлэх шаардлагатай байна.


3.Төлөвлөлтийн үе шат дахь төслийн ангилал, төрөл: Төсвийн хөрөнгө оруулалтын суурь онол, ойлголтоор олон улсад төслийг хамрах хүрээ, салбар, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжүүлж буй байгууллага, эрсдэлийн зэрэг, шинж чанар, зорилго зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

Зураг 9.Хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл



Төслийн ангилал нь хөрөнгө оруулалтын шийдвэрт чухал нөлөөтэй. Учир нь төслийн ангилал, төрлөөс хамаарч эрсдэл, өгөөж, санхүүжилтийн эх үүсвэр, хэрэгжүүлэх арга зам нь өөр байдаг. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн нэг эх үүсвэр нь төсөв бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төслийг дараах байдлаар ангилдаг байна. Үүнд:

Зураг 10.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл



Төсвөөс санхүүжих төслийг хөрөнгө оруулалтын хэмжээгээр ангилах нь төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжилтийг оновчтой болгох, хяналт тавих, үр дүнг тооцоход чухал ач холбогдолтой. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг хөрөнгө оруулалтын хэмжээгээр нь дараах байдлаар ангилдаг байна.

Хүснэгт 7.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал /хөрөнгө оруулалтын хэмжээгээр/

	Жижиг төсөл	Дунд төсөл	Том төсөл	Мега төсөл
Хүчин зүйл	• Хөрөнгө оруулалт: Төсвийн хөрөнгийн хэмжээ, хуваарилалт; • Эдийн засгийн үр ашиг: Төслийн эдийн засгийн үр ашиг, үр өгөөж; • Нийгмийн хэрэгцээ: Хүн амын хэрэгцээ, шаардлага, нийгмийн ач холбогдол; • Байгаль орчны нөлөөлөл: Төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэл; • Техникийн боломж: Төслийг хэрэгжүүлэх техникийн боломж, чадавх			
Онцлог	Орон нутгийн чанартай, хүн амын өдөр тутмын хэрэгцээг хангахад чиглэсэн, богино хугацаанд хэрэгжих боломжтой төсөл;	Орон нутгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах, нийгмийн ач холбогдолтой, дунд хугацаанд хэрэгжих төсөл;	Бүс нутгийн хөгжилд нөлөөлөхүйц, эдийн засгийн өгөөжтэй, урт хугацаанд хэрэгжих төсөл	Улсын хэмжээнд стратегийн ач холбогдолтой, эдийн засаг, нийгэмд чухал нөлөө, байгаль орчинд томоохон нөлөө үзүүлэх, урт хугацаанд хэрэгжих төсөл;

Жишээ	Сум, хорооны цэцэрлэг, сургуулийн засвар, тоног төхөөрөмж худалдан авах; Орон нутгийн зам засварлах; Орон нутагт спорт заал барих; Эмнэлгийн анхан шатны тусламжийн кабинетыг тоноглох.	Сургууль, цэцэрлэгийн өргөтгөл; Соёлын төвийн засвар, тоног төхөөрөмж худалдан авах; Орон нутгийн авто зам барих; Усан хангамжийн системийг сайжруулах; Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах	Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг барих, засварлах; Томоохон сургууль, цэцэрлэг барих; Бүс нутгийн чанартай авто зам барих, засварлах; Цэвэрлэх байгууламж барих; Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах.	Улсын чанартай авто зам, төмөр зам барих; Усан цахилгаан станц барих; Олон улсын нисэх онгоцны буудал барих; Үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах.

3.1.Мега төсөл: Төсвийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийн талаар заагаагүй болно. Харин урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Үндэсний баялгийн сан болон Мега төслийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын “Үндэсний баялгийн сан” хэсэг, зорилтыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна гэж, зорилтыг хэрэгжүүлэх II үе шат (2031-2040)-нд *4.6-д “Мега төслүүдэд хөрөнгө оруулалт хийх болсноор нийгмийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, улмаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чадавхыг бүрдүүлсэн байна.”* гэж тодорхойлсон.

- Урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Үндэсний баялгийн сан” хэсэг, *4.6.6-д “Хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбарууд болох зам тээвэр, эрчим хүч, усны менежмент, харилцаа холбоо зэрэг салбаруудыг дэмжиж, цаашлаад уул уурхай дагасан дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэн дотогшоо чиглэсэн хөрөнгө оруулалт хийнэ. Томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг сангийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.”* гэж заажээ.

- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор[41] батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн “Үндэсний баялгийн сан” хэсэг, 4.6.1-д “*Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна*.” гэж хүрэх үр дүнг тодорхойлсон.

- УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт үндэсний баялгийн сангийн хөрөнгөөр дэд бүтцийн мега төсөл хэрэгжүүлэхээр заасан бөгөөд мега төсөлд ямар шинж бүхий төслийг хамруулах талаар заагаагүй болно. Төслийн ангиллыг хуульд тодорхой тусгахгүй бол үндэсний баялгийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлтэй давхардах эрсдэл гарч болзошгүй бөгөөд өөр эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслүүдийг ямар шалгуур үзүүлэлтээр хэрхэн ялгаж үзэх нь тодорхой бус байна.

Тухайлбал 14 мега төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллээс үзэхэд 5 нь ТХХТ, 4 нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 2 нь гадаад зээл, 2 нь шууд хөрөнгө оруулалт, 1 нь улсын төсөв, 1 нь бусад эх үүсвэр байна.[42] Эдгээр төслийн 2025 онд санхүүжих дүн 100-805 тэрбум төгрөг болно. Өөрөөр хэлбэл; “мега” төсөлд ямар төсөл, арга хэмжээг, ямар шалгуур үзүүлэлтээр хамруулж байгаа нь тодорхой бус болно.

14 мега төслөөс 2 мега төсөл нь гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байна. Дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах, импортын хараат байдлыг бууруулах өндөр ач холбогдол бүхий Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь хангаж жилд дунджаар 30.0 тэрбум төгрөгийн орлого олох боломжтой Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл нь Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байна.

Монгол Улс 2021–2025 онд нийт 10.7 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоход нийт 8.3 тэрбум ам.доллар зарцуулсан бөгөөд энэ нь жилд дунджаар 2.1 сая тонн бүтээгдэхүүн импортолж, 1.7 тэрбум ам.долларын валютын урсгал гадагш чиглэж байгааг харуулна. 2025 оны гүйцэтгэлийн үзүүлэлтээр нийт 2.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолж, 2.1 тэрбум ам.доллар зарцуулсан нь

[41] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15584
[42] Эдийн засаг, хөгжлийн яамны тоон мэдээлэл

2021 онтой харьцуулахад импортын тоо хэмжээ 61 хувиар, импортын үнэ өртөг 110 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цаашид дотоодын хэрэглээ тогтмол нэмэгдэхийн хэрээр газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ болон валютын гадагшлах урсгал нэмэгдэх хандлагатай байна.

Энэ нөхцөлд Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж, төлөвлөсөн хугацаанд нь ашиглалтад оруулах нь эдийн засгийн хувьд зайлшгүй шаардлагатай юм. Тус үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр жилд дунджаар 1.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ойролцоогоор 1.0 тэрбум ам.долларын борлуулалтын орлого олох боломжтой юм. Үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг 2024 оны импортын түвшинтэй харьцуулан тооцоход, дотоодын газрын тосны бүтээгдэхүүний нийт хэрэглээний 50–60 орчим хувийг хангах боломжтой бөгөөд энэ нь жилд дунджаар 1.0 тэрбум ам.долларын валютын урсгалыг дотоодод үлдээх үр нөлөөтэй юм.

Мөн баруун бүсийн эрчим хүчний систем нь хэрэглээнийхээ 80 гаруй хувийг гадаадын эх үүсвэрээс, тэр дундаа 74 хувийг Оросын Холбооны Улсаас, 2 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортоор хангадаг нь эрчим хүчний хамаарал өндөр байгааг илтгэнэ. Тухайлбал, 2024 онд баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ 305.3 сая кВт.ц-д хүрч, өмнөх оноос 13.9 хувиар өссөн ба энэ өсөлт нь цаашид жилд дунджаар 8–11 хувиар үргэлжлэх хандлагатай байна. Иймд Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлснээр жилд 366 сая кВт.ц цахилгаан үйлдвэрлэх, баруун бүсийг 2030 оноос эхлэн 100 хувь дотоодын эрчим хүчээр найдвартай хангах боломж бүрдэх юм. Энэхүү эх үүсвэрийн хүчин чадлаар 52,000 ахуйн хэрэглэгч, 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын өрхийг цахилгаанаар хангахын зэрэгцээ жил бүр 17.5 тэрбум төгрөгийн импортын зардлыг хэмнэх боломжтой. Түүнчлэн усны нөөцийг нэмэгдүүлж, цаг уурын өөрчлөлттэй тэмцэх, хүлэмжийн хийн ялгарлыг 330 мянган тонноор бууруулах зэрэг байгаль орчинд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Дээрх нөхцөл байдал нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, эрчим хүчний хараат бус байдал, валютын урсгалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй учраас Газрын тос боловсруулах үйлдвэр болон Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц зэрэг стратегийн бүтээн байгуулалтын төслийг төлөвлөсөн хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх нь эдийн засгийн үр ашиг, тогтвортой хөгжлийн тулгуур нөхцөл болж байна.

Бусад улсад мега төсөлд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд урт хугацаанд томоохон нөлөө үзүүлэх төслийг ойлгодог бөгөөд эдгээр төсөл нь ихэвчлэн ТХХТ-ээр хэрэгждэг ба урт хугацаа зарцуулдаг хэмээн үздэг байна.

Зураг 11.Мега төслийн онцлог, төрөл



Мега төслийг амжилттай хэрэгжүүлэхэд нарийвчилсан төлөвлөлт, үр дүнтэй удирдлага, олон талын оролцогчдын хамтын ажиллагаа, эрсдэлийн удирдлага чухал үүрэгтэй юм.

Мега төсөлд ямар шинж, төсөвт өртөг бүхий төсөл хамаарах талаар тодорхойлоогүй хэдий ч дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт 14 мега төсөл хэрэгжүүлэхээр тусгасан. Эдгээр төслөөс 2 мега төслийг гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлж байна. Бусад улсад мега төслийг олон шалгуур үзүүлэлтээр ангилж, тодорхойлдог. Иймд мега төсөлд ямар төсөл хамаарахыг тодорхой болгох нь зүйтэй.

4.Төслийн төсөвт өртөг: Төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд хэрэгжүүлсэн төслийн төсөвт өртгийн хамгийн их нь 256,391.1 сая төгрөг байсан бол хамгийн бага нь 8.3 сая төгрөг, 2025 онд хэрэгжүүлсэн төслийн төсөвт өртгийн хамгийн их нь 319,998.9 сая төгрөг байгаа бол хамгийн бага нь 155.0 сая төгрөг байна. Төсөвт тусгагдсан төслийн хамгийн их болон хамгийн бага төсөвт өртгийн зөрүү нэлээд их байна. Түүнчлэн, гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн төсөвт өртөг 23 тэрбумаас 5.8 их наяд төгрөг хүртэл төсөвт өртөгтэй байна.


Хүснэгт 8.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслийн тоо /төсөвт өртгөөр/

Он	Төсөвт өртөг (сая төгрөг)			Төслийн тоо								
	Хамгийн бага	Дундаж	Хамгийн их	100 сая төг хүртэлх	100-500 сая төг	500-1000 сая төг	1-2 тэрбум төг	2-5 тэрбум төг	5-10 тэрбум төг	10-20 тэрбум төг	20-50 тэрбум төг	50 тэрбум төг-өөс дээш
2025	165.0	15,137.3	324,000.0		6	12	54	232	128	99	55	37
2024	50.0	8,997.0	676,272.0	18	103	137	187	448	206	129	56	35

2023	50.0	6,927.2	318,000.0	3	81	118	273	370	166	71	40	21
2022	10.0	5,152.2	264,089.2	40	214	169	315	385	137	65	31	20
2021	10.0	4,277.8	264,089.2	48	251	159	276	209	97	38	14	14
2020	10.0	3,816.6	251,466.5	129	344	167	313	242	90	31	22	18
2019	6.4	2,876.2	176,405.4	83	245	208	377	247	84	22	20	7
2018	4.0	3,261.0	176,405.4	75	138	132	184	136	48	23	13	5
2017	17.1	7,365.4	176,405.4	10	20	42	79	101	68	41	19	8
2016	8.3	6,186.5	256,391.1	13	61	139	197	202	107	59	29	14

ХБТТУтХ-ийн 4.1.12-т “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичиг” гэж тодорхойлсон. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлд УХОХ-ийн төлөвлөлтийн талаар зохицуулсан ба 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг УХОХ-т тусган холбогдох шаардлага, шалгуурын дагуу төлөвлөж уг төслийг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр заасан.

График 10. 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төслийн тоо



Жилд дунджаар 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ батлагдсан байх бөгөөд төсөвт өртөг жил ирэх тусам нэмэгдэж байна.

Гадаад зээлийн төслийн төсөвт өртгийн хэмжээгээр ангилан үзвэл 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 7 төсөл, 100.0-500.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 45 төсөл, 50.0-100.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл, 50.0 тэрбум төгрөг хүртэл төсөвт өртөгтэй 27 төсөл тус тус хэрэгжиж байна. Эдгээрээс хамгийн өндөр төсөвт өртөгтэй нь Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл бөгөөд нийт 6.0 их наяд төгрөгийн өртөгтэй байна. Харин хамгийн бага төсөвт өртөгтэй нь 28.6 тэрбум төгрөгийн өртөгтэй Монгол-Германы хамтарсан ашигт малтмалын технологийн их сургууль төсөл байна. УИХ-аас 2026 оны төсвийн тухай хуулиар гадаад зээлийн ашиглалтад нийт 1.2 их наяд төгрөгийг баталсан бөгөөд үүнээс 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 төслийн зээлийн ашиглах хэмжээ нь нийт батлагдсан зээлийн ашиглалтын 20 хувийг, үлдсэн 69 төслийн ашиглалт 80 хувийг тус тус эзэлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр бүх салбарын бүхий л төслийг төсөвт өртгөөс үл хамааран хэрэгжүүлж байна. Хөрөнгө оруулалтын төслийг нийт санхүүжилт буюу хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран ангилах, төрөлжүүлэх, ангилал, төрлөөс хамаарч төлөвлөх, хэрэгжүүлэх зохицуулалт, шалгуур үзүүлэлт, шаардлагыг ялгаатай тодорхойлох, төсөл хэрэгжих хугацааг бодитой тогтоох шаардлагатай. Ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, эдийн засгийн үр ашиг сайжирна.

Дүгнэлт:


1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт нь бэлтгэл үе шатнаас хамаарна. Төсөвт тусгагдсан боловч зарим төслийн гэрээ байгуулагдаагүй нь бэлтгэл үе шатны ажил хангалтгүй байгаатай холбоотой. Үүнд, ТЭЗҮ, зураг төсөл зэрэг ойлголтын талаар нэгдсэн тодорхойлолт байхгүй, хэрхэн хэрэглэх нь тодорхой бус зэрэг шалтгаан бий.
2. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд урьдчилсан үнэлгээ хийж эхэлсэн нь Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатанд нийцнэ. Гэсэн ч, урьдчилсан үнэлгээний үр дүнг төслийн бэлэн байдлын үнэлгээтэй холбох, нийцүүлэх шаардлага байна.
3. Монгол Улсад төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг заагаагүй боловч мега төсөл гэх нэр томьёо хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдан, хэрэгжиж байна. Бусад улсад төслийг хамрах хүрээ, салбар, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын хэмжээ, эрсдэлийн зэрэг, санхүүжилтийн эх үүсвэр, төслийн шинж чанар, зорилго, хэрэгжих хугацаа зэрэг олон шалгуур үзүүлэлтээр ангилдаг байна. Монгол Улсад ямар хэмжээний төслийг санхүүгийн ямар эх үүсвэрээр хэрэгжүүлэх бодлого тодорхой бус, зохицуулалт байхгүйн улмаас улсын төсвөөр 8 сая төгрөгөөс 320 тэрбум төгрөгийн өртөг хүртэл дүн бүхий төслийг санхүүжүүлж байна. Ямар төслийг санхүүгийн ямар эх үүсвэрээр хэрэгжүүлэхийг тодорхой болгох нь төслийн ангилал, төрөлтэй шууд хамааралтай тул энэ асуудлыг тодорхой болгож, зохицуулах нь зүйтэй юм.

1.1.1.5.2.Төслийн хэрэгжилт

Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн үе шатанд хэрэгжилт төдийгүй эрх шилжүүлэх, багц хуваарилах, худалдан авах ажиллагаа, гэрээний удирдлага, гүйцэтгэлийн асуудлыг авч үзлээ. Төслийн хэрэгжилтийн харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулдаггүй бөгөөд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор[43] баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах журам”-аар зохицуулдаг.

[43] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760272322161&showType=1

Зураг 12.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийн цаглавар



1.Эрх шилжүүлэх: ТЕЗ нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор эрхээ дараах байдлаар шилжүүлж болохоор заасан. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 14.4-т зааснаар төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг хэсэгчилж, эсхүл бүхэлд нь шилжүүлэх;
- Худалдах авах ажиллагааг зохион байгуулах эрхийг ТБОНӨХБАҮХАтХ-д зааснаар шилжүүлэх;
- Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх.

Эрх шилжүүлсэн этгээд нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагналт, үр дүн, гүйцэтгэлд эрх бүхий этгээдийн хувиар хариуцлага хүлээхээр журамд тусгасан.

2.Багц хуваарилах: Төсвийн тухай хуулиар багцалсан дүнгээр аймаг, бүс нутаг, улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний багцын задаргааг ТЕЗ нь Сангийн сайдтай хамтран тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хуваарилж, шийдвэр гарснаас хойш ажлын 3-5 хоногт багтаан цахим системд оруулдаг. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.6-д багц төслийн зохицуулалт нь Төсвийн тухай хуулийн 33.2.6-д нийцсэн байх бөгөөд холбогдох хууль, энэ журамд заасан зохицуулалтыг дагаж мөрдөнө хэмээн заасан.

3.Худалдан авах ажиллагаа: Төсөвт тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХАтХ-ийн дагуу зохион байгуулж, захиалагч нь гүйцэтгэгчтэй хуулиар батлагдсан төсөвт өртөг, хугацаа, санхүүжих дүнд багтаан гэрээ байгуулдаг.

4.Гэрээний удирдлага: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар ТБОНӨХБАҮХАтХ-ийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн тухай тавдугаар бүлэг, 39, 40, 41, 42, 43 дугаар зүйлд тусгасан. Төсвийн тухай хуулийн 48.2-т зааснаар ТЕЗ нь өөрийн багцад батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийг хангах үүрэг хүлээдэг.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.7 гэрээний удирдлагын талаар дараах байдлаар зохицуулсан. Үүнд:


- Гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан цахим системийн гэрээний удирдлага хэсэгт бүртгэж баталгаажуулах;
- Гэрээнд тухайн төслийн зураг төслийн магадлалаар баталгаажсан төсөвт өртгийн задаргааны дагуу гэрээний нийт дүнг зардлын нэр төрөл бүрээр тусгах бөгөөд тухайн гүйцэтгэгч татварын өртэй тохиолдолд санхүүжилтээс суутган тооцох тухай тусгах;
- Гэрээг иж бүрэн байгуулж, ТБОНӨХБАҮХАтХ-д заасан шаардлагаас гадна төсөл хэрэгжүүлэх үе шатны хуваарь, санхүүжилтийн хуваарийг хавсаргах;
- Гэрээний тусгай нөхцөлд гэрээтэй холбоотой аливаа зохицуулалт, үүний дотор алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг тусгах;
- Барилга угсралтын дүнгээс бусад зардлыг давхардуулж олгохоос сэргийлэх;
- Түүнчлэн, цахим системд баталгаажуулах, мэдээлэл татах зэрэг.

Практикт барилга байгууламжийн төслийн гэрээний хэрэгжилт сул, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ордоггүй, гэрээгээр тохиролцсон үнэ буюу төсөвт өртөг нэмэгддэг зэрэг хүндрэл гардаг. Эдгээр хүндрэл нь захиалагч, гүйцэтгэгч хэн аль нь гэрээний хэрэгжилтийн явцад үүргээ хангалтгүй биелүүлдэг, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх цаг хугацаа болон эдийн засгийн алдагдлыг тооцдоггүй, зохих хариуцлага хүлээдэггүй зэргээс үүдэлтэй байна.


ТБОНӨХБАҮХАтХ-ийн гэрээний хариуцлагын талаарх зохицуулалт тодорхой бус ба хуулийн 39.3.10-т гэрээ цуцлах болон гэрээнээс татгалзах үндэслэл, журмын талаар худалдан авах гэрээнд тусгана хэмээн заасан. Харин жишиг гэрээнд ихэвчлэн гэрээг цуцлах, гэрээний үүргийн харилцаанд захиалагч байгууллага зардал, эрсдэл хүлээхээр тусгасан нь гүйцэтгэгчид боломж олгох эрсдэлтэй байна.

4.1.Гэрээний нийт зардал: Өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн гэрээний нийт дүнд судалгаа хийж үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын нийт зардлын дунджаар 86 орчим хувийг барилга байгууламж, 8 орчим хувийг НӨАТ, 6 орчим хувийг бусад зардалд зарцуулдаг байна.

Зураг 13.Гэрээний дүн, зардлын хэмжээ, дундаж үзүүлэлт /тэрбум.төг, эзлэх хувиар/



Зураг 14.Гэрээний нийт болон бусад зардлын ангилал /эзлэх хувиар/



Барилга ашиглалтад оруулахтай холбоотой зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэх зардлыг бусад зардал гэдэг. Үүнд; магадалшгүй ажлын зардал 2 хувь, захиалагчийн техник, технологийн хяналтын зардал 2 хувь, зураг төсөл, төсөв зохиогчийн хяналтын зардал 2 хувь болон барилга, эрчим хүч, зам тээврийн салбарын норм, норматив, стандарт, баримт бичгийг сайжруулахад зориулсан нормчлолын санд дунджаар 0.18-0.4 хувийн зардал багтана.

Гэрээний нийт зардлын бүрэлдэхүүн болох бусад зардлын хувьд 27 орчим хувийг эзэлдэг захиалагчийн хяналт, 11 орчим хувийг эзэлдэг зохиогчийн хяналт болон 3 орчим хувийг эзэлдэг норм, нормативын сангийн зардлын талаар доор танилцуулъя.

4.1.1.Захиалагчийн хяналтын зардал

Захиалагчийн хяналт гэдэг нь хөрөнгө оруулагчаас мэргэжлийн байгууллагаар төлөөлүүлэн төслийн явц, чанар, аюулгүй байдалд тавих хяналт, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэлнэ. Монгол Улсад захиалагчийн хяналтын үйл ажиллагааг Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм” болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-аар зохицуулдаг.

Барилгын ажлын захиалагчийн хяналтыг “Барилгын хөгжлийн төв”[44] ТӨҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ, “Эрчим хүчний үндэсний төв”[45] төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэрэгжүүлж байна.

Барилгын тухай хуулийн[46]:

- ✓ 37.1.4-т “захиалагч барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”;
- ✓ 37.2-т “Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.”;
- ✓ 42.1.8-д “барилгын салбарын зөвлөх үйлчилгээг барилга байгууламжийн захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр үзүүлэх”;
- ✓ 42.4-т “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журмыг Засгийн газар батална.” хэмээн хуульчилсан байна;

Авто замын тухай хуулийн[47]:

- ✓ 4.1.26-д ““техник, технологийн хяналт” гэж авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлыг батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн

[44] УИХ-ын 2013 оны 58 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламжид захиалагчийн хяналт хийх чиг үүрэг бүхий Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яамны дэргэдэх Барилга захиалагчийн алба, товчоог татан буулгаж, хяналтын чиг үүргийг инженерүүдийн орон тоо, цалингийн сангийн хамт “Барилгын хөгжлийн төв”-д шилжүүлсэн. Улмаар, Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг “Барилгын хөгжлийн төв”-өөр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр тогтсон.

[45] Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор “Эрчим хүчний хөгжлийн төв” болон “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нийлүүлэн “Эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн зохион байгуулсан. Уг тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн дүрмийг баталсан бөгөөд дүрмийн 1.2-т “... эрчим хүчний салбарт улсын төсвийн болон гадаад, дотоодын болон бусад хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт тавих, эрчим хүчний барилга байгууламжийг барих ажлын зураг, төсөвт магадлал хийх, шүүмж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах ... чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.” гэж заажээ.

[46] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11705

[47] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12656

баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах ажиллагааг";

- ✓ 6.1-д "Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих үйл ажиллагааг улс, орон нутгийн төсөв, гадаад зээл тусламж, дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.";
- ✓ 10.1.5-д "олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжийн барилга, засвар, арчлалтын ажил, зөвлөх үйлчилгээ, захиалагчийн болон техник, технологийн хяналтыг улсын төсөв, гадаад зээл, тусламж, бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх";
- ✓ 21.1-д "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.";
- ✓ 21.2-т "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.";
- ✓ 21.3-т "Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн авто зам, замын байгууламжийн төсөвт өртөгт тусгана.";
- ✓ 33.2-т "Авто зам, замын байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд Зөвшөөрлийн тухай хуульд заасан шаардлагаас гадна мэргэжилтэй хүний нөөц, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг илтгэх нэмэлт шаардлагыг тавих бөгөөд энэ талаарх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." хэмээн хуульчилсан.

Эрчим хүчний тухай хуульд "захиалагчийн техникийн хяналт"-ын талаар зохицуулалт тусгагдаагүй бөгөөд Засгийн газрын 2022 оны 318 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүчний үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн[48]:

- ✓ 4.2.Компани нь үндсэн зорилтын хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:
- ✓ 4.2.1.эрчим хүчний салбарт улсын төсөв болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд захиалагчийн үүрэг гүйцэтгэж, техникийн хяналт тавих;
- ✓ 4.2.2.эрчим хүчний барилга байгууламжийг барих, зөвлөх үйлчилгээний ажлын зураг төсөвт магадлал, шүүмж, дүгнэлт хийх, эдгээртэй холбоотой ажлыг зохион байгуулах гэж заасан.

Захиалагчийн техник, технологийн хяналт тавих үйл ажиллагааг дээрх хууль, дүрэм, журмаар зохицуулдаг бол зардлын хэмжээг Барилга, хот байгуулалтын

[48] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531275671681&showType=1

сайдын 2020 оны 30 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын төсөв зохих дүрэм”-д[49] тусгасан. “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.1-д “Захиалагчийн техникийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 2 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 2 хувиар тооцно.” гэж, 6.3-т “Барилгын тухай хуулийн 42.2-т заасны дагуу өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжид зөвлөх үйлчилгээг авахдаа ажлын гэрээ байгуулж ажиллах ба зөвлөх үйлчилгээний зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 5 хүртэл хувиар тооцож захиалагчийн техникийн хяналтын зардлыг давхардуулахгүйгээр барилгын төсөвт өртөгт тусгана.” хэмээн заасан.

Захиалагчийн хяналтын гол үүргийг дараах байдлаар тодорхойлдог:

- Барилгын ажлын зөвшөөрөл, бичиг баримтыг бүрдүүлэх: Шаардлагатай бүх зөвшөөрөл, бичиг баримтыг барилгын ажил эхлэхээс өмнө хууль, дүрмийн дагуу бүрдүүлэх;
- Ажлын явцад хяналт тавих: Барилгын ажил зураг төсөл, холбогдох стандарт, техникийн нөхцөлийн дагуу явагдаж буй эсэхийг шалгах;
- Санхүүгийн хяналт тавих: Төсөв, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр ашигтай байдлыг хангах;
- Барилга ашиглалтад оруулах: Барилгын ажлыг дууссаны дараа хүлээн авч, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах.

Олон улсад захиалагчийн хяналт нь төслийн менежментийн салшгүй хэсэг бөгөөд төслийн чанар, аюулгүй байдал, хугацаа, зардлыг хянахад чиглэгдэг.

Захиалагчийн хяналтын зардалд барилгын төсөвт өртгийн 2.5 хувьтай тэнцэх хөрөнгийг хуваарилдаг тул төсөл бүрд харьцангуй ялгаатай байна. Тухайлбал, Улаанбаатар хот болон Увс аймагт баригдаж байгаа барилгын захиалагчийн техник хяналтын зардал өөр байна. Захиалагчийн хяналтын зардлын хувь хэмжээг зөв тогтоож, оновчтой хуваарилах шаардлагатай.

Захиалагчийн хяналтыг орон нутагт тэр бүр хийж чадахгүй байна. Захиалагчийн хяналтын багийн орон тоо цөөн, олон барилгад нэгэн зэрэг хүрч ажиллах боломжгүй байдаг.

Түүнчлэн, санхүүжилтийн баримт бичигт захиалагч, зохиогчийн хяналт тавиагүй этгээдийн нэр байдаг. Гүйцэтгэгчид тухайн хүнээр гарын үсэг зуруулах гэж үргүй зардал гаргаж, хөрөнгө мөнгө зарцуулах явдал гардаг. Захиалагчийн болон зохиогчийн хяналт тавьсан “цөөн тооны” этгээдээр гарын үсэг зуруулдаг болох шаардлагатай.

[49] https://legalinfo.mn/mn/detail?lawId=210720&showType=1

Захиалагчийн хяналтын талаар Барилгын тухай хууль, Авто замын тухай хуульд тусгагдсан бол Эрчим хүчний тухай хуульд тусгагдаагүй байна. “Барилгын төсөв зохиох дүрэм”-д захиалагчийн техникийн хяналтын зардлыг төсөвт өртгийн 2 хувиар, өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн хувьд зөвлөх үйлчилгээ авахдаа 5 хүртэл хувиар тооцож болохоор заасан. Зөвлөх үйлчилгээний зардлыг захиалагчийн техникийн хяналтын зардалтай давхардуулахгүйгээр олгоно.

4.1.2.Зохиогчийн хяналтын зардал

Зохиогчийн хяналт нь барилгын зураг төслийг боловсруулсан байгууллага (зохиогч) тухайн зураг төслийн дагуу барилгын ажил хийгдэж буй эсэхийг хянах үйл ажиллагаа бөгөөд барилгын чанар, стандарт, аюулгүй байдал, зураг төслийн шийдлийг бүрэн хэрэгжүүлэх зорилготой.

Зохиогчийн хяналтыг Барилгын тухай хуулиар зохицуулсан бөгөөд Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй болно.

Барилгын тухай хуулийн 4.1.32-т “зураг төсөл зохиогчийн хяналт” гэж барилгын ажил, зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн дагуу гүйцэтгэж байгаа эсэхийг зохиогчоос хянаж байгаа үйл ажиллагааг ойлгоно гэж тодорхойлсон бөгөөд уг хуулийн 33.1.21-д “барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих журам”-ыг батлах, 38 дугаар зүйлд зураг төсөл зохиогчийн чиг үүргийг тусгасан. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм"-ийг батлан мөрдүүлж байна. Уг дүрэмд зохиогчийн хяналтыг дараах 3 хэлбэрээр гүйцэтгэхээр заасан:

1. Байнгын хяналт – Барилгын ажлын явцад тогтмол ажиллах;
2. Тогтмол хяналт – Тухайн үе шатанд шалгалт хийх;
3. Ажлын үе шатны хяналт – Барилгын гол хэсгийн ажлын чанарыг баталгаажуулах.

“Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн 6.2-т “Зохиогчийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн тооцооны 2-7 дугаар бүлгийн дүнгээс 1 хувиар тооцно. Нэгдсэн төсөв зохиогдоогүй нөхцөлд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн 1 хувиар тооцно.” гэж тусгасан.

“Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 6 дугаар бүлэгт зохиогчийн хяналтын ажлын үнэлгээний талаар зохицуулсан бөгөөд хяналтын төрөл, төслийн онцлогоос хамаарч захиалагчтай тохиролцон тогтоох, үнэлгээнд тусгах зардлын төрөл, хэрэгжүүлж буй төслийн эх үүсвэрээс хамааруулан өртгийг тооцохоор тусгасан. Дээрх захиргааны хэм хэмжээний актад зохиогчийн хяналтын зардлыг зохицуулсан боловч одоогоор барилгын төсөвт өртгийн 0.5-2 хувиар тооцдог.

Зохиогчийн хяналтын үндсэн зорилго, ач холбогдлыг дараах байдлаар ойлгодог:

- Барилгын ажил зураг төслийн дагуу хийгдэж буй эсэхийг хянах;
- Чанарын хяналт тавьж, барилгын аюулгүй байдал, стандартыг хангах;
- Зураг төсөлд гарсан алдаа, зөрчлийг илрүүлэх, засварлуулах;
- Шаардлагатай өөрчлөлт, сайжруулалтыг инженерийн үндэслэлтэйгээр баталгаажуулах;
- Барилгын материал, инженерийн шийдлийг зөв сонгож буй эсэхийг хянах.

Зохиогчийн хяналтын зохицуулалт улс бүрд харилцан адилгүй боловч олон улсын хэмжээнд дараах нийтлэг стандартыг баримталдаг байна. Үүнд:

- FIDIC гэрээний нөхцөл – Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC) зураг төслийн зохиогчийн хяналтын үүрэг, хариуцлагыг гэрээний хүрээнд тодорхойлдог;
- Европын холбооны стандарт (EN) – Барилгын зураг төслийн зохиогчийн хяналт, чанарын шалгалтын үйл ажиллагааг нарийвчлан заасан;
- АНУ болон Их Британи – Барилгын хяналт, инженерийн стандартыг дагаж мөрдөхөд зохиогчийн хяналт чухал үүрэг гүйцэтгэдэг;
- Олон улсын байгууллага – ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо), ISO 45001 (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй) зэрэг стандартыг мөрддөг.

Олон улсад барилгын төслийн хяналтын зардал нь төслийн цар хүрээ, нарийн төвөгтэй байдал, байршил, орон нутгийн зах зээлийн нөхцөл зэргээс хамааран ялгаатай байдаг бөгөөд зардлыг тооцоход дараах аргыг ашигладаг болно. Тухайлбал,

- Хувь хэмжээний арга: Зохиогчийн хяналтын зардлыг төслийн нийт өртгийн тодорхой хувиар тооцох. Энэ хувь хэмжээ нь төслийн нарийн төвөгтэй байдал, цар хүрээнээс хамааран өөрчлөгддөг;
- Тогтмол хөлсний арга: Төслийн тодорхой үе шат, эсхүл бүхэлд нь тогтмол зардал тохирох. Энэ нь ихэвчлэн тодорхой цар хүрээтэй, тодорхойлсон ажилд ашиглагддаг;
- Цагийн хөлсний арга: Хяналтын үйл ажиллагаанд зарцуулсан цагийн тооцоогоор хөлсийг тооцох. Энэ нь төслийн цар хүрээ тодорхойгүй, эсхүл өөрчлөгдөх боломжтой үед ашиглагддаг.

Эдгээр аргыг төслийн онцлог, талуудын тохиролцооноос хамааран дангаар нь, эсхүл хослуулан ашиглаж болдог.

Зохиогчийн хяналтын талаар Барилгын тухай хуульд заасан бөгөөд Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд заагаагүй байна. “Барилгын төсөв зохиох дүрэм”-д зохиогчийн хяналтын зардлыг төсөвт өртгийн 1 хувиар, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д хяналтын төрөл, төслийн онцлогоос хамаарч захиалагчтай тохиролцон тогтоож болгохоор тусгасан олгоно.

4.1.3.Захиалагч болон зохиогчийн хяналтын уялдаа холбоо

Захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь тус тусын үүрэгтэй боловч барилгын ажил стандартын дагуу, зураг төслийн шаардлагыг хангасан, чанартай хийгдэж буй эсэх асуудлаар хамтран ажиллаж, харилцан нэгнийхээ үйл ажиллагааг хянана.

Хүснэгт 9.Захиалагч болон зохиогчийн хяналтын уялдаа холбоо

Чиг үүрэг	Захиалагчийн хяналт	Зохиогчийн хяналт
Барилгын ажлын хяналт	Санхүүжилт, гэрээ, ажлын явцыг хянах	Зураг төслийн дагуу баригдаж буй эсэхийг хянах
Чанарын хяналт	Барилгын ажил стандарт, техникийн шаардлага хангасан эсэхийг хянах	Инженерийн шийдэл, зураг төсөлтэй нийцэж буй эсэхийг хянах
Зураг төслийн өөрчлөлт	Барилгын ажилд шаардлагатай өөрчлөлтийг зөвшөөрөх	Зураг төслийн өөрчлөлт оруулах дүгнэлт гаргах
Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл	Барилгын гүйцэтгэгчийн ажлын явцыг хянах	Барилгын ажлын технологийн дагуу хийгдэж буй эсэхийг хянах
Материалын сонголт, стандарт	Барилгын материалыг гэрээний дагуу нийлүүлж буй эсэхийг хянах	Барилгын материалын стандарт, чанарт хяналт тавих
Барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх	Барилгын бэлэн байдлыг дүгнэж, хүлээж авах	Барилга зураг төслийн дагуу баригдсан эсэхийг баталгаажуулах

Захиалагчийн хяналт нь төслийн санхүү, гэрээний хэрэгжилт, барилгын явц, хүлээлгэн өгөх үйл явцыг хянах бол зохиогчийн хяналт нь барилгын ажил зураг төслийн шаардлагад нийцэж байгаа эсэх, стандарт мөрдөгдөж буй эсэхийг хянах үүрэгтэй.

Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөөгүй, хэрэгжилтийн явцад захиалагч, зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн систем, цахим сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал ажиглагдаж байна гэж дүгнэсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар “Норм батлах тухай” тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНбД 81-013-2019 дүрмийн[50]:

- 5.4.4-т “Авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс дараах хувь хэмжээгээр тооцно” гэвд авто замын барилга, их засварын ажлын техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлыг төсөвт тооцсон тохиолдолд захиалагчийн хяналтын зардлыг техник, технологийн хяналтын (зөвлөх үйлчилгээ) зардлын дүнгээс 10 хувиар тооцож төсөвт тусгана;
- 5.4.5-д “Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал болон гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засвар, ээлжит засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 4 хувиар тооцно”;
- 5.4.6-д “Техник, технологийн хяналтыг захиалагч байгууллага нь хэрэгжүүлэх 5.0 тэрбум төгрөг хүртэлх төсөвт өртөг бүхий авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажилд захиалагчийн хяналтын зардлыг төсвийн шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцох бөгөөд техник, технологийн хяналтын зардлыг давхардуулан тооцохгүй.” гэж заасан.

Авто зам, гүүрэн байгууламжийн урт, хэрэгжүүлэх эх үүсвэр, төсөвт өртгөөс хамааруулан 4-5 хувь байхаар тус тус зохицуулсан.

Хүснэгт 10.Авто зам, гүүрний ажлын техник, технологийн хяналтын зардлын хэмжээ /эзлэх хувиар/

Д/д	Замын урт (км)	Техник, технологийн хяналтын зардлын хэмжээ (шууд зардлын дүнгээс)
1	0-50	5
2	51-100	4.8
3	101-150	4.6
4	151-200	4.4
5	201-300	4.2
6	301-ээс дээш	4
Д/д	**Гүүрийн урт (м)**	**Техник, технологийн хяналтын зардлын хэмжээ (шууд зардлын дүнгээс)**
1	200 хүртэл	5
2	201-300 хүртэл	4.8
3	301-ээс дээш	4.6

Захиалагч, зохиогчийн хяналтын зардлыг Монгол Улсад төсөвт өртгийн тодорхой хувиар тооцдог бол бусад улсад төслийн төрөл, онцлог, хамрах хүрээ, гүйцэтгэгч, захиалагчийн гэрээний нөхцөлөөс хамааран уян хатан, хөрвөх боломжтой байдлаар тооцдог.

[50] https://legalinfo.mn/mn/detail?lawId=210059&showType=1

4.1.4.Норм, нормативын сан

Норм, нормативын сан гэдэг нь барилга, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ болон бусад салбарт мөрдөгдөх дүрэм, журам, заавар, стандартын цогц юм.[51] Норм, нормативын сан барилга, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгож, үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, салбарын үйл ажиллагааг хууль зүйн хүрээнд зохицуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг тогтоож, харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой.

Норм, нормативын талаар дараах хууль тогтоомжид доор дурдсан байдлаар тусгажээ. Үүнд:

Барилгын тухай хуулийн,

- ✓ 5.5-д “барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг боловсруулах, батлах, сурталчлах зэрэг үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон Барилга байгууламжийн норм, нормативын сангаас санхүүжүүлнэ”;
- ✓ 5.7.1-д “Барилга байгууламжийн төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлогыг төвлөрүүлнэ.”;
- ✓ 34.1-д “Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг сурталчлах, нэвтрүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, барилга байгууламжийн норм, нормативын сан бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасан. Тодруулбал; төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас норм, нормативын санд төвлөрүүлсэн зардлыг зарцуулж байна.

Авто замын тухай хуулийн 8.4-т авто замын норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, батлах, боловсронгуй болгож хөгжүүлэх “Авто замын норм, нормативын сан”-тай байх бөгөөд уг сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ гээд 8.4.1-д “авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртгийн 0.4 хувиар тооцсон орлого” гэж заасан.

---

[51] Норм (Norm): Тодорхой нөхцөлд хүрэх ёстой хэмжээ, үзүүлэлт, шаардлага. Жишээлбэл; барилгын материалын бат бэх, агаар дахь хорт бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, ажилчдын ажиллах цагийн норм зэрэг. Норматив (Standard): Нормыг хэрэгжүүлэх аргачлал, заавар, журам. Жишээлбэл; барилгын зураг төсөл боловсруулах аргачлал, аюулгүй ажиллагааны заавар, бүтээгдэхүүний чанарын шаардлага гэх мэт. Стандарт (Standard): Тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээ, процессын чанар, аюулгүй байдал, гүйцэтгэлийг тодорхойлсон баримт бичиг.

Эрчим хүчний тухай хуулийн 6.1-д “Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нормативын баримт бичгийг батлах, стандарт боловсруулах эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд хувь хэмжээг нь хуулиар тогтоогоогүй байна. Засгийн газрын 2015 оны 360 дугаар тогтоолын[52] 2.1-д баримт бичгийг боловсруулах ажлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ гээд 2.1.1-д “эрчим хүчний барилга байгууламжийн угсралт, засвар, өргөтгөл, шинэчлэлийн хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хайгуул, судалгаа шинжилгээ, зураг төсөл боловсруулах ажлын нийт төсөвт өртгийн үнийн дүнгийн 0.18 хувь” гэж заасан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 04 дүгээр тушаалаар [53] батлагдсан “Барилга байгууламжийн норм, нормативын сангийн журам”-д “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ сангийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж, Сангийн удирдах зөвлөл болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавихаар, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалаар[54] батлагдсан “Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”-д норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах ажлыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ хариуцан зохион байгуулах, сангийн үйл ажиллагаанд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Удирдах зөвлөл хяналт тавихаар зохицуулсан.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д улсын төсвөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнээс норм, нормативын санд тусгах орлогын тооцоолол, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах хүрээнд тухайн жилд төвлөрүүлсэн санхүүжилт, жилийн нэгдсэн тайлан, зарцуулалт, үр дүнгийн талаарх тайланг холбогдох төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ гэж заасан.

Барилгын салбарт сүүлийн 3 жилийн хугацаанд норм, нормативын санд төвлөрсөн орлогын хэмжээг авч үзэхэд 2023 онд 5.1 тэрбум төгрөг, 2024 онд 6.8 тэрбум төгрөг, 2025 онд 8.9 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлж, жил бүр дунджаар 30 хувиар өссөн байна.

Сангийн зарцуулалтын төлөвлөгөө болон бодит зарцуулалтын гүйцэтгэлийн харьцуулан үзэхэд гүйцэтгэлийн хувь тогтмол доогуур байгаа бөгөөд үүний гол шалтгаан нь норм, нормативын баримт бичиг боловсруулах ажлын хангалтгүй хэрэгжилт байна. Тухайлбал:

[52] https://legalinfo.mn/mn/detail?lawId=206892&showType=1

[53] https://mcud.gov.mn/resource/mcud/LegalDocumentAttachment/2019/04/24/cbdo3i3f5fxrhqyg/04_nncangin%20juram.pdf

[54] https://rtdc.gov.mn/wp-content/uploads/2023/12/

- 2023 онд норм, нормативын баримт, бичиг боловсруулах ажилд 3,118.7 сая төгрөг төлөвлөснөөс 881.8 сая төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 28.3 хувь;
- 2024 онд норм, нормативын баримт, бичиг боловсруулах ажилд 3,118.1 сая төгрөг төлөвлөснөөс 516.4 сая төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 16.6 хувь;
- 2025 онд норм, нормативын баримт, бичиг боловсруулах ажилд 4,547.6 сая төгрөг төлөвлөснөөс 552.3 сая төгрөгийг зарцуулж, санхүүжилтийн гүйцэтгэл 12.1 хувь байна. Энэ нь төлөвлөлт болон хэрэгжилтийн уялдаа хангалтгүй, төвлөрсөн хөрөнгийг бүрэн ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.

Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн норм, нормативын сангийн сүүлийн 3 жилийн тайлангаас дүгнэхэд барилгын салбарт норм, нормативын санд төвлөрч буй орлогын хэмжээ тогтвортой өссөн хэдий ч уг санхүүжилт нь норм, нормативын баримт бичгийг боловсруулах үндсэн зорилгод бүрэн нийцэхгүй, зарцуулалтын үр ашиг хангалтгүй байна. Тодруулбал, их хэмжээний орлого төвлөрдөг боловч норм, нормчлолын баримт бичгийн боловсруулалтын ажил удаашралтай, их хэмжээний хуримтлагдсан үлдэгдэл бүрэн ашиглагдаагүй, мөн зардлын бүтэц нь үндсэн зорилгод бүрэн нийцэж байгаа эсэх талаар мэдээлэл хангалтгүй байна.

Салбарын яамнаас барилгын салбарын норм, нормативын баримт бичигт үзлэг хийж, техникийн түвшин тогтоох үйл ажиллагааг 2015 онд хийжээ. Уг үзлэгээр норм норматив хоцрогдсон, боловсруулах мэргэжлийн хүний нөөц байхгүй, тогтмол хугацаанд техникийн түвшний үзлэг хийж байх, норм норматив боловсруулах ажлын зарцуулалтыг хянах зэрэг дүгнэлт гарсан бөгөөд уг дүгнэлтээс хойш үзлэг хийгээгүй байна. Түүнчлэн, норм норматив боловсруулах ажлын зарцуулалт, сангийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд ил тод, мэдээлээгүй байна гэж үзжээ.[55]

Хүснэгт 11.Барилгын норм, норматив боловсруулах сангийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалт /тэрбум.төг/

Он	Орлого төвлөрүүлэлт	Зарцуулалт	Үлдэгдэл
2015	1.616	0.964	0.652
2016	1.528	0.873	0.655
…	…	…	…
2021	3.449	1.646	1.803
2022	3.202	1.756	1.446

[55] Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2023 он, 40 дүгээр тал

Анхаарах зүйл: Дээрх хүснэгтээс харахад сангийн жилийн дундаж орлого төвлөрүүлэлт нь 1.66 тэрбум төгрөг, зарцуулалт нь дунджаар 0.99 тэрбум төгрөг бөгөөд батлагдсан норм, нормативын баримт бичгийн тоотой харьцуулахад зарцуулалт нэмэгдсэн ч батлагдсан норм, нормативын баримт бичгийн тоо буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь норм, нормативын баримт бичгийн боловсруулах жишиг үнэ өсөж, норм, норматив боловсруулах инженер техникийн ажилтан, “Сан”-гийн ажлын албыг чадавхжуулах, тогтвортой ажиллах нөхцөлийг сайжруулах зардал нэмэгдсэнтэй холбоотой гэж үзжээ. Тодруулбал, норм, нормативын сангаас зарцуулалт хийгддэг ч норм, нормативын баримт бичиг хоцрогдсон, шинэчлэл хийгдэхгүй хугацаа алддаг тал байна.

Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд дурдсан зарим асуудлыг танилцуулъя. Үүнд:

1.Барилгын салбарын статистикаас үзэхэд 2016 онд 4.47 тэрбум төгрөг, 2017 онд 5.3 тэрбум төгрөг төвлөрөх магадлалтай байгаагаас төвлөрүүлэлт 39.1 хувьтай байгаа буюу төлөвлөснөөс дутуу байх тул орлого төвлөрүүлэлтийг сайжруулах;

2.Барилгын норм, норматив боловсруулах сангийн хөрөнгөөр боловсруулж буй норм, нормативын баримт бичгийн боловсруулалтыг сайжруулах, “Сан”-гийн ажлын албаны инженер, техникийн ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах нөхцөлийг хангах шаардлагатай байна гэжээ.[56]

Барилга, эрчим хүч, авто замын салбарын норм, нормативын санд төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас ижил хувь хэмжээгээр хөрөнгө төвлөрүүлдэг хэдий ч норм нормативын баримт бичгийг шинэчлэх ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг, хариуцлагын тогтолцоо сул болох нь холбогдох хяналт, шалгалтаар тогтоогдсон. Төсвийн хөрөнгө ийнхүү үр ашиггүй зарцуулагдаж буйг өөрчилж, норм, нормативын сангийн удирдлага, менежментийг шинэчлэх шаардлагатай байна.

Норм, нормативын санд төвлөрөх хөрөнгийг Барилгын тухай хуульд 0.18 хувь, Авто замын тухай хуульд 0.4 хувь гэж заасан бол Эрчим хүчний тухай хуульд тодорхой хувь хэмжээ заагаагүй байна. Харин Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг тооцоолохтой холбогдсон зардлыг санхүүжүүлэх журам”-д 0.18 хувь гэж тусгасан байна.

4.1.5.Фидикийн гэрээний талаар /FIDIC/: Олон Улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ноос эрхлэн гаргадаг жишиг гэрээг Дэлхийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Карибын хөгжлийн банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллага өөрсдийн санхүүжүүлдэг

[56] Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2023 он, 117, 118 дугаар тал

төсөлд заавал хэрэглэхийг шаарддаг. Эдгээр гэрээ нь түгээмэл хэрэглэгддэг төдийгүй Монгол Улсын үндэсний компани болон гаднын хөрөнгө оруулагчид энэхүү жишиг гэрээний дагуу төслүүдийг санхүүжүүлэхээ илэрхийлдэг.

Фидик бүтээн байгуулалтын салбарт жишиг, стандарт бий болгох зорилгоор загвар гэрээг боловсруулсан бөгөөд эдгээрээс 6 өнгийн ном буюу 6 жишиг гэрээг дэлхий дахинд худалдан авах ажиллагаанд түгээмэл хэрэглэж байна.

Хүснэгт 12.Фидикийн гэрээний төрөл

Улаан ном	Барилга угсралтын ажил, Захиалагч зураг төслийг бүрэн хийж өгсөн байдаг, Гүйцэтгэгч зөвхөн барилгын ажлыг хийдэг
Шар ном	Design & Build (Төсөл боловсруулах ба барих), Гүйцэтгэгч зураг төсөл болон барилгын ажлыг хариуцна, Илүү уян хатан гэрээ
Саарал ном	EPC/Turnkey гэрээ (Түлхүүр гардуулах нөхцөлтэй), Эрдэс баялаг, томоохон үйлдвэрүүд, дэд бүтэц зэрэг төслүүдэд хэрэглэнэ, Гүйцэтгэгч бүх эрсдэлийг үүрдэг
Ногоон ном	Жижиг хэмжээний төсөл, Харьцангуй хялбаршуулсан гэрээний хэлбэр, Богино хугацаатай, энгийн төсөлд тохиромжтой
Цагаан ном	Зөвлөх үйлчилгээний гэрээ, Инженерүүд болон зөвлөхүүдийн гэрээ байгуулахад ашигладаг
Цэнхэр ном	Усан байгууламжийн гэрээ, Усны гүнзгийрүүлэлт, далан, эргийн байгууламж, Усан орчны онцлог, байгаль орчны хүчин зүйл, Тусгай зориулалтын ажил гүйцэтгэх

Фидикийн гэрээ нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, эрсдэлийг тодорхой хуваарилсан, мэдүүлэг, маргаан шийдвэрлэх тодорхой заалттай, захиалагч ба гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлагыг тодорхой тусгаснаараа онцлог байдаг.

Хүснэгт 13.Фидикийн гэрээний жишээ

Гэрээний төрөл	Ашиглах нөхцөл	Жишээ төсөл	Зураг төсөл боловсруулагч этгээд	Гэрээний онцлог
Улаан ном (Traditional Design-Bid-Build)	Захиалагч зураг төслийг бэлдсэн үед	Улаанбаатар-Дархан чиглэлийн замын бүтээн байгуулалт (ADB санхүүжилттэй)-Шинэ гүүр барих төсөл	Захиалагч (Government or Consultant)	Хуваарилагдсан эрсдэл, инженер хянаж гүйцэтгэл батална.

Шар ном (Design & Build)	Гүйцэтгэгч зураг төсөл болон барилга хариуцах	Цэвэрлэх байгууламжийн шинэчлэл (Jlca төсөл) Нарны цахилгаан станц	Гүйцэтгэгч	Зураг, барилга хосолсон. Эрсдэлийг гүйцэтгэгч илүү хариуцна.
Саарал ном (EPC/Turnkey)	Хугацаа, үр дүн чухал үед	Усан цахилгаан станц, дулааны цахилгаан станцын төслүүд (Erdenes Tavantoloi Power Plant) Газрын тос боловсруулах EPC гэрээ	Гүйцэтгэгч	Захиалагч бараг оролцохгүй, бүх эрсдэл гүйцэтгэгчид шилжинэ.
Ногоон ном (Short Form)	Бага өртөгтэй, богино хугацааны ажил	1-2 сая ам.долларын жижиг төсөл- Сургуулийн засвар өргөтгөл	Ихэвчлэн захиалагч	Энгийн, хурдан тохиролцоо, маргаан багатай.
Шар ном (Design, Build & Operate)	Гүйцэтгэлийн дараах ашиглалт багтсан үед	Ус цэвэршүүлэх байгууламж, 10 жил ашиглалт, бохирын системийн концесс төсөл	Гүйцэтгэгч	Удаан хугацаанд ажиллуулах нөхцөлтэй, хяналт урт хугацаанд үргэлжилнэ.

Монгол Улсын байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан бүтээн байгуулалтын ажил улирлын чанартай, богино хугацаанд хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлага үүсдэг бөгөөд хугацаа алдвал өртөг өсөхөөс гадна хөдөлмөр, аюулгүй ажиллагааны шаардлага өндөр, хүйтэн цаг агаарын нөлөөллөөс үүдсэн өндөр чанартай, өртөг ихтэй материал хэрэглэдэг, төвөгшил нэмэгдэх тусам мэргэжлийн ур чадвар шаарддаг зэргээс шалтгаалан жишиг гэрээг онцлог байдалд тохируулан нутагшуулан хэрэглэх асуудал чухал байна. Түүнчлэн, төрийн худалдан авах ажиллагаанд жишиг гэрээг хэрэглэдэг нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслийн явц, гүйцэтгэлд үүссэн асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй, хугацаа алдах, гүйцэтгэгчтэй хариуцлага тооцох зохицуулалт сул зэрэг дутагдалтай талтай байна. Иймд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төслийн гэрээний удирдлагад Фидикийн гэрээг нэвтрүүлэх, хэрэглэх шаардлага тулгарч байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөлд жишиг гэрээг хэрэглэдэг. Барилга байгууламжийн төслийн гэрээний хэрэгжилт сул, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад ордоггүй, гэрээгээр тохиролцсон үнэ буюу төсөвт өртөг нэмэгддэг зэрэг хүндрэл гардаг бөгөөд жишиг гэрээнд ихэвчлэн гэрээг цуцлах, гэрээний үүргийн харилцаанд захиалагч зардал, эрсдэл хүлээхээр тусгасан нь гүйцэтгэгчид боломж олгодог. Харин Фидикийн гэрээ нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй эрсдэлийг тодорхой хуваарилсан, маргаан шийдвэрлэх тодорхой зохицуулалттай, захиалагч болон гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлагыг тодорхой тусгасан байдаг. Иймд Фидикийн гэрээг хэрэглэсэн нөхцөлд дээрх асуудлыг тодорхой хэмжээнд буурах тул гэрээг нэвтрүүлэх боломжийг хуульд авч үзэх нь зүйтэй.

4.1.6.Төсөл хэрэгжих хугацаа: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2025 онд 2,874 бүтээн байгуулалтын төсөл батлагдсан бөгөөд 42.5 хувь буюу 1,219 төслийн төсөвт өртөг нэмэгджээ. Бүтээн байгуулалтын нэг төсөл дунджаар 0.9 жилээр хойшилж, 2.7 жилийн хугацаанд хэрэгжсэн судалгаа гарсан.

Судалгаанаас харахад, төслийн хэрэгжилтийн дундаж хугацаа 1.8-4.7 хүртэл жил байна.

График 11.Төслийн хэрэгжилтийн дундаж хугацаа /жилээр/






График 12.Таваас дээш жил үргэлжилж байгаа төслийн тоо, нийт төслийн тоонд эзлэх хувь



Таваас дээш жил хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний тоо 2018 онд 73 буюу нийт төсөл, арга хэмжээний 9.7 хувийг эзэлж байсан бол 2019-2022 онд 26-аас 45-ын хооронд буюу 2.1-3.3 хувьтай байсан. Харин 2023 онд 58 буюу 5.1 хувь, 2024 онд 119 буюу 9.0 хувь болж өсөөд 2025 онд 47 буюу 7.5 хувь болж буурчээ.

График 13.Олон жил үргэлжилж байгаа төслийн тоо, 2025 оны төсвийн хууль



Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтыг авч үзэхэд 2011-2020 онд эхэлсэн 47 төсөл, арга хэмжээ байгаагаас 35 төсөл, арга хэмжээ нь ҮАГ-ын дүгнэлтээр 2024 онд тусгагдан 2025 онд үргэлжлэн хэрэгжиж байна.

Дүгнэлт:

1. Төслийн хэрэгжилт, гүйцэтгэлийн явцад захиалагч болон зохиогчийн хяналт тавих тогтолцоог боловсронгуй болгох, хариуцлага тооцох журмыг тодорхой болгох, улмаар гэрээний удирдлагад Фидикийн гэрээг нэвтрүүлэх шаардлагатай.
2. Захиалагч болон зохиогчийн хяналт, норм, нормативын сангийн зардлыг төслийн төсөвт өртгийн зэрэгцээ төслийн хамрах хүрээ, хүчин чадал, хэрэгжих байршил, гэрээний талуудын эрх, үүрэг, зохицуулалт зэрэг хүчин зүйлээс хамааран оновчтой тогтоох нь зүйтэй.
3. Норм, нормативын баримт бичгийн шинэчлэл хангалтгүй, тус сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах явдал гарч байгаа нь төслийн зорилгод үл нийцэх тул сангийн удирдлага, менежментийг шинэчлэх нь зүйтэй.

1.1.1.5.3.Төслийн санхүүжилт

Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлэх, санхүүжилт олгох, хуваарилах, гүйцэтгэлийг хянах үйл ажиллагаа Төсвийн тухай хуулийн нийтлэг зохицуулалтын хүрээнд хэрэгждэг ч санхүүжилтийн нарийвчилсан үйл явцыг журмаар зохицуулдаг. Тухайлбал, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам нь анх 1996 онд Сангийн сайдын тушаалаар батлагдсанаас хойш 12 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг.

2023 онд Төсвийн тухай хуулийн 10.1.13 дахь заалтыг “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг батлах” гэж өөрчлөн найруулсан. Үүний дагуу Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” нь 6 бүлэг, 33 зүйл, 186 заалт, 20 хавсралт бүхий томоохон журам бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээний эргэн төлөлт, төсвөөс санхүүжих ТХХТ-ийн төсөл, арга хэмжээ, Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил, үйлчилгээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад мөрддөг.

Журмын дөрөвдүгээр бүлэгт санхүүжилтийн үйл ажиллагаа, дараалал, хяналт тавих үе шатыг тусгайлан зохицуулсан боловч төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үндсэн зарчим, шалгуур, гүйцэтгэлийн хяналт, тайлагналт, хариуцлагын тогтолцоо зэрэг чухал харилцааг зохицуулдаг нь дараах эрсдэлийг бий болгож байна. Үүнд:

- Эрх зүйн чадамж сул;
- Хариуцлагын тогтолцоо хангалтгүй;
- Хувьсах, тогтворгүй зохицуулалт;
- Нийтээр дагаж мөрдөх боломж муу.

1.Санхүүжилтттэй холбоотой авч хэрэгжүүлдэг санхүүжилтийн зохицуулалтын арга хэмжээ: Монгол Улсын 2018-2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах хүрээнд Засгийн газраас “улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 386, 2019 оны 430, 2020 оны 253, 2021 оны 397, 2022 оны 495, 2023 оны 456, 2024 оны 249 дүгээр тогтоолыг тус тус баталсан.

Уг тогтоолоор зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан ТЕЗ-ийн багцын дүнд зохицуулалт хийх, барьцаа хөрөнгийн дансанд байршуулж он дамжуулан хэрэгжүүлэх, дараа оны тогтоосон хугацааны дотор гүйцэтгэлд хяналт тавих, тогтоосон хугацаанд барьцаа дансан дахь санхүүжилтийг чөлөөлөх, санхүүжилт олгох нөхцөл, шаардлагыг тусгайлан заасан бөгөөд нийт 1.8 их наяд төгрөгийг захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Хэдийгээр төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч төслийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, тогтоосон хугацаанд чөлөөлөхгүй байгаа нь захиалагч, гүйцэтгэгчийн төсвийн сахилга батыг сулруулж, олон жил үргэлжилсэн төслийн тоо нэмэгдэх, улмаар төсөвт өртгийн нэмэгдэл үүсэх зэрэг олон сөрөг үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал, 2018, 2019, 2020 онд дараа оны 07 дугаар сарын 30-ны дотор, 2021, 2022 онд дараа оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан санхүүжүүлэхийг үүрэг болгосон боловч 2019-2021 оны барьцаа данс дахь санхүүжилт олгох хугацаа дуусаж 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр, 2022 оны 32.5 тэрбум төгрөгийг олгох хугацаа 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөр тус тус сунгасан байна.

2.Санхүүжилтийн гүйцэтгэл: Тухайн жилийн төсөвт батлагдсан төслийн төсөвт өртгийн санхүүжилтийн гүйцэтгэл дунджаар 89.3 хувь байна. Тодруулбал; 2020 оноос хойш төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 100 хувьд хүрч байсангүй.

График 14.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл /эзлэх хувиар/





График 15.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэл /улирлаар, эзлэх хувиар/



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДИЙЛЭНХ ХУВЬ НЬ IV УЛИРАЛД ГАРДАГ нь төслийн бэлтгэл ажил, худалдан авах ажиллагаа, захиалагчийн хяналт, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас хамаарч байна.

2018-2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн 44.0 хувь нь IV улиралд, 8.1 хувь нь I улиралд зарцуулагджээ.


3.Зардлын хэтрэлт буюу нэмэлт санхүүжилтийн асуудал: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн хувьд сүүлийн 2 жилд нэмэлт санхүүжилт үүссэн бөгөөд энэ нь төслийн эрсдэл болж байна. Гадаад зээлээр хэрэгжиж байгаа төсөлд ч мөн нэмэлт санхүүжилт гардаг. ОНХС-аар хэрэгжиж

байгаа төсөлд нэмэлт санхүүжилт үүсдэг эсэх талаарх мэдээлэл байхгүй учир нь төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг хамруулсан нэгдсэн зохицуулалт одоогоор алга байна.

2016-2022 онд жилд дунджаар 58 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 114.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байдаг. 2023 онд “Ковид-19” цар тахлаас үүдэлтэй хилийн хорио, инфляц, үнийн өсөлтөөс үүдэн төслийн хэрэгжилт удааширсан бөгөөд эхлүүлсэн төслийг дуусгах, барилгын салбарт тулгамдаж буй бараа материалын үнийн өсөлт болон бусад нэмэлт ажлын санхүүжилтийн магадлалын дүгнэлтэд аудитын хяналт хийгдсэн зэрэгт нийт 1 их наяд орчим төгрөгийг дараах байдлаар зарцуулжээ. Үүнд:

1. УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолоор[57] 2021 оноос өмнө хэрэгжиж эхэлсэн төслийн цалингийн зардал 2009 оны индексээр тооцогдсон байсныг 2019 оны индексээр тооцохоор шийдвэрлэж, нийт 638 төсөл хэрэгжүүлэгч 391 хуулийн этгээдэд 303.4 тэрбум төгрөгийн төсвийг 2023 онд тусгасан;
2. УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоолоор[58] ҮАГ-аас төсөвт өртгийн нэмэгдэл шаардлагатай гэж дүгнэсэн нийт 289 төсөлд 660.6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийг 2024 онд тусгасан.

Зураг 15.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт олон нэмэлт санхүүжилт /тэрбум.төг/




Төсвөөс 2023, 2024 онд барилгын материал болон цалингийн нэмэгдэлд зориулан нийт 964 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд нэмэлт санхүүжилт үүссэн шалтгааныг тодруулахаар

[57] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389673897601
[58] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532125803621

гүйцэтгэгч байгууллагаас 2023-2024 онд цахим системээр дамжуулан судалгаа авсан бөгөөд уг судалгаанд оролцогчдын 79-87 хувь нь барилгын материалын үнийн өсөлт гэсэн бол 46-47 хувь нь зураг төслөөс болж өртөг нэмэгдсэн гэж хариулсан байна.

График 16.Нэмэлт санхүүжилт үүссэн шалтгаан нөхцөл /эзлэх хувиар/



Барилгын тухай хуулийн 33.1.10-т ”Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, үнийн индекс барилгын ажилтны тарифт цалинг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.” гэж заасан. Тодруулбал, барилгын салбарын ажилтны цалин болон бараа материалын үнэ зах зээлийн зарчмаар бус төрийн зохицуулалтаар тогтоогдож байна.

Төсөвт өртгийн нэмэгдлийн асуудал 2022 оноос өмнө харьцангуй бага байсан боловч энэ талаарх нарийвчилсан хууль, журмын зохицуулалт тодорхой бус байгаагаас асуудал даамжирч төсөвт ихээхэн ачаалал үүсгэж байна.

УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоолын[59] дагуу Сангийн яамны хүсэлтэд үндэслэн магадлал хийсэн нэмэлт санхүүжилтэд ҮАГ аудит хийсэн хийсэн бөгөөд уг аудитын тайлан, дүгнэлтээр нийт нэмэлт санхүүжилтийн дийлэнх хэсэг нь зураг төсөл болон захиалагчийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэж үзсэн болно.

Түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ашиглалтад оруулахын тулд зураг төслийн магадлалд үндэслэн барилгын материалын үнийн өсөлт болон бусад үндэслэл *(зураг төсөл, төсөвт өөрчлөлт орох, нэмэлт ажил бий болох гэх мэт)*-ээр бий болсон нэмэлт санхүүжилтийг төсөвт тусган шийдвэрлэсэн байдаг.

[59] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532125803621

Дүгнэлт:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашигт чухал нөлөө үзүүлдэг бэлтгэл үе шатнаас эхлээд зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах талаар ойлголт, зохицуулалт дутмаг, нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэх зохицуулалт байхгүй байна.
2. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт өртөг нэмэгддэг, нэмэгдэл санхүүжилт гардаг нь одоогийн норм нормативын баримт бичиг шаардлага хангахгүй, түүнийг сайжруулахгүй байгаа болон норм нормативын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаатай холбоотой байна.

1.1.1.5.4.Төслийн хяналт, тайлагналт

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем “PIMIS”-д 2018 оноос төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгосон. Түүнчлэн, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь цахим системээр хяналт тавих боломжтой болсон зэргээр төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд тавих хяналтыг сайжруулах, олон нийтийн оролцоог хангах талаар Сангийн яамнаас арга хэмжээ авч ажилласнаар үр дүнгүүд гарч байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3-т хяналт тавихтай холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Журмын 5.3.1, 5.3.2, 5.3.3, 5.3.7-д захиалагч, захиалагчийг төлөөлж техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж байгаа байгууллага болон зохиогчийн хяналтын талаар;
- Журмын 5.3.4, 5.3.5-д санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт шалгалт хийх, ингэхдээ мэргэжлийн байгууллагыг татан оролцуулж болох;
- Журмын 5.3.6, 5.3.8-д ТЕЗ барилгын чанарт тавих хяналтыг бүрэн хариуцах, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагаар хөндлөнгийн хяналт тавиулж болох;
- Журмын 5.3.9-д иргэд гомдол гаргавал нутгийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, боломжгүй бол асуудлыг ТЕЗ, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нэн даруй тавьж шийдвэрлүүлэх.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4-т тайлагналт, үр дүнтэй холбоотой харилцааг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Журмын 5.4.1, 5.4.2-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын явц, хэрэгжилт болон гүйцэтгэлийн танилцуулгыг улирал бүр Засгийн газарт танилцуулах, санхүүжилтийн дүн, явц байдлыг мэдээллийн санд байршуулах;
- Журмын 5.4.3-т ТЕЗ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг цахим системд нийтлэх, мэдээлэх;
- Журмын 5.4.4, 5.4.5, 5.4.6-д захиалагч хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэх;
- Журмын 5.4.7, 5.4.8-д ТЕЗ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын тайланг дараа сарын 05-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- Журмын 5.4.9-д ТЕЗ ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

Төсөлд хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлснээс барилга байгууламж чанар, стандартын шаардлагад нийцэхгүй болох, төсөвт өртөг нэмэгдэх, хугацаа сунгагдах зэрэг асуудал зөрчил гардаг. ТЕЗ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж журамд заасан хугацаанд тайлангаа ирүүлэхгүй байх, эсхүл тайлан нь шаардлага хангахгүй буюу тоон мэдээлэл, баримт материал дутуу байх зэрэг асуудал мөн гарч байна.

Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан. Уг зохицуулалтад 2023 онд ажлаас халах, албан тушаалаас чөлөөлөхтэй холбоотой 70.2, 70.3, 70.4 дэх хэсэг нэмсэн боловч үүнд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөлд хяналт тавих, тайлагнах үүргээ биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй гэсэн нөхцөл тусгагдаагүй болно. Иймд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөлд хяналт тавих, тайлагнах үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага тооцох боломж хязгаарлагдмал байна.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн хяналт, тайлагналтын харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

1.1.1.5.5.Өмчийн удирдлага, ашиглалт

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байх, төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд мөн хамаарахаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан.

Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өмчийн удирдлага, ашиглалтын харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулдаг. Уг хуулийн гуравдугаар бүлэгт төрийн өмчийн удирдлага буюу УИХ, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, яам, тусгай газрын бүрэн эрх, эрх хэмжээг, тавдугаар бүлэгт төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг нарийвчлан заасан. Тухайлбал, төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журамд төрийн өмчийн эд хөрөнгийг олж авах, төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх, бүртгэх, төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, төрийн өмчийн эд хөрөнгийг төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийг худалдах, төрийн өмчийн эд хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэх, эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах харилцааг зохицуулсан.

Түүнчлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн есдүгээр бүлэгт орон нутгийн өмчийн зүйлсийн талаар тусгасан бөгөөд уг хуулийн 80 дугаар зүйлд орон нутгийн өмчийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг энэ хуулийн тавдугаар бүлэгт заасны дагуу зохицуулна хэмээн тусгасан.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслийн үр дүнд бий болсон өмч хөрөнгийн удирдлага, ашиглалтын асуудлыг төсвийн хөрөнгө оруулалттай холбон үзэхгүй нөхцөлд төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, үр өгөөж буурч, үүнээс улбаалан “алдагдсан боломж” үүснэ. Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатны нэг нь өмчийн удирдлага, ашиглалт байдаг. Иймд өмчийн удирдлага, ашиглалтын асуудлыг төсвийн хөрөнгө оруулалтын 5 дахь үе шат гэж үздэг.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.5-д өмчийн удирдлага, 5.6-д ашиглалт, түүний өгөөжийг тооцох талаар дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

- Журмын 5.5.1, 5.5.2, 5.5.3-т төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж бүртгүүлэх хүсэлтийг цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтийн хамт илгээх, эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэл баталгаажих;
- Журмын 5.6.1, 5.6.2, 5.6.3, 5.6.4, 5.6.5-д төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр дүн, ашиглалт, түүний үр өгөөжид үнэлгээ өгөх үйл ажиллагааг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түүвэрлэн зохион байгуулах, үнэлгээ хийх удирдамжийг ТЕЗ нарт хүргүүлэх, үнэлгээг цахим системээр хэрэгжүүлэх, үнэлгээнд дотоод

болон хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын байгууллага, шинжээч оролцуулан зохион байгуулж болох.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн буюу төсвөөс мөнгө хөрөнгө зарцуулсан төслийн үр дүнд бий болсон өмч хөрөнгийг бүртгэх, улмаар уг өмчийг ямар хугацаанд ашиглах, хэрхэн хэрэглэх, үр өгөөж нь ямар болохыг тогтоох, элэгдэл, хорогдол нь жилд ямар хэмжээтэй байх зэргийг тооцох, эдгээр мэдээлэлд үндэслэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх нь төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх нэг нөхцөл юм.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах бүрэн эрхтэй болно. Гэсэн ч төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн систем боловсронгуй болоогүй, түүнчлэн ТЭЗҮ зэрэг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төслийн үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэдэггүй зэрэг учир дутагдалтай тал бий. Иймд 2024 оны төсөвт төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн систем хийх хөрөнгө тусгагдан ба уг систем хийгдэж байна. Цаашид төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системийг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системтэй холбох хөгжүүлэлтийн ажил хийхээр төлөвлөсөн байна.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын болон төрийн өмчийн бүртгэл, мэдээллийн системийн уялдаа холбоог хангах, төрийн өмчийн удирдлага, ашиглалтын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай болно.

1.1.1.6.Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем

Сангийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг сайжруулах, олон нийтэд ил тод, нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах чиглэлээр PIMIS системийг үе шаттай хөгжүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь дараах үндсэн зорилготой болно. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх, өмчид бүртгэх, ашиглах зэрэг “төслийн амьдралын мөчлөг”-ийн үйл ажиллагааг бүрэн цахим болгох;
2. Төсвийн хөрөнгө оруулалтын “төслийн амьдралын мөчлөг”-ийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах, ил тод нээлттэй болгох юм.

Анх зөвхөн “Улсын төсвийн хөрөнгө оруулалт”-ын үйл ажиллагааг цахим болгож, иргэд, олон нийтэд ил, тод нээлттэй болгох зорилготой байсан ч өнөөдөр төсвийн хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрүүдийн мэдээллийг агуулсан хөрөнгө оруулалтын нэгдсэн мэдээллийн сан болон үе шаттайгаар хөгжиж байна.

Зураг 16.Төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийн хөгжил



Төсвийн хөрөнгө оруулалтын www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны аппликейшнаар дамжуулан доорх мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгоод байна. Үүнд:

- ✓ Олон эх үүсвэрийн мэдээлэл /улсын төсөв, орон нутгийн төсөв, нийслэлийн төсөв, концесс, гадаад, зээл тусламж/;
- ✓ Батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээлэл /ТЕЗ-аар, байршлаар, газрын зургаар, төслийн төрлөөр/;
- ✓ Төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;
- ✓ Санхүүжилтийн мэдээлэл /үе шатаар/;
- ✓ Мэдээллийн самбарын мэдээлэл /MNS 7023:2023 стандарт/;
- ✓ Ашиглалтад орсон төслийн мэдээлэл;
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн мэдээлэл.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоог хангах чиглэлээр 2023 онд анх удаа “2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал”-д төсвийн хөрөнгө оруулалтын аппликейшнаар санал авсан. Иргэд “E-mongolia” бүртгэлээ ашиглан, өөрийн бүртгэлтэй байршилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээндээ санал өгөв. Иргэдээс 2023 онд 16,900 гаруй, 2024 онд 11,000 гаруй, 2025 онд 12,000 гаруй санал ирүүлсэн байна.

PIMIS систем нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгохдоо хууль, эрх зүйн баримт бичиг, УАГ, Авлигатай тэмцэх газар, иргэний нийгмийн байгууллага, Дэлхийн банк, ОУВС зэрэг байгууллагын зөвлөмжийг тусган хэрэгжүүлж байна. Системийг өнөөдөр 32,000 гаруй хэрэглэгч ашигладаг бөгөөд үүнээс 2,620 нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллагын мэргэжилтэн, инженерүүд байгаа бол 2,763 нь гүйцэтгэгч иргэн, аж ахуйн нэгж байна.

2023.05.23-нд PIMIS 3.1 хувилбарын ашиглалтад оруулснаас хойш 5,641 санхүүжилтийг цахим системээр олгоод байна.

График 17.Цахим системээр олгосон санхүүжилтийн тоо



Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем нь өнөөдрийн байдлаар улсын төсөв, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг “төслийн амьдралын мөчлөг”-ийн хүрээнд 100 хувь цахимжуулсан бөгөөд цаашид дараах үйл ажиллагааг бүрэн цахимжуулах шаардлага, хэрэгцээ байна. Үүнд:

1. Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх;
2. Гадаад зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн ашиглалтад орсны дараах хяналт;
3. Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг цахим системд бүрэн шилжүүлэх;
4. 21 аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг цахим системд бүрэн шилжүүлэх;
5. 330 сум, 9 дүүргийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг “төслийн амьдралын мөчлөг”-ийн хүрээнд бүрэн цахимжуулах;
6. ОНХС-гийн үйл ажиллагааг нэгтгэх */орон нутгийн мэргэжилтнүүд орон нутгийн төсөвтэй хамт ОНХС-гийн үйл ажиллагааг PIMIS-т нэгтгэх талаар байнга хүсэлт тавьдаг/;*
7. Зураг төсөл, төсөв зохиогчийн хяналтын үйл ажиллагааг цахим системд бүрэн шилжүүлэх;
8. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулах;
9. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 2 дугаар албан даалгаврын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд их өгөгдөл ашиглан, хиймэл оюун ухааныг үе шаттайгаар нэвтрүүлж, хүний үйл ажиллагааг хөнгөвчлөх,

цахим систем дэх зарим үйл ажиллагааг автоматжуулах, салбар хоорондын зөрүүгүй нэгдсэн мэдээллийн эх сурвалжтай болсон байх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй аливаа шийдвэр гаргалтад туслах;

10. Төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрүүдийн мэдээллийг агуулсан нэгдсэн сан бий болгох.

Дүгнэлт:

1. Сангийн яамнаас 2020 онд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийг үе шаттай нэвтрүүлснээр санхүүжилтийн явцыг ил тод болгосон, санхүүжилтийг шууд гүйцэтгэгчийн дансанд шилжүүлдэг болсон, цаасны хэрэглээг 90 хувиар бууруулсан, анх удаа иргэдээс цахимаар санал авсан, захиалагчийн техник, технологийн хяналтыг цахим системд шилжүүлсэн, урьдчилсан үнэлгээг цахимаар хийдэг болсон, улсын төсөв, нийслэлийн төсвийн үйл ажиллагааг 100 хувь цахим болгосон, олон эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэсэн зэрэг олон ахиц дэвшил гарсан болно.
2. Цаашид төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд зохиогчийн хяналтыг шилжүүлэх, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, ОНХС-гийн эх үүсвэрийг үргэлжлүүлэн илүү ил тод, нээлттэй болгох, төсвийн хөрөнгө оруулалтыг нэг цонхоор төлөвлөх, хэрэгжүүлэх, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг үе шаттайгаар нэвтрүүлснээр хүний үйл ажиллагааг бууруулах, санхүү, нийгэм, эдийн засгийн шинжилгээг бүрэн цахимжуулж, сайжруулах технологийн шинэчлэл хийхээр төлөвлөн ажиллаж байна.

1.1.1.7.Төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол

Төсвийн хөрөнгө оруулалт нь нийгэм, эдийн засагт олон талын ач холбогдолтой бөгөөд урт хугацаанд эдийн засгийн үр ашиг бий болгодог. Иймд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ нийгмийн хэрэгцээ, эдийн засгийн үр ашгийг харгалзан үзэх, үр дүнтэй удирдлагаар хангах нь чухал юм.

Төсвийн хөрөнгө оруулалтаар нийгэм, эдийн засгийн хувьд дараах 5 салбарт голлон анхаардаг.

- Боловсрол;
- Эрүүл мэнд;
- Зам, тээвэр;
- Эрчим хүч;
- Хот, суурины дэд бүтэц.

Эдгээрийг төрийн зүгээс шийдвэрлэснээр нийгэм, эдийн засгийн бусад асуудлыг хувийн хэвшил өөрсдийн оролцоогоор хөгжүүлэх үндэс суурь нь тавигддаг гэж үздэг. Мөн улс орны хөгжлийн бодлогоос хамааран төслийн хөрөнгө оруулалтыг

бусад салбарт хуваарилан, хэрэгжүүлдэг. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжсэнээр хувийн хэвшлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, хадгалахаас гадна эдийн засгийн өсөлтийг салбараар дамжуулан тэтгэдэг.

Эдийн засгийн үүднээс төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулснаар дараах эерэг үр дүн гарна гэж үздэг. Үүнд:

1. Урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт хэрэгжинэ. Үүнд, улс, орон нутаг, салбарын 8-10 жилийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө, 4-5 жилийн хөтөлбөр, түүнд тусгасан зорилт хангагдана;
2. Төрийн төсөв, санхүүгийн удирдлага сайжирна. Төсвийн санхүүгийн нэгдмэл хариуцлага, нөөцийн оновчтой хуваарилалт, төрийн үйлчилгээний үр ашигтай зорилт хангагдана;
3. Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн нэмэгдэнэ. Хөрөнгө оруулалтын удирдлагын зөв тогтолцоо нь нэгж төслийн хөрөнгө оруулалтын бүтээмж, үр өгөөжийг өсгөх замаар гүйцэтгэлийг сайжруулдаг.

Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлснээр дараах эдийн засгийн үр ашиг гарна хэмээн үздэг. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлээр дэд бүтцийн төсөл, авто зам, төмөр зам, эрчим хүчний сүлжээ зэрэг салбарт хийсэн хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, хуулийн этгээдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлтэй холбогдох логистикийн хөгжлийг дэмжих, худалдаа, экспортын өсөлтийг хангана;
2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр барилга, бүтээн байгуулалтын ажил нь богино хугацаанд олон ажлын байр бий болгох бөгөөд иргэдийн орлогыг нэмэгдүүлж, хэрэглээг өсгөх замаар эдийн засгийн эргэлтийг сайжруулна;
3. Бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр зам тээвэр, цахилгаан, инженерийн шугам сүлжээ, харилцаа холбооны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт нь хувийн хэвшлийн бизнес эрхлэх орчныг сайжруулах, шинэ хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар өргөжиж, татварын орлого нэмэгдэнэ.

Төсвийн хөрөнгө оруулалт нь дараах нийгмийн ач холбогдолтой болно. Үүнд:

1. Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх буюу боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын салбарын хөрөнгө оруулалт нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулж, урт хугацаанд нийгмийн хөгжилд эергээр нөлөөлнө;
2. Нийгмийн тэгш байдлыг хангах буюу орон нутаг болон хотын хөгжлийн тэнцвэргүй байдал, амьдралын чанарын зөрүүг багасгах, ядуурлыг бууруулахад төсвийн хөрөнгө оруулалт чухал үүрэгтэй. Мөн дэд бүтэц

хөгжүүлэх замаар иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэн төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулдаг;

3. Байгаль орчин, тогтвортой хөгжлийг дэмжих буюу ногоон эдийн засаг, сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх нь уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтолтой тэмцэх, хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулахад эергээр нөлөөлнө.

Төсвийн хөрөнгө оруулалт нь дараах эдийн засаг, нийгмийн үр нөлөө үзүүлдэг. Үүнд:

1. Урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, инновацыг дэмжих, тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт нь ирээдүйд нийгэм, эдийн засгийн үр нөлөөг баталгаажуулдаг;
2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон нийтэд хандсан төсвийн хөрөнгө оруулалт нь төрийн үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлнэ. Цахим засаглал, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл нь авлигыг бууруулах, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулна;
3. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлийн төсвийн хөрөнгө оруулалт нь инфляцыг зохицуулах, нийт эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхэд нөлөөлөх бөгөөд өрийн дарамтыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл болно.

ОУВС-гийн 2023 оны “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл тайлан”-д “Ази Номхон далайн орнууд болон хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудын дундаж оноотой харьцуулбал Монгол Улс олон жилийн төсөв, багцын удирдлага, байгууллагын чадавхын хяналтаас бусад институтийн загварчлалын ихэнх тал дээр өндөр, эсхүл ижил оноотой байна. Гэвч үр нөлөөний хувьд Монгол Улс төсвийн зорилт, дүрэм, олон жилийг хамарсан төсөвлөлт, төсвийн цогц ба нэгдмэл байдал, хөрөнгө оруулалтын төсөв, засвар арчлалтын санхүүжилт зэрэг чиглэлээр ижил түвшний улс орноос хоцорч байна” гэж дүгнэжээ.

Төслийн нийгмийн ач холбогдлыг тоон үзүүлэлтээр богино хугацаанд хэмжих боломж хязгаарлагдмал бөгөөд энэ нь урт хугацааны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагатай уялддаг. Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх нь эдийн засгийн олон талт үр өгөөжтэй ч үр ашигтай, зорилтот байдлаар хуваарилах нь хамгийн чухал гэж үздэг.

Анхаарах зүйл: Сүүлийн 4 жилд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд 1,873 барилга байгууламж ашиглалтад орж, жилд дунджаар 3,100 гаруй хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, 45,000 гаруй ажлын байрыг хадгалсан. Гэсэн ч, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр нөлөө нь ижил түвшний улсаас бага байгааг ОУВС-гаас сануулсан болно.

Дүгнэлт:

1. Төслийн нийгмийн ач холбогдлыг тоон үзүүлэлтээр богино хугацаанд хэмжих боломж хязгаарлагдмал бөгөөд энэ нь урт хугацааны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагатай уялддаг.
2. Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх нь эдийн засгийн олон талт үр өгөөжтэй ч үр ашигтай, зорилтот байдлаар хуваарилах нь хамгийн чухал бөгөөд бодлогын зөв зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулснаар бодит үр нөлөөг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.
3.
4. Төсвийн хөрөнгө оруулалт нийгмийн хөгжлийн суурь хэмжүүр болох хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй хэдий ч оновчтой төлөвлөх, ач холбогдлоор нь эрэмбэлэх, үр ашгийг тооцох, хууль зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг ҮАГ, ТТБЗ-ийн дүгнэлт, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагын зөвлөмжид тусгасан. Тиймээс төсвийн хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн бодит хэрэгцээ, урт хугацааны өгөөжид тулгуурлан оновчтой хуваарилах аргачлал, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ байна.

1.1.2.Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин

Төсвийн хөрөнгө оруулалтын хууль зүйн зохицуулалтын 3 шатлал: Дэлхийн банкнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын дараах 3 шатлал бүхий хууль зүйн зохицуулалтыг тохиромжтой хэмээн зөвлөсөн байна:[60]


1. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон хууль;
2. Дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэр, удирдамж болон үүрэг хариуцлага, дүн шинжилгээ зэргийг багтаасан журам, дүрэм;
3. Арга зүйн удирдамж, нарийвчилсан шалгуур, норм зэргийг тодорхойлсон процедурын баримт бичиг.

[60] Kim, Jay-Hyung, Jonas Arp Fallov, and Simon Groom. 2020. Public Investment Management Reference Guide. International Development in Practice. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1529-4. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO

I шатлал буюу төсвийн хөрөнгө оруулалтын хууль зүйн үндэслэлийг тодорхойлсон хуульд дараах хууль тогтоомж хамаарна гэж үздэг. Үүнд:

1.Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах;
2.Төсвийн тухай хуульд тусгах;
3.Төсвийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомжид заах.

Зураг 17.Төсвийн хөрөнгө оруулалтын хууль зүйн зохицуулалтын шатлал



Засгийн газар, Сайд зэрэг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг II шатлалын хууль зүйн зохицуулалтад хамруулдаг. Тодруулбал; захиргааны хэм хэмжээний акт хамаарна. II шатлалын хууль, эрх зүйн зохицуулалтыг үнэлгээний арга зүй, үнэлгээний нарийвчилсан шалгуур, техникийн удирдамж буюу III шатлалын зохицуулалтаар дэмжих шаардлагатай гэж үздэг.

Дэлхийн банкны дээрх 3 шатлалын дагуу Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны хууль, эрх зүйн орчныг авч үзье.[61]

I шатлалын хууль тогтоомжид Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж хамаарна. Хууль тогтоомжийг нийтлэг зохицуулалттай хууль, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд шууд хамаарах болон шууд бус хамаарах хууль тогтоомж хэмээн үзэж болно. Нийтлэг зохицуулалттай хууль тогтоомжид Захиргааны ерөнхий хууль, Иргэний хууль, МУЗЗНДНТУтХ хамаарна. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд шууд хамаарах хууль тогтоомжид Төсвийн тухай хууль, ТТБтХ, Төрийн хэмнэлтийн тухай хууль, шууд бус хамаарах хууль тогтоомжид Авто замын тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль зэрэг хамаарна.

II шатлалд хамаарах захиргааны хэм хэмжээний актаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулдаг. Эдгээрийг Засгийн газрын тогтоол болон Сайдын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний акт гэж ангилж болно. Засгийн газрын тогтоолоор батлагдсан захиргааны хэм хэмжээний акт нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар

[61] Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцаанд хамаарах хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын жагсаалттай тандан судалгааны тайлангийн хавсралт № 2-оос танилцана уу.

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” болон бусад журам, дүрэм байна.

III шатлалд барилга, авто зам, эрчим хүчний салбарын стандарт, бусад аргачлал, удирдамж, заавар зэрэг багтана.

I шатлал.Төсвийн хөрөнгө оруулалтын хууль тогтоомж:

Монгол Улсын хөрөнгө оруулалт нь улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаад зээл, тусламж, ТХХТ болон бусад эх үүсвэрээр санхүүжилтээр хэрэгждэг.

Хүснэгт 14.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, тэдгээрийн хууль зүйн зохицуулалт

Эх үүсвэр	Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны үе шат				
	Төлөвлөлт	Хэрэгжилт	Санхүүжилт	Хяналт, тайлагналт	Өмчийн удирдлага, ашиглалт
Улсын төсөв	-Төсвийн тухай хууль; -ХБТТУтХ; -Төрийн хэмнэлтийн тухай хууль; -“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”; -Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, аргачлал	- Төсвийн тухай хууль; - ТБОНӨХБАҮХАтХ; - Төрийн хэмнэлтийн тухай хууль; - Авто замын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Барилгын тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - Төрийн аудитын тухай хууль; - “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”			
Орон нутгийн төсөв, ОНХС	-Төсвийн тухай хууль; -ХБТТУтХ; -МУЗЗНДНТУтХ; -МУНУХЭЗБтХ; -“Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”	- Төсвийн тухай хууль; - ТБОНӨХБАҮХАтХ; - Төрийн хэмнэлтийн тухай хууль; - Авто замын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Барилгын тухай хууль; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - Төрийн аудитын тухай хууль; - “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”			
Гадаад зээл, тусламж	-ТТБтХ; -ХБТТУтХ; -Төсвийн тухай хууль; -ӨУтХ;	- ӨУтХ; - ТБОНӨХБАҮХАтХ; - “Гадаадаас тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”;			

	- Олон улсын гэрээний тухай хууль	- “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”; - Санхүүжүүлэгч байгууллагын холбогдох журам, дүрэм, аргачлал
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүжилт	- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль; - -Компанийн дүрэм	- ТБОНӨХБАҮХАтХ; - Компанийн тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Компанийн дүрэм
ТХХТ-ийн санхүүжилт	- ТХХТтХ; - Төсвийн тухай хууль; - Холбогдох гэрээ	

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалт гэсэн үе шатанд үйлчилдэг хууль, эрх зүйн зохицуулалтыг хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр нь авч үзье.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- төлөвлөлтийн харилцаанд Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, ХБТТУтХ, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, аргачлал;
- хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд ТБОНӨХБАҮХАтХ, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль болон “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” тус тус үйлчилж байна.

Орон нутгийн төсөв, ОНХС-гийн хөрөнгө оруулалт:

- төлөвлөлтийн харилцаанд Төсвийн тухай хууль, МУЗЗНДНТУтХ, МУНУХЭЗБтХ;
- хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАтХ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тус тус үйлчилж байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжих хөрөнгө оруулалт:

- төлөвлөлтийн харилцаанд ТТБтХ, Төсвийн тухай хууль, ӨУтХ, Олон улсын гэрээ эрх зүйн тухай хууль, санхүүжүүлэгч байгууллагын дүрэм, журам;
- Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц төслүүдийн санхүүжилт, хяналт, тайлагналтын харилцаанд Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль;
- хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд ӨУтХ, ТБОНӨХБАҮХАтХ, Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам” болон санхүүжүүлэгч байгууллагын холбогдох журам, дүрэм, аргачлал мөрдөгдөж байна.

ТХХТ-ээр хэрэгжих хөрөнгө оруулалт:

- төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд ТХХТтХ, Төсвийн тухай хууль болон холбогдох гэрээ мөрдөгдөж байна.

Төрийн өмчит болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт:

- төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАтХ, хуулийн этгээдийн дүрэм, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар үйлчилдэг.

Хувийн хэвшил, бусад сангийн хөрөнгө оруулалт:

- төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд Компанийн тухай хууль, холбогдох хууль, хуулийн этгээдийн дүрэм, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар үйлчилж байна.

Дээрхээс үзэхэд, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжин хэрэгждэг ба санхүүгийн эх үүсвэрээс хамааран хууль зүйн ялгаатай зохицуулалтууд үйлчилдэг.

Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтын талаарх нарийвчилсан зохицуулалт:

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг Төсвийн тухай хуулиар голлон зохицуулсан бөгөөд тус хуулийн 27 дугаар зүйлд төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, 27[1] дүгээр зүйлд улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ, 28 дугаар зүйлд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн

төлөвлөлт, 29 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын төсөвлөлт, 29[1] дүгээр зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагын талаар тус тус хуульчилсан.

Хүснэгт 15.Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтын талаарх нарийвчилсан зохицуулалт

Төсвийн тухай хуулийн зүйл	Төсвийн тухай хуулийн хэсэг, заалт	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан огноо	Тайлбар
4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт	4.1.24.“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг[62];	2022.04.22.	Уг заалтын “хөрөнгө оруулалт” гэсний өмнө “төсвийн” гэж, “төсвөөс” гэсний өмнө “улсын болон орон нутгийн” гэж нэмсэн.
10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх	10.1.15.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлах;	2015.02.18.	Энэ заалтыг нэмсэн.
11 дүгээр зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх	11.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.23.улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээний аргачлалыг батлах.	2022.04.22.	Энэ заалтыг нэмсэн.
12 дугаар зүйл.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	12.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.23.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн урьдчилсан үнэлгээг жил бүрийн 02 дугаар сарын 1-нээс 04 дүгээр сарын 1-ний дотор хийж,	2022.04.22.	Энэ заалтыг нэмсэн.

[62] Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэлийн хүрээнд 2022 онд уг заалтыг илүү тодорхой болгож сайжруулсан.

	дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй уялдуулах ажлыг Засгийн газрын түвшинд зохион байгуулна.		
14 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний бүрэн эрх	14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;		
27 дугаар зүйл.Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага	27.1.Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: 27.1.2.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;	2023.07.07.	Уг заалтын “макро” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан” гэж нэмсэн.
	27.1.8.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;	2021.12.24.	Энэ заалтыг нэмсэн.
	27.2.Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх жилийн төсвийн хязгаар нь дараах шаардлагыг хангасан байна: 27.2.2.хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах.		
	27.3.Улсын төсөвт хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг тусгасан төсвийн удирдамжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.		
	27.4.Төсвийн удирдамжид дараах зүйлийг тусгана: 27.4.4.хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага;		
	27.5.Орон нутгийн төсвийн төсөл бэлтгэх нарийвчилсан зааврыг төсвийн	2024.06.05.	Уг заалтын “даргад” гэснийг

	удирдамжид тусган, аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчид хүргүүлнэ.		“дарга, улсын зэрэглэлтэй хотын Захирагчид” гэж өөрчилсөн.
	27.6.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална: 27.6.1.шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;	2022.04.22.	Энэ заалтыг нэмсэн.
	27.6.2.их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ;	2022.04.22.	Энэ заалтыг нэмсэн.
	27.6.3.шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ.	2022.04.22.	Энэ заалтыг нэмсэн.
27[1] дүгээр зүйл.Улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ	27[1].1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд нь энэ хуулийн 11.1.23-т заасан аргачлалын дагуу улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээний нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгсөн төслүүд байна.	2022.04.22.	Энэ хэсгийг нэмсэн.
	27[1].2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын хөрөнгө оруулалтын төслүүдийн урьдчилсан үнэлгээнд оруулах төслийн саналыг энэ хуулийн 11.1.23-т заасан аргачлалын дагуу бэлтгэж, жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	2022.04.22.	Энэ хэсгийг нэмсэн.
	27[1].3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг урьдчилсан үнэлгээний аргачлалын дагуу нэгдсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлно.	2022.04.22.	Энэ хэсгийг нэмсэн.
	28.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.	2015.11.26.	Энэ хэсгийн “эдийн засгийн өсөлтийг” гэснийг “эдийн засаг, нийгмийн хөгжлийг” гэж өөрчилсөн.

28 дугаар зүйл.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт		2021.12.16.	Энэ хэсгийн “урт хугацаанд” гэснийг хассан.
	28.2.Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг дараах журмаар боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ: 28.2.1.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг санал боловсруулах бүх шатанд олон нийтээр хэлэлцүүлсэн байх;	2023.07.07.	Энэ заалтыг өөрчлөн найруулсан.
	28.2.2.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд орон нутгийн иргэдийн саналыг авсан байх.	2023.07.07.	Энэ заалтыг өөрчлөн найруулсан.
	28.3.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг дараах зүйлийг харгалзан тогтооно:	2023.07.07.	Энэ заалтыг өөрчлөн найруулсан.
	28.4.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8, 28.3.12-т заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийнэ.	2023.07.07.	Энэ хэсгийг өөрчлөн найруулсан.
	28.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг энэ хуулийн 28.3.9, 28.3.11-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулна.	2022.04.22.	Энэ хэсгийн “үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчилсөн.

	28.6.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ.	2023.07.07.	Энэ хэсгийн “үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчилсөн.
	28.10.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт төсөв, гадаад зээллэг, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төр, хувийн хэвшлийн түншлэл, Засгийн газрын өрийн баталгаа Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих төсөл, арга хэмжээ хамаарна.	2021.12.16.	Энэ хэсэгт “төр, хувийн хэвшлийн түншлэл” гэж нэмсэн.
		2022.12.09.	Энэ хэсгийн “концессын” гэснийг “төр, хувийн хэвшлийн түншлэлийн” гэж өөрчилсөн.
	28.11.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	2021.12.16.	Энэ хэсгийг өөрчлөн найруулсан.
	29.1.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бэлтгэнэ.	2023.07.07.	Энэ хэсгийн “үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчилсөн.
	29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо,		

29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төсөвлөлт	санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.		
	29.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана:	2024.06.05.	Энэ хэсэгт “Засаг дарга” гэсний дараа “хот, тосгоны Захирагч” гэж нэмсэн.
	29.3.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах;		
	29.3.2.улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах;		
	29.3.3.нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;		
	29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;		
	29.3.5.шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;	2022.11.11.	Энэ заалтыг “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэж өөрчлөн найруулсан.
		2023.07.07.	Энэ заалтын “арга хэмжээг” гэсний дараа “хэрэгжүүлэх

			хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож” гэж нэмсэн.
	29.3.6.тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.	2022.11.11.	Энэ заалтыг нэмсэн.
	29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.		
	29.5.Энэ хуулийн 28.3-т заасан шаардлагыг нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд нэгэн адил мөрдөнө.		
	29.6.Нийт төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөгтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо судалгааг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хийх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль тогтоомжид нийцүүлэн тухайн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнтэй болохыг тогтоосон нөхцөлд төсөвт тусгана.	2021.12.16.	Энэ хэсгийн “энэ хуулийн 28.6-д заасны дагуу” гэснийг “хууль тогтоомжид нийцүүлэн” гэж өөрчилсөн.
	29.7.Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө.		
	29.8.Гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас хамаарч энэ хуулийн 29.7-д заасан нөхцөл байдал үүссэн нь хөрөнгө оруулалтын төсөвт өртгийг өөрчлөх үндэслэл болохгүй.		
	29^{1}.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга	2022.04.22.	Энэ зүйл, хэсгийг нэмсэн.

29[1] дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага	байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.		
	29[1].2.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:		
	29[1].2.1.тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;		
	29[1].2.2.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;		
	29[1].2.3.техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх;		
	29[1].2.4.урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;		
	29[1].2.5.тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх;		
	29[1].2.6.олон нийтээр хэлэлцүүлсэн байх.	2023.07.07.	Энэ заалтыг нэмсэн.
	29[1].3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан үнэлгээг хийж төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад зээл, тусламж зэрэг санхүүжилтийн эх үүсвэрийг эрэмбэлэн тогтооно.	2022.04.22.	Энэ хэсгийг нэмсэн.
	29[1].4.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө		

	оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлнэ.		
	29[1].5.Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг Засгийн газар, Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад зохион байгуулах олон нийтийн хэлэлцүүлэгт салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.	2023.07.07.	Энэ хэсгийг нэмсэн.
31 дүгээр зүйл.Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл	31.1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна: 31.1.4.эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;		
	31.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана: 31.4.3.шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо;		
	31.4.4.нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй болсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах санал, тооцоо;		

Дээрхээс үзэхэд Төсвийн тухай хуулийн 27, 27[1], 29, 29[1] дүгээр зүйлээр төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг голлон зохицуулсан. Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах дээрх зохицуулалтад нийт 44 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд 2022.04.22, 2022.11.11 болон 2023.07.07-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт нь зарчмын ач холбогдол бүхий зохицуулалт байна.

Төсвийн тухай хуульд УХОХ-ийн төлөвлөлтийн талаар заасан бөгөөд УХОХ нь улсын таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх баримт бичиг болох талаар ХБТТУтХ-ийн 4.1.12-т “УХОХ гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг ойлгоно.” хэмээн тусгасан.[63] Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд урьдчилсан үнэлгээ хийх ба уг аргачлалыг Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар баталсан.[64]

[63] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15403
[64] publicinvestment.gov.mn.law

Төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилна. Гэтэл улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь төсвийн төслийг УИХ-д өргөн барьсны дараа батлагдаж байна. Жишээ нь; УИХ-ын 2024.10.18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор[65] “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” батлагдсан. Засгийн газраас Монгол Улсын төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор УИХ-д өргөн мэдүүлэх хуультай. Эндээс үзэхэд төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх боломжгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхөд баримтлах эрэмбийг Төсвийн тухай хуулийн 27.6-д төслийн хугацаа, шинж чанараар нь хуульчилжээ.

Бусад хуулийн төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах зохицуулалт:

Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой зарим харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулдаггүй болохыг танилцуулсан бөгөөд төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцаанд үйлчилдэг бусад хуулийн зохицуулалтыг судалж үзлээ.

- ТТБтХ-аар нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоож, эрдэс баялгийн орлогоор эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой харилцааг зохицуулдаг;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмыг тогтоосон. Уг хуулийн 13.3-т улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний, 13.4-т улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгахыг хориглох зүйлсийг хуульчилсан. Тухайлбал; хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ зэрэг;
- ТБОНӨХБАҮХАтХ-аар төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах буюу тендер шалгаруулалт зохион байгуулах, захиалагч шийдвэр гаргах, тендер шалгаруулалтын арга, гэрээний үүргийн гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны удирдлага, гомдол гаргах, түүнийг шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулдаг;

[65] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142249144031&showType=1

- ӨУтХ-аар өрийн зохистой түвшнийг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, зээллэг хийх замаар өр үүсгэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулдаг. ӨУтХ-ийн 6.4.4-т гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах, 24.1.3-т Засгийн газар, яам, тэдгээрийн харьяа байгууллагын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж болохоор тусгасан;
- ТХХТтХ-аар нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт ТХХТ-ийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулдаг. Улмаар, уг хуульд ТХХТ хэрэгжүүлэх салбарыг тодорхойлж, санхүүжилтээс нь хамааран түншлэлийг 3 төрлөөр хэрэгжүүлж болох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээ, түншлэл хэрэгжүүлэх талаар нарийвчлан тусгасан;
- МУЗЗНДНТУтХ-аар орон нутгийн чиг үүрэг болон нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийг зааглан хуульчилсан. Орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсвөөс, харин нэгжийн удирдлагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээний зардлыг төрөөс хариуцна. Тухайлбал; уг хуулийн 20.1.18-д зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар нь орон нутгийн чиг үүрэгт хамаарна. Иймд эдгээр барилга байгууламжийн засварын зардлыг орон нутгийн төсвөөс, их засварын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ;
- МУНУХЭЗБтХ-аар нийслэл хотын тусгай болон бусад чиг үүргийг тогтоосон. Уг хуулийн 11.2-т зааснаар нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өмчийг төрийн нийтийн зориулалттай өмч болон төрийн өөрийн өмч хэмээн ангилж, төрийн өмч (төрийн өөрийн өмч)-ийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг хуульчилсан. Тодруулбал; төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон өмч хөрөнгийг хэрхэн төрийн болон орон нутгийн өмчид олж авах, үнэлэх, бүртгэх, эзэмших, ашиглах, түрээслүүлэх, худалдах, устгахтай холбоотой харилцааг зохицуулна;
- Барилгын тухай хуулиар барилгын ажлын төрөл, барилга байгууламжийн ангилал, барилгын үйл ажиллагааны үндсэн шаардлагыг тодорхойлохын зэрэгцээ барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга байгууламжийн төсөв, зураг төсөлд магадлал хийх, хяналт тавих, оролцогч талуудын эрх, үүргийг хуульчилсан;

- Эрчим хүчний тухай хуулийн 9.1.15, 21.2.9, 25.1.9-д хөрөнгө оруулалттай холбоотой харилцааг зохицуулсан. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 3-5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа тусгай зөвшөөрөл олгогчид мэдэгдэх, бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авах үүрэгтэй бөгөөд Зохицуулах хороо уг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх бүрэн эрхтэй байна;
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.3.2, 7.4 дэх хэсгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр эрчим хүч үйлдвэрлэгчид цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгох зохицуулалт хамаарахгүй гэж тусгасан;
- Авто замын тухай хуулийн 6 дугаар зүйлд авто замын байгууламжийн санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэр байна гэж заасан. Уг хуулийн 9, 10 дугаар зүйлд авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Засгийн газраар батлуулах, Засгийн газар авто замын салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгасан.

Түүнчлэн, бусад хуулиар төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зарим харилцааг зохицуулдаг. Тухайлбал; Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 46.8 дахь хэсэгт шүүхийн төсвийг боловсруулж батлах тусгай журам тогтоосон бөгөөд Улсын дээд шүүх өөрийн, Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх, Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, Засгийн газар шүүхийн төсвийн төслийг буруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгах, УИХ жилийн төсвийг хэлэлцэн батлахдаа Улсын дээд шүүх болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэхээр заасан.

II шатлал.Төсвийн хөрөнгө оруулалтын захиргааны хэм хэмжээний акт:

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг шинэчлэн баталсан.[66] Уг журамд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрт улсын төсөв, орон нутгийн төсөв, улсын төсвөөс эргэн төлөгдөх концесс,

[66] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760272322161&showType=1

төсвөөс санхүүжих нөхцөлтэй ТХХТ болон Засгийн газрын тусгай сан хамаарах талаар тусгасан. Улмаар, төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч эрх бүхий этгээдийн чиг үүрэг, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, тавигдах шаардлага, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагналт, ил тод, нээлттэй байдал, ашиглалт, үр өгөөж тооцох болон цахим системийн удирдлага, зохион байгуулалтын талаар зохицуулсан.

Түүнчлэн, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”[67], Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”[68], Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын төсөв зохиох дүрэм”[69], 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”[70], Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 256 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм”[71], Эрчим хүчний сайдын 2024 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засварын ажлын төсөв зохиох журам”[72] гэх мэт захиргааны хэм хэмжээ хамаарна.

III шатлал.Төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээний арга зүй, удирдамж:

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар[73] “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал”, “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ыг баталж, улмаар үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт, оноо өгөх аргачлалыг тусгасан. Уг тушаалаар батлагдсан журам, аргачлалд Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал гаргах, бэлэн байдлыг үнэлэх процессыг нарийвчлан тусгаж, төслийг 10 шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх, оноо өгөх, сонгох аргачлалыг тогтоосон.

Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар [74] улсын хөрөнгө оруулалтын төслийг урьдчилан үнэлэх, “тэнцсэн”, “тэнцээгүй”, “тодорхойгүй” гэсэн үнэлгээ өгөх талаар зохицуулж, урьдчилсан үнэлгээний асуулгын маягтыг баталжээ.

---

[67] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12862
[68] https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123489780751
[69] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15143
[70] https://legalinfo.mn/mn/detail?lawId=12276
[71] https://legalinfo.mn/mn/detail?lawId=14607
[72] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17350509327631
[73] https://publicinvestment.gov.mn/law/1000?url=/api/file/downloadFile/admin/
[74] https://publicinvestment.gov.mn/law/1020?url=/api/file/downloadFile/pimis/

Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтын талаарх зохицуулалтыг Дэлхийн банкны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатаар нягталж үзвэл:

1. Хөрөнгө оруулалтын стратеги, бодлого холбоотой зарим харилцааг Төсвийн тухай хуулийн 27[1] дүгээр зүйл, Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”-аар зохицуулж байна;
2. Төслийн албан ёсны үнэлгээ (урьдчилсан зураг төсөл, ТЭЗҮ, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, төслийн техникийн хүчин чадал, цар хүрээ хүрээ зэргийг багтаасан)-тэй холбоотой харилцаанаас УХОХ-ын төслийн хувьд Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тусгасан бөгөөд бусад хөрөнгө оруулалтын талаар Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй;
3. Төслийн хөндлөнгийн үнэлгээтэй холбоотой харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулаагүй;
4. Төслийн сонголт ба төлөвлөлт (төслийн зохистой байдал, ач холбогдол, зардал, санхүүжилт зэргийг шалгах)-тэй холбоотой харилцааг Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй бөгөөд “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” болон Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлал”-аар зохицуулж байна;
5. Төслийн хэрэгжилтийн харилцааг Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй “Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар зохицуулдаг;
6. Явцын тохируулга, сайжруулалттай холбоотой харилцааг Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй;
7. Хөрөнгийн удирдлагатай холбоотой харилцааг Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулдаг;
8. Төслийн хяналт, тайлагналтын харилцааг Төсвийн тухай хуульд тодорхой тусгаагүй бөгөөд “Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар зохицуулдаг.

Дээрхээс дүгнэхэд, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатад тусгагдсан зарим харилцааг Төсвийн тухай хуулиар, зарим харилцааг журмаар зохицуулдаг бөгөөд зарим харилцааны талаар Төслийн тухай хуульд тусгаагүй. Өөрөөр хэлбэл; төсвийн хөрөнгө оруулалтын харилцаа нь нэгдмэл цогц байдлаар зохицуулагдаагүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын суурь харилцааг Төсвийн тухай хууль болон Засгийн газар, Сангийн сайдын батлсан дээр дурдсан журмаар зохицуулдаг нь төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн нэгдмэл орчин байхгүйг илэрхийлнэ. Энэ нь төрийн үйл ажиллагаанд хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчим, иргэний Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлэх үндсэн үүрэг, нийтээр дагаж мөрдөх зохицуулалтыг журмаар бус зөвхөн ард түмнээс мандат авсан парламент хуулиар тогтоох тухай УИХ-ын бодлогод нийцэхгүй юм. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг олон тооны журмаар бус хуулиар нэгтгэн зохицуулах нь УИХ-ын бодлого, хүн төвт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн үзэл санаанд бүрэн нийцнэ.

Нөгөөтээгүүр, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх хөгжлийн бодлогын баримт бичиг болон төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчинд шууд хамаарахгүй хэдий ч дурдах ёстой нэг баримт бичиг нь УИХ-ын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө”[75] юм. УИХ үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг дэмжсэн, цаг үеийн шаардлага, нийгмийн амин чухал эрэлт, хэрэгцээг тооцсон шийдвэр гаргана хэмээн стратегийн зорилгоо тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд хууль тогтоомж нь Монгол Улсын хөгжлийн бодлогын уялдаа, залгамж чанарыг хангасан, харилцан туршлага, судалгаа, нотолгоо, хууль хэрэглээний практикт суурилсан байх зорилт дэвшүүлсэн.

Түүнчлэн, эрх бүхий албан тушаалтны нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг үндэслэн хүчингүй болгох, захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон хуулийг хүчингүй болгох, шинэчлэн найруулах, эрх олгосон заалтад агуулгын өөрчлөлт оруулах тохиолдолд захиргааны хэм хэмжээний актын төслийг хамтад нь боловсруулах тухай Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.3, Захиргааны ерөнхий хуулийн 60.6 дахь хэсгийг чанд мөрдөж ажиллах талаар Ерөнхий сайдын 2023 оны 193 дугаар захирамж, Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд тусгасан болно.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврын 3.5-д “Төсвийн хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр нарт” даалгаж шийдвэрлэсэн.

Бусад хуулийн зохицуулалт: Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн зохицуулалтад нийтлэг зохицуулалттай хууль, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд шууд хамаарах болон шууд бус хамаарах хуулиуд байгаа талаар өмнөх хэсэгт танилцуулсан. Эдгээрээс гадна “төсвөөс санхүүжүүлнэ”, “төсөвт тусгаж

[75] https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333367826241&showType=1

санхүүжүүлнэ” зэрэг хэм хэмжээ агуулсан нэлээд хуулиуд байна.[76] Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг тодорхой бус, ойлгомжгүй болгоход нөлөөлнө.

Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн нэгдмэл орчин байхгүй буюу “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай” анхдагч хуулийн төсөл боловсруулж батлах хэрэгцээ, шаардлага байгаа өнөөгийн нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт зэрэг харилцааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах шаардлагатай. Тодруулбал, аль ч хуульд “төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ”, эсхүл түүнтэй адил агуулга бүхий хэм хэмжээ байсан ч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, төлөвлөхөд нэгдсэн аргачлал, зохицуулалт баримтлах нь зүйтэй.

Дүгнэлт:

1. Төсвийн тухай хуулиар улсын төсөв, орон нутгийн төсөв болон ОНХС-гаар хийгдэх хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой харилцааг зохицуулдаг бөгөөд гадаад зээл, тусламж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүжилт болон ТХХТ-ээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарах харилцааг тодийлөн зохицуулахгүй байна.
2. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны чухал үе шат нь төлөвлөлт байдаг. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх харилцааг “ерөнхийдөө” Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний актаар, төлөвлөлт, холбогдох бусад харилцааг салбарын хууль, журмаар зохицуулж байна.
3. Дэлхийн банкны зөвлөсөн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатанд нийцсэн хууль, эрх зүйн нэгдмэл орчин шаардлагатай байна.

1.1.3.Төрийн, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын дүгнэлт, санал, зөвлөмж

1.1.3.1.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж

ТТБЗ нь 2018 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.[77] ТТБтХ-д 2023.07.07-ны өдөр зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд ТТБЗ, түүний үйл ажиллагааг зохицуулсан 16[1] дүгээр зүйл нэмэгдсэн.[78] Улмаар, ТТБтХ-д 2024.06.05-

[76] Бусад хуулийн жагсаалттай тандан судалгааны тайлангийн хавсралт № 5-аас танилцана уу.
[77] Legalinfo.mn, эрх зүйн мэдээллийн цахим сан, https://legalinfo.mn/mn/detail?lawId=13058, УИХ-ын 2017 оны 83 дугаар тогтоолоор ТТБЗ-ийг байгуулж, түүний дүрмийг баталсан.
[78] ТТБтХ-ийн 2023.07.07-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу УИХ-аас 2024.01.11-ний өдөр ТТБЗ-ийн гишүүдийг томилсон.

ны өдөр өөрчлөлт оруулан ТТБЗ-ийн бүрэн эрх, үйл ажиллагааг дараах байдлаар тодорхой болгосон.

ТТБтХ-ийн 16[1].5.2-т “Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, Монгол Улсын тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт гаргах”, 16[1].5.3-т “Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”, 16[1].5.4-т “Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу төсөвтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж, гаргаж танилцуулах” гэж өөрчилсөн.

ТТБЗ-өөс Монгол Улсын төсвийн төсөлд тусгасан төсвийн хөрөнгө оруулалтын талаар 2023-2025 онд өгсөн дүгнэлтээс голлох хэсгийг танилцуулъя.[79]

Монгол Улсын 2023 оны төсөвт тухайн онд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ тусгаагүй бөгөөд олон жил дамнан хэрэгжиж буй төслийг дуусгах, УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан материалын үнийн өсөлтийн зөрүүг төсөвт бүрэн тусгах чиглэлд төвлөрсөн жил байв. ТТБЗ уг төсвийн төсөлд сайшаалтай үнэлгээ өгсөн нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга батыг баримталсан бодлого байсныг илтгэнэ.

2024 оны төсвийн хөрөнгө оруулалт 3,853.6 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 58 хувийг шинэ төсөл, арга хэмжээнд, 2025 оны санхүүжилт 3,231.2 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 37 хувийг шинэ төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн. Энэ нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслийн хэмжээ өссөн болохыг харуулна.

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт: Засгийн газраас нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалтад түлхүү анхаарч байгаа нь сайн боловч хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, орлого олох төслийг нэмэгдүүлэх шаардлагатай. ТТБЗ-өөс “... Аливаа төслийг урьдчилан сайтар судалсны үндсэн дээр түүнийг ямар эх үүсвэрээс, ямар арга замаар санхүүжүүлэх нь хамгийн оновчтой болохыг тодорхойлдог. Бүхий л төслийг улсын төсвөөс, гадаад зээлээр санхүүжүүлнэ гэж төлөвлөх нь оновчтой бус бөгөөд зарим томоохон мега төсөлд төсвийн болон гадаад зээллэгийн санхүүжилт ашиглахаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө

[79] ТТБЗ-өөс 2023, 2024, 2025 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй тандан судалгааны хавсралт № 3-аас дэлгэрүүлэн танилцана уу.

оруулалтыг оролцуулсан холимог санхүүжилтийн аргыг (Blended finance) хэрэглэх нь оновчтой байдгийг анхаарах...” гэж дүгнэсэн.[80]

Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт: Олон төслийг нэгэн зэрэг эхлүүлж, жил дамнан бүтээн байгуулах бус, цөөн тооны ач холбогдол өндөртэй төсөлд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм.[81]

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үнэлгээ: Хөрөнгө оруулалтыг үнэлж эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь Засгийн газар, Сангийн яамны баталсан журмын хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь сул талтай байна. Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явц нь ЭЗХЯ, Сангийн яам, ТЕЗ-ийн оролцоотой хийгддэг боловч үүнд ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдаж байна. Мөн төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төслийг тусгахдаа холбогдох дүрэм, журмыг баримталдаг эсэх нь тодорхойгүйгээс гадна хөгжлийн бодлого, УХОХ-т тусгагдаагүй, зураг төсөл, ТЭЗҮ нь гараагүй, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй төслийг улсын төсөвт тусгах асуудал байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Иймд хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлж эрэмбэлэх, сонгох одоогийн хууль, дүрэм журмыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгсөн.[82]

Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин: Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн цогц орчныг бүрдүүлэхийн тулд олон улсын сайн туршлагад тулгуурлан “*Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай*” хуулийг шинээр боловсруулах нь зайлшгүй чухал бөгөөд энэхүү шинэ хууль нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эрэмбэлэлт, санхүүжилтийн зохицуулалтыг тодорхой болгож, төслийн үр ашгийг сайжруулах, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох ач холбогдолтой хэмээн үзэж байгаа талаар ТТБЗ-ийн дүгнэлтэд онцгойлон тусгасан.[83]

ТТБЗ-ийн сүүлийн 3 жилийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөлд өгсөн санал, зөвлөмжөөс үзэхэд шинэ хөрөнгө оруулалтын үр ашгийг бодитой үнэлэх, дээшлүүлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх аргачлал дутмаг болохыг санууллж байна. Засгийн газар болон Сангийн яамны дүрэм, журам нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, төлөвлөлтийн оновчтой байдлыг бүрэн хангаж чадахгүй байгаа тул хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн.

---

[80] ТТБЗ-ийн “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”, УИХ-ын цахим хуудас, https://www.parliament.mn/nn/62969/

[81] ТТБЗ-ийн “Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”

[82] ТТБЗ-ийн “Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт”, УИХ-ын цахим хуудас, https://www.parliament.mn/nn/62969/

[83] https://www.parliament.mn/nn/63556/

Дүгнэлт: ТТБЗ төслийн урьдчилсан судалгааг сайн хийх, үүний үндсэн дээр төслийг санхүүгийн ямар эх үүсвэрээр, ямар арга замаар хэрэгжүүлэх нь оновчтой болохыг тодорхойлох, төслийг ач холбогдлоор нь эрэмбэлэх, хөндлөнгийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, олон нийтийн оролцоог хангах, төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авахыг чухалчилсан байна.

1.1.3.2.Үндэсний Аудитын газрын дүгнэлт, зөвлөмж

УАГ-аас Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн нэмэгдэл буюу нэмэлт санхүүжилт зэрэгт 2021-2024 онд өгсөн улсын төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах голлох дүгнэлтийг танилцуулъя.[84]

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт: Санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр гурван жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээнд төсөв батлагдахгүй орхигдох эрсдэлийг үүсгэж байна. Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэн, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх.[85]

УАГ-ын 2023 оны тайланд “... Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөхгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашиглахгүй байна.”, “... Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, эрэмбийг баримтлаагүйгээс төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөхгүй байгаа нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна ...” гэж тусгасан.

Захиалагч, зохиогчийн хяналтын зардал, зураг төслийн магадлал:

- Төсөвт өртөг, нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих хяналт хангалтгүй байгаад ТЕЗ нар анхаарч, үе шатны хяналтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, захиалагч болон зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцох;
- Барилга байгууламжийн ажилд үе шатны хяналт гүйцэтгэж байгаа байгууллагын мэргэжлийн хүний нөөцийн хангамж, ур чадвар, мэргэшсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх;

[84] УАГ-аас 2021-2024 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжтэй тандан судалгааны хавсралт № 3-аас дэлгэрүүлэн танилцана уу.
[85] УАГ-ын 2024 оны тайлан

- Барилга байгууламжийн үе шатны ажилд хяналт тавих үйл ажиллагаа, захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маягтгүй, нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгахгүй байгаагаас захиалагч, гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү үүсэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд илүү, дутуу дүнгээр тусгах эрсдэлийг арилгаж, нэгдсэн загварт оруулж, баталгаажуулах.

Норм, нормчлолын сан:

- Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо норм, нормативын зардлыг холбогдох байгууллагад шилжүүлээгүй;
- Барилгын салбарт мөрдөж байгаа норм, дүрмийн шинэчлэл хийгдэхгүй хугацаа алддаг, цалин, тариф, үнийн индекс, нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ хуучирсан зэргээс шалтгаалан барилга угсралтын ажил удааширч зураг төслийн дагуу гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэж байна. Норм, нормативын санд төвлөрсөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй үлдэгдэлтэй;
- Барилга байгууламжийн гүйцэтгэлд тулгардаг нийтлэг асуудалд үндэслэн зураг төслөө өөрчлөх, чанаргүй гүйцэтгэх шалтгаан нөхцөлийг судалж, холбогдох норм, дүрмийг шинэчлэх шаардлага үүссэн;
- Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд гарч байгаа нийтлэг зөрчил, асуудалд судалгаа, шинжилгээ хийж, барилгын норм, дүрэм, стандартыг өөрчлөн шинэчлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах, норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах гэжээ.

ТЭЗҮ, зураг төсөл: ҮАГ-ын 2023, 2024 оны тайланд барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгамдаж байгаа асуудалд судалгаа, шинжилгээ хийж, норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох гэж дүгнэсэн.

Төсөвт өртгийн нэмэгдэл: ҮАГ-ын 2022 оны тайланд төсөвт өртгийн нэмэгдлийн суурь нь магадлал бөгөөд төслийн байршил өөрчлөгдөх, барилга байгууламжийн үндсэн хийцлэлд өөрчлөлт орох, төлөвлөсөн хугацаанд ажил эхлээгүй зэрэг шалтгааны улмаас төслийн төсөвт өртгийг шинээр магадлах нөхцөл үүсдэг гээд, төсөл нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталдаг нь цаашид төсөвт өртөг нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог хэмээн үзсэн.

Хууль, эрх зүйн орчин: Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд барилгын материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатал гарч төсөл бүрэн дуусахгүй, хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүссэн зэрэг нь цаашид энэ тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх хууль зүйн орчныг тодорхой болгох, 2022 онд хариуцлагыг нэмэгдүүлэх, захиалагч болон зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцох, 2024 онд цахим систем нэршлээр төсвийн төсөлд тусгасан төсөл болон ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох хэмээн дүгнэсэн.

ОНХС: ҮАГ-аас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, 21 аймаг, нийслэлийн ОНХС-гийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийжээ.[86] Улсын төсөвт 2023 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 298,478.6 сая төгрөгөөр баталсан. Улмаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого өссөнтэй уялдуулан 2023 оны 6 дугаар сард сангийн хөрөнгийг 71,460.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон. Түүнчлэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас 174,460.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон. Ингэснээр тухайн онд нийт 544,390.0 сая төгрөгийг санд төсөвлөсөн бөгөөд 94.3 хувь нь бүрдсэн болно.

Тайлант хугацаанд нийт 8,672 төсөл, арга хэмжээг 521,864.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулснаас 408,507.6 сая төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 105,238.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар 2023 онд нийт 162,768.3 сая төгрөгийн зөрчил илэрчээ. Үүнд аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас 550.8 сая төгрөгийн 62 төлбөрийн акт тавьжээ. Мөн 76,245.0 сая төгрөгт албан шаардлага, 85,908.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, 63.8 сая төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог бүрэн хангаагүй, төсөвт өртгийг хэт жижиглэснээр тендер оролцогчгүй болох, ажил он дамжих, хугацаа алдах сөрөг нөлөөлөл байна гэж үзжээ. Түүнчлэн, удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу болон огт оруулаагүй байхад сангаас санхүүжилт олгох зөрчил давтагдсаар байна. Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд төсөл, арга хэмжээний үр дүн, үр өгөөжийг урьдчилан тооцолгүйгээр урсгал шинжтэй зардалд төлөвлөн зарцуулсан нь сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан. Захиалагчаас төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, үр өгөөж, холбогдох тооцоо судалгааг бодитой хийгээгүйгээс зарим аймагт чанаргүй, ашиглалтгүй хөрөнгө бий болж, орон нутагт ажлын байр нэмэх, иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, тэдний орлого нэмэгдэх боломж алдагдсан. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах

[86] https:// maudit.mn/?p=32474

байгууллагын хяналт сулаас хөрөнгө эзэнгүйдэж, эвдэрч гэмтэн ашиглалтгүй болж хөрөнгийг дахин засаж сэлбэх, урсгал засвар хийх шаардлага үүсэж төсвийн зардлыг нэмэгдүүлсэн байна.

Үүнтэй, холбоотойгоор иргэдийн саналгүй, эсхүл өргөн мэдүүлсэн төсөл, арга хэмжээг өөрчлөн баталсан иргэдийн хурлын байгууллагуудад хариуцлага тооцох, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос ОНХС-д олгох шилжүүлэг тооцох аргачлалыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, сангийн удирдлага, мэдээллийн системд өгч буй иргэдийн саналыг ил тод бүртгэх, сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг бүрэн арилгах хүртэл санхүүжилтийг олгохгүй байх арга хэмжээ авах зөвлөмжийг Засгийн газар, Сангийн яам болон бүх шатны ИТХ, Засаг даргад өгсөн байна.[87]

Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө: УАГ-ын “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-д 194 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 13.9 их наяд төгрөгийн хөрөнгө шаардлагатай байхаар баталж, гүйцэтгэлээр нийт 6.4 их наяд төгрөг зарцуулсан байна гээд дараах гол дүгнэлтийг хийжээ.[88] Үүнд:

- 194 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52.1 хувь гэж дүгнэсэн;
- Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зарим төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг оновчтой тодорхойлоогүй, улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн Төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй, мөн хуульд заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлага, ХБТТУтХ-д заасан төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчмыг хангаагүй, зарцуулсан хөрөнгийг үнэн зөв, бодитой тайлагнаагүйгээс нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хөрөнгийн үнэ цэнийг бүрэн бий болгож чадаагүй;
- Зарим төсөл, арга хэмжээ ТЭЗҮ, зураг төсөлгүй, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй зөрчлүүд давтагдан гарч байгаагаас бодлогын хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй;
- Бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах, бодлогын хувилбарыг урьдчилан төлөвлөж чадаагүй, салбарын онцлогт нийцсэн үзүүлэлт, индекс, гүйцэтгэлийн чанарын стандарттай нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалгүй нь тухайн салбарын бодлогын үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг тооцож чадахгүй байх эрсдэлтэй.

[87] https://audit.mn/?p=32474
[88] https://www.facebook.com/undesniiauditingazar/photos

Таван жилийн үндсэн чиглэл: ҮАГ-аас “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар 2021-2024 онд нийт 21.7 их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхой бус гэдгийг онцолж, хэрэгжилт 67.7 хувь гэж дүгнэсэн. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 2021-2025 онд хэрэгжүүлэх 150 төсөл, арга хэмжээ, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийх, тэргүүлэх чиглэл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаа бодитой төлөвлөн, салбар бүрийн онцлогт тохирсон аргачлал бий болгох зөвлөмж өгчээ.[89]

Дүгнэлт: ҮАГ-аас төсвийн хөрөнгө оруулалтыг илүү үр ашигтай, ил тод, хариуцлагатай байх зорилгод чиглүүлэх, хөрөнгө оруулалтын явцад гарсан алдаа, дутагдлыг засах, сайжруулах талаар тодорхой арга хэмжээ авах, төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, шаардлагатай тохиолдолд хууль, эрх зүйн орчныг сайжруулахыг зөвлөсөн.

1.1.3.3.Олон улсын байгууллагын санал, зөвлөмж

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үйл ажиллагаанд дараах 2 байгууллагаас олон улсын үнэлгээ хийдэг. Үүнд:

1.ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ”;

2.Дэлхийн банкны “Төсвийн зарлага, удирдлагын үнэлгээ” (5 жил тутамд).

Сангийн яамнаас олон улсын байгууллагын зөвлөмж, төсвийн хөрөнгө оруулалтын үнэлгээг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлснээр зарим үр дүн гарсан.

Хүснэгт 16.ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ /2016, 2023 он/


2016 PIMA						2023 PIMA				
		Үе шат	Зохицуулалт	Хэрэгжилт				Үе шат	Зохицуулалт	Хэрэгжилт
А.Төлөвлөлт	1	Төсвийн зарчим ба шаардлага	Дунд	Муу		А.Төлөвлөлт	1	Төсвийн зарчим ба шаардлага	Дунд	Муу
	2	Үндэсний болон салбарын төлөвлөлт	Дунд	Дунд			2	Үндэсний болон салбарын төлөвлөлт	Дунд	Дунд
	3	Төв, орон нутгийн уялдаа	Дунд	Дунд			3	Байгууллага хоорондын уялдаа	Дунд	Дунд
	4	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Муу	Муу			4	Төслийн үнэлгээ	Дунд	Дунд
	5	Дэд бүтцийн компанийн зохицуулалт	Дунд	Дунд			5	Дэд бүтцийн бусад санхүүжилт	Сайн	Дунд
С.Х.Э	6	Олон жилийн төсөвлөлт	Дунд	Муу		С.Х	6	Олон жилийн төсөвлөлт	Дунд	Муу

[89] ҮАГ-ын цахим хуудас, https://audit.mn/?p=32222

	7	Төсвийн иж бүрэн байдал	Дунд	Муу			7	Төсвийн иж бүрэн, нэгдмэл байдал	Дунд	Муу
	8	Төсвийн нэгдмэл байдал	Дунд	Дунд			8	Хөрөнгө оруулалтын төсөвлөлт	Дунд	Дунд
	9	Төслийн үнэлгээ	Дунд	Муу			9	Засвар үйлчилгээний санхүүжилт	Дунд	Муу
	10	Төслийн сонголт	Дунд	Муу			10	Төслийн сонголт	Сайн	Дунд
	11	Хөрөнгө оруулалтын хамгаалалт	Дунд	Дунд			11	Худалдан авах ажиллагаа	Сайн	Дунд
	12	Санхүүжилтийн олдоц	Муу	Муу			12	Санхүүжилтийн олдоц	Сайн	Сайн
	13	Төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал	Сайн	Сайн			13	Багцын удирдлага, хяналт	Дунд	Дунд
	14	Төслийн хэрэгжилтийн удирдлага	Муу	Муу			14	Төслийн хэрэгжилтийн удирдлага	Сайн	Дунд
	15	Төрийн өмчийн хөрөнгийн хяналт-шинжилгээ	Сайн	Сайн			15	Төрийн өмчийн хөрөнгийн хяналт-шинжилгээ	Сайн	Сайн

ОУВС-гийн 2016 оны үнэлгээгээр зохицуулалтын 3, хэрэгжилтийн 8 үзүүлэлт, нийт 11 үзүүлэлтэд “муу” үнэлгээ авсан бол 2023 оны үнэлгээгээр зөвхөн хэрэгжилтийн 4 үзүүлэлтэд “муу” үнэлгээ авсан.

Зураг 18.ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний үр ашгийн үзүүлэлт” /2016, 2023 он/



ОУВС-гаас 2023 оны тайланг 2016 оны тайлантай харьцуулаад төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн зөрүү 14 хувиар сайжирсан гэж дүгнэсэн. Дэлхийн банкны 2021 оны 3 үр дүн, 7 тулгуур багана, 31 шалгуур үзүүлэлт, 94 хэмжүүр бүхий PEFA үнэлгээгээр “B” үнэлгээ авсан байна.

ОУВС-гийн техник туслалцааны хүрээнд 2016, 2023 он, Дэлхийн банкны 2021 оны үнэлгээний тайлангаас төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах дүгнэлт, зөвлөмжийг төсөл, арга хэмжээний үе шатаар түүвэрлэн судалсан.[90]

[90] Олон улсын байгууллагын дүгнэлт, зөвлөмжтэй олон улсын харьцуулсан судалгааны тайлангаас дэлгэрүүлэн танилцана уу.

ОУВС-гийн 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл - техникийн туслалцааны тайлан”-д улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл явц болон Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр дүнг сайжруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх дараах 5 зөвлөмжийг өгсөн. Үүнд:

1. Төсвийн хялбаршуулсан дүрмийг баталж, төсвийн хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар төсвийн хариуцлагыг бэхжүүлэх;
2. Төсвийг гурван жилийн хугацаанд төлөвлөхийн тулд дунд хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж төсвийг боловсруулах. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг төсвийн үйл явцын эхэн үед улс төрийн түвшинд тохиролцон нөөцийн хуваарилалтыг чиглүүлнэ. Олон жилийн төсвөөр батлагдсан томоохон төслийг УХОХ-т шинэчлэн тусгах;
3. Төрийн өмчит томоохон компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төсвийг ЭЗХЯ болон Сангийн яамаар хянуулж, хэлэлцүүлэх журам тогтоож, төрийн өмчит компанийн удирдлага, хяналтыг сайжруулах. Төрийн өмчит компанийн санхүүгийн гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд хийсэн дүн шинжилгээг олон нийтэд нээлттэй, ил тод нийтлэх;
4. Төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгон шалгаруулах зохицуулалтыг боловсронгуй болгох замаар төсөвт тусгах төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явцын чанарыг дээшлүүлэх. Бүх томоохон төсөл сахилга баттай байхын тулд тэдгээр нь санхүүжилтийн бүх эх үүсвэр (дотоод, гадаад, ТХХТ)-ээр хэрэгжих байсан ч улсын бүх хөрөнгө оруулалтад хамаарна. Мега төсөл, тусгай зориулалтын хөрөнгийн төсөл болон санхүүжилтийн эх үүсвэрийн дүн шинжилгээнд нийт зардал, эрсдэлийг бүрэн тусгахын тулд нэмэлт үнэлгээ хийх, үнэлгээний шаардлага, сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах боломжтой;
5. Төслийн хэрэгжилтийн хяналт, үр дүнгийн үнэлгээ, явцын тохируулга, дахин хуваарилалт зэрэг төслийн хяналтын шинэчилсэн зохицуулалтыг Сангийн яамаар дамжуулан бий болгох. Эдгээр зохицуулалтын хэрэгжилт нь төслийн удаашралт, төсөвт өртгийн нэмэгдлийн давтамж, хамрах хүрээг хязгаарлахад тусална.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслийн үр өгөөж хангалтгүй нь төлөвлөлт муутай холбоотой бөгөөд ямар арга хэмжээ авахыг олон улсын байгууллагаас дараах байдлаар зөвлөсөн. Үүнд:

- Төлөвлөлтийг улсын дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх, ТЕЗ, орон нутгийн төсвийн захирагч, улсын төсөв хоорондын уялдааг хангах;[91]
- Төлөвлөлтийг яамдын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэх;[92]

[91] ОУВС, 2023, “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл-Техникийн туслалцааны тайлан”
[92] Дэлхийн банк, 2021, “Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлага- Үнэлгээний тайлан”

- Монгол Улсын нийтэд чиглэсэн хөрөнгө оруулалт нь хэд хэдэн эх үүсвэрээс санхүүждэг боловч эдгээрийг хөрөнгө оруулалтаар нь ангилан эрэмбэлэх тодорхой тогтолцоо байхгүй;[93]
- УХОХ нь дунд болон урт хугацааны санхүүгийн менежменттэй уялдаж байгаа эсэх, эсхүл тохиромжтой эсэхийг Сангийн яам хэрхэн тодорхойлох зохицуулалт байхгүй. Улсын хөгжлийн төсөл боловсруулах зохицуулалт хангалтгүй байна.[94]

Дүгнэлт: ОУВС, Дэлхийн банкны үнэлгээгээр Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээ тодорхой хэмжээнд ахисан болно..

Олон улсын байгууллагаас төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үнэлгээ, сонголт, хэрэгжилт, тохируулга, зохицуулалт болон хяналт тайлагналтын үе шат бүрд дүгнэлт зөвлөмж өгсөн. Эдгээр дүгнэлт зөвлөмжөөс гол хэсгийг танилцуулъя:

1. Төлөвлөлтийг хөгжлийн бодлогод нийцүүлэх, төлөвлөлтийг Дэлхийн банкны тодорхойлсон үе шатаар хийх;
2. Бүх төслийг үнэлгээний аргачлалаар үнэлсэн байх;
3. Төслийн ангилал, төрөл, байршил зэрэгт тохирсон үнэлгээний ялгамжтай аргачлал боловсруулж хэрэгжүүлэх;
4. Төсөлд эрсдэлийн үнэлгээ, үүн дотроо уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээ хийх;
5. ТЭЗҮ-ийн талаар стандарттай болох;
6. Үнэлгээ хийгдсэн боловч сонгогдоогүй төслийг дараа жилийн төсөвт тусгах төслөөс сонгохдоо давуу эрх олгох;
7. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан албан хаагчдад шалгуур тавих, тэднийг сургаж мэргэшүүлэх;
8. Төслийн хэрэгжилтийн хяналт, гүйцэтгэлийн үнэлгээ, явцын тохируулгад хамаарах харилцааг зохицуулах, ингэхдээ хөндлөнгийн хяналт, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэх.

1.1.3.4.Иргэний нийгмийн байгууллагын санал, зөвлөмж

“Нээлттэй Нийгэм форум”-ын дэргэдэх төсвийн зөвлөлөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд 2022-2024 онд санал, зөвлөмж өгсөн.[95] Эдгээр санал, зөвлөмжийг тоймлон танилцуулъя.[96]

---

[93] Дэлхийн банк, 2025, “Монгол улсын төрийн санхүүгийн үнэлгээ”

[94] ОУВС, 2018, “Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг сайжруулах-Техникийн туслалцааны тайлан”

[95] Forum.mn, https://forum.mn/uploads/users/3092/files/11_FC's%20opinion%20on%202024%20budget%20proposal-Final-202310(1).pdf

[96] “Нээлттэй Нийгэм форум”-аас 2022-2024 онд өгсөн санал, зөвлөмжтэй тандан судалгааны хавсралт № 3-аас дэлгэрүүлэн танилцана уу.

Төслийн төлөвлөлт, шаардлага: Эх үүсвэр үл хамааран УХОХ-т тусгагдаагүй төсөл, арга хэмжээг жилийн төсвийн төсөлд тусгахгүй байх, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах, шинээр эхлэх барилга, байгууламжийн хэрэгжүүлэх хугацааг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах, тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх, ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөл, төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгах шаардлагатай.

Төслийн хяналт, хэрэгжилт: 2023 онд хийгдсэн нэг ололт нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийг кодчилох явдал байсан. Энэхүү дэвшилтэт арга хэрэгслийг улам төгөлдөржүүлж энэ жилийн төсвөөс эхлэн батлагдсан төслийг кодоор нь шилэн дансанд байршуулж иргэд болон хуулийн этгээд, олон нийтийн төлөөлөл, байгууллага төслийн явц, байдлыг нь фото зураг болон мэдээллээр оруулж хэрэгжилт, мониторинг, хяналт хийдэг олон нийтийн тогтолцоог бий болгох нь зүйтэй байна. ; төслийг хөндлөнгийн экспертээс бүрдсэн багаар хөндлөнгийн үнэлгээ хийдэг болох. Үүний дараа төслийн ач холбогдлын эрэмбийг тодорхойлох.

Хууль, эрх зүйн орчин: Төсвийн холбогдох хууль, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид ямар арга хэмжээ авахыг тодорхой болгох, түүнчлэн УИХ-аас төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл баталсан тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах, ажлаа цаг хугацаандаа дуусгаагүй гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулах, үлдсэн ажлыг өөрийнх нь хөрөнгөөр дуусгах зохицуулалтыг тусгах гэж зөвлөсөн.

“Нээлттэй Нийгэм форум” төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн талаар 2022-2024 онд өгсөн санал зөвлөмжид “... Төсвийн төлөвлөлтөд шинэ төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлоготой уялдуулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршил, зориулалт, сонголт дээр холбогдох тооцоо, судалгааг нарийн хийх, төслийн үр ашгийн мэдээллийг нийтэд ил болгох, судлаачид, олон нийтийн оролцоог зайлшгүй хангах ...”-ыг зөвлөсөн.

Түүнчлэн, “Нээлттэй Нийгэм форум”-ын судалгаагаар “... олон улсын сайн туршлагын дагуу төсвийн зарцуулалтыг хүйсээр нь ангилан гаргадаг, жендерийн мэдрэмжтэй төсөв боловсруулалтыг нэвтрүүлэх хэрэгтэй. Мөн төсвийн бүх шатанд (боловсруулалт, хуваарилалт, гүйцэтгэл болон хяналт) хүйсээр нь ангилан, дүн шинжилгээ хийдэг жендерийн эрх, тэгш байдлыг харгалзан үзсэн төсөвлөлт нэвтрүүлбэл жендерийн эрх, тэгш байдалд төсвийн зарцуулалтын үзүүлж буй үр нөлөөг ойлгох, сайжруулах үр дүнтэй арга байх болно ...” гэж үзсэн.[97]

“Нээлттэй Нийгэм форум”-аас 2012-2024 онд улсын төсвөөс санхүүжүүлэхээр

[97] “Нээлттэй Нийгэм форум”, “Монгол Улс: Төсвийн гүйцэтгэл ба Тогтвортой хөгжлийн зорилтууд” судалгаа, 2023 он, 26 дугаар тал

тусгасан хөрөнгө оруулалтын шинэ төслийн төлөвлөлтийн талаар судалгаа хийжээ. Уг судалгаагаар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн дийлэнх хувь эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ногдож байна гэж үзсэн.[98]

УХОХ-т тусгаагүй, бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй төсөл төсөвт батлагдаж байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Энэ талаар “Нээлттэй Нийгэм форум”-ын судалгаанд дараах байдлаар тусгажээ. “... Сонгуулийн жилийн төсвийн төслийг УИХ-аас хэлэлцэх явцад хөрөнгө оруулалтын төсөл нэмэх байдал ажиглагддаг... 2024 оны төсвийн төслийг УИХ хэлэлцэх явцад 711.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 209 хөрөнгө оруулалтын төслийг нэмж баталсан... Төсвийн төслийг урьдчилан нарийн тооцоолж, шаардлагатай төслийг эхнээс нь тусгах нь төсвийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх чухал алхам юм ...” гэжээ.[99]

Дүгнэлт: Төсөл төлөвлөсөн хугацаандаа дуусахгүй олон жил дамжин хэрэгжих нь төсвийн хөөргөдөл үүсгэж байна. Үүний гол шалтгаан нь төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг буруу хийсэн, зураг төсөл, газрын зөвшөөрөл нь шийдэгдээгүй төслийг баталсан явдал хэмээн үзсэн.

1.1.3.5.Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн

Төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэл, Төсвийн хөрөнгө оруулалтын тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын талаар Сангийн яамнаас санаачлан дангаар болон бусад төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 2025 оны 02 дугаар сараас эхлэн цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хүснэгт 17.Төсвийн хөрөнгө оруулалтын талаарх хэлэлцүүлгийн нэгдсэн мэдээлэл

Д/д	Хэлэлцүүлгийн сэдэв	Хэлэлцүүлгийн огноо	Зохион байгуулагч	Оролцогч тал	Оролцогчдын тоо
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй ажлуудын зураг төсөв, холбогдох норм дүрэм,	2025.02.13	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Сангийн яам	Барилга болон авто замын салбарын зураг төсөв боловсруулагч, ТББ, хувийн	105

[98] “Нээлттэй Нийгэм форум”, “Чухал сэдэв”, Д.Баярмаа, “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт ба сонгууль”, 2025 оны 01 дүгээр сар, 6 дугаар тал, https://forum.mn/uploads/users/3092/files/0_Chuhal%20sedev%202025-FINAL-Web.pdf

[99] “Нээлттэй Нийгэм форум”, “Чухал сэдэв”, Д.Баярмаа, “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт ба сонгууль”, 2025 оны 01 дүгээр сар, 10 дугаар тал https://forum.mn/uploads/users/3092/files/0_Chuhal%20sedev%202025-FINAL-Web.pdf

	тулгамдсан асуудал			хэвшлийн төлөөлөл	
2	Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн танилцуулга	2025.02.21	Сангийн яам	Барилга угсралтын ажлын гүйцэтгэгч болон бусад этгээд	130
3	Төсвийн хөрөнгө оруулалтын тухай анхдагч хуулийн төслийн танилцуулга	2025.03.13	Сангийн яам	УАГ, АТГ, ТТБЗ, Нээлттэй Нийгэм форум, төрийн бус байгууллагын төлөөлөл	100
4	Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх, сайжруулах арга зам	2025.04.04	Боловсролын яам, Сангийн яам	Орон нутгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Аймгийн ЗДТГ-ын бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, зураг төсөлд магадлал хийх чиг үүрэг бүхий байгууллагын төлөөлөл	90
5	Төсвийн хөрөнгө оруулалтын 11 дэх удаагийн чадавх бэхжүүлэх сургалт	2025.06.06	Сангийн яам	УИХ, Засгийн газрын харьяа байгууллага, -Шүүх эрх мэдлийн байгууллага, -Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчид	250
6	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг	2025.09.28	Сангийн яам	-Дэд ажлын хэсэг, -Нээлттэй нийгэм форум, -аймаг, яамдын хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчид	30
7	Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг 12 дахь удаагийн чадавх бэхжүүлэх нэгдсэн сургалт, хэлэлцүүлэг	2026.02.27	Сангийн яам	УИХ, Засгийн газрын харьяа байгууллага, -Шүүх эрх мэдлийн байгууллага, -Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчид	250
8	Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай	2026.04.06	Сангийн яам	-Барилга, авто замын салбар,	105


	анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэг			-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар, -Орон нутгийн компаниудын төлөөлөл	

Дээр дурдсан найман удаагийн олон нийтийн уулзалт, хэлэлцүүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч бүх талын төлөөллийг оролцуулснаараа онцлогтой болно. Тухайлбал; 2025.02.13-ны өдрийн хэлэлцүүлэгт барилгын зураг төсөл зохиогч, 2025.02.21, 2026.04.06-ны өдрийн хэлэлцүүлэгт төслийн гүйцэтгэгч, барилгын ажлын гүйцэтгэгч, 2025.03.13-ны өдрийн хэлэлцүүлэгт төсвийн хөрөнгө оруулалтад хяналт тавьж, дүгнэлт зөвлөмж өгөх үүрэг бүхий этгээд, 2025.04.04-ний өдрийн хэлэлцүүлэгт орон нутгийн хөрөнгө оруулалт болон барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан албан хаагч, зураг төсөлд магадлал хийх эрх бүхий этгээд, 2025.06.06, 2026.02.27-ний өдрийн хэлэлцүүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд төрийг төлөөлөн оролцдог төрийн албан хаагчид, 2025.09.28-ны өдрийн хэлэлцүүлэгт дэд ажлын хэсэг, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан болно.

• Санал асуулга явуулах: Олон нийтийн найман удаагийн уулзалт, хэлэлцүүлгээр төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, ТХОУтХ-ийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах зорилгоор оролцогчдоос санал асуулга авсан.

Хэлэлцүүлэгт оролцогчдоос төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох зорилгоор санал асуулга авсан ба үр дүнг нэгтгэн танилцуулъя.

График 18.Тулгамдаж байгаа нийтлэг асуудал



Хэлэлцүүлэг 1-т барилгын зураг төсөл, төсөв зохиогч, хэлэлцүүлэг 2-т барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, хэлэлцүүлэг 3-т төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад хяналт тавих эрх бүхий төрийн байгууллага, хэлэлцүүлэг 4-т орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн албан хаагчид оролцсон.

Дээрх зургаас үзвэл төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд ямар эрх, үүрэгтэй оролцож байгаагаас хамааран тэдэнд тулгамдаж байгаа асуудал ялгаатай байна. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд гүйцэтгэгчийн хувиар буюу зураг төсөл, төсөв зохиогч болон барилгын компанид зураг төсөл, төсөв, холбогдох баримт бичиг, төрийн байгууллагын үйл ажиллагаа болон тендер шалгаруулалттай холбоотой асуудал үүсдэг байна. Харин төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд төлөвлөх, зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэгтэй оролцдог төрийн болон орон нутгийн байгууллагад төлөвлөлт хангалтгүй, төслийн хэрэгжилт хангалтгүй, төсөлд тавих хяналт сул гэсэн асуудал илүүтэй тулгардаг болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцүүлэг бүрээр нарийвчлан танилцуулъя.

Хэлэлцүүлэг 1

- *Зураг төсөл, төсөв, холбогдох баримт бичгийн боловсруулалт хангалтгүй:* Архитектор төлөвлөлтийн даалгавар чанаргүй, техникийн нөхцөл чанаргүй, ТЭЗҮ боловсруулалт хангалтгүй, зургийн даалгавар хэт ерөнхий, ойлгомжгүй, тодорхой бус, зураг төсөл, төсвийн боловсруулалт хангалтгүй, зураг төслийн магадлал чанаргүй хийгддэг, мөн чирэгдэл ихтэй;
- *Хяналтын тогтолцоо сул:* Захиалагчийн хяналт хангалтгүй, газрын асуудал шийдэгдээгүй, эсхүл норм дүрмийн дагуу төлөвлөхөд олгосон газрын хэмжээ хүрэлцдэггүй, зохиогчийн хяналт сул, зохиогч зохих журмын дагуу хяналт тавихад захиалагч байгууллагаас дарамт шахалт үзүүлдэг;
- *Жишиг үнэлгээ, үнэ тариф зах зээлийн үнэ тарифаас зөрүүтэй:* ТЭЗҮ боловсруулах жишиг үнэлгээ байхгүй, төсөв боловсруулахад мөрдөх жишиг үнэ зах зээлийн үнээс бага, бараа материал болон барилгын салбарын ажилтны цалин, бусад зүйл дээр үнийн зөрүү нэлээд үүсдэгl
- *Улсын төсөвт тусгах процесс алдаатай:* Барилга угсралтын төсвийг олон жилд бага багаар хувааж тусгадаг, зураг төсөлгүй төсөл, арга хэмжээг шууд баталдаг, 2-3 жилийн өмнө хийгдсэн зураг төсөл, төсвийн санхүүжилт төсөвт тусгагдсан хэмээн уг зураг төслөөр тендер шалгаруулалт зарладаг төсөвт өртөг нэмэгдэх нэг нөхцөл болдог;
- *Төрийн байгууллагын үйл ажиллагаа уялдаа холбоогүй:* Барилгын норм дүрэм уян хатан бус, хоцрогдсон байгааг өөрчилдөггүй, төрийн байгууллагаас үр дүн муутай олон давхар хяналт хийдэг, хүнд суртал ихтэй;
- *Хүний нөөцийн чадвар сул:* Барилгын салбарын, нэн ялангуяа архитектор, төсөвчин, норм норматив, зураг төсөл боловсруулдаг мэргэжилтний болон төрийн байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадвар хангалтгүй;
- *Тендер шалгаруулалтын үр дүн хангалтгүй:* Худалдан авах ажиллагааг анхнаасаа буруу зохион байгуулдаг, хуулийн этгээдийн чадварын

шаардлагад инженерийг голлон заахаас мэргэжлийн ажилтны талаар тусгадаггүй, түлхүүр гардуулах нөхцөлөөр гэрээ байгуулсан тендер шалгаруулалтын төсөвт өртөг нэмэгддэг;

- *Хариуцлагын тогтолцоо байхгүй:* Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч бүх талуудын, ялангуяа зураг төсөл зохиогчдын хүлээх хариуцлагын тогтолцоо сул, хангалтгүй.

Хэлэлцүүлэг 2

- *Төрийн байгууллагын хүнд суртал их:* төрийн байгууллагууд олон гарын үсэг цуглуулдаг, ажлын уялдаа холбоо муу, өөрсдийн хийх ажлаа гүйцэтгэгчээс шаарддаг, дарамт шахалт үзүүлдэг, томилолтын мөнгө нэхдэг;
- *Гүйцэтгэл баталгаажуулалт удаашралтай*, улсын комисст хүлээлгэн өгөхөд хүндрэлтэй;
- *Худалдан авах ажиллагаа хангалтгүй*: төслүүд маш өндөр, эсхүл маш бага дүнгээр зарлагддаг. Нэг жижиг ажил авахад өөр ажил авах боломжгүй болдог;
- Зураг төсөл, төсөв чанаргүй;
- НӨАТ-ын хувь хэмжээ өндөр;
- Төсөвт өртөг хүрэлцдэггүй;
- Газрын маргаан.

Хэлэлцүүлэг 3

- *Төлөвлөлт хангалтгүй*: төлөвлөлт оновчтой бус, ТЭЗҮ, төслийн үр ашиг, ач холбогдол, хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа холбоог хангадаггүй, ТЭЗҮ-г хангалтгүй боловсруулдаг, төслийн сонгон шалгаруулалт муу;
- *Мэдээлэл ил тод, нээлттэй бус:* төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, хяналт зэрэг ажиллагааны талаарх мэдээлэл ил тод, нээлттэй бус, иргэд санал, гомдол гаргах боломж хязгаарлагдмал;
- *Төсөв батлах үйл явц асуудалтай:* УИХ төсөвлөлтийн шаардлага хангахгүй олон төсөл, арга хэмжээг төсвийн төсөл хэлэлцэх үед нэмдэг;
- *Төслийн хэрэгжилт хангалтгүй:* төслийн хэрэгжилт удаан, төсөвт өртөг нэмэгддэг, төслийн чанар муу;
- *Төсөлд тавих хяналт сул:* хяналт, хөндлөнгийн хяналтын тогтолцоо байхгүй, төслийн тайлагналт сул.

Хэлэлцүүлэг 4

- *Төлөвлөлт хангалтгүй:* зураг төсөл, төсөв, ТЭЗҮ боловсруулалт хангалтгүй, иж бүрэн бус, төлөвлөлт муу, төсвийг он дамжуулан төлөвлөдөг, төсөлд үнэлгээ хийх аргачлал тодорхой бус;
- *Төслийн хэрэгжилт хангалтгүй:* барилгын зураг, шугамын ажлыг салгаж тендер зарладаг, гүйцэтгэгч байгууллага чадамжгүй, хүний нөөц, ялангуяа

хяналт тавих хүний нөөц дутагдалтай, чадвар сул, гүйцэтгэгч компанитай холбоотой асуудалд яаралтай арга хэмжээ авдаггүй;

- *Төсөлд тавих хяналт сул:* зураг төслийн магадлал хийлгэхэд их хугацаа ордог, магадлал чанаргүй хийдэг, хяналт, хөндлөнгийн хяналтын тогтолцоо байхгүй.

1.1.4.Тулгамдаж буй асуудлууд

Төсвийн хөрөнгө оруулалтад тулгамдаж байгаа асуудлыг өнөөгийн нөхцөл байдал, ҮАГ, ТТБЗ-ийн дүгнэлт зөвлөмж, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын санал, зөвлөмж зэрэгт тулгуурлан дараах байдлаар тодорхойлж байна.

1.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт удаан, төлөвлөсөн хугацаандаа ихэвчлэн ашиглалтад орохгүй байна. 2010 оноос хойш үргэлжилж байгаа 980.3 тэрбум төгрөгийн 636 төсөл, арга хэмжээ (үүнээс 2010-2019 оны 171 төсөл), 10-13 жил үргэлжилж, дуусаагүй байсан 80 сургууль, 63 цэцэрлэг, 53 авто зам, 43 эмнэлэг, 47 соёлын төв, 24 спортын байгууламж, 35 дэд бүтэц, 12 эрчим хүчний байгууламж байсан. Эдгээрийн санхүүжилтийг 2023 онд шийдвэрлэсэн.

2010-2024 онд төсөвт тусгагдсан боловч санхүүжилтээ огт аваагүй 1,296 төсөл, 2018-2024 онд төсөвт батлагдсан боловч гэрээ байгуулагдаагүй 310 төсөл, үүний 194 нь зураг төсөлгүй байв. Судалгаанаас үзэхэд, нэг төсөл дунджаар 0.9 жилээр хойшилж, 2.7 жилийн хугацаанд хэрэгждэг байна.

Дээрх статистикаас үзэхэд тухайн жилийн төсөвт батлагдсан боловч санхүүжилтээ огт аваагүй төслүүд, төсөвт батлагдсан боловч гэрээ байгуулаагүй төслүүд, олон жил үргэлжилсэн төслүүд нь тулгамдсан асуудал болж байна.

2.Төслийн төсөвт өртөг нэмэгдэж төсөвт ачаалал үүсгэх тохиолдол их байна. Төслийн хэрэгжилт удааширсантай холбоотойгоор бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан төслийн төсөвт өртөг нэмэгддэг. 2016-2025 онд 2,874 бүтээн байгуулалтын төсөл батлагдсанаас 42.5 хувь буюу 1,219 төслийн төсөвт өртөг нэмэгдсэн.

2020 оноос өмнө төслийн нэмэгдэл санхүүжилт харьцангуй бага байсан бол “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр 2023, 2024 онд барилгын салбарын ажилтнуудын тарифт цалин болон бараа материалын үнийн зөрүүнд нийт 967 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт төрөөс олгосон. Тухайлбал, 2023 онд УИХ-ын 88 дугаар тогтоолоор 638 төсөл хэрэгжүүлэгч 391 аж ахуйн нэгжид нийт 303.4 тэрбум төгрөгийг материалын үнийн өсөлтөд, 2024 онд УИХ-ын 72 дугаар тогтоолоор ҮАГ-ын дүгнэлтэд үндэслэн 289 төсөлд 660.6 тэрбум төгрөгийг төсөвт өртгийн нэмэгдэлд зарцуулсан.

Төсөвт өртгийн нэмэгдлийг хэрхэн шийдвэрлэх талаарх хууль зүйн зохицуулалт тодорхой бус байгаагаас асуудал даамжирч төсөвт ачаалал үзүүлж байна.

3.Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг сайжруулах шаардлагатай байна. Энэ нь төслийн хэрэгжилт удаан, төсөвт өртөг нэмэгддэг зэрэгтэй шууд хамааралтай. ОУВС-аас ижил түвшний улстай харьцуулахад Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үр өгөөж хангалтгүй болохыг тэмдэглэсэн.

4.Төсвийн хөрөнгө оруулалтын олон эх үүсвэрийн зориулалт, ангилал тодорхой бус байна. Төсвийн хөрөнгө оруулалтыг улсын төсөв, орон нутгийн төсөв, ОНХС, гадаад зээл, тусламж, ТХХТ, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, Хөгжлийн сан, хувийн хэвшил болон санхүүгийн бусад эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа ч эдгээр төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалтын харилцаанд хэд хэдэн хууль тогтоомж үйлчилж байна. Үүнээс болж төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд давхардах, хэрэгцээгүй болох, эсхүл бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байх зэрэг сөрөг тал гарч байна. Иймд төсвийн хөрөнгө оруулалтад төслийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагаар нэгдмэл зохицуулалт дутагдаж байна.

5.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрлийг хуульд тодорхойлоогүй байна. Сүүлийн жилүүдийн судалгаанаас үзэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 сая төгрөгийн, 80 тэрбум төгрөгийн төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээрт нэгэн ижил хууль зүйн зохицуулалт үйлчилж байна. Олон улсад төслийг төсөвт өртөг, төслийн эрсдэл, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын салбар зэрэг шалгуур үзүүлэлтэд үндэслэн ангилдаг бөгөөд төслийн ангилал бүрд төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт тайлагналт болон өмчийн удирдлага, ашиглалтын тохирсон, оновчтой зохицуулалт үйлчилж байна. Монгол Улсад улсын төсвийн хөрөнгөөр ямар ангиллын төсөл хэрэгжүүлэх, орон нутгийн төсвийн хөрөнгөөр ямар ангиллын төсөл хэрэгжүүлэх зэрэг санхүүгийн эх үүсвэртэй уялдсан бодлогоо тодорхой болгосон нөхцөлд төр, орон нутгийн чиг үүргийн хуваарилалт оновчтой болж, төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол нэмэгдэнэ гэж үзэж байна.

6.ТЭЗҮ, зураг төсөл, төсөв зэрэг ойлголтыг нэг мөр ойлгож хэрэглэхгүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл амжилттай хэрэгжих эсэх нь төслийн төлөвлөлтийн үе шатнаас, тодруулбал төслийн бэлтгэл үе шатнаас ихээхэн хамаардаг. Харин төслийн бэлтгэл үе шат нь ТЭЗҮ, зураг төсөл, төсөв, магадлал зохих ёсоор хийгдсэн эсэхээс хамаарна.

ТЭЗҮ гэдэг ойлголтыг Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд тусгасан боловч нэр томьёоны тайлбар хийгээгүй байна.

Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хуульд зураг төсөл гэж тусгасан боловч Төсвийн тухай хуульд зураг төсөл, зураг төсөв хэмээн тусгасан. Нэр томьёоны ойлгомжгүй, тодорхой бус байдлаас шалтгаалан ТЭЗҮ нь ямар агуулга, бүтэцтэй байх, зураг төсөл нь ТЭЗҮ-ээс хэрхэн ялгагдах, төсвийг хэрхэн тооцох зэрэг асуудал шийдэлгүй хэвээр байна. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүх төсөлд ТЭЗҮ, зураг төсөл, төсөв шаарддаг нь төсөвт тусгагдахгүй бол 2 жилийн дараа хэрэглэгдэхгүй болж үргүй зардал гарах, чанаргүй хийгдэх зэрэг сөрөг талтай болно. Мөн, Дэлхийн банкнаас ТЭЗҮ-ийн талаар нийтлэг стандарттай болох зөвлөгөө өгснийг хэрэгжүүлэх шаардлагатай.

7.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтыг хангахад зарим талаар чиглэгдэж чадахгүй байна. УАГ-ын гүйцэтгэлийн аудитын тайлангаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэхэд 2020-2024 онд 21.7 их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойгүй гээд 67.7 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэсэн.

7. Гадаад зээлийн төслүүдийн талаар. Монгол Улсын Их Хурлаас батлагдсан сүүлийн таван жилийн Төсвийн тухай хуулиудаар улсын төсвийн нийт зарлагын дундаж хэмжээ 20.0 их наяд төгрөгөөр батлагдсан байна. Үүнээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төслүүдэд дунджаар 1.5 их наяд төгрөгийн зээлийн ашиглалт батлагдсан нь гэрээ байгуулсан нийт гадаад зээлийн үлдэгдлийн 14.4 хувийг л ашиглаж байгааг харуулж байна.

2026 оны Төсвийн тухай хуулиар гадаад зээлийн ашиглалтад 1.2 их наяд төгрөг батлагдсан нь төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн нийт 5.3 их наяд төгрөгийн саналын 23 хувийг хангаж байгаа бөгөөд энэ нь гадаад зээлийн нийт ашиглагдаагүй үлдэгдлийн 9 хувьтай тэнцэж байна. Өөрөөр хэлбэл, гадаад зээлийн ашиглалтыг хангалттай түвшинд баталж чадахгүй байгаагаас шалтгаалан гурван төсөл тутмын нэг нь хугацаа сунгах шаардлагатай болж, төслийн дундаж хэрэгжилтийн хугацаа 1–2 жилээр уртсаж, таван жил болж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа гол асуудал нь төслийн хэрэгжилт удаан, өртөг нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэдэг, эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалттай бус, Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй болох нь тогтоогдсон. Төслийн хэрэгжилтийн сайжруулалт, тохируулга, зураг төсөл, ТЭЗҮ-гийн талаар нэгдсэн стандарт байхгүй, төслийн эрсдэл, хүний эрхийн болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, хөндлөнгийн үнэлгээ, хяналтын нэгдсэн тогтолцоо сул, гэрээний хэрэгжилт, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, олон нийтийн оролцоо, хариуцлагын талаарх зохицуулалт хангалтгүй байна.

Иймд, Монгол Улсад гадаад зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх, хөрөнгийн үр ашигтай, үр дүнтэй зарцуулалтыг хангах, валютын урсгалыг дотооддоо шингээх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий бүтээн байгуулалтуудыг хугацаанд нь дуусгах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс гадаад зээлийн санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хуулийн төслийг боловсруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

Тодруулбал, төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналын дөнгөж 24 хувь нь төсвөөр батлагдаж байгаа, нийт гэрээ байгуулсан зээлийн дөнгөж 14.8 хувь нь л жил бүрийн төсвөөр ашиглагдаж буй, ашиглагдаагүй үлдэгдэл жил ирэх тусам хуримтлагдаж буй, санхүүжилтийн хэмжээ хангалтгүйгээс шалтгаалан төслийн хэрэгжилтийн хугацаа уртсаж, зардал өсөх, зорилтот үр дүнгээ бүрэн хангаж чадахгүй болох зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж байна. Цаашлаад стратегийн бүтээн байгуулалт болох Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц зэрэг мега төслүүд санхүүжилтийн хомсдолоос шалтгаалан хугацаа алдаж, Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэлд эрсдэл үүсгэх нөхцөл бүрдэж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд дараах практик шаардлагууд тулгамдаж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг хамруулсан санхүүжилтийн оновчтой хуваарилалт, зориулалт, хамрах хүрээг тогтоогоогүйн улмаас хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийг бууруулах, хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилт бүрэн хангагдахгүй байх, хувийн хэвшил, орон нутаг, Засгийн газрын хэрэгжүүлэх төслүүд давхардах зэрэг асуудал, зөрчлүүд гарч байна;
- Хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл ажил буюу зураг төсөл, ТЭЗҮ зэрэг ойлголтууд зохицуулалтын хувьд бүрхэг, тодорхой бус учир бүх төсөлд ижил шаардлага тавигддаг, мөн төлөвлөж хэрэгжүүлэхэд төслийн хугацаа болон зардал нэмэгдэхэд нөлөөлж байна;
- Төслийн төсөвт өртөг буюу нийт хөрөнгө оруулалтыг бодитой тодорхойлдоггүй, төслийн онцлогт тохирсон ангилал, төрөл байхгүй тул төлөвлөлт оновчгүй болж хэрэгжилт удааширч улмаар төслийн менежментийн зардал нэмэгдэх, төслийн хэрэгжилтэд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсдэг;
- Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны ил тод байдалд тавих хяналт хангалтгүй, гарсан зөрчилд хариуцлага хүлээлгэдэггүй, мөн тус сангийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог бүрэн хангахгүй, төсөвт өртгийг хэт жижиглэснээр тендер оролцогчгүй болох, ажил он дамжих, хугацаа алдах, удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу болон огт оруулаагүй байхад сангаас санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд гарсаар байна;
- Барилга, эрчим хүч, авто зам зэрэг салбарын норм, нормативын санд төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас ижил хувь хэмжээгээр хөрөнгө төвлөрүүлдэг

хэдий ч норм нормативын баримт бичгийг шинэчлэх ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг, хариуцлагын тогтолцоо сул болох нь холбогдох хяналт, шалгалтаар тогтоогдсон. Төсвийн хөрөнгө ийнхүү үр ашиггүй зарцуулагдаж буйг өөрчилж, норм, нормативын сангийн удирдлага, менежментийг шинэчлэх шаардлагатай байна;

- Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч байгууллагын хариуцлага, хяналтын талаарх зохицуулалт хангалтгүйн улмаас өмчийн удирдлага сулрах, ашиглалтын үр өгөөжийг тооцохгүй байх, түүнчлэн чанаргүй барилга байгууламж баригдах зөрчлүүд их гарч байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ашиглалтын зардлыг бууруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарим харилцааг хуулиар, зарим харилцааг журмаар зохицуулдаг бөгөөд зарим асуудлууд огт зохицуулалтгүй буюу хууль зүйн хийдэл үүссэн. Тухайлбал:
  1) улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг бэлтгэх асуудлыг Төсвийн тухай хуульд тусгасан хэдий ч бусад хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар хуульд тодорхой тусгаагүй;
  2) мега төсөл, ногоон хөрөнгө оруулалт, их өгөгдөлд суурилан төлөвлөлтийг хийх талаарх зохицуулалт байхгүй;
  3) төсөлд тохируулга хийх болон төсөлд (бие даасан) хяналт тавих, төслийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулаагүй;
  4) төсөл хэрэгжүүлэх, төслийн тогтвортой үйл ажиллагааг хангахтай холбогдсон харилцааг хуульд тодорхой авч үзээгүй гэх мэт.

Дүгнэлт: Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд нэн тэргүүнд дараах асуудал тулгамдаж байна хэмээн үзэж болно. Үүнд, 1.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт удаан, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ордоггүй, 2.Төслийн төсөвт өртөг нэмэгдэж төсөвт ачаалал үүсгэдэг, 3.Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй байна, 4.Төсвийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг хангахад чиглэгдэж чадахгүй байна.

1.1.5.Шүүхийн практикийн тойм судалгаа

Төсвийн хөрөнгө оруулалт, холбогдох бусад харилцаанд хамаарах хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд голлон үүсдэг асуудлыг тодорхойлох, шүүхээс өгсөн дүгнэлтийг судлах, улмаар асуудлыг бууруулахын тулд юунд илүүтэй анхаарах шаардлагатайг илрүүлэхийг зорьсон. Энэ зорилгын хүрээнд шүүн таслах ажиллагааны бүх төрөл буюу эрүү, иргэн болон захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн 2020.01.01-ний өдрөөс 2025.04.26-ны өдрийн шийдвэрийг судлан үзлээ. Хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх эрх хэмжээтэй гэдэг утгаар нь

хяналтын шатны шүүхийн шийдвэрт илүүтэй ач холбогдол өгсөн болно. Энэ хэсэгт уг судалгааны дүгнэлт хэсгийг оруулав.[100]

Энэхүү шүүхийн шийдвэрийн тойм судалгаанд захиргааны 8 хэрэг, иргэний 12 хэрэг, эрүүгийн 3 хэрэг, нийт 23 хэрэгт хамаарах анхан, давж заалдах болон хяналтын шатны бүгд 76 шийдвэрийн холбогдох хэсгийг түүвэрлэн судалсан бөгөөд энэхүү тайланд захиргааны 5 хэрэг, иргэний 5 хэрэг, эрүүгийн 3 хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийг тоймлон тусгасан.

Нэг.Захиргааны хэргийн шүүхээр тендер шалгаруулалттай холбоотой олон хэрэг маргааныг хянан шийдвэрлэдэг. Тендер шалгаруулалт нь судалгааны үндсэн сэдэв болох төсвийн хөрөнгө оруулалтаас “ялимгүй” хазайх тул тендер шалгаруулалтаас бусад төрлийн маргаан шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг сонгон авахыг зорив.

Захиргааны хэргийн шүүхээр гүйцэтгэлийн баталгааг цуцлахгүй байгаа, төсөл хэрэгжүүлэхэд гарсан зардал, нэмэлт зардал, хохирол олгохгүй байгаа, дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалсан, өмчлөгчөөр тогтоолгох, концессоос үүссэн алдагдлыг төсөвт тусгуулахыг даалгах зэрэг шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл; захиргааны хэргийн шүүхэд төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой үүссэн хэрэг маргаанд нэхэмжлэгчдээс үүрэг хүлээлгэх, тогтоолгох, өөрчлөх буюу хүчингүй болгуулах нэхэмжлэлийн аль алийг гаргаж байна. Захиргааны хэргийн нэхэмжлэгчид нь төсөл хэрэгжүүлэгч буюу гүйцэтгэгчид байдаг. Харин хариуцагчид нь захиргааны байгууллага, албан тушаалтан байна.

Захиргааны хэргийн шүүхээс захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхэд өгсөн хууль зүйн дүгнэлтүүд адил төстэй хэрэг маргаанд ач холбогдолтой, түүнчлэн захиргааны байгууллага үйл ажиллагааныхаа алдааг илрүүлэх, улмаар залруулахад мөн нөлөөтэй. Иймд захиргааны хэргийн шүүхийн хууль зүйн дүгнэлтээс “онцлох” хэсгийг танилцуулъя.

- “Сонгосон талбай” гэдэгт барилгажих орон сууцны барилгууд орчны газрын хамт, эсхүл зөвхөн ус, дулаан дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмж, инженерийн барилга байгууламжийн газар хамаарах эсэхийг ялган тодорхойлох;
- Нэхэмжлэгчийн гаргасан зардал болон нэхэмжлэгчид учирсан хохирол ялгаатай ойлголт болох;
- Орон нутгийн өмчийн хөрөнгийг захиргааны байгууллага захиран зарцуулахтай холбоотой харилцаа нь нийтийн эрх зүйн харилцаанд хамаарах;
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 52.5.2-т заасны дагуу нэхэмжлэгч захиргааны актаас гадна захиргааны хууль бус

[100] Төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах шүүхийн практикийн тойм судалгаатай тандан судалгааны тайлангийн хавсралт № 4-өөс танилцана уу.

үйл ажиллагааны улмаас учирсан хохирол шаардах боломжтой бөгөөд энэ тохиолдолд шүүх захиргааны үйл ажиллагаа хууль ёсны эсэхийг дүгнэх;

- Тооцоо нийлсэн актыг захиргааны гэрээ гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, аливаа гэрээний талуудаас гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой гаргасан шийдвэр нь захиргааны акт, захиргааны гэрээний шинжийг агуулахгүй;
- Хариуцагч “төрд илтэд хохиролтой” гэж үзсэн бол гэрээ байгуулахаас татгалзах, цуцлах, улмаар эрх хэмжээгээ хэтрүүлсэн албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх, үр дагаврыг таслан зогсоох бүрэн эрхтэй, боломжтой байсан. Гэтэл гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан шүүхэд үүссэний дараа өмнөх шийдвэрээ үгүйсгэн маргаж буй нь үндэслэлгүй, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах;
- Концессын гэрээнд гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлийг тогтоосон бол уг нөхцөл хангагдсан эсэхийг нягтлах гэх мэт.

Хоёр.Төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах нэлээд хэрэг маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэдэг хэмээн үзэж болно. Энэ нь ТБОНӨХБАҮХАтХ-ийн 60.4-т “Захиргааны гэрээнд хамаарах худалдан авах гэрээг Захиргааны ерөнхий хуульд үндэслэн цуцалснаас бусад гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргааныг иргэний хэргийн шүүхэд харьяалан шийдвэрлүүлнэ.” гэж заасантай холбоотой. Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан этгээдтэй захиалагч ихэвчлэн ажил гүйцэтгэх, эсхүл төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулах нь нийтлэг байна. Эдгээр гэрээний нэг тал нь захиалагч буюу төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтан, нөгөө тал нь гүйцэтгэгч буюу хувийн хэвшлийн хуулийн этгээд байна.

Цөөн тохиолдолд нэхэмжлэгч нь төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтан байв. Захиргааны байгууллага, албан тушаалтан оролцдог, нийгмийн дэд бүтцийн шинжтэй төсөл хэрэгжүүлдэг гэдэг агуулгаар тухайн гэрээнд хамаарах тусгайлсан зохицуулалтыг нийтийн эрх зүйн хүрээнд тогтоодог ч гэрээ нь агуулгын хувьд иргэний эрх зүйн гэрээ байдаг. Иймд гэрээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилттэй холбоотой хэрэг маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэж байна.

Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэж байгаа хэрэг маргааны нэхэмжлэлийн шаардлагын дийлэнх нь зардал, нэмэлт зардал, хохирол гаргуулах, гэрээг хүчин төгөлдөр бус хэлцэлд тооцуулах, гэрээний үүргийн гүйцэтгэлийн төлбөр, санхүүжилтийн үлдэгдэл гаргуулах, улсын комисс ажиллуулахыг даалгах зэрэг байна. Өөрөөр хэлбэл; иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэгчид ихэвчлэн гэрээнээс үүдэлтэй ажлын хөлс, зардал, үлдэгдэл санхүүжилт болон учирсан хохирлоо гаргуулах шаардлага гаргадаг.

Иргэний хэргийн шүүхийн хууль зүйн дүгнэлтээс “онцлох” хэсгийг танилцуулъя.

- Нэхэмжлэгч нэмэлт ажил хийсэнтэй холбоотой зардал шаардсан нөхцөлд нэмэлт төсөв хөрөнгийн асуудлыг захиалагчид урьдчилан танилцуулсан эсэх, зохих журмын дагуу шийдвэрлүүлж байсан эсэх, энэ талаар ямар баримт өгсөн зэрэг нь нотолгооны ач холбогдолтой;
- Нэг тал мөнгөн хөрөнгө гаргах, нөгөө тал тохиролцсон зүйл, ажлыг гүйцэтгэх, тодорхой хугацааны дараа мөнгөний оронд гэрээгээр тохирсон зүйлийг өгөх талуудын тохиролцоог худалдах-худалдан авах гэрээ гэж үзэх үндэслэлтэй;
- Гэрээнд заасан зарим ажлыг хийх, мөн гэрээнд заасан зарим ажлыг өөрчилж хийх, түүнчлэн гэрээнд заагаагүй зарим ажил хийх нь ялгаатай үр дагавар үүсгэх боломжтой;
- Улсын төсвөөс санхүүжилт дутуу орж ирсэн бол энэ талаар зохих хууль, журмын дагуу шаардлага гаргах, санхүүжилтийг хариуцан шийдвэрлүүлэх этгээд нь захиалагч болох;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан эд хөрөнгийг ашиглалтад орсон үеэс нь шилжүүлэн авч, холбогдох зардлыг хариуцах;
- Хуулийн хориглосон хэм хэмжээ зөрчсөн гэрээ бүхэн хүчин хүчин төгөлдөр бус байх хэлцлийн үр дагаврыг үүсгэдэггүй;
- Гэрээнээс татгалзсан явдалд хоёр талын аль нэгийг буруутгах үндэслэл тогтоогдоогүй тохиолдолд татгалзсантай холбоотой хохирлыг хэн өмнө хүлээх үүргийг хүлээдэггүй;
- Концессын гэрээ нь төр, хувийн хэвшлийн аль алины ашиг сонирхолд үндэслэн байгуулагддаг зах зээлийн харилцаанд суурилан бизнесийн үйл ажиллагааны зарчмаар, харилцан итгэлцэлд суурилсан гэрээ бөгөөд иргэний эрх зүй дэх гэрээний суурь зарчим нэгэн адил үйлчилнэ.

Гурав. Эрүүгийн хэргийн шүүхээр тендер шалгаруулалтын журам зөрчих, бусдад хууль бус давуу байдал олгох зэргээр 2005 оны Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, 2015 оны Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг үйлдсэн эсэх асуудал хянан шийдвэрлэгдэж байна.

Эрүүгийн хэргийн шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ хийсэн хууль зүйн дүгнэлтийн дийлэнх нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаар байна.

- Үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн ханшаар үнэлж, үнэлэгдсэн хэмжээгээр нь нийт хохирлын дүнгээс хасаж, хохирлыг бодитой тогтоох;

- Иргэний нэхэмжлэгч тухайн гэмт хэрэгт гомдол санал, нэхэмжлэх зүйлгүй гэсэн ч гэмт хэргийн улмаас улсад учруулсан хохирлыг гаргуулах;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээ, түүнийг нөхөн төлж барагдуулсан эсэх нь гэмт хэргийн нийгмийн аюулын түвшнийг багасгах буюу ихэсгэх, хэргийн зүйлчлэл болоод ялын бодлогод шууд нөлөөлдөг тул уг нөхцөл байдлыг эргэлзээгүй, хөдөлбөргүй тогтоохоос гадна уг хохирлыг хэн хариуцах талаар дүгнэх гэх мэт.

Иргэний хэргийн шүүх зөвхөн иргэний хууль тогтоомжийг хэрэглэж бус тухайн хэрэг маргааны онцлогоос хамааран нийтийн эрх зүйн хууль тогтоомжийг хэрэглэх тохиолдол байна. Үүний нэгэн адил, захиргааны хэргийн шүүх зөвхөн нийтийн эрх зүйн хууль тогтоомжийг хэрэглэж бус хэрэг маргааны онцлогоос хамааран иргэний хууль тогтоомжийг хэрэглэх тохиолдол байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанаас үүдэлтэй хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн захиргаа, иргэний болон эрүүгийн хэргийн шүүхийн шүүн таслах ажиллагааны тоон статистик байхгүй тул нэгдсэн дүгнэлт өгөхөд учир дутагдалтай.

Дүгнэлт: Дээр дурдсан захиргаа, иргэн болон эрүүгийн хэргийн шүүхийн хууль зүйн дүгнэлт нь тухайн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэсэн хийгээд тухайн хэрэг маргааны нөхцөл байдалд тулгуурлан өгсөн дүгнэлт тул тэдгээр дүгнэлтийг бүхий л хүрээнд мөн утгаар хэрэглэгдэнэ хэмээн үзэх боломжгүй. Дүгнэлт: Дээр дурдсан захиргаа, иргэн болон эрүүгийн хэргийн шүүхийн хууль зүйн дүгнэлт нь тухайн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтад үндэслэсэн хийгээд тухайн хэрэг маргааны нөхцөл байдалд тулгуурлан өгсөн дүгнэлт тул тэдгээр дүгнэлтийг бүхий л хүрээнд мөн утгаар хэрэглэгдэнэ гэж үзэх боломжгүй. Гэхдээ төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа зарим асуудлыг бууруулах, захиргааны байгууллагын алдааг залруулахад тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд

Төрөөс нийтийн хэрэгцээг хангах зориулалттай, нийтээрээ ашиглах эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, эрчим хүч, дулаан хангамж, зам, дэд бүтцийн барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг төсөл, арга хэмжээ нь ихэвчлэн барилга байгууламж, их засвар, техник, тоног төхөөрөмж болон ТЭЗҮ гэсэн 4 зүйл байдаг. Тухайн жилийн төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг тусгайлан баталдаг. Тухайлбал, иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг хангах хүрээнд эмнэлэг, эрүүл мэндийн төв, лаборатори, өрхийн эмнэлэг, хүүхдийн эмнэлэг, хавдрын эмнэлэг, сурч боловсрох эрхийг хангах хүрээнд цэцэрлэг, сургууль, сургуулийн спорт заал,

хүүхдийн болон оюутны дотуур байр, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, их, дээд сургууль зэрэг.

Нийтийн хэрэгцээг хангах зориулалттай, нийтээрээ ашиглах шаардлагаар дулааны станц, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд бүтцийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цэвэр усны байгууламж, худаг, үерийн далан, усан сан, авто зам, гүүрний барилга байгууламж, нисэх буудал, зорчигч тээврийн авто үйлчилгээний төв, гудамж, зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, услалтын систем, агропарк зэрэг бүтээн байгуулалтыг төсвийн хөрөнгө оруулалтаар хийдэг.

Түүнчлэн, спорт цогцолбор, хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, ахмадын ордон, өргөө, хүүхдийн зуслан, театр, номын сан, музей, соёлын төв зэрэг барилга байгууламжийг барьж байгуулдаг. Төр, орон нутгийн байгууллага хорооны барилга, иргэдэд үйлчлэх төв, Засаг даргын Тамгын газрын байр зэрэг барилга байгууламжийг төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулан хуульд зааснаар иргэдэд үйлчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх 16 багц үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хуульчилсан. Дээрхээс дүгнэхэд, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангах, иргэнийхээ өмнө төрийн хүлээсэн хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ гүйцэтгэхэд чиглэгддэг.

Иймд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар Монгол Улсын иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол шууд болон шууд бус байдлаар хөндөгдөнө. Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхгүй, эсхүл үр дүн муутай хэрэгжүүлэх нь нийт иргэдийн төрөөс нийгмийн суурь дэд бүтцээр хангуулах эрх, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн зарим бүлгийн төрөөс үйлчилгээ авах эрх, ашиг сонирхол хөндөгдөх болно.

Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаа нь захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаанд эерэг болон сөрөг байдлаар нөлөөлөх боломжтой.

1.3.Асуудал үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл

Монгол Улсад төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг мега төсөл,

хөрөнгө оруулалт болон дэд бүтцийн төсөлд зарцуулах чиглэл баримталж байгааг олон улсын болон дотоодын эрх бүхий байгууллагаас эергээр дүгнэсэн байна.

Гэсэн ч, төсвийн хөрөнгө оруулалтад дараах асуудал тулгамдаж байна:

1. Төслийн хэрэгжилт удаан;
2. Төслийн төсөвт өртөг нэмэгдэж төсөвт ачаалал үүсгэдэг;
3. Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй;
4. Төсвийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг хангахад чиглэгдэж чадахгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт удаан, төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ордоггүй нь дараах шалтгаан нөхцөлтэй байна. Үүнд:

- Төлөвлөлтийн шаардлага хангахгүй (газрын асуудал шийдэгдээгүй, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөл батлуулаагүй) төслийг төсөвт тусгадаг;
- Төлөвлөлтөд эрэмбэ баримталдаггүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөдөггүй;
- Төлөвлөлтийг Төсвийн тухай хууль, Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалаар, мөн төлөвлөлт болон бусад харилцааг салбарын хууль тогтоомж, захиргааны актаар зохицуулдаг буюу хууль, эрх зүйн орчин нэгдмэл бус, ойлгомжгүй;
- Төслийн хэрэгжилтийн бүхий л үе шатанд хяналтын тогтолцоо сул;
- Төлөвлөлтийг салбарын бодлоготой уялдуулдаггүй;
- Зураг төсөл, архитектур төлөвлөлтийн даалгавар, техникийн нөхцөл, зургийн даалгавар, ТЭЗҮ боловсруулалт, зураг төслийн магадлал муу, чанаргүй хийгддэг;
- ТЭЗҮ-д тавигдах шаардлагыг тогтоосон стандарт байхгүй;
- Төсвийн хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэгчид хамаарах асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг, хариуцах байгууллага, авах арга хэмжээ, хугацаа, шат дараалал тодорхойгүй, гэрээний хариуцлага тооцох хууль зүйн зохицуулалт хангалтгүй;
- Хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчийн туршлага, чадварт шаардлага тавьдаггүй;
- Төслийн эрсдэл, түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг тооцдоггүй;
- Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулдаг.

Төслийн төсөвт өртөг нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэдэг нь дараах шалтгаан нөхцөлтэй байна. Үүнд:

- Төлөвлөлтийн шаардлага хангахгүй (газрын асуудал шийдэгдээгүй, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөл, төсөв батлуулаагүй) төслийг төсөвт тусгадаг;
- Төсөлд тавих захиалагч болон зохиогчийн хяналт хангалтгүй, захиалагч болон зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх байдал сул;
- Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явцад ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдалтай;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажил чанаргүй, магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маягтгүй;
- ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын жишиг зардлыг тооцох, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, заавар журам хангалтгүй;
- Нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгадаггүй, үүнээс захиалагч, гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү гардаг;
- Шинээр хэрэгжүүлэх төслийн төсөвт өртөг, олон жил дамжсан хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн өөрчлөлт болон ижил төстэй хөрөнгө оруулалтын зардлын ялгаатай байдлыг хөндлөнгөөс хянах тогтолцоо байхгүй;
- Хөрөнгө оруулалтын бүх төслийг үнэлгээний аргачлалаар үнэлдэггүй;
- Хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчийн туршлага, чадварт шаардлага тавьдаггүй;
- Шинээр хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөдөггүй;
- Өмнө хийгдсэн зураг төслөөр тендер шалгаруулалт зарладаг.

Төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй байгаа нь “ерөнхийдөө” төслийн хэрэгжилт удаан, төслийн төсөвт өртөг нэмэгддэг байдалтай шууд хамааралтай хэдий ч дараах шалтгаан нөхцөл мөн нөлөөлж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, эдийн засгийн үр ашгаар нь эрэмбэлж төлөвлөдөггүй;
- Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлдэг;
- Төслийн төлөвлөлтийг хүнээс аль болох хамаарал багатай шийдэх буюу их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах зохицуулалт байхгүй;
- Төслийн ангилал, төрөл тодорхой бус;
- Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн оновчтой хуваарилалт байхгүй, зориулалт ойлгомжгүй;

- Төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн тогтолцоо байхгүй;
- Захиалагч болон зохиогчийн хяналтын тогтолцоо сул, төсөвт өртөг, нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих хяналт хангалтгүй;
- Санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр гурван жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээнд төсөв батлагдахгүй орхигдох эрсдэл үүсгэдэг;
- Төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн зарим зураг төсөл, тоног төхөөрөмжийг ашигладаггүй;
- Их засварын зардлыг бодит шаардлага, хэрэгцээнд тулгуурлан хангалттай төлөвлөдөггүй;
- Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөгөө хангалтгүй байна;
- Сонгон шалгаруулалтгүйгээр төсөл нэмэгддэг;
- Өмнө үнэлгээ хийгдсэн төслийг сонгоход давуу эрх тооцдоггүй;
- Төслийн явцын тохируулга, сайжруулалтын талаарх журам, зохицуулалт байхгүй;
- Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөхгүй байна;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой ашигладаггүй, улсын төсвийн хөрөнгөөр бүхий л салбарын төслийг төсөвт өртөг үл хамааран санхүүжүүлэн хэрэгжүүлдэг, хөрөнгө оруулалт нь хэд хэдэн эх үүсвэрээс санхүүждэг боловч эдгээрийг хөрөнгө оруулалтаар нь ангилан эрэмбэлэх тодорхой тогтолцоо байхгүй.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг хангахад чиглэгдэж чадахгүй байгаа нь дараах шалтгаан нөхцөлтэй болно. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлэн баталдаггүй, төсөвт урт хугацааны бодлогын төлөвлөлт, зорилт тусгадаггүй;
- ТЕЗ, орон нутгийн төсвийн захирагч, улсын төсөв хоорондын уялдаа холбоог хангадаггүй;
- УХОХ нь урт болон дунд хугацааны санхүүгийн менежменттэй уялдаж байгаа эсэх, эсхүл тохиромжтой эсэхийг Сангийн яам хэрхэн тодорхойлох зохицуулалт байхгүй;
- Улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах зохицуулалт хангалтгүй.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд дээрх асуудал үүсэхэд дараах шалтгаан, нөхцөл нөлөөлж байна. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт оновчтой бус болно. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, эдийн засгийн үр ашгаар нь эрэмбэлдэггүй, шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгадаг, төслийн ангилал, төрөл тодорхой бус, үүнээс улбаалан төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн оновчтой хуваарилалт байхгүй, зориулалт ойлгомжгүй, төлөвлөлтийг хүнээс хамаарал багатай буюу их өгөгдөлд суурилан хийх зохицуулалт байхгүй зэрэг болно.

2. Хууль, эрх зүйн орчин нэгдмэл бус, тодорхой бус, олон тооны захиргааны актаар зохицуулдаг. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөөс эхлээд хүлээж авах хүртэлх бүх үе шатанд дагаж мөрдөх хууль байхгүй, ерөнхийдөө Төсвийн тухай хуулийг голлон хэрэглэх боловч төслийг үнэлэх, сонгох шалгаруулах, санхүүжүүлэх зэрэг үе шатанд Засгийн газар, Сангийн сайдын шийдвэрээр батлагдсан журам үйлчилдэг. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАтХ, төслийн үр дүнд бий болсон өмч хөрөнгийг ашиглах харилцаанд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гэх зэргээр нэгдмэл зохицуулалт байхгүй.

3. Төслийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал тодорхой бус, төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулах ажиллагааны мэдээлэл сүүлийн жилүүдэд олон нийтэд харьцангуй нээлттэй болж байгаа ч үр дүнтэй бус, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хаана, аль шатанд, хэрхэн хангах талаарх хууль, эрх зүйн орчин хангалтгүй байна.

4. Төслийн хөндлөнгийн үнэлгээний болон төслийн хэрэгжилтэд тавих хөндлөнгийн хяналтын тогтолцоо байхгүй. Төсөл санаачлагч болон үнэлгээний баг төслийн үнэлгээ хийхийн өмнө, эсхүл дараа нь хөндлөнгийн үнэлгээний баг тэднээс хараат бусаар ажиллаж үнэлгээний дүгнэлтийг мэргэжлийн хүрээнд гаргаж танилцуулах зохицуулалт байхгүй. Түүнчлэн, төслийн хэрэгжилтийн үе шат бүрд хөндлөнгийн хяналт тавих механизм хангалтгүй байна.

5. Төслийг хэрэгжүүлэхэд эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх заавар, аргачлал дутмаг болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж буй дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээг нэн тэргүүнд авах шаардлагатай байна. Үүнд:

Хууль, эрх зүйн орчны хүрээнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлж эрэмбэлэх, сонгох хууль, эрх зүйн орчныг шинэчлэх;

- Барилгын материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатлаас төслийн хэрэгжилт удаашрах нөхцөл үүсэх зэрэг тохиолдлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох;
- Төслийн явцын тохируулга, сайжруулалтын талаарх журам, зохицуулалттай болох;
- Хөрөнгө оруулалт хариуцсан албан хаагчид шаардлага тавих;
- Хариуцлагын тогтолцоог сайжруулах.

Төлөвлөлтийн хүрээнд:

- Төсвийн төлөвлөлтөд шинэ төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлоготой уялдуулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий цөөн төсөлд хуваарилж, богино хугацаанд хэрэгжүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Хөрөнгө оруулалтын төслийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд онцгой анхаарах;
- Аль салбарт, ямар үйл ажиллагааг төр цаашид санхүүжүүлэхгүй вэ гэдгийг шийдэх;
- Төслийн хэрэгжих хугацааг үндэслэлтэй төлөвлөх;
- Яамдын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэх;
- ТЕЗ, орон нутгийн төсвийн захирагч, улсын төсөв хоорондын уялдаа холбоог хангах;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршил, зориулалт, сонголт дээр холбогдох тооцоо, судалгааг нарийн хийх.

Үнэлгээний хүрээнд:

- Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэх;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд хяналт тавих, иргэн хуулийн этгээдийн магадлал хийх эрх олгох, тэгш өрсөлдөөнийг бий болгох;
- Эрсдэлийн үнэлгээ хийх, энэ нь төслийн үнэлгээний хэсэг байх, түүнийг даван туулах төлөвлөгөөтэй болох, хэрхэн боловсруулах талаар заавар гаргах;
- Магадлалын дүгнэлтийг нэгдсэн загварт оруулж, баталгаажуулах;
- ТЭЗҮ-ийн стандарт бүтцийг тодорхойлох, түүнд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлын үнэлгээг оруулах;
- Үнэлгээ хийгдсэн боловч сонгогдоогүй төслийг дараа жилийн төсөвт тусгах төслөөс сонгохдоо давуу эрх олгох;
- Хөндлөнгийн экспертээс бүрдсэн багаар хөндлөнгийн үнэлгээ хийдэг болох, үүний дараа төслийн ач холбогдлын эрэмбийг тодорхойлох.

Хяналтын хүрээнд:

- Төслийн хэрэгжилтэд ТЕЗ, захиалагчийн хяналтыг сайжруулах;
- Захиалагч болон зохиогчийн хяналт тавих гэрээний хэрэгжилтийг дүгнэх, хариуцлага тооцох журам тогтоох;
- Гүйцэтгэгч, хяналт хэрэгжүүлэгч байгууллагын ажлын үр дүнг тооцож ажиллах;
- ТЕЗ, захиалагчийн саналд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн багаар дүгнэлт гаргуулах;
- ТЕЗ, захиалагчаас хараат бус байгууллага төслийн өртөг, гарц, үр дүнг хамарсан гүйцэтгэлийн дараах хяналт тавих;
- Барилга байгууламжийн ажилд хяналт хэрэгжүүлэх этгээдийн хүний нөөцийн үр чадвар, мэргэшсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх;
- Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд гарч байгаа нийтлэг асуудалд шинжилгээ хийх, тухай бүр арга хэмжээ авах.

Төслийн зардлын хүрээнд:

- Төслийн төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төслийн жишиг зардлын хувь хэмжээг тодорхойлох, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалт бий болгох;
- Шинээр хэрэгжүүлэх төслийн төсөвт өртөг, олон жил дамжсан хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн өөрчлөлт болон ижил төстэй хөрөнгө оруулалтын төслийн өртгийн ялгаатай байдлыг хөндлөнгөөс хянах стандарт, шалгуурыг бий болгох;
- Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх;
- Норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах;
- Урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдэхдээ өмнө нь хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд үндэслэх.

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хүрээнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахад ил тод, хариуцлагатай байх зарчмыг мөрдөх;
- Төслийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, судлаач, олон нийтийн оролцоог зайлшгүй хангах;
- Төсөл санаачлагчийн мэдээллийг ил болгох;
- Мониторинг, хяналт хийдэг олон нийтийн тогтолцоог бий болгох.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Тандан судалгааны өмнөх үе шатанд асуудалд дүн шинжилгээ хийж асуудлын мөн чанар, хамрах хүрээ, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлж, асуудал үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг илрүүлсэн. Энэ үе шатанд төсвийн хөрөнгө оруулалтад үүссэн асуудлыг шийдвэрлэх зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байхаар томьёолохыг зорьсон.

Дүн шинжилгээ хийснээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаан, төсөвт өртөг нэмэгддэг, эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй, Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж чадахгүй байгаа, олон нийтийн оролцоо хангалтгүй, хөндлөнгийн хяналтын тогтолцоо байхгүй зэрэг асуудал байгааг тогтоосон. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалтгүй, хэрэгжилт удаан байх нь Монгол Улсын нийт иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд шууд болон шууд бус байдлаар нөлөөлж болзошгүй. Эдгээр асуудал үүсэхэд голлон нөлөөлсөн шалтгаан, нөхцөл нь хууль, эрх зүйн орчин нэгдмэл бус, үнэлэх, эрэмбэлэх аргачлал тодорхой бус, мэдээллийн ил тод байдал хангалтгүй, хяналтын тогтолцоо сул, төслийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх заавар, аргачлал дутмаг байдал юм.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх гол зорилгыг төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах, ялангуяа төсвийн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдмэл хууль тогтоомжтой болгох хэмээн томьёолж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх гол зорилго нь ерөнхий зорилго болно. ОУВС-гийн 2023 оны үнэлгээгээр Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийн зөрүү 2016 оныхоос 14 хувиар сайжирсан бөгөөд уг үнэлгээг ахиулах зорилго тавьсан.

Удаах гол зорилго нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах бөгөөд ерөнхий зорилго болно. Дэлхийн банкнаас 2021 онд Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг “B” гэж үнэлсэн байгааг сайжруулах зорилго дэвшүүлж байна.

Дараах гол зорилго нь төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд нэгдмэл, цогц хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, Дэлхийн банкны зөвлөсөн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын 8 үе шатыг бүрэн хамруулж зохицуулах хэмээн үзэж байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалд:

1. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоох;
2. Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
3. Харьцуулалтад үндэслэн хамгийн үр дүнтэй хувилбарыг сонгох ажиллагааг гүйцэтгэхээр заажээ.

3.1.Асуудлыг зохицуулах хувилбарууд

Тандан судалгааны 2 дугаар бүлэгт тусгасан зорилгоо биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбарыг өргөн хүрээнд тодорхойлно. Зохицуулалтын хувилбаруудыг зорилгод хүрэх байдал болон бусад дагалдах үр нөлөөгөөр нь ерөнхий байдлаар шалгаж, бага зардлаар өндөр үр дүнд хүрэх шийдлийг сонгож санал болгоно.

Зохицуулалтын хувилбар тус бүрээр үнэллээ.

3.1.1.“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг одоогийн буюу Төсвийн тухай хууль, холбогдох бусад хууль, олон тооны захиргааны актаар зохицуулж байгаа байдлыг хэвээр үлдээвэл төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг муу, хэрэгжилт удаан зэрэг асуудал буурахгүй, харин нэмэгдэх магадлалтай. Ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын төслийн эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ.

Зохицуулалтын “Тэг” хувилбарыг сонговол цаашид төсвийн хөрөнгө оруулалтад тусгах зардлын дүн нэмэгдэж болох ч, түүнийг даган төсөл, арга хэмжээний өгөөж нэмэгдэх хандлага байхгүй ба төсөл, арга хэмжээг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, өгөөжийг харгалзан эрэмбэлэхгүй нөхцөлд өгөөж буурах эрсдэлтэй болно.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Зорилгод хүрэх боломжгүй	Хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх ч үр өгөөж нэмэгдэхгүй, буурах эрсдэлтэй	Сөрөг

3.1.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх талаар олон нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, өдөр тутмын сонин, олон нийтийн цахим сүлжээ, цахим хуудсаар дамжуулан явуулж болно. Түүнчлэн, олон нийтэд зориулан хэлэлцүүлэг, сургалт, гарын авлага болон бусад хэлбэрээр мэдээлэл хүргэж болно.

Зохицуулалтын энэ хувилбарыг сонгосон нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, олон нийтийн оролцоо хангалтгүй байгаа шалтгаан нөхцөл буурах магадлалтай. Гэхдээ төслийн эдийн засгийн үр ашиг муу, хэрэгжилт удаан зэрэг асуудал үүсэхэд нөлөөлсөн үндсэн шалтгаан, нөхцөл арилахгүй, хэвээр байх тул төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ.

Олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгааны ажилд санхүүгийн эх үүсвэр (нэмэлт зардал) шаардлагатай бөгөөд олон нийтийн оролцоог хангах нь төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төслийн өгөөжийг нэмэгдүүлэх шууд үндэслэл болохгүй. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт, бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байх, олон нийтийн оролцоог хангах нь зүйтэй боловч зөвхөн уг арга хэмжээг дангаар авснаар төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөж нэмэгдэхгүй.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал шаардлагатай ба үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг

3.1.3.Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх

Зохицуулалтын энэ хувилбараар зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээг төрөөс хэрэгжүүлэхийг ойлгоно. Үүнд, татвар, хураамж, зөвшөөрөл, лиценз, квот тогтоох, өөрчлөх зэрэг.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс хөгжлийн хөрөнгө оруулалтад чиглэсэн, эсхүл мега төслийн хувьд төрөөс тусгайлан дэмжиж зах зээлийн эдийн засгийн хэрэгслээр зохицуулалт хийх боломжтой. Харин төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л харилцаанд зохицуулалтын энэ хувилбарыг хэрэглэх боломжгүй.

Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийснээр төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ. Төрөөс эдийн засгийн арга хэрэгслээр зохицуулалт хийснээр зардал гарах бөгөөд тухайн төслийн хувьд үр өгөөж гарах боломжтой хэдий ч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөж өөрчлөгдөхгүй болно.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Төрөөс эдийн засгийн зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал нэмэгдэх ч тухайн төслийн хувьд үр өгөөж нэмэгдэх боломжтой, нийт төслийн хувьд үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг

3.1.4.Төрөөс санхүүгийн интервенц хийх

Зохицуулалтын энэ хувилбараар төрөөс тухайн асуудалд шууд мөнгөн хэлбэрийн дэмжлэг үзүүлэхийг ойлгоно. Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх нь төрөөс эдийн засагт санхүүгийн интервенц хийж байгаа нэг хэлбэр болно. Иймд зохицуулалтын энэ хувилбарыг сонгосон нөхцөлд төсөл, арга хэмжээний үр ашиг муу, хэрэгжилт удаан зэрэг асуудал буурахгүй, харин нэмэгдэх магадлалтай. Ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтын төслийн өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ.

Төрөөс санхүүгийн интервенц хийх нь зардал нэмэгдүүлэх ба асуудал үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг арилгахгүй тул төсөл, арга хэмжээний үр өгөөж нэмэгдэхгүй болно.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Төрөөс санхүүгийн интервенц хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал нэмэгдэх ч үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг

3.1.5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх

Зохицуулалтын энэхүү хувилбараар төрийн гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гуравдагч этгээд буюу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх нь оновчтой эсэхийг шалгадаг.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн[101] 19.1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.” гэж, 19.2 дахь хэсэгт “Төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, уг ажлаа Монгол Улсын зохих сайдын өмнө хариуцна.” гэж заасан. Энэхүү зохицуулалт нь төрийн чиг үүргийг төрийн бус байгууллага, эсхүл хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох нийтлэг зохицуулалт бөгөөд юуны өмнө тухайн харилцааг зохицуулсан хуульд энэ талаар тусгасан байхыг шаардана. Хуульд үндэслээд Засгийн газрын шийдвэр гарч, улмаар талуудын хооронд гэрээ байгуулагдсанаар төрийн бус байгууллага, хувийн хэвшил нь төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэх боломжтой болно.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны талаар ОУВС болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжид хөндлөнгийн үнэлгээний болон хяналтын тогтолцоо байхгүй, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой болохыг дурддаг. Эндээс үзэхэд, төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах, үнэлж эрэмбэлэх, төсөвт тусгах, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг хүлээж авах зэрэг процесс ажиллагааны аль нэг үе шатанд захиалагч болон төсөл хэрэгжүүлэгчээс хараат бус этгээдийн оролцоо шаардлагатай байж болох юм.

Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа гол хууль болох Төсвийн тухай хуульд энэ талаар зохицуулалт байхгүй. Иймд төрийн тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хэрэгцээ шаардлага байж болох ч хууль, эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаан дахь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх хувилбарыг сонгосон нөхцөлд төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг муу, хэрэгжилт удаан зэрэг асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөл бүрэн арилахгүй. Иймд төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаан дахь төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлсэн нөхцөлд холбогдох зардлыг төрөөс бүрэн, эсхүл хэсэгчлэн хариуцах тул төрөөс гарах зардлын дүнд өөрчлөлт орохгүй. Төсөл, арга хэмжээний үр өгөөж тодорхой хэмжээнд нэмэгдэж болзошгүй.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн

[101] https://legalinfo.mn/mn/detail?lawId=344

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал өөрчлөгдөхгүй, үр өгөөж тодорхой хэмжээнд нэмэгдэх	Сөрөг

3.1.6.Захиргааны шийдвэр гаргах

Захиргааны ерөнхий хуулийн[102] 11.1 дэх хэсэгт захиргааны үйл ажиллагааны үндсэн 3 хэлбэрийг тодорхойлсон. Үүнд, захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээний акт хамаарна. Захиргааны дээрх шийдвэрийг гаргасан нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд үүсээд байгаа асуудлууд шийдвэрлэгдэх боломжтой эсэхийг судална.

Захиргааны ерөнхий хуулийн 37.1 дэх хэсэгт “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.” гэж хуульчилсан. Өөрөөр хэлбэл, захиргааны акт нь зөвхөн тодорхой нэг тохиолдлыг зохицуулахад чиглэгддэг. Иймд захиргааны акт гаргаснаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны бүхий л асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Захиргааны ерөнхий хуулийн 52.1-д “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно.” гэж заасан. Захиргааны гэрээг холбогдох хуульд заасан хэм хэмжээг үндэслэн байгуулна. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд ТБОНӨХБАҮХАтХ-д зааснаар захиалагч нь гүйцэтгэгчтэй гэрээ байгуулдаг бөгөөд уг гэрээ нь захиргааны гэрээ болдог. Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцаанд захиргааны гэрээ байгуулах талаар зохицуулалт байхгүй. Иймд захиргааны гэрээ байгуулагдах хууль, эрх зүйн орчин бүрдээгүй болно.

Захиргааны ерөнхий хуулийн 59.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.” гэж хуульчилсан. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд Засгийн газар, Сангийн сайд, хуулиар эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтны баталсан захиргааны шийдвэрүүд үйлчилж байна.

[102] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11259

Захиргааны шийдвэр нэмж гаргаснаар төсвийн хөрөнгө оруулалтад үүссэн асуудлын шалтгаан нөхцөлийн нэг болох төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхөөс эхлээд хүлээж авах хүртэлх бүх үе шатанд дагаж мөрдөх нэгдмэл хууль байхгүй гэсэн шалтгаан нөхцөл арилахгүй бөгөөд хууль, эрх зүйн зохицуулалт улам ойлгомжгүй, нэгдмэл бус болно.

Захиргааны шийдвэр гаргах зохицуулалтын хувилбарыг сонгосон нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилго биелэх боломжгүйд хүрнэ. Захиргааны шийдвэр гаргах, мэдээлэх, мөрдүүлэхэд тодорхой хэмжээний нэмэлт зардал гарах хэдий ч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд нөлөөлөл үзүүлэхгүй болно.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Захиргааны шийдвэр гаргах	Зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарах, үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг

3.1.7.Хууль тогтоомжийн төсөл боловсруулах

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг Төсвийн тухай хуулиар голлон зохицуулахын зэрэгцээ холбогдох бусад 10 гаруй хууль, Засгийн газар, Сангийн сайд, эрх бүхий байгууллага, албан тушаалтны баталсан олон тооны захиргааны шийдвэрээр зохицуулж байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин ойлгомжгүй, тодорхой бус, салангид, нэгдмэл бус байгааг илэрхийлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөж муу, хэрэгжилт удаан байгаа зэрэг олон асуудлын суурь шалтгаан нөхцөл нь:

1. Хууль, эрх зүйн орчин тодорхой бус;
2. Төсөл үнэлэх, эрэмбэлэх аргачлал хангалтгүй, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, олон нийтийн оролцоо хангалтгүй;
3. Төслийн хөндлөнгийн үнэлгээний болон төслийн хэрэгжилтийн явцад тавих хөндлөнгийн хяналтын тогтолцоо байхгүй;
4. Төслийг хэрэгжүүлэхэд эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх заавар, аргачлал дутмаг байдал болохыг тандан судалгаагаар тогтоосон.

Эдгээр асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг хууль тогтоомжийн төсөл боловсруулснаар бууруулах, арилгах боломжтой байна. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл боловсруулснаар хууль, эрх зүйн орчин тодорхой бус гэх шалтгаан нөхцөл арилна. Түүнчлэн, уг хуулийн төсөлд бусад

шалтгаан нөхцөл буюу мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгох, олон нийтийн оролцоог хангах, хөндлөнгийн үнэлгээ, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх болон төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний асуудлыг тусгах боломжтой хэмээн үзэв.

ТТБЗ-ийн 2024.09.20-ны өдрийн дүгнэлтэд “Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцоход журмын зохицуулалт хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орнуудын сайн туршлагын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг шинээр боловсруулах асуудлыг УИХ-аас тусгайлан судалж холбогдох шийдвэрийг гаргах шаардлагатай.” гэж тусгажээ.

Хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг цогц байдлаар тусгаснаар төсвийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах зорилгод хүрэх боломж нээгдэнэ. Хуулийн төсөл боловсруулахад тодорхой хэмжээний зардал гарах ч төслийн үр өгөөж нэмэгдэнэ. Тодруулбал, хуулийн төсөл боловсруулахад гарах зардлаас илүүтэй төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, өгөөж нэмэгдэх нь чухал ач холбогдолтой болно.

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
Хуулийн төсөл боловсруулах	Зорилгод хүрэх боломжтой	Нэмэлт зардал гарах, үр өгөөж нэмэгдэх	Эерэг

3.2.Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Тандан судалгааны өмнөх буюу 3.1 дэх үе шатанд асуудлыг зохицуулах 7 хувилбарыг тодорхойлж, тэдгээрийн зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцааг судалсан. Энэхүү үе шатанд зохицуулалтын хувилбарын эерэг, сөрөг талыг нэгтгэн судална.

Хүснэгт 18.Зохицуулалтын хувилбаруудын эерэг болон сөрөг талын харьцуулалт

Зохицуулалтын хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Зорилгод хүрэх боломжгүй	Хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх ч үр өгөөж нэмэгдэхгүй, буурах эрсдэлтэй	Сөрөг
Олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал шаардлагатай ба үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг
Төрөөс эдийн засгийн зохицуулалт хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал нэмэгдэх ч тухайн төслийн хувьд үр өгөөж нэмэгдэх боломжтой, нийт	Сөрөг

		төслийн хувьд үр өгөөж нэмэгдэхгүй	
Төрөөс санхүүгийн интервенц хийх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал нэмэгдэх ч үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Зорилгод хүрэх боломжгүй	Зардал өөрчлөгдөхгүй, үр өгөөж тодорхой хэмжээнд нэмэгдэх	Сөрөг
Захиргааны шийдвэр гаргах	Зорилгод хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарах, үр өгөөж нэмэгдэхгүй	Сөрөг
Хуулийн төсөл боловсруулах	Зорилгод хүрэх боломжтой	Нэмэлт зардал гарах, үр өгөөж нэмэгдэх	Эерэг

Зохицуулалтын 7 хувилбараас зөвхөн нэг нь буюу хуулийн төсөл боловсруулах зохицуулалтыг сонгосон нөхцөлд зорилгод хүрэх боломжтой болох бөгөөд бусад 6 хувилбарыг сонговол зорилгод хүрэх боломжгүй байна.

Төрөөс эдийн засгийн зохицуулалт хийх хувилбарыг сонгосон нөхцөлд зардал нэмэгдэх ч тухайн төслийн хувьд үр өгөөж нэмэгдэх боломжтой, бусад төслийн хувьд үр өгөөж нэмэгдэхгүй байна. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлбэл зардал өөрчлөгдөхгүй ч төслийн үр өгөөж тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай болно. Хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг сонгосон нөхцөлд төсөл боловсруулах, хуулийг сурталчлан танилцуулах зэрэгт нэмэлт зардал гарах ч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр өгөөж нэмэгдэх магадлалтай байна. Бусад зохицуулалтын хувилбарын хувьд нэмэлт зардал гарсан ч үр өгөөж нэмэгдэхгүй тул сонгох шаардлагагүй гэж үзэв.

3.3.Хамгийн үр дүнтэй байж болох зохицуулалтын хувилбар

Тандан судалгааны өмнөх үе шатаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд үүсээд байгаа асуудлыг шийдвэрлэж болох зохицуулалтын хувилбар нь:

1. Төрөөс эдийн засгийн зохицуулалт хийх;
2. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
3. Хуулийн төсөл боловсруулах болох нь тогтоогдсон. Энэхүү үе шатанд зохицуулалтын 3 хувилбараас хамгийн үр дүнтэй байж болох хувилбарыг сонгоно.

Төрөөс эдийн засгийн арга хэрэгслээр дамжуулан зохицуулалт хийх нь тухайн төсөл, арга хэмжээний хувьд байж болох хувилбар мөн боловч төсвийн хөрөнгө оруулалтын нийт харилцаанд хэрэглэх боломж хязгаарлагдмал болно. Энэ

хувилбарыг сонгосноор зорилгод хүрэх боломжгүй нь тогтоогдсон, үр дүн сөрөг гарсан.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлсэн нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний үр өгөөж тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай байна. Гэхдээ зохицуулалтын уг хувилбарыг сонгосон нөхцөлд хууль, эрх зүйн орчин бүрдээгүйн улмаас хэрэгжих боломжгүй. Нөгөө талаас, энэ хувилбарыг дангаар хэрэгжүүлэх нөхцөлд зорилгод хүрэх боломжгүй, үр дүн сөрөг болохыг анхаарах шаардлагатай.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг сонгосон нөхцөлд төсвийн хөрөнгө оруулалтын харилцааны нэгдмэл хууль зүйн орчин бүрдэх боломжтой болно. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлж болох хууль зүйн орчин бүрдэнэ. Зохицуулалтын уг хувилбараар тавьсан зорилгод хүрэх боломж нээгдэж, үр дүн эерэг гарах магадлалтай байна.

Иймд төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбараас хамгийн үр дүнтэй байж болох хувилбар нь хуулийн төсөл боловсруулах болно. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг төлөвлөхөөс эхлээд төсөл, арга хэмжээний эцсийн үр дүнг хүлээн авах, бүртгэх, түүнийг ашиглах, эзэмшихтэй холбоотой харилцааг зохицуулах талаар тусгах нь зүйтэй.

Түүнчлэн, хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг оновчтой хуваарилах, төслийн ангилал, төрлийг тодорхойлох, төслийн ангилал, төрөлд тохирсон журам тогтоох, зураг төсөл, ТЭЗҮ-ийн талаар нэгдсэн ойлголт, стандарт гаргах, төлөвлөлт, хэрэгжилтэд их өгөгдөл, хиймэл оюун ухаан ашиглах, олон нийтийн оролцоог хангах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэх, төслийн явц дахь хөндлөнгийн үнэлгээ болон хяналтын тогтолцоог бий болгох болон төслийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөний талаар тусгаснаар асуудлыг үүсгэж байгаа шалтгаан нөхцөлийг бууруулах, арилгах боломжтой болно.

ДӨРӨВ.ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАР, ТҮҮНИЙ ҮР НӨЛӨӨ

4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хууль

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбарыг дараах үндэслэлээр сонгосон. Үүнд:

-Бие даасан хууль боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай зөрчилдөх нөхцөл үүсэхгүй болно. Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл байна. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хууль батлагдсанаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын оновчтой, зөв бодлогыг тодорхойлж, улс, бүс нутаг болон орон нутгийн хөгжилд зориулсан төслийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн болон нийгмийн хөгжлийг түргэтгэн төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн нэгдмэл, цогц, таатай орчныг бүрдүүлэх томоохон ач холбогдолтой юм.

-Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлснээр 2021 онд PIMIS цахим систем нэвтрүүлж, 2022 онд Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөлд тавигдах шаардлага, эрэмбийн талаарх зарчмын зохицуулалтыг нэмж тусган, 2023 онд төсөвт иргэдээс анх удаа санал авах зэрэг ажлыг гүйцэтгэж үр дүнд хүрсэн болно. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем PIMIS-д улсын төсвийн зэрэгцээ гадаад зээл, тусламж, нийслэлийн болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, ТХХТ-ийн санхүүжилтээр хэрэгжих төслийн мэдээлэл орох боломжтой болсон. Түүнчлэн, их өгөгдөл, хиймэл оюун ухаан нэвтрүүлэх, сум, дүүргийн төсөв болон ОНХС-гийн төсвөөр хэрэгжих төслийн мэдээллийг оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

4.2.Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу тандан судалж, энэхүү тайланд Хавсралт № 1-ээр оруулав. Үүнд:

1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг аргачлалд заасны дагуу шалгуур асуултуудад хариулах замаар дүгнэв. Хүний эрх,

нийгэм болон байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлэхэд сөрөг, шууд нөлөөлөл илрээгүй болно. Харин эдийн засагт тодорхой хэмжээнд эерэг нөлөөлөл үзүүлэх магадлалтай гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргээ төрөөс хэрэгжүүлэн нийгмийн суурь хэрэгцээг хангах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг тул Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрхийн зарчим, зохицуулалтад нийцнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтын асуудлаар Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ байхгүй. Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй зөрчилдөхгүй болно.

ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу төсвийн хөрөнгө оруулалтын зохицуулалтын олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийв.[103]

5.1.Олон улсын эрх зүйн зохицуулалт

Төсвийн хөрөнгө оруулалтын талаар Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, олон улсын байгууллагын эрх зүйн баримт бичиг (тогтоол, шийдвэр, тунхаглал) байхгүй байна. Өөрөөр хэлбэл, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд шууд хамаарах олон улсын эрх зүйн зохицуулалт байхгүй. Харин төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, түүний Киотогийн протокол, Парисын хэлэлцээр шууд бусаар хамаарна хэмээн үзэж болох юм.[104]

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенцоор Монгол Улс уур амьсгалын тогтолцоонд учруулах хүний аюултай үйл ажиллагааг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах үүрэг хүлээсэн. Иймд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг дэмжихэд чиглэх учиртай. Энэ талаар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Ногоон хөгжил” хэсгийн зорилго 6-д “Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.” гэж тусгасан.

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Парисын хэлэлцээр ёсоор уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд нүүрстөрөгч багатай буюу хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх эдийн засагт шилжихийн тулд эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлагатай гэж үздэг.[105] Тодруулбал, эрх тэгш, хүртээмжтэй байдлыг бэхжүүлэх ногоон эдийн засгийг бүрдүүлэх учиртай. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь байгаль орчинд ээлтэй байхын сацуу төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь ногоон эдийн засгийг дэмжих, бүрдүүлэхэд чиглэх шаардлагатай.

НҮБ-ын 2015 оны 70 дугаар чуулганаар 2016-2030 оны тогтвортой хөгжлийн 17 зорилго, 169 зорилтыг баталсан бөгөөд НҮБ-ын Статистикийн комиссын 2017 оны 48 дугаар чуулганаар хэрэгжилтийг дүгнэх 244 шалгуур үзүүлэлтийг

[103] Олон улсын харьцуулсан судалгааны тайланг тусад нь боловсруулж энэхүү тайланд хавсаргасан. Дэлгэрэнгүйг уг тайлангаас харна уу.

[104] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn, Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцыг 1993 онд, Киотогийн протоколыг 1999 онд, Парисын хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталсан.

[105] https://www.undp.org/mn/mongolia/news/uur-amsgalyn-oorchloltiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorchloltiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avlaga

тодорхойлсон. [106] “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”-аас төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд холбогдох нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, хуурай газрын эко системийг хамгаалах зорилтууд болно. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилт нь агуулгаараа “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан байдаг.

НҮБ-ын Хөгжлийн санхүүжилтийн олон улсын III бага хурлаар Аддис Абабагийн үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан бөгөөд тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад төсвийн хөрөнгө оруулалт чухал үүрэгтэйг тэмдэглээд дараах асуудлыг тусгасан. Үүнд:

- төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулах;
- төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрт хөрөнгө оруулалт хийх;
- төсвийн хөрөнгө оруулалтыг тэгш бус байдлыг бууруулахад чиглүүлэх, хүртээмжтэй болгох;
- иргэн, бусад оролцогчдод хөрөнгө оруулалтын урсгалыг хянах, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг баталгаажуулах хялбарчилсан, ойлгомжтой, ил тод төсөв боловсруулах үйл явцыг хэрэгжүүлэх.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн байгууллагаас 2014 онд “Засаг захиргааны бүх шатанд төсвийн хөрөнгө оруулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх зөвлөмж” гаргасан бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бэхжүүлэх зорилгоор дараах зарчмыг хэрэгжүүлэхийг гишүүн улсуудад зөвлөсөн. Үүнд:[107]

- Тухайн газарт тохирсон хөрөнгө оруулалтын стратеги боловсруулж ажиллах;
- Засаг захиргааны шатлал хоорондын уялдаа холбоог хангах арга хэрэгсэл хэрэглэх;
- Төсвийн хөрөнгө оруулалтыг газар зүйн бүсэд нийцүүлэхийн тулд бүс нутгийн, эсхүл орон нутгийн засаг захиргаа хоорондын уялдаа холбоог зохицуулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын урт хугацааны үр нөлөө, эрсдэлийг урьдчилан үнэлэх;
- Хөрөнгө оруулалтын мөчлөгийн туршид төр, хувийн хэвшил, иргэд зэрэг оролцогч бүх талууд хамтран ажиллах;
- Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, чадавхыг бэхжүүлэхийн тулд хувийн хэвшил болон санхүүгийн байгууллагыг дайчлах;

[106] sdg.1212.mn, “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхий нийтийн урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болно.
[107] https://legalinstruments.oecd.org/en/instruments/OECD-LEGAL-0402

- Төсвийн хөрөнгө оруулалтад оролцож буй төрийн албан хаагч, байгууллагын мэдлэг чадварыг дээшлүүлэх;
- Хөрөнгө оруулалтын үр дүнд чиглэсэн механизмыг баримтлах;
- Хөрөнгө оруулалтын зорилтод нийцсэн төсвийн тогтолцоог боловсруулах;
- Засаг захиргааны бүх шатанд ил тод санхүүгийн удирдлага, төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдал, зохицуулалтын тогтолцооны чанар, тууштай байдлыг хангах, хэрэгжүүлэх.

5.2.Гадаад улсын хууль тогтоомж

Хөрөнгө оруулалтын тодорхойлолт болон цар хүрээ нь төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцооны суурь болдог. Бусад улсад ямар үйл ажиллагааг хөрөнгө оруулалтад тооцох, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад хамруулах тухай тогтолцоондоо тогтоож өгсөн байна.

Лаос Улс хөрөнгө оруулалтыг дэд бүтцийн барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдаж авах болон техникийн дэмжлэгийн хөрөнгө оруулалт гэж ангилсан.[108] Бүгд Найрамдах Солонгос Улс, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс зэрэг хөгжингүй улс биет хөрөнгөөс гадна технологи, судалгаа, хөгжүүлэлт зэрэг дижитал шилжилтийн эрин үед чухал биет бус хөрөнгө оруулалтад анхаарч, эдгээрийг төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоондоо хамруулж байна.[109] Цаашлаад, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн төрлөөр Бүгд Найрамдах Солонгос Улс нь том хэмжээний орон нутгийн хөрөнгө оруулалт болон төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтыг төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагад хамруулдаг. Лаос Улсын хувьд ТХХТ-ийн хөрөнгө оруулалтын 30-аас дээш хувь нь улсын төсвөөс санхүүжих тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн удирдлагад хамруулахаар тогтоож өгсөн.

Дүгнэлт: Монгол Улсын хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын бодлого, засаг захиргааны тогтолцооны онцлог зэрэгтэй уялдуулан төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцооны цар хүрээг тодорхойлох шаардлагатай байна.

Шийдвэр гаргагчдын болон төсөвлөлтийн үйл явцын хязгаарлагдмал цаг хугацаа, салбарын эрсдэлийн түвшин зэргийг харгалзан төслийг өртөг, хэмжээ, эсхүл салбараар ялган ангилах нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтоосон хугацаанд илүү үр дүнтэй хэрэгжүүлэх арга болно.

Бүгд Найрамдах Солонгос Улсад том хэмжээний төсөл гэж 50 тэрбум воноос давсан өртөгтэй төслийг тодорхойлж, энэхүү босгоос давсан төсөлд урьдчилсан

[108] Public Investment Law No: 72/NA (2015) of Lao People's Democratic Republic.
[109] National Finance Act (2016).
https://www.kdi.re.kr/kdidata/departments/pimac/guideline_national_finance_act.pdf
Infrastructure and Projects Authority. (2016, March). *National Infrastructure Delivery Plan 2016–2021*.
https://assets.publishing.service.gov.uk/media/5a7f2f1540f0b6230268df36/2904569_nidp_deliveryplan.pdf

ТЭЗҮ гүйцэтгэх, хараат бус хяналт тавих зэрэг нэмэлт шаардлагыг тогтоосон байх бөгөөд төслийн салбар, ач холбогдлоос хамааран энэхүү нэмэлт шаардлагыг тавихгүй байх төслийг ч мөн тодорхойлсон. Вьетнам, Лаос Улсад мөн төсөвт өртөг, салбар зэргээс хамааран төслийг 4-6 бүлэгт нарийвчлан ангилсан бөгөөд үүний дагуу төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцын бүхий л шатанд тавигдах шаардлага, хийгдэх үйл ажиллагааг ялган тодорхойлсон байна.[110]

Дүгнэлт: Салбарын онцлог болон төсөвт өртгийн хэмжээ нь тухайн улсын эдийн засгийн үзүүлэлт, туршлагаас шалтгаалан өөр байх боловч төслийг ангилах нь шийдвэр гаргалт, хэрэгжүүлэлт, хяналтын үе шатыг илүү оновчтой хэрэгжүүлэхэд нөлөөтэй байна.

Төсвийн хөрөнгийг үр ашигтай, зохистой зарцуулахад төсөл сонгох үе шат чухал ач холбогдолтой бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд бодит, үнэн зөв үнэлгээний тогтолцоо шаардлагатай.

Казахстан Улсын Төсвийн хуульд гагцхүү ТЭЗҮ хийгдсэн, эерэг үнэлгээ авсан төслийг төсвийн төсөлд тусгахаар заасан бөгөөд ТЭЗҮ, үнэлгээ хийх, төсөл сонгох нарийвчилсан аргачлалыг Засгийн газар тогтоохоор хуульчилсан.[111] Чили Улсад төсөл бэлдэх, үнэлэх аргачлалыг тогтоох, төрийн албан хаагчдыг төсөл бэлдэх, үнэлэх үйл ажиллагаанд мэргэшүүлэх зэрэг чиг үүргийг Сангийн яамны төсөвлөлтийн үйл ажиллагаанаас бүрэн тусгаарлан Нийгмийн хөгжлийн яам хэрэгжүүлдэг.[112] Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний санхүүгийн хуульд урьдчилсан ТЭЗҮ-ийн үйл ажиллагааны удирдамж, төслийн нийт зардлын удирдлагын удирдамж, салбарын арга зүйн удирдамжийг гаргах эрхийг Эдийн засаг, сангийн яаманд олгосон бөгөөд эдгээрийг яамны харьяа Төрийн болон хувийн хэвшлийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын удирдлагын төв гүйцэтгэдэг байна.

Дүгнэлт: Дээрх улсуудын туршлагаас харахад төслийн үнэлгээ хийх шаардлагыг ерөнхий хуульд тусгаж, харин үнэлгээний нарийвчилсан нөхцөлийг нэгдсэн байдлаар тогтоох эрхийг зарим байгууллагад олгодог байна. Иймд, Монгол Улсад үнэлгээний нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлж, хууль эсхүл, эрх бүхий байгууллагаас батлах эрх зүйн баримт бичигт зохицуулах шаардлагатай юм.

Хөрөнгө оруулалтын үйл явцад зохих хяналтыг тогтмол хэрэгжүүлж, төлөвлөгөөт хугацаанаас хоцрох, тооцоолоогүй эрсдэл, асуудал үүсэх зэрэг

[110] Law on Public Investment No. 58/2024/QH15 (2024). https://english.luatvietnam.vn/dau-tu/law-on-public-investment-no-58-2024-qh15-379074-d1.html
[111] Budget Code of the Republic of Kazakhstan. https://adilet.zan.kz/eng/docs/K080000095
[112] Kim, Jay-Hyung, Jonas Arp Fallov, and Simon Groom. 2020. *Public Investment Management Reference Guide*. International Development in Practice. Washington, DC: World Bank. https://documents1.worldbank.org/curated/en/548751582775237521/pdf/Public-Investment-Management-Reference-Guide.pdf

тохиолдолд төсөлд тохируулга хийх боломжтой байх нь төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зайлшгүй байх шаардлагатай хэмээн үздэг.

Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад төслийн явцад холбогдох үнэлгээ хийж, үнэлгээний үр дүнг улаан-шар-ногоон гэсэн тэмдэглэгээгээр тайлагнаж, шаардлагатай бол төсөлд тохируулга хийх, эсхүл зогсоох зэрэг ажиллагаа хийдэг. Бүгд Найрамдах Солонгос Улсад төслийн явцад нийт өртөг нь 20 хувиас дээш нэмэгдсэн төслийн ТЭЗҮ-ийг дахин үнэлэх, тодорхой тохиолдолд төслийн эрэлтийг дахин үнэлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.[113]

Дүгнэлт: Төслийн хяналт, шалгалтын үр дүнд үндэслэн төсөлд холбогдох тохируулга хийж, төслийн зарлагын үр ашигтай байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр холбогдох албан хаагчдыг чадавхжуулах асуудал чухал ач холбогдолтой байна. Чили Улсад Нийгмийн хөгжлийн яам нь төсөл бэлтгэх, үнэлгээ хийх чиглэлээр төрийн албан хаагчдыг сургах ажиллагааг тогтмол явуулдаг бөгөөд цахим гарын авлага, сургалтын материалаар хангадаг байна.[114] Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад албан хаагчдад төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд нь туслах зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх агентлаг байгуулжээ.[115]

Дүгнэлт: Төрийн захиргааны байгууллага, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан ажилтнуудыг холбогдох чиглэлээр нь сургах, чадавхжуулах тогтолцоог бүрдүүлэх нь зүйтэй байна.

[113] Korea Development Institute (KDI). (2022, November). *Public Investment Management (PIM) in Korea - Focusing on Preliminary Feasibility Study (PFS).* https://observatorioplanificacion.cepal.org/sites/default/files/session/1%20Buenas%20pr%C3%A1cticas%20de%20gobernanza_el%20caso%20de%20CoraYOO%20EUN%20KOH%20KDI.pdf

[114] Regional Observatory on Planning for Development in Latin America and the Caribbean. 2022. *National Public Investment System of Chile*. https://observatorioplanificacion.cepal.org/en/planning-systems/national-public-investment-system-chile

[115] German Federal Ministry for Economic Affairs and Climate Action. *Boosting investment.* https://www.bmwk.de/Redaktion/EN/Dossier/investment-strategy.html

Дүгнэлт

I. Тандан судалгаагаар асуудалд дүн шинжилгээ хийж, төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хууль, эрх зүйн нэгдмэл орчин байхгүй, тодорхой бус, зарим асуудлыг нэгдсэн байдлаар бүрэн зохицуулаагүй, Төсвийн тухай хуулиар төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх, үр дүнг тооцох, тайлагнах, өмч ашиглалттай холбоотой асуудлыг бүрэн зохицуулаагүй, зөвхөн төслийн төлөвлөлттэй холбоотой харилцааг зохицуулдаг, зарим харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулдаг, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, олон нийтийн оролцоо хангалтгүй, төслийн хөндлөнгийн үнэлгээ, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо сул, эрсдэлийн удирдлагын менежмент дутмаг болох нь тогтоогдлоо.

II. Тандан судалгаагаар дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч нэгдмэл зохицуулалтгүй, зарим зохицуулалт тодорхой бус, ойлгомжгүй тул төслийн эдийн засгийн үр ашиг, үр өгөөж хангалтгүй байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм, эдийн засгийн үр ашгийг сайжруулахын тулд хөрөнгө оруулалтын төслийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд онцгой анхаарах, төслийг сонгох, эрэмбэлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах нь зүйтэй;
- Он дамжсан, урт хугацаанд сунжирсан хөрөнгө оруулалтыг бууруулахын тулд түүний шалтгаан нөхцөлийг тогтоож зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай;
- Хуульд заасан хөрөнгө оруулалтын шалгуурыг иж бүрнээр ашиглах, сонгон шалгаруулах үйл явцыг ил тод болгох, хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төслийн зардлын тодорхой стандарт, шалгуурыг бий болгох хэрэгтэй байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарим харилцааг хуулиар, зарим харилцааг журмаар зохицуулдаг бөгөөд зарим асуудлууд огт зохицуулалтгүй буюу хууль зүйн хийдэл үүссэн байх тул үүнийг хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд жигдлэх, сайжруулах хэрэгтэй;
- Мега төсөл, ногоон хөрөнгө оруулалт, их өгөгдөлд суурилан төлөвлөлт хийх, төсөлд тохируулга хийх болон төсөлд (бие даасан) хяналт тавих, төслийн үнэлгээ хийх, төсөл хэрэгжүүлэх, төслийн тогтвортой үйл ажиллагааг хангах зэрэг асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна;
- Хөрөнгө оруулалтыг төлөвлөхөөс эхлээд төслийг сонгон шалгаруулах, гэрээлэх, хэрэгжүүлэх бүх үе шатанд төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулах, журмаар зохицуулах нь хангалтгүй бөгөөд

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг шинээр боловсруулах асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй;

III. Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг хамруулсан санхүүжилтийн оновчтой хуваарилалт, зориулалт, хамрах хүрээг тогтоогоогүйн улмаас хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг буурах, хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилт бүрэн хангагдахгүй байх, хувийн хэвшил, орон нутаг, Засгийн газрын төслүүд давхардах зэрэг асуудал, зөрчил гарч байна;
- Хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл ажил буюу зураг төсөл, ТЭЗҮ зэрэг ойлголт зохицуулалтын хувьд бүрхэг, тодорхой бус учир бүх төсөлд ижил шаардлага тавигддаг, мөн төлөвлөж хэрэгжүүлэхэд төслийн хугацаа болон зардал нэмэгдэхэд нөлөөлдөг;
- Төслийн төсөвт өртөг буюу нийт хөрөнгө оруулалтыг бодитой тодорхойлдоггүй, төслийн онцлогт тохирсон ангилал, төрөл байхгүй тул төлөвлөлт оновчгүй болж хэрэгжилт удааширч улмаар төслийн менежментийн зардал нэмэгдэх, төслийн хэрэгжилтэд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсдэг;
- Орон нутгийн төсөв, ОНХС-д тавих хяналт хангалтгүй, сангийн төлөвлөлтөд иргэд, олон нийтийн оролцоог бүрэн хангахгүй, төсөвт өртгийг хэт жижиглэснээр тендер оролцогчгүй болох, ажил он дамжих, удирдлагын мэдээллийн системд мэдээллийг дутуу болон огт оруулаагүй байхад сангаас санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд гарсаар байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, хамрах хүрээ өргөжихийн хэрээр, мөн төслийн хэрэгжилтэд тулгамдаж буй зарим асуудлаас үүдэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, зохицуулалтыг сайжруулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч байгууллагын хариуцлага, хяналтын талаарх зохицуулалт хангалтгүйн улмаас өмчийн удирдлага сулрах, ашиглалтын үр өгөөжийг тооцохгүй байх, түүнчлэн чанаргүй барилга байгууламж баригдах зөрчил гарч байна;
- Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ашиглалтын зардлыг бууруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна;
- Хөрөнгө оруулалтын олон эх үүсвэр, ялангуяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслийн талаарх нэгдсэн мэдээлэл байхгүйн улмаас Монгол Улсын хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл иж бүрэн байх шаардлагад нийцэхгүй

байна. Иймд эхний ээлжид, төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг төслийн мэдээллийг цахим системд оруулах, нэгдсэн мэдээлэлтэй болох шаардлагатай байна.

IV. Монгол улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмч, ашиглалтыг илүү үр өгөөжтэй, үр ашигтай болгоход чиглэсэн зохицуулалтын гол хувилбар нь **хуулийн төсөл боловсруулах** болох нь Тандан судалгааны дүгнэлтээр тогтоогдсон болно.

V. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16[1].5.4-т[116] заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай багц хуулийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцоход журмын зохицуулалт хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орнуудын сайн туршлагын дагуу *Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах шаардлагатай*” болохыг чухалчлан зөвлөсөн байна.

VI. Төсвийн хөрөнгө оруулалтын улс, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад зээл, тусламж зэрэг олон эх үүсвэрүүдийн бодлого, зохицуулалтыг сайжруулах, эх үүсвэрүүдийг давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, оновчтой төлөвлөж, хуваарилах, ач холбогдлын эрэмбэ, үнэлгээнд үндэслэх, шаардлагагүй тохиолдолд гадаад зээл авахгүй байх, төсөл, арга хэмжээг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд ТЕЗ, төрийн байгууллага болон бусад оролцогч талын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, санхүүжилт, зарцуулалт, бүртгэл, тайлагналт, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

VII. Иймд, төсвийн хууль тогтоомж дахь зарчмуудыг хэрэгжүүлэх, бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтыг нэгдмэл удирдлагаар хангах хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх буюу **Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг** боловсруулж, батлуулах нь зүйтэй байна.

Зөвлөмж

Дээрх дүгнэлтийн дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөлд дараах зохицуулалтуудыг тусгахыг зөвлөж байна. Үүнд:

1. Хуулийн үндсэн зорилгыг “*Төсвийн эх үүсвэрийн оновчтой хуваарилалт, зохицуулалтын дагуу эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрлийг*

[116] Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 16[1].5.4.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу төсөвтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах;

тодорхойлж, төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалтын үйл ажиллагааг нийтэд үр ашигтай, ил тод, их өгөгдөл болон цахим системийн удирдлагад суурилан хэрэгжүүлэхэд зориулж эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх" гэж тодорхойлох;

2. Хуулийн төсөлд хуулийн үйлчлэх хүрээг тогтоож, төсвийн хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ, ТЭЗҮ, мега төсөл зэрэг нэр томьёоны тодорхойлолтыг тусгах, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад баримтлах зарчим, төслийн ангилал, төрөл, цаглавар болон хориглох зүйлийн талаар зохицуулах;
3. Төсвийн хөрөнгө оруулалтын талаарх УИХ, Засгийн газар, яамд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, оролцогч бусад этгээдийн бүрэн эрх, чиг үүрэг, салбар хоорондын уялдаа холбоог авч үзэх;
4. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, үнэлгээ, төслийн шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг хуулийн төсөлд тусгах, тодруулбал, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, тэргүүлэх салбар, хөрөнгийн эх үүсвэрийн зориулалт, төлөвлөлтийн үйл ажиллагаа буюу төслийг төлөвлөх, бэлтгэх үе шат, төслүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, төлөвлөлтөд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, цахим систем ашиглах, төслийн эрсдэлийг тооцох талаар тусгах;
5. Хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх нийтлэг журам, эрх шилжүүлэх асуудал, төслийн ангилал тус бүрээр гүйцэтгэлийн санхүүжилт, түүний бүрдүүлбэр болон оролцогч байгууллагуудын чиг үүрэгт хамаарах зохицуулалтыг тусгаж, төслийн гүйцэтгэлд тавих хяналт, захиалагчийн техник, технологийн болон зохиогчийн хяналт, гэрээний удирдлага, төслийн хэрэгжилтийн тайлагналт, үр дүнгийн талаар буюу төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналтын талаар тусгайлан зохицуулах;
6. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх, дижитал технологийг ашиглах, төлөвлөлт, хэрэгжилтэд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах зэрэг асуудлыг хуулийн төсөлд тусгаж, мэдээллийн нэгдсэн сан, түүний удирдлагын талаар авч үзэх;
7. Төрийн өмчит хуулийн этгээдийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлдэг төслийн талаарх мэдээллийг нэгтгэн гаргадаг болох, улмаар холбогдох мэдээлэл төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим санд төвлөрдөг болох;
8. Хөрөнгийн удирдлага, ашиглалт, түүний үр өгөөжийг хуульд тусгах, энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон өмч, хөрөнгийг нийтийн буюу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх,

нийтийн өмч, хөрөнгийн ашиглалт, сайжруулалт, тэдгээрийн үр өгөөжийг тооцож, хөрөнгийн үнэлгээ хийх, бүртгэлжүүлэх, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах талаар зохицуулах;

9. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн асуудлыг энэ хуулиар нэгдмэл болгож зохицуулах шаардлагатай байна. Тодруулбал, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гэрээний дүнгээс тодорхой хувь хэмжээгээр тооцож төвлөрүүлж ирсэн норм, нормативын сангийн санхүүжилт, түүний зарцуулалтыг зохицуулах;
10. Түүнчлэн, төслийн эрсдэл, гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудал, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд үүсэх маргааныг шийдвэрлэх, хууль тогтоомж, гэрээний үүргийн зөрчилд хариуцлага хүлээлгэх үндэслэл, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай.
11. Үүнээс гадна, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөлтэй уялдуулан холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шилжилтийн үеийн зохицуулалт шаардлагатай бол дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл болон хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төсөл боловсруулах эсэх асуудлыг хамтад нь судалж, шийдвэрлэх нь зүйтэй.

----------o0o----------

Нэг.Монгол Улсын Үндсэн хууль

Хоёр.Олон улсын гэрээ

- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, түүний Киотогийн протокол, Парисын хэлэлцээр

Гурав.Хууль тогтоомж

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль,
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын шүүхийн тухай хууль;
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- УИХ-ын 2021 оны “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 88 дугаар тогтоол;
- УИХ-ын 2022 оны “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоол;
- УИХ-ын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө;
- УИХ-ын 2020 оны “Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 39 дүгээр тогтоол

Дөрөв.Хөгжлийн бодлогын баримт бичиг

- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”;
- УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”;
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- УИХ-ын 2024.10.08-ны өдрийн 35 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”

Тав.Захиргааны хэм хэмжээний акт

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам";
- Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор батлагдсан “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт”;
- Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”;
- Засгийн газрын 2022 оны “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” 318 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох журам болон аргачлалууд”, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаал;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”;
- Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалаар "Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм";
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 142 дугаар тушаалаар батлагдсан “Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”;
- Бусад захиргааны акт.

Зургаа.Албан даалгавар

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025.03.06-ны өдрийн 02 дугаар албан даалгавар;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2024.10.30-ны өдрийн 02 дугаар албан даалгавар.

Долоо.Эрх бүхий болон бусад байгууллагын тайлан, дүгнэлт, судалгаа

- ҮАГ-ын Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн нэмэгдэл буюу нэмэлт санхүүжилт зэрэгт 2021-2024 онд хийсэн тайлан дүгнэлт;
- ҮАГ-ын “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө”-ний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан;
- ТТБЗ-ын 2023, 2024, 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт;
- Дэлхийн банкны “Монгол улсын төрийн санхүүгийн үнэлгээ” тайлан, 2025 он;
- Дэлхийн банкны “Төсвийн зарлага, санхүүгийн хариуцлага – Үнэлгээний тайлан”, 2021 он;
- ОУВС-гийн техник туслалцааны хүрээнд хийсэн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл” тайлан, 2023 он;
- ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг сайжруулах - Техникийн туслалцааны тайлан”, 2018 он;
- Монгол Улсын 2016-2024 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээлэл, түүний хэрэгжилт, гүйцэтгэл;
- “Монгол Улсын жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлт сургамж, дараагийн алхам” бодлогын танилцуулга
- “Нээлттэй Нийгэм форум”-ын дэргэдэх төсвийн зөвлөлөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх хүрээнд 2022-2024 онд санал зөвлөмж;
- “Нээлттэй Нийгэм форум”, “Монгол Улс: Төсвийн гүйцэтгэл ба Тогтвортой хөгжлийн зорилтууд” судалгаа, 2023 он;
- Жендерийн Үндэсний хороо, “Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, салбар дундын стратеги төлөвлөгөө /2022-2031/” эмхэтгэл, 2022 он;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн тандан судалгаа;
- Барилга, хот байгуулалтын яам, “Барилгын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2023 он

Найм.Цахим хуудас

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, legalinfo.mn;
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем, publicinvestment.gov.mn;
- УИХ-ын цахим хуудас; https://www.parliament.mn;
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан;
- УАГ-ын цахим хуудас;
- https://open.audit.mn;
- Иргэдийн төсөв;
- https://energy.gov.mn/c/1374
- www.mcs.mn

Ес.Гадаад хэл дээрх эх сурвалж

- Law on Public Investment, The Socialist Republic of Vietnam;
- Law on Public Investment, Laos;
- Kim, Jay-Hyung, Jonas Arp Fallov, and Simon Groom. 2020. Public Investment Management Reference Guide. International Development in Practice. Washington, DC: World Bank. doi:10.1596/978-1-4648-1529-4. License: Creative Commons Attribution CC BY 3.0 IGO;
- IMF, “Well Spent How Strong Infrastructure Governance Can End Waste In Public Investment”, 2020;
- Public Investment Law No: 72/NA (2015) of Lao People’s Democratic Republic;
- National Finance Act (2016);
- Infrastructure and Projects Authority. (2016, March). *National Infrastructure Delivery Plan 2016–2021*; ht2904569_nidp_deliveryplan.pdf
- Law on Public Investment No. 58/2024/QH15 (2024);
- Budget Code of the Republic of Kazakhstan;
- Korea Development Institute (KDI). (2022, November). *Public Investment Management (PIM) in Korea - Focusing on Preliminary Feasibility Study (PFS)*;
- Regional Observatory on Planning for Development in Latin America and the Caribbean. 2022. *National Public Investment System of Chile*;
- German Federal Ministry for Economic Affairs and Climate Action. *Boosting investment;*
- Law on Public Investment (2024).

ХАВСРАЛТ № 1

ХҮНИЙ ЭРХ, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

1.ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	**Үгүй**	
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	**Тийм**	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах	**Тийм**	Үгүй	

	механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх			
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө байхгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	**Үгүй**	
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Эрх агуулагчийн талаар хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэх зохицуулалт байхгүй.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	**Үгүй**	
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	**Үгүй**	
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	**Үгүй**	
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Сөрөг нөлөө байхгүй.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар тусгана.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	

2.ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар

1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Өрсөлдөөний харилцааг зохицуулахгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалтын дүнд дэд бүтэц, бизнесийн орчин сайжирч, гадаадаас хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	**Тийм**	Үгүй	Түүхий эдийн үнэ, гадаадын хөрөнгө оруулалтын бууралтын сөрөг нөлөөг төсвийн хөрөнгө оруулалтыг өсгөх замаар сөрөх боломжтой.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй. Өрсөлдөөний зарчмаар явагдах худалдан авах ажиллагааны нэг гол шалгуур нь бага үнэ байна.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй. Худалдан авах ажиллагаа хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжинэ.
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Бүх төслийн гүйцэтгэгчийг өрсөлдөөнөөр сонгон шалгаруулна.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	**Үгүй**	Төсвийн хуулийн одоогийн зохицуулалттай

болон захиргааны зардал				адилаар, зөвхөн сонгон шалгаруулалтад оролцохтой холбоотой зардал гарна.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг хязгаарлалт хийгдэхгүй
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Захиргааны шинж чанартай нэмэлт зардал бий болгохгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг удирдах, ашиглах өнөөгийн хуулийн зохицуулалтыг илүү сайжруулна.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Хувийн хэвшлийн өмчлөх эрхэд ямар нэг хязгаарлалт хийгдэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийн судалгаа, үнэлгээ хийх мэдээллийн бааз бүрдэнэ.

	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй. Худалдан авалтаар дамжин шууд бус эерэг, сөрөг нөлөө үзүүлэх боломжтой боловч одоогийн Төсвийн хуулийн зохицуулалтаас дордуулахгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг нөлөө үзүүлэхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийгдсэнээр хэрэглэгчдийн эрх ашигт эергээр нөлөөлнө.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Хөрөнгө оруулалтын нийгмийн үр өгөөжнь хувь хүн/иргэдийн санхүүгийн байдалд эергээр нөлөөлнө.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжих бүс нутаг, чиглэлд шинэ ажлын байр бий болгоно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалт

				хэрэгжиж буй бүс нутгийн жижиг, дунд үйлдвэрт шууд ба шууд бус эерэг нөлөө үзүүлэх боломжтой.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Улсын төсвийн нэг бүрэлдэхүүн учир шууд нөлөөлнө
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	**Үгүй**	Шинээр байгууллага байгуулах, бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдахгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Шинэ чиг үүрэг нэмэгдэхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалтаар дамжин улс болон бүс нутгийн эдийн засгийн өсөлт, гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	**Тийм**	Үгүй	
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй. Худалдан авалтаар дамжин шууд бус эерэг, сөрөг нөлөө үзүүлэх боломжтой боловч одоогийн Төсвийн хуулийн зохицуулалтаас дордуулахгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Хуулийн төслийг Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

3.НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр ажлын байр шинээр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Эерэг байдлаар нөлөөлнө. ТХО-ын гэрээг хэрэгжүүлснээр ажлын чанар, стандарт дээшлэх боломжтой.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	**Тийм**	Төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төслийн зардлыг тооцох нэгдсэн стандарттай болно.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Нэмэлт хөрөнгө оруулалтаар шинэ технологийн шинэчлэл хийгдэж ажлын байранд

				эерэг өөрчлөлт орох боломжтой.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч төсөв захирагчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгоно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүргийг тодорхой болгоно.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд утгаар сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд утгаар сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд утгаар сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Эергээр нөлөөлнө. Хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх болно.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Хэрэв ТХО-ын төсөл амжилттай хэрэгжвэл сөрөг бус эерэг нөлөө үзүүлэх ёстой.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	ТХО-ын хэрэгжилт нь нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх тул эерэг нөлөө үзүүлнэ.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.

	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.
8. Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө байхгүй.

4.БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр Нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	

4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Шууд нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	

ХАВСРАЛТ № 2

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХАРИЛЦААНД ХАМААРАХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ

Д/д	Эрх зүйн баримт бичгийн нэр	Батлагдсан шийдвэрийн нэр, огноо, дугаар	Танилцах холбоос
1	**Монгол Улсын Үндсэн хууль**	1992.01.13	https://legalinfo.mn/mn/detail?lawId=367
	Хоёр.Нийтлэг зохицуулалттай хууль		
2.1	Авлигын эсрэг хууль	2006.07.06	https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928
2.2	Газрын тухай хууль	2002.06.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=216
2.3	Галын аюулгүй байдлын тухай хууль	2015.07.02	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11222
2.4	Гамшгаас хамгаалах тухай хууль	2017.02.02	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12458
2.5	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль	2004.04.15	https://legalinfo.mn/mn/detail?lawId=271
2.6	Захиргааны ерөнхий хууль	2015.06.19	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11259
2.7	Зөвшөөрлийн тухай хууль	2022.06.17	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530780109311
2.8	Иргэний хууль	2002.01.10	https://legalinfo.mn/mn/detail?lawId=299
2.9	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	1993.05.06	https://legalinfo.mn/mn/detail?lawId=344
2.10	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	2020.12.24	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891904801
2.11	Монгол Улсын шүүхийн тухай хууль	2021.01.15	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106892006021
2.12	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль	2004.04.15	https://legalinfo.mn/mn/detail?lawId=363
2.13	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	2012.01.19	https://legalinfo.mn/mn/detail?lawId=397
2.14	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	2021.12.17	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601
2.15	Төрийн албаны тухай хууль	2017.12.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025
2.16	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль	2023.05.04	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759635984401
2.17	Төрийн болон албаны нууцын тухай хууль	2016.12.01	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12408
2.18	Төрийн хяналт шалгалтын тухай хууль	2003.01.03	https://legalinfo.mn/mn/detail?lawId=500
2.19	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	2020.05.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=15403
2.20	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль	2016.02.05	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11711
2.21	Хөдөлмөрийн тухай хууль	2021.07.02	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751

2.22	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008.05.22	https://legalinfo.mn/mn/detail?lawId=564
2.23	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль	2018.06.21	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13589
	Гурав.Төсвийн хөрөнгө оруулалтад шууд хамаарах хууль		
3.1	Өрийн удирдлагын тухай хууль	2015.02.18	https://legalinfo.mn/mn/detail?lawId=10933
3.2	Төсвийн тухай хууль	2011.12.23	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12254
3.3	Төсвийн тогтвортой байдлын тухай хууль	2010.06.24	https://legalinfo.mn/mn/detail?lawId=503
3.4	Төрийн хэмнэлтийн тухай хууль	2022.04.29	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468624002961
3.5	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	2023.06.16	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760359992351
3.6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль	1996.05.27	https://legalinfo.mn/mn/detail?lawId=492
3.7	Тухайн жилийн төсвийн тухай хууль		
	Дөрөв.Төсвийн хөрөнгө оруулалтад шууд бус хамаарах хууль		
4.1	Авто замын тухай хууль	2017.05.11	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12656
4.2	Барилгын тухай хууль	2016.02.05	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11705
4.3	Боловсролын ерөнхий хууль	2023.07.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759958962301
4.4	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	2016.02.04	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11703
4.5	Зөрчлийн тухай хууль	2017.05.11	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12695
4.6	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль	2002.01.10	https://legalinfo.mn/mn/detail?lawId=302
4.7	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль	2021.07.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230779072091
4.8	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль	2023.12.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960742235481
4.9	Соёлын тухай хууль	2021.07.02	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709374521
4.10	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль	2007.01.11	https://legalinfo.mn/mn/detail?lawId=465
4.11	Төмөр замын тээврийн тухай хууль	2023.07.07	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760186498011
4.12	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль	2022.12.09	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532629445571
4.13	Үндэсний баялгийн сангийн тухай хууль	2024.04.19	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140188869101
4.14	Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль	2025.01.23	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355878201151
4.15	Хот байгуулалтын тухай хууль	2008.05.29	https://legalinfo.mn/mn/detail?lawId=530
4.16	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль	2015.06.26	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11219
4.17	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	1993.12.20	https://legalinfo.mn/mn/detail?lawId=532

4.18	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль	2024.06.05	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140723492761
4.19	Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хууль	2024.06.05	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140723874621
4.20	Эрүүгийн хууль	2002.01.03	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12172
4.21	Эрүүгийн хууль	2015.12.03	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634
4.22	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	2017.05.18	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694
4.23	Эрүүл мэндийн тухай хууль	2011.05.05	https://legalinfo.mn/mn/detail?lawId=49
4.24	Эрчим хүчний тухай хууль	2001.02.01	https://legalinfo.mn/mn/detail?lawId=60
4.25	Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль	2015.11.26	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11488
	Тав.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг		
5.1	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	УИХ-ын 2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=15406
5.2	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140840005441
5.3	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	УИХ-ын 2024.08.27-ны өдрийн 21 дүгээр тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311
5.4	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	УИХ-ын 2020.08.28-ны өдрийн 23 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=15584
5.5	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө	УИХ-ын 2024.10.18-ны өдрийн 35 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17142247261431
5.6	Шинэ сэргэлтийн бодлого	УИХ-ын 2021.12.30-ны өдрийн 106 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431
	Зургаа.Засгийн газрын тогтоолоор батлагдсан захиргааны хэм хэмжээний акт		
6.1	Барилгын ажлын захиалагчийн дүрэм	Засгийн газрын 2017.06.14-ний өдрийн 170 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12862
6.2	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм	Засгийн газрын 2021.07.20-ны өдрийн 213 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084743981

6.3	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм	Засгийн газрын 2021.07.20-ны өдрийн 212 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231084731981
6.4	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм	Засгийн газрын 2019.03.21-ний өдрийн 108 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=14275
6.5	Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм	Засгийн газрын 2017.12.22-ны өдрийн 353 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13036
6.6	Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам	Засгийн газрын 2016.03.28-ны өдрийн 176 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11885
6.7	Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал	Засгийн газрын 2018.01.24-ний өдрийн 20 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13231
6.8	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал	Засгийн газрын 2023.12.20-ны өдрийн 457 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960745365341
6.9	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам	Засгийн газрын 2023.07.09-ний өдрийн 278 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760272296931
6.10	Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний нөөцийн үндэсний балансыг тооцоолохтой холбогдох зардлыг санхүүжүүлэх журам	Засгийн газрын 2015.09.07-ны өдрийн 360 дугаар тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11314
6.11	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай	Засгийн газрын 2018.02.14-ний өдрийн 51 дүгээр тогтоол	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13222
	Долоо.Сайдын тушаалаар батлагдсан захиргааны хэм хэмжээний акт		
7.1	Авто зам барилгын үйлдвэрлэлийн жишиг норм	Зам, тээврийн хөгжлийн	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760042623261

	/ЗЗБНбД 83-17-2023/, Авто зам барилгын ажлын төсвийн жишиг норм /ЗЗБНбД 83-25-2023/	сайдын 2023.05.05-ны өдрийн А/141 дүгээр тушаал	
7.2	Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.03.14-ний өдрийн 49 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13340
7.3	Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.10.18-ны өдрийн 228 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13740
7.4	Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.08.08-ны өдрийн 168 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=13624
7.5	Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм /ЗЗБНбД 81-13-2019/	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.07.31-ний өдрийн 256 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=14607
7.6	Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.06.27-ны өдрийн 142 дугаар тушаал	
7.7	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертэд тавих шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам	Барилга, хот байгуулалтын сайдын 2019.12.27-ны өдрийн 213 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=14961
7.8	Барилгын төсөв зохиох дүрэм /БНбД 81-95-12* /2020/	Барилга, хот байгуулалтын сайдын 2020.02.05-ны өдрийн 30 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=15143
7.9	Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх барилгын норм дүрэм /БНбД 35-01-22/	Барилга, хот байгуулалтын сайдын 2022.05.31-ний өдрийн	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530810432291

		123 дугаар тушаал	
7.10	Барилга байгууламжийн суурийн зураг төсөл зохиох норм дүрэм /БНбД 50-01-16/	Барилга, хот байгуулалтын сайдын 2016.05.31-ний өдрийн 102 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12064
7.11	Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм /БНбД 11-04-16/	Барилга, хот байгуулалтын сайдын 2016.11.10-ны өдрийн 178 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12276
7.12	Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацаа тогтоох дүрэм	Барилга, хот байгуулалтын сайдын 2023.03.28-ны өдрийн 60 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759006261251
7.13	Барилгын зураг төслийн ажлын жишиг үнэ /БД 81-16-20/	Барилга, хот байгуулалтын сайдын 2020.06.10-ны өдрийн 108 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=15540
7.14	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх этгээдэд үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих нөхцөл, шаардлага	Барилга, хот байгуулалтын сайдын 2025.02.10-ны өдрийн 36 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17356118309801
7.15	Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам	Барилга, хот байгуулалтын сайдын 2023.11.02-ны өдрийн 259 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089502530801
7.16	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам	Барилга, хот байгуулалтын сайдын 2021.09.28-ны өдрийн 211 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16231162297631
7.17	Барилгын ажилтны тарифт цалингийн жишиг	Барилга, хот байгуулалтын сайдын 2024.05.21-	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140516767721

		ний өдрийн 95 дугаар тушаал	
7.18	Барилга байгууламжийн 2021, 2022 оны үнийн индекс	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.09.12-ний өдрийн 44 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141538948481
7.19	Барилга байгууламжийн норм нормативын сангийн журам	Барилга, хот байгуулалтын сайдын 2019.01.09-ний өдрийн 04 дүгээр тушаал	https://mcud.gov.mn/resource/mcud/LegalDocumentAttachment/2019/04/24/cbdo3i3f5fxrhqyg/04_nncangin%20juram.pdf
7.20	Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам	Сангийн сайдын 2021.01.11-ний өдрийн 4 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123489780751
7.21	Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын гэрээний үлгэрчилсэн загвар	Барилга, хот байгуулалтын сайдын 2016.11.10-ны өдрийн 179 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=12289
7.22	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам	Сангийн сайдын 2021.05.24-ний өдрийн 86 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230667295741
7.23	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам	Сангийн сайдын 2018.12.25-ны өдрийн 295 дугаар тушаал	https://publicinvestment.gov.mn/law/1000?url=/api/file/downloadFile
7.24	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журамд оруулсан нэмэлт, өөрчлөлт	Сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/264 дүгээр тушаал	https://publicinvestment.gov.mn/law/1080?url=/api/file/downloadFile/pimis
7.25	Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал	Сангийн сайдын 2023.07.04-ний өдрийн 137 дугаар тушаал	https://publicinvestment.gov.mn/law/1020?url=/api/file/downloadFile/pimis/
7.26	Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар	Сангийн сайдын	https://mof.gov.mn/files/uploads/legacy/2021_

		2021.10.29-ний өдрийн 190 дүгээр тушаал	
7.27	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025.01.20-ны өдрийн А/08 дугаар тушаал	
7.28	Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам	Эрчим хүчний сайдын 2019.05.01-ний өдрийн 125 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=14397
7.29	Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам	Эрчим хүчний сайдын 2015.12.28-ны өдрийн 188 дугаар тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=11554
7.30	Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засварын ажлын төсөв зохиох журам /ЭХН-8-81-01-2024/	Эрчим хүчний сайдын 2024.12.04-ний өдрийн А/259 дүгээр тушаал	https://legalinfo.mn/mn/detail?lawId=17350509327631
	Найм.Стандарт		
8.1	Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага	MNS 7023:2023	https://publicinvestment.gov.mn/law/1140?url=/api/file/downloadFile/pimis/

ХАВСРАЛТ № 3

ТӨРИЙН БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж

Агуулга	2023 оны төсвийн төсөлд	2024 оны төсвийн төсөлд	2025 оны төсвийн төсөлд
Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт	2010 оноос хойш үргэлжилж байгаа 980.3 тэрбум төгрөгийн 636 төсөл, арга хэмжээний (үүнээс 2010-2019 оны 171 төсөл) санхүүжилтийг 2023 онд бүрэн хийж, 10-13 жил үргэлжлэн шилжсээр ирсэн дуусаагүй байсан 80 сургууль, 63 цэцэрлэг, 53 авто зам, 43 эмнэлэг, 47 соёлын төв, 24 спортын байгууламж, 35 дэд бүтэц, 12 эрчим хүчний байгууламжийг барьж дуусган ашиглалтад оруулахаар төлөвлөсөн нь бүх талаар дэмжих төсөл болжээ. Ингэхдээ барилга, объектын төсөвт өртгийн зайлшгүй үнийн өсөлт болох 303.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг ч шийдсэн байна. 636 төсөл хэрэгжүүлэгч 476 компанийн 28 мянган ажиллагчид ажлын байраа хадгална.	Засгийн газраас нийгмийн чиглэлийн хөрөнгө оруулалтад түлхүү анхаарч байгаа нь сайн боловч хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, орлого олох төслийг нэмэгдүүлэх шаардлагатай.	Аливаа төслийг урьдчилан сайтар судалсны үндсэн дээр түүнийг ямар эх үүсвэрээс, ямар арга замаар санхүүжүүлэх нь хамгийн оновчтой болохыг тодорхойлдог. Бүхий л төслийг улсын төсвөөс, гадаад зээлээр санхүүжүүлнэ гэж төлөвлөх нь оновчтой бус бөгөөд зарим томоохон мега төсөлд төсвийн болон гадаад зээллэгийн санхүүжилт ашиглахаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг оролцуулсан холимог санхүүжилтийн аргыг (Blended finance) хэрэглэх нь оновчтой байдгийг анхаарах.

Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт	2022 онд шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн боловч гэрээ байгуулаагүй 193.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2023 онд шилжин санхүүжих 153 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардах 47 төсөл, арга хэмжээг төсөвт тусгаагүй хойшлуулжээ. Эдгээрийг төсөлд тусгасан ч хэрэгжихгүй, хуулийн заалтыг зөрчсөн урьд оны төлөвлөлтийг давтсан хэрэг болох байсан.	Олон төслийг нэгэн зэрэг эхлүүлж, жил дамнан бүтээн байгуулах бус, цөөн тооны ач холбогдол өндөртэй төсөлд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм.	Шинэ төслийн төсөвт өртөг, олон жил дамнасан хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийн өөрчлөлт болон ижил төстэй хөрөнгө оруулалтын зардлын ялгаатай байдлыг хөндлөнгөөс хянахын тулд стандарт, шалгуурыг бий болгох зайлшгүй шаардлагатай. Хөгжлийн зарим төслийн хувьд ТЭЗҮ, зураг төслийн зардлаас гадна ямар урьдчилсан судалгаа, тооцоонд үндэслэн нийт төсөвт өртгийг гаргасан нь тодорхойгүй байгаа нь цаашид олон улсын нэршлээр “Цагаан заан” төслийг бий болгох эрсдэлийг нэмэгдүүлж магадгүй. Иймээс хөрөнгө оруулалтын төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төслийн жишиг зардлын хувь хэмжээг тодорхойлсон хязгаарыг бий болгох хэрэгтэй.
Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт	Өнөөгийн явц, хэрэгжилтээс үзэхэд зохих журам, хуулийн дагуу гүйцэтгэл гаргах боломжгүй, 2023 онд хэрэгжих ямар ч найдвар, боломжгүй хоёр объектын 6 тэрбум төгрөгийг төсөвт тусгах боломжгүй гэж үзсэн нь зүйтэй байна.	2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлоготой бүрэн уялдаж чадсан эсэх нь эргэлзээтэй байна.	ОУВС-аас төсвийн хөрөнгө оруулалтын менежментийн үнэлгээг 2023 онд хийж, тайлан гаргасан. Уг тайлангаар Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг бүс нутаг, хөгжиж буй орнуудын хэмжээнд доогуур байгааг анхаарч төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бодитойгоор хэмжих, дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын нийгэм,

			эдийн засгийн үр ашгийг сайжруулахын тулд хөрөнгө оруулалтын төслийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд онцгой анхаарах.
Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үнэлгээ	Урьд оны төсөл, арга хэмжээний санхүүжилтээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн (13.1.1) дагуу тендерээр хэмнэлт гарсан 409 төсөл, объектын 65.8 тэрбум төгрөгийг 2023 онд зарцуулахаар төлөвлөснийг дэмжиж байна.	2024 онд олон төслийг нэгэн зэрэг эхлүүлж, жил дамнан бүтээн байгуулах бус, цөөн тооны ач холбогдол өндөртэй төсөлд илүү ач холбогдол өгч богино хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахад анхаарах нь тухайн төслийн өртөг жил бүр өсөх, үйлдвэрлэлийн явц удааширч алдагдсан боломжийн өртөг нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөг бууруулах боломжтой юм.	Хөрөнгө оруулалтыг үнэлж эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь Засгийн газар, Сангийн яамны баталсан журмын хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь сул талтай байна. Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явц нь ЭЗХЯ, Сангийн яам, ТЕЗ-ийн оролцоотой хийгддэг боловч үүнд ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдаж байна. Мөн төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төслийг тусгахдаа хөрөнгө оруулалттай холбоотой дээрх дүрэм, журмыг баримталдаг эсэх нь тодорхойгүйгээс гадна хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй, зураг төсөл, ТЭЗҮ нь гараагүй, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй төслийг улсын төсөвт тусгах асуудал байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Иймд хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлж эрэмбэлэх,

			сонгох одоогийн хууль, дүрэм журмыг сайжруулах шаардлагатай.
Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хууль, эрх зүйн орчин	Төсвийн хөрөнгө оруулалтаар ирэх онд санхүүжүүлэх төслийн 50 гаруй (51.9) хувийг орон нутагт хэрэгжүүлэх санал зүйтэй байна.	Урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдэхдээ өмнө нь хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд үндэслэдэг байх хэрэгтэй.	Хөрөнгө оруулалтын бодлого чиглэл, бүтцийн хувьд сайжирч байгаа боловч макро эдийн засаг, нийгмийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь санхүүжилтийн эрсдэл, гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болзошгүй юм. Хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх хууль зүйн орчныг эрс сайжруулах шаардлагатай.

Хоёр. Үндэсний Аудитын газрын дүгнэлт, зөвлөмж

2021 он	2022 он	2023 он	2024 он
1.Төсөл, арга хэмжээний бэлтгэл			
Хөрөнгө оруулалтыг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий цөөн төсөлд хуваарилж, богино хугацаанд хэрэгжүүлэх. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байгаагаас хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч, төсөвт ачаалал үүсэж байна.	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ ялангуяа барилга байгууламжид төлөвлөлтийн үе шатнаас эхлэн ашиглалтын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хяналт тавих нэгдсэн систем, цахим сан байхгүйгээс төсөл, арга хэмжээ дутуу орхигдох, хаягдах, зарцуулсан хөрөнгө үргүйдэх байдал ажиглагдаж байна.	Төсөвт өртөг, нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих хяналт хангалтгүй байгаад ТЕЗ нар анхаарч, үе шатны хяналтыг сайжруулах. Барилга байгууламжийн ажилд үе шатны хяналт гүйцэтгэж байгаа байгууллагын хүний нөөцийн хангамж, ур чадвар, мэргэшсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, захиалагчийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай.	Санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр гурван жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээнд төсөв батлагдахгүй орхигдох эрсдэлийг үүсгэж байна. Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэн, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх.
2.Төслийн төлөвлөлт			

Төсвөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлэн баталж, салбарын түвшинд төлөвлөөгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хүн ам зүй, газар зүйн байршил, бусад хүчин зүйлстэй бүрэн уялдуулж төлөвлөөгүйгээс нийгмийн тогтвортой хөгжилд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн.	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөдөг зөрчлийг давтан гаргасаар байгаа ТЕЗ нарт хариуцлага тооцох. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий цөөн төсөлд хуваарилж, богино хугацаанд хэрэгжүүлэх.	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, эрэмбийг баримтлаагүйгээс төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөхгүй байгаа нь хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх шалтгаан болж байна.	Төсвийн төслийн хамт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
3.ТЭЗҮ, зураг төсөл			
Газрын асуудал шийдэгдээгүй, ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсөл, төсөв батлуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээний дүнгээс магадлалаар баталгаажсан төсвийн дүн бага байх, хэрэгжилтэд тавих дотоод хяналт тавих.	Зарим зураг, төсөл, тоног төхөөрөмжийг ашиглахгүй байгаагаас шаардлага хангахгүй болж төсвөөс үргүй зардал гарах нөхцөлийг үүсгэж байна.	Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын чанар, гүйцэтгэлд илэрч байгаа нийтлэг зөрчил, тулгамдаж байгаа асуудалд судалгаа, шинжилгээ хийж норм нормативын сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч ажиллах.	ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох.
4.Төсөвт өртгийн нэмэгдэл болон барилгын үнийн өсөлт			

Магадлалаар баталгаажаагүй төслийг төсөвт өртгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нь хуулийн шаардлага хангаагүй, улмаар төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Барилгын материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатал гарч төсөл бүрэн дуусахгүй, хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүссэн зэрэг нь цаашид энэ тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай.	Төсөвт өртгийн нэмэгдлийн суурь нь магадлал бөгөөд төслийн байршил өөрчлөгдөх, барилга байгууламжийн үндсэн хийцлэлд өөрчлөлт орох, төлөвлөсөн хугацаанд ажил эхлээгүй зэрэг шалтгааны улмаас төслийн төсөвт өртгийг шинээр магадлах нөхцөл үүсдэг. Төсөл нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталдаг нь цаашид төсөвт өртөг нэмэгдэх, олон жил үргэлжлэх, төсөв хэмнэх боломжийг алдах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.	Төсөвт өртөг, нэмэгдэл зардлын үндэслэл, тооцоололд тавих хяналт хангалтгүй байгаад ТЕЗ нар анхаарч, үе шатны хяналтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, захиалагч болон зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцох шаардлагатай. Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаанд хяналт хийж, холбогдох хууль, журмын хэрэгжилтийг тооцож, иргэн хуулийн этгээдийн магадлал хийх эрх олгох үйл ажиллагаанд тэгш өрсөлдөөнийг бий болгох.	Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.
5.Хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл			
Улсын төсвөөр санхүүжүүлж байгаа төслийн хэрэгжилтэд зохиогч болон захиалагчийн хяналт үр дүнтэй хэрэгжээгүйгээс барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах боломжгүйд хүрч хөрөнгийн ашиглалт, чанарыг		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, эдийн засгийн үр өгөөжөөр нь эрэмбэлж төлөвлөхгүй, санхүүжилтийн эх	

бууруулж байгаад анхаарч, гүйцэтгэгч, хяналт хэрэгжүүлэгч байгууллагатай чанарын үр дүнг тооцож ажиллах		үүсвэрийг оновчтой ашиглахгүй байна.	
6.Хууль, эрх зүйн орчин			
Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд барилгын материалын хомсдол, үнийн өөрчлөлт, тээвэрлэлтийн саатал гарч төсөл бүрэн дуусахгүй, хэрэгжилт удаашрах нөхцөл байдал үүссэн зэрэг нь цаашид энэ тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаарх хууль зүйн орчныг тодорхой болгох шаардлагатайг толилуулж байна.	Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад зарцуулсан хугацаа аймагт дунджаар 7-68 хоног байгаа бөгөөд сонгон шалгаруулах зарим үйл ажиллагаа хууль, журмын хүрээнд зохион байгуулагдаагүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийг боловсруулахад ил тод, хариуцлагатай байх зарчмыг мөрдөж ажиллахад УИХ-тай хамтарч ажиллах.	Магадлалын дүгнэлтийн нэршил янз бүр, нэгдсэн загвар маягтгүй, нэмэлт ажлын магадлалын дүгнэлтэд барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг тусгахгүй байгаагаас захиалагч, гүйцэтгэгч нарт ойлголтын зөрүү үүсэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд илүү, дутуу дүнгээр тусгах эрсдэлийг арилгаж, нэгдсэн загварт оруулж, баталгаажуулах. Хариуцлагыг нэмэгдүүлэх, захиалагч болон зохиогчийн хяналт гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцох шаардлагатай.	Цахим систем нэршлээр төсвийн төсөлд тусгасан төсөл болон ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох. Төслийн байршлыг “бүсүүдэд” болон “улсын хэмжээнд”, “салбарын хөрөнгө оруулалт” зэрэг нэршлээр тодорхой бус байдлаар төлөвлөснийг байршил, төсөвт өртгийг тусгайлан хэлэлцэж батлах шаардлагатай.

Гурав.“Нээлттэй Нийгэм Форум”-ын санал, зөвлөмж

	2022	2023	2024
Тулгамдсан асуудал	Улсын төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд баримтлах зарчим хэрэгжихгүй байна. Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөхгүй байна.	Төсөвт урт хугацааны бодлогын төлөвлөлт, зорилт тусгадаггүй, ихэвчлэн богино хугацааны “гал унтраах” зорилгыг хамруулж эхний ээлжид хуулийн хугацаанд нь төсвөө батлуулаад явц дунд нь тодотгол хийдэг практик байна.	Төсөл, арга хэмжээний төлөвлөлт буруу, газрын зөвшөөрөл шийдэгдээгүй ажлыг төсөвт тусгаснаас үүдэн төсөвт өртөг нэмэгдэж, хэрэгжилт удааширдаг.
Төслийн төлөвлөлт, шаардлага	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг санал болгож байна. Үүнд:-Аль салбарт, ямар үйл ажиллагааг төр цаашид санхүүжүүлэхгүй вэ гэдгийг шийдэх; - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга, объектын эдийн засгийн үр ашиг, ашиглалтын байдлыг дүгнэх; Чанар муутай барилга, объект барьж, хүлээн авч байгаа нь улсын төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нэг нөхцөл болно. Иймд чанар, стандартыг цоо шинээр мөрдүүлэх. Улсын төсвийн хөрөнгөөр ирэх онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний	2024 онд өмнөх жилүүдээс шилжин ирсэн төслийн өртгийн өсөлт 1.2 их наяд төгрөгт хүрсэн, мөн дэд бүтцийн бүтээн байгуулалт, сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж ихээр төлөвлөсөн нь бодлогогүйгээр эхлүүлсэн ажил болж төсөвт дарамт бий болгосон. Төсвийн төлөвлөлтөд шинэ төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлоготой уялдуулах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршил, зориулалт, сонголт дээр холбогдох тооцоо, судалгааг нарийн хийх, төслийн үр ашгийн мэдээллийг нийтэд ил болгох, судлаачид, олон нийтийн оролцоог зайлшгүй хангах шаардлагатай гэж үзэж байна.	Эх үүсвэр үл хамааран УХОХ-т тусгагдаагүй төсөл, арга хэмжээг жилийн төсвийн төсөлд тусгахгүй байх, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаах; Шинээр эхлэх барилга, байгууламжийн хэрэгжүүлэх хугацааг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах; Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх; ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөл, төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

	маягтад шинээр эхлэх төслийн хувьд “тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг нийт төсөвт өртөгт эзлэх хувиар”, шилжих төслийн хувьд “анх батлагдсан төсөвт өртөг” гэсэн мэдээллийг нэмэх.		
Хяналт, хэрэгжилт	Яамдаас ирүүлсэн саналд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн багаар дүгнэлт гаргуулж, дүгнэлтийг хэлэлцэх; төсөл санаачлагчийн мэдээллийг ил болгох; Төсөл, арга хэмжээнд дахин давтагдахгүй код өгөх; Хуулийн дугаараар явж буй одоогийн байдлыг өөрчлөх, уг кодыг төсөл хэрэгжиж эхлэхээс улсын хөрөнгийн бүртгэлд бүртгэн, ашиглаж дуусах хүртэлх бүхий л шатанд хэрэглэх	2023 онд хийгдсэн нэг ололт нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийг кодчилох явдал байсан. Энэхүү дэвшилтэт арга хэрэгслийг улам төгөлдөржүүлж энэ жилийн төсвөөс эхлэн батлагдсан төслийг кодоор нь шилэн дансанд байршуулж иргэд болон хуулийн этгээд, олон нийтийн төлөөлөл, байгууллага төслийн явц, байдлыг нь фото зураг болон мэдээллээр оруулж хэрэгжилт, мониторинг, хяналт хийдэг олон нийтийн тогтолцоог бий болгох нь зүйтэй байна.	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтөөс эхлээд гүйцэтгэж дуусах хүртэл бүхий л үе шатыг хамарсан цахим хувийн хэрэг нээж, олон нийтэд ил тод болгох замаар олон нийтийн хяналтад оруулах; төслийг хөндлөнгийн экспертээс бүрдсэн багаар хөндлөнгийн үнэлгээ хийдэг болох. Үүний дараа төслийн ач холбогдлын эрэмбийг тодорхойлох.
Хууль, эрх зүйн орчин			Төсвийн тухай хууль, "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам" зэрэг төсвийн холбогдох хууль, журмыг зөрчсөн

			төрийн албан хаагчдад ямар арга хэмжээ авахыг тодорхой болгох. Түүнчлэн УИХ-аас төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл баталсан тохиолдолд хүлээх хариуцлагыг чангатгах, ажлаа цаг хугацаандаа дуусгаагүй гүйцэтгэгчийг хар жагсаалтад оруулах, үлдсэн ажлыг өөрийнх нь хөрөнгөөр дуусгах зохицуулалтыг Төсвийн тухай хуульд оруулах.

ХАВСРАЛТ № 4

ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТОЙМ СУДАЛГАА

УДИРТГАЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаа нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, төсөвт тусгах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах, төслийн үр дүнд бий болсон хөрөнгө буюу төрийн болон орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, удирдах гэсэн үе шатаас бүрддэг. Эдгээр бүхий л үе шатанд шүүхэд ямар хэрэг маргаан үүсэж байна, хэрхэн шийдэгдэж байгаа зэргийг судлах нь төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдсан асуудал, төрийн болон орон нутгийн байгууллагын үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдлыг илрүүлэхийн сацуу асуудлыг шийдвэрлэх санал боловсруулахад дөхөм болно. Шүүхийн практикийн тойм судалгааг дээрх зорилгоор хийв.[117]

НЭГ.ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

УДШ-ийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдаанаар 2018.01.01-ний өдрөөс 2025.04.26-ны өдрийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэсэн төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хамаарах захиргааны хэргийг түүвэрлэн судлав. Тухайн хэрэг маргааныг шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн тогтоолын хууль зүйн дүгнэлтүүдээс төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулсан анхдагч хуулийн төсөл боловсруулахад ач холбогдолтой хэмээн үзсэн хэсгийг авсан болно.

1.1.Барилгын ажлын тендерийг оны төгсгөлд зарлах нь ажил гүйцэтгэх хугацааг гэрээнд бодитой тусгахгүй байх, улмаар уг хугацаа зөрчигдөхөд нөлөөлж байна.

Хэргийн мэдээлэл:	“А” ХХК-ийн нэхэмжлэлтэй Эрүүл мэндийн яаманд холбогдох захиргааны хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Гүйцэтгэлийн баталгааг цуцлахаас татгалзсан Эрүүл мэндийн яамны шийдвэрийг хууль бус болохыг тогтоож, цуцлахыг даалгах

Хэргийн үйл баримт: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2018.10.02-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, улмаар 2018.10.30-ны өдөр “А” ХХК зооноз өвчин судлалын төвийн агуулахын барилга барих гэрээ

[117] Шүүхийн практикийн тойм судалгаанд анхан шатны шүүхийн шийдвэрийг “шийдвэр”, давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг “магадлал” гэж, хяналтын шатны шүүхийн шийдвэрийг “тогтоол” гэж тусгав.

байгуулсан. Гэрээнд зааснаар 16.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банканд байршуулсан. ҮАГ-ын 2019.06.05-ны өдрийн актаар санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. “А” компани гүйцэтгэлийн баталгааг цуцлахаар Эрүүл мэндийн яаманд хандсан боловч татгалзсан хариу авсан. Нэхэмжлэгч гэрээнд заасан хугацаанд барилгын ажлыг хийж гүйцэтгээгүй бөгөөд санхүүжилт авахын тулд барилга угсралтын ажил 68 орчим хувийн гүйцэтгэлтэй гэж хуурамч материал бүрдүүлжээ.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: ТБОНӨХБАҮХАтХ-ийн 5.1.17, 43.1, 43.2, 43.3, 43.4, 43.4.1-д зааснаар гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангахыг баталгаажуулж, гэрээнд гарын үсэг зурахаас өмнө ирүүлсэн банкны баталгааг гүйцэтгэлийн баталгаа гэж ойлгох бөгөөд уг баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байхаар хуульд зохицуулагджээ.

Нэхэмжлэгч 2018 онд барилга угсралтын ажлыг гүйцэтгээгүйн дээр ажлын бодит бус гүйцэтгэлийг Барилгын хөгжлийн төв болон тус яамаар баталгаажуулан санхүүжилт авахаар хандаж, хууль зөрчсөн нь шалгалтын явцад илэрсэн тул ТБОНӨХБАҮХАтХ-ийн 43.3-т заасныг дурдаж гүйцэтгэлийн баталгааг цуцлахаас татгалзсан хариуцагчийн 2019.08.08-ны өдрийн 2/3561 дүгээр шийдвэр хууль зөрчөөгүй байна.

Нэхэмжлэгчээс “... объектив хүчин зүйлийн улмаас ажлыг гүйцэтгэх боломжгүй байсан ...” гэж маргаж байгаа ч нэхэмжлэгчийн хувьд анх өөрөө хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцож шалгарсан, 2018.11.30-ны өдөр захиалагчтай гэрээ байгуулахдаа гэрээний 4-т “... агуулахын байрны барилга угсралтын ажлыг 2018.11.30-ны өдөр эхэлж, 2019.06.30-ны өдөр ашиглалтад оруулна.” гэж тохиролцсон тул дээрх гомдлыг хүлээн авах боломжгүй.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхив.

Оны төгсгөлд тендер зохион байгуулсан нь төсвийн жил дуусах үетэй зэрэгцэж байгаагаас гэрээнд ажил гүйцэтгэх хугацааг хэрэгжих боломжтой байдлаар тусгаагүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл удаашрах нэг шалтгаан нөхцөл нь энэ болно. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтыг буцаан татахаас өмнө санхүүжилт авах зорилгоор хуурамч баримт бичиг бүрдүүлж, үүнд нь төрийн болон нийтийн албан хаагчид оролцжээ. 1.Цаашид төсвийн жил хуанлийн жилтэй адил байх нөхцөлд зайлшгүй шалтгааны улмаас оны төгсгөлд гэрээ байгуулсан төслийн санхүүжилтийг буцаан татахгүй байх талаар судлах, 2.Төрийн болон нийтийн албан хаагчид хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, түүнд оролцсон нь тогтоогдсон нөхцөлд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг ойлгомжтой, тодорхой болгох шаардлагатай байна.

1.2.Төсвийн тухай хуульд нэмэлт зардлыг тусгасан нь гүйцэтгэгчид уг дүнгээр санхүүжилтийг шууд олгох үндэслэл болохгүй.

Хэргийн мэдээлэл:	“Э-Ө” ХХК-ийн нэхэмжлэлтэй Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргад холбогдох захиргааны хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлын үлдэгдэл болон нэмэлт зардлын төлбөрийг 2019 оны Монгол Улсын нэгдсэн төсөвт тусгагдсан дүнгээр олгохоос татгалзсан Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын үйлдлийг хууль бус болохыг тогтоож, үлдэгдэл болон нэмэлт төлбөрийг Монгол Улсын нэгдсэн төсөвт тусгагдсан дүнгээр олгуулах тухай шийдвэр гаргаж, гэрээ байгуулахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргад даалгах

Хэргийн үйл баримт: “Э-Ө” компани Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны чиглэлийн 35 кв-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг 8.4 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр 2014.04.24-нд гэрээ байгуулсан. Гэрээгээр ажлыг 2014.05.01-ний өдрөөс 2014.09.30-ны өдрийн дотор гүйцэтгэхээр тохиролцсон. Ажил хүлээлгэн өгөх хугацааг 2 удаа сунгасан. 2016.12.28-нд туршилтын хүчдэлд залгахаар шийдвэрлэж, 2019.09.05-нд ашиглалтад оруулсан.

Нэхэмжлэгч 2017 оны 01 дүгээр сард төсөвчинд захиалга өгсөн ба уг ажлын төсвийг 2014 оны үнэд биш 2017 оны норм дүрэм, жишиг үнэд тулгуурлан төсөвт өртгийн дүн 11.4 тэрбум төгрөг буюу 3 орчим тэрбум төгрөгийн илүү зардал гарсан гэж тооцсоныг ЭХХТ-ийн 2017 оны магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018.08.24-

ний өдрийн в/300 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүсэлт хүргүүлсэн бөгөөд Сангийн яамнаас 2019 оны төсөвт тусган батлагдсан.[118]

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Төсөвчин ямар үндэслэлээр 2017 онд мөрдөгдөж байсан норм дүрэм, жишиг, үнэд тулгуурлан дахин төсөвт өртгийг 11.4 тэрбум төгрөгөөр тооцож гаргасан талаарх болон Эрчим хүчний хөгжлийн төв 2017 оны 170/2017 дугаар магадлалын ерөнхий дүгнэлт гаргах болсон шалтгаан, үндэслэл зэргийг тодруулах ажиллагааг хийх шаардлагатай.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхив.

1.Ажил гүйцэтгэх хугацааг шалтгаан, үндэслэлийг сайтар судалсны үндсэн дээр сунгах, ингэхдээ гэрээний нийт үнийн дүнг нэмэгдүүлэхгүй тухай заалт гэрээнд оруулах шаардлагатай. 2.Гэрээнд гүйцэтгэгчийн хүлээх хариуцлагыг ойлгомжтой, тодорхой тусгадаг болох нь зүйтэй. 3.Эрх бүхий этгээд (ЭХХТ зэрэг) төсөвт өртгийн нэмэгдлийг баталгаажуулахдаа хариуцлагатай ханддаг болох, гэрээний аль талын буруутай үйл ажиллагааны улмаас төсөвт өртөг нэмэгдсэн талаар дүгнэдэг байх нь төсөвт өртөг шалтгаангүйгээр нэмэгдэх явдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

Тайлбар: УДШ-ийн дээрх тогтоолын дараа Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020.11.05-ны өдрийн 128/ШШ2020/0732 дугаар шийдвэр[119], Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021.01.28-ны өдрийн 221/МА2021/0069 дүгээр магадлалаар[120] барилга угсралтын ажлын үлдэгдэл болон нэмэлт зардлын төлбөрийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тусгагдсан дүнгээр санхүүжилт олгохоос татгалзсан Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын үйлдэл хууль бус болохыг тогтоож, гэрээний үүргийг дүгнэж, нэмэгдсэн зардлыг бодит үнийн дүнгээр тооцож олгуулах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, гэрээ байгуулахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргад даалгажээ.

---

[118] Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт болох “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын “XVI.Эрчим хүчний сайд” гэсэн хэсгийн XVI.1.1-д “Баруун-Урт-Асгат-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/ эхлэх 2014, дуусах 2019, төсөвт өртөг 11,484.1 сая төгрөг, санхүүжих дүн 3,504.8 сая төгрөг” гэжээ. https://legalinfo.mn/mn/detail?lawId=208793&showType=1

[119] https://shuukh.mn/single_case/7434?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1

[120] https://shuukh.mn/single_case/3972?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1

1.3.Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах эрх авснаас хойш зургаан сарын хугацаанд барилгын ажлаа эхлүүлээгүй нь уг эрхийг цуцлах үндэслэл болно.

Хэргийн мэдээлэл:	“Х” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Нийслэлийн Засаг даргын 2019.03.18-ны өдрийн А/202 дугаар “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах тухай” захирамжийг хүчингүй болгуулах

Хэргийн үйл баримт: Нийслэлийн Засаг даргын 2014.04.28-ны өдрийн А/340 дүгээр захирамжаар нэхэмжлэгч “Х” ХХК-ийг Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 7 дугаар хорооны нутаг дэвсгэр “Ханын материал орчим” ГХДТ-201/31 багцын “Б1”, “В1” талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсныг батламжилсан. Нэхэмжлэгч нь “В1” талбайд газар чөлөөлөлт хийгээгүй, барилгын ажлыг эхлүүлээгүй тул нийслэлийн Засаг даргын 2019 оны А/202 дугаар захирамжаар төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцалсан.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 46 дугаар тушаалаар батлагдсан “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”-ын[121] 5.2-т “Төсөл хэрэгжүүлэгч нь ... барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авснаас хойш 6 сар хүртэл хугацаанд барилгын ажлыг эхлүүлээгүй, төслийг хэрэгжүүлэх явцдаа үйл ажиллагааны болоод техникийн зөрчил гаргасан, төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай дахь чөлөөлсөн газрыг төсөлд тусгагдсанаас өөр зориулалтаар ашигласан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, гурван талт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгээгүй тохиолдолд Хяналтын хорооны саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга нь төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцална.” гэж заасан. Энд төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах зэрэгцсэн 3 нөхцөлийг заасан байх бөгөөд нэхэмжлэгчийн хувьд “... барилгын ажлыг эхлүүлээгүй, ... гурван талт гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй...” гэсэн нөхцөл бүрдсэн.

[121] https://legalinfo.mn/mn/detail?lawId=208364&showType=1

“Эрх бүхий байгууллагаар тогтоолгоогүй” гэсэн үндэслэлээр хэргийг дахин хэлэлцүүлэх шаардлагагүй. Нөгөөтээгүүр, тухайн талбайд ямар ч ажил хийгдээгүй нь тодорхой байхад “төслийг хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны болоод, техникийн ноцтой зөрчил удаа дараа гаргасан эсэхийг эрх бүхий этгээдээр тогтоолгох шаардлагатай ...” гэж байгаа нь ойлгомжгүй бөгөөд боломжгүй юм.

Маргаан бүхий актад журмын 5.3 дахь заалтыг үндэслэсэн боловч бодит нөхцөлд уг нөхцөл бүрдсэн эсэхээс үл хамааран журмын 5.2-т заасан нөхцөл нь дангаараа төсөл хэрэгжүүлэх эрхийг цуцлах хангалттай үндэслэл болно.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхив.

Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журмын 4.8-д “Сонгосон талбайд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах инженерийн болон нийгмийн дэд бүтцийн төрийн нийтийн зориулалттай барилга байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээг тухайн шатны Засаг дарга хариуцан хэрэгжүүлнэ.” гэж заасан талаар нэхэмжлэгч тал тайлбарлан маргадаг.
Цаашид адил төстэй төсөл хэрэгжүүлэх гэрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг хэн, ямар хугацаанд хийх талаар тодорхой тусгах нь зүйтэй.

1.4.Төсөл хэрэгжүүлэх газар чөлөөлөхөд гарсан зардал болон учирсан хохирол нь хууль зүйн хувьд ялгаатай ойлголт юм.

Хэргийн мэдээлэл:	“Г” ХХК болон “В” ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд холбогдох захиргааны хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	1.Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.09.26-ны өдрийн “Нийслэлийн өмчид хөрөнгө бүртгэн авах тухай” 147 дугаар тогтоолын “Г” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, 2. Инженерийн барилга байгууламж байрлаж байгаа газрыг чөлөөлөхөд гарсан 3.6 тэрбум төгрөгийн учирсан хохирлыг нийслэлийн Засаг даргаас гаргуулах

Хэргийн үйл баримт: “Г” болон “В” ХХК-иудын түншлэлийг нийслэлийн Засаг даргын 2014.06.04-ний өдрийн А/464 дүгээр захирамжаар төсөл хэрэгжүүлэгчээр батламжилсан. Нэхэмжлэгч төсөл хэрэгжүүлэх явцад 3*3 хэмжээтэй, 2.1 км инженерийн байгууламж бүхий дулаан, цахилгаан, цэвэр ус, холбоо дохиоллын шугам сүлжээ, ариутгах татуурга буюу бохир усны хоолой зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018.09.26-ны өдрийн 147 дугаар тогтоолоор

Хөгжлийн банк, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо, Батлан хамгаалахын их сургууль орчимд байрлах хавсралтад заасан нийт 12.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий ус, дулаан дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийн нэвтрэх сувгийн байгууламж, гадна дулааны шугам сүлжээг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрсөн.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 147 дугаар тогтоолын “Г” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, газар чөлөөлөхөд гарсан 3.6 тэрбум төгрөгийн хохирлыг нийслэлийн Засаг даргаас гаргуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгож, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 147 дугаар тогтоолын “Г” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, газар чөлөөлөхөд гарсан хохирлыг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014.02.20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны журам”-ын 4.22-т “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн сонгосон талбайн газар чөлөөлөх ажлын зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.” гэж заасан. “Сонгосон талбай” гэдэгт барилгажих орон сууцны барилгууд орчны газрын хамт, эсхүл зөвхөн ус, дулаан дамжуулах төвийн барилга, тоног төхөөрөмж, инженерийн барилга байгууламжийн газар хамаарах эсэхийг ялган эрх зүйн үндэслэл бүхий дүгнэлтийг нэг мөр хийлгүйгээр “Иргэний хуульд заасан эд хөрөнгө нийлэх, холилдох нөхцөл үүссэн” гэж, “газар чөлөөлөх зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцахаар заасан байхад уг зардлыг хохирол учирсан гэж хариуцагчаас гаргуулахаар нэхэмжилж байгаа нь үндэслэлгүй” хэмээн анхан болон давж заалдах шатны шүүх дүгнэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчимд нийцэхгүй байна.

Нэхэмжлэгчийн гаргасан зардал болон нэхэмжлэгчид учирсан хохирол ялгаатай ойлголт.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд буцаав.

Дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх гэрээнд зардал, хохирол гэдэгт юу багтах болон гэрээний аль тал, хэрхэн хариуцахыг тодорхой тусгах шаардлагатай.

Тайлбар: УДШ-ийн дээрх тогтоолын дараа Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2022.09.13-ны өдрийн 128/ШШ2022/0667 дугаар шийдвэрээр[122] нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 147 дугаар тогтоолын "Г" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, зардлын санхүүжилтийг шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй Нийслэлийн Засаг даргын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, зардлын санхүүжилтийг шийдвэрлэж төлөхийг Нийслэлийн Засаг даргад даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, "Г" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагаас зарим хэсгийг хангаж, газар чөлөөлөх зардлын санхүүжилтийг шийдвэрлэх үүргээ биелүүлээгүй Нийслэлийн Засаг даргын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, 3.08 тэрбум төгрөгийн зардлын санхүүжилтийг шийдвэрлэж "Г" ХХК-д төлөхийг Нийслэлийн Засаг даргад даалгаж, нэхэмжлэлийн шаардлагаас нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 147 дугаар тогтоолын "Г" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, дэд бүтцийн газар чөлөөлөлтийн 583.4 сая төгрөгийн зардлын санхүүжилтийг шийдвэрлэж төлөхийг Нийслэлийн Засаг даргад даалгах шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.

1.5.Концессын гэрээнд гадаад валютын ханшийн зөрүүг тооцох аргачлалыг тодорхой тусгах шаардлагатай.

Хэргийн мэдээлэл:	"А" ХХК-ийн нэхэмжлэлтэй Сангийн яам, ЭЗХЯ-нд холбогдох захиргааны хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Монгол Улсын Засгийн газар болон "А" ХХК-ийн хооронд байгуулсан "Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн Барих-шилжүүлэх" (BT) концессын гэрээний эргэн төлөлт хийгдсэн өдрийн гадаад валютын ханшийн зөрүүнээс концесс эзэмшигч "А" ХХК-д үүссэн алдагдал болох 2 сая ам.доллар буюу 5.7 тэрбум төгрөгийг ирэх жилийн улсын төсөвт тусгах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхгүй байгаа хариуцагч Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, концесс эзэмшигч "А" ХХК-д үүссэн алдагдал болох 2 сая ам.доллар буюу 5.7 тэрбум төгрөгийг, мөн концессын гэрээний 8.2-т заасны дагуу олгоогүй алданги болох 2.8 тэрбум төгрөгийг ирэх жилийн улсын төсөвт тусгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг хариуцагч нарт даалгах, концессын гэрээний 2.11-д заасан хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг концесс олгогчоос хуваарийн дагуу концесс эзэмшигчид нөхөн төлөөгүйн улмаас банкны зээлийн хүүд илүү төлсөн хохирол болох 10.7 тэрбум

[122] https://shuukh.mn/single_case/14056?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1

	төгрөгийг улсын төсөвт тусгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг хариуцагч нарт даалгаж, уг хохирлыг хариуцагч нараас гаргуулан нэхэмжлэгчид олгохыг даалгах
Сөрөг нэхэмжлэлийн шаардлага:	Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн Барих-шилжүүлэх /BT/ концессын гэрээний 2.4, 2.11, 2.12, 2.13 дахь заалтыг илт хууль бус болохыг тогтоолгох, 2021.06.22-ны өдрийн Чойр дэд станц төслийн эргэн төлөлтөд гадаадын валютын ханшийн зөрүүнээс үүссэн алдагдал гэсэн гэрээг илт хууль бус захиргааны актад тооцуулах, улсын төсвөөс илүү төлсөн гэх 3.5 тэрбум төгрөгийг нэхэмжлэгчээс буцаан гаргуулах

Хэргийн үйл баримт: 2017.03.30-нд “А” ХХК болон Төрийн худалдан авах ажиллагааны газар, одоогийн ЭЗХЯ-ны хооронд “Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт төслийн барих-шилжүүлэх” концессын гэрээ байгуулагдсан бөгөөд уг гэрээ хүчин төгөлдөр байна. “А” компани концессын зүйл болох ажлыг 2018.06.30-ны өдрийн дотор бүрэн дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөх, хариуцагч гэрээний нийт үнэ буюу төслийн нийт хөрөнгө оруулалт нь 31.7 сая ам.долларыг шилжүүлэхээр тохиролцжээ.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хохирол гаргуулахыг даалгах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, үлдэх хэсгийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Хариуцагч нь эрх бүхий этгээдийн хувиар 2021.06.22-ны өдөр “ханшийн зөрүүнээс үүссэн алдагдал” гэх баримт үйлдэж баталгаажуулсан, үүнийг хүчингүй болгосон ямар нэгэн шийдвэр байхгүй тул уг тооцоо нийлсэн актын дагуу нэхэмжлэгчид төлбөр нэхэмжлэх эрх үүссэн. Тооцоо нийлсэн актад 2020.08.15-аас 2021.08.15 хүртэлх төсвийн жилд баримтлах Сангийн яамны тооцооны ханш болох 2,845.27 ам.доллароор тооцсон нь холбогдох хууль болон гэрээг зөрчсөн хэмээн үзэх үндэслэлгүй. Тооцоо нийлсэн актыг захиргааны гэрээ гэж үзэхгүй. Өөрөөр хэлбэл, аливаа гэрээний талуудаас гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой гаргасан шийдвэр нь захиргааны актын, захиргааны гэрээний шинжийг агуулахгүй юм.

Хариуцагч хэрэв “төрд илтэд хохиролтой” гэж үзсэн бол гэрээ байгуулахаас татгалзах, цуцлах, улмаар эрх хэмжээгээ хэтрүүлсэн албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэж, үр дагаврыг таслан зогсоох бүрэн эрхтэй, боломжтой байсан. Гэтэл гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан шүүхэд үүссэний

дараа өмнөх шийдвэрээ үгүйсгэн маргаж буй нь үндэслэлгүй, үйл ажиллагааныхаа үр дагаврыг өөрөө хариуцах ёстой.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106.6-д “захиргааны үйл ажиллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлэх ба хохирлын хэмжээний талаар маргаан гарч, хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ” гэж заасан. Энэ тохиолдолд хохирлын хэмжээний талаар маргаантай байгаагаас гадна нэхэмжлэгч нэхэмжилж буй алданги, торгуулийн үндэслэл, тооцооллоо тодорхой гаргаж, хамтатган нэхэмжлээгүй гэж үзэхээр байна.

Концессын гэрээг анх байгуулахдаа гэрээний үнийг ам.долларoор тодорхойлсон боловч төлбөрийг төгрөгт шилжүүлэн тооцох агуулга бүхий заалттай (2.12, 2.13), бодит байдалд төлбөрийг төгрөгөөр шилжүүлсэн байх тул “үндэсний мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоог гүйцэтгэх хууль зөрчсөн” гэх хариуцагчийн гомдол үндэслэлгүй, анх гэрээ байгуулахдаа хуульд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгах нь хариуцагчийн хуулиар хүлээсэн үүрэг юм.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хүлээн авахаас татгалзаж, сөрөг нэхэмжлэлийн зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Концессын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнд үнийн дүнг гадаад валютаар илэрхийлэх эсэх, хэрэв илэрхийлсэн нөхцөлд төлбөр тооцоог зөвхөн монгол төгрөгөөр гүйцэтгэх, ханшийн зөрүүг хэрхэн тооцох аргачлалыг тодорхой тусгах шаардлагатай. Түүнчлэн, ханшийн зөрүүнээс үүссэн ашиг, алдагдлыг тооцох бариmтыг зөвхөн концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл бус санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллийг оролцуулан нягталж баталгаажуулах нь зүйтэй.

ХОЁР.ИРГЭНИЙ ХЭРЭГ

УДШ-ийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2020.01.01-ний өдрөөс 2025.04.26-ны өдрийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэсэн төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хамаарах иргэний хэргийг түүвэрлэн судлав. Тухайн хэрэг маргааныг шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн тогтоолын хууль зүйн дүгнэлтүүдээс төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулсан анхдагч хуулийн төсөл боловсруулахад ач холбогдолтой хэмээн үзсэн хэсгийг авсан болно.

2.1.Ажил гүйцэтгэгч нэмэлт ажил хийх зайлшгүй шаардлага гарсан нөхцөлд захиалагчид энэ талаар урьдчилан мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

Хэргийн мэдээлэл:	“Р” ХХК-ийн нэхэмжлэлтэй БХЯ, “Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл” төрийн өмчит үйлдвэрийн газарт холбогдох иргэний хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Нэмэлт ажлын зардал 1.5 тэрбум төгрөг гаргуулах тухай

Хэргийн үйл баримт: 2013.07.01-ний өдрийн гэрээний дагуу “Т Ө” сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэж, 2016 оны 1 сард улсын комисст хүлээлгэн өгсөн. Гэрээнд заасан 5.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авсан. Ажил гүйцэтгэх явцад хийсэн нэмэлт ажлын зардал 1.4 тэрбум төгрөг, цэргийн казармын хуучин барилга буулгуулж цэвэрлүүлсний зардал 64 сая төгрөг, нийт 1.5 тэрбум төгрөгийг гаргуулна хэмээн шаардсан.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж буюу 211.5 сая төгрөгийг гаргуулж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Нэхэмжлэгч нэмэлтээр 11 төрлийн ажил хийсэн гэж тайлбарлах боловч нэмэлт ажил хийх зайлшгүй шаардлагатай болсныг мөн тухайн ажил бүрийн нэмэлт төсөв санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэсэн, улсын төсвөөр санхүүжиж буй барилгын хувьд эрх бүхий этгээдийн ямар шийдвэр гарсан болох, төсвийн хэмжээ нэмэгдэх болсныг ажил гүйцэтгэгчид хуульд заасны дагуу хэрхэн мэдэгдэж шийдвэрлүүлсэн талаар хуульд нийцсэн баримт гаргаагүй байна.

Нэхэмжлэгчийг барилгын нэмэлт ажил, түүнтэй холбогдох нэмэлт төсөв хөрөнгийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлж байгаагүй, нэхэмжлэлийн барилгын төсөв нэмэгдсэн гэх шаардлагыг хуулийн хүрээнд нотлоогүй гэж дүгнэхдээ Иргэний хуулийн 343, 344, 345 дугаар зүйлийн холбогдох зохицуулалтыг, мөн Барилгын тухай хуулийн 24.2 дахь хэсгийг зөв тайлбарлан хэрэглэжээ.

Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсэг буюу барилгын зураг төсөл, төсөвт огт тусгагдаагүй ажил (гал тогооны тоног төхөөрөмжийн цахилгаан угсралт, гадна халаалт, цэвэр ус, дулааны узелийн болон гадна бохир усны ажлын)-ын зардлыг тооцож 211.5 сая төгрөгийг гаргуулж шийдвэрлэхдээ хэргийн нотлох баримтыг үнэлэх хуульд заасан журмыг зөрчөөгүй байна.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхив.

Нэмэлт ажил, зайлшгүй шаардлага гэх ойлголтыг тодорхой болгох, нэмэлт ажил хийлгэх зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд захиалагч, ажил гүйцэтгэгч тал хийгдэх ажил, хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулдаг байх нь зүйтэй.

2.2.Төслийн гэрээнд заасан буцаан төлөх үүрэг биелэгдэнэ.

Хэргийн мэдээлэл:	“Г” ХХК-ийн нэхэмжлэлтэй Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд холбогдох иргэний хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	2013.12.16-ны өдрийн ХАГ2013-1220-001 тоот Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Франц Улсаас импортолж авсан махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхрийг үржүүлж, хамтран ашиглах гэрээг хүчин төгөлдөр бусд тооцож, ХАГ2013-1220-001 тоот хүчин төгөлдөр бус гэрээг үндэслэн 176 толгой үхэр шаардахгүй байхыг хариуцагчид даалгах

Хэргийн үйл баримт: “Г” ХХК нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр импортолж, үржлийн аж ахуй эрхлэх төсөл” сонгон шалгаруулалтад шалгарч 2012.07.23-ны өдөр хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, 1 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Гэрээгээр тохирсон махны чиглэлийн үүлдрийн 176 үхрийг импортоор оруулж ирэх үүргээ биелүүлсэн тул 2013.12.16-ны өдөр хамтран ашиглах гэрээг байгуулж үлдэгдэл санхүүжилт 1 тэрбум төгрөг авсан бөгөөд 6 жилийн хугацаанд үржлийн аж ахуйг явуулж, 176 толгой үхрийг тус яаманд хүлээлгэн өгөхөөр тохиролцсон.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Хариуцагч мөнгөн хөрөнгө гаргах, нэхэмжлэгч махны чиглэлийн цэвэр үүлдрийн үхэр оруулж ирэн үржүүлэх, тодорхой хугацааны дараа мөнгөний оронд гэрээгээр тохирсон үүлдрийн үхэр өгөх талуудын тохиролцоог худалдах-худалдан авах гэрээ гэж үзсэн давж заалдах шатны шүүхийн дүгнэлт Иргэний хуулийн 243.1 дэх хэсгийг зөрчөөгүй байна. Талуудын хооронд ашиг алдагдлыг хариуцах, хамтын ажиллагааны шинж байхгүй тул хамтран ажиллах гэрээ гэж үзэхгүй.

Төсөлд анхнаасаа зээл олгож, тодорхой хугацааны дараа уг зээлийн оронд махны чиглэлийн цэвэр үүлдрийн өсвөр насны тодорхой тооны үхэр авах стандарт

нөхцөл тодорхой тусгагдсан, нэхэмжлэгч нь зөвшөөрч гэрээг байгуулсан тул 176 толгой үхэр шаардахгүй байхыг даалгуулах нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй юм.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалд хууль хэрэглээний өөрчлөлт оруулан шийдлийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн гомдлыг хангахгүй орхив.

Төсвийн хөрөнгөөр, тухайлбал хөрөнгө оруулалт, урсгал зардал болон бусад эх үүсвэрээр хөдөө аж ахуйн (мал аж ахуйн) төсөл хэрэгжүүлэх боломжтой эсэх, боломжтой нөхцөлд аль эх үүсвэрээр хэрэгжүүлэх зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай.

2.3.Автобус эзэмшүүлж, ашиглуулах гэрээ нь иргэний эрх зүйн харилцаа давамгайлсан худалдах-худалдан авах гэрээ болно.

Хэргийн мэдээлэл:	Зам, тээврийн хөгжлийн яам, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар, Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газрын нэхэмжлэлтэй “ЭТ” ХХК-д холбогдох иргэний хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Гэрээний үүргийн гүйцэтгэлд 2.1 тэрбум төгрөг гаргуулах тухай

Хэргийн үйл баримт: 400 автобус авахад улсын төсвөөс 31.7 тэрбум, аж ахуйн нэгж, байгууллагаас 4.1 тэрбум төгрөг гарсан. 2009.08.18-ны өдрийн гэрээний дагуу “ЭТ” ХХК 30 ширхэг автобус эзэмшилдээ авч, нийтийн тээврийн үйл ажиллагаа явуулж байна. Автобус нэг бүрийн үнэ 62.9 мянган ам.доллар, нийт 1.9 орчим сая ам.доллар төлөхөөс 503.8 сая төгрөг төлсөн.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх автобус гаргуулж олгуулахаар шийдвэрлэсэн. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2.1 тэрбум төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Нэхэмжлэлийн үндэслэл болж буй 2009.07.29-ний өдрийн “Эд хөрөнгө эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр эзэмшүүлэх гэрээ”, 2009.08.18-ны өдрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн автобусыг зээлээр эзэмшүүлэх гэрээ” нь захиргааны байгууллага оролцсон, нийтийн тээврийн үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгыг агуулсан боловч улсын төсвөөс хөрөнгө гаргаж автобус худалдан авч тээврийн компаниудын эзэмшилд шилжүүлсэн, тээврийн компани төлбөрийг тодорхой хугацаанд эргэн төлөх харилцан үүргийг агуулсан байх ба иргэний эрх зүйн харилцаа давамгайлсан, эдгээр гэрээг худалдах-худалдан авах гэрээ гэж үзсэн шүүхийн дүгнэлт хууль зөрчөөгүй.

2014.12.08-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын тэмдэглэлд “... 2009 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 3.6 тэрбум төгрөгийг нийтийн тээврээс Нийслэлийн ИТХ-ын шийдвэрээр хасаж тооцсон. Үүнийг автобусны эргэн төлөлтийн үнээс хасуулна. 2008, 2011 онд автобусны тасалбарын үнэ 200-300 төгрөг, 300-400 төгрөг болж нэмэгдсэн 100 төгрөгийн зөрүүг Нийтийн тээврийн салбарт өгөөгүй. Энэ мөнгөн дүнг автобусны үнээс суутгуулах саналыг аж ахуйн нэгж байгууллагуудаас гаргасан. Дээрх үнийн дүнг тооцож үзвэл 10.1 тэрбум төгрөг болно. Энэ 10.1 тэрбум төгрөгийг тухайн оны гүйцэтгэлээр аж ахуйн нэгжүүдэд хуваарилахад 2009-2010 оны нөхөн олговор болох 7.5 тэрбум төгрөг 10 аж ахуйн нэгжээс хөнгөлөлт маягаар суутгах боломжтой. Цаана нь үлдсэн 2.4 тэрбум төгрөг нь бусад аж ахуйн нэгжүүдэд хуваарилагдах тооцоо гарч байна. Хэрэв энэ 7.5 тэрбум төгрөгийг автобусны үнээс суутгана гэж үзвэл нийт төлсөн төлбөр нь 15.9 тэрбум төгрөг болно. Өөрөөр хэлбэл, одоо аж ахуйн нэгжүүд 15.8 тэрбум төгрөг төлөх ёстой. Одоогийн байдлаар эдгээр 10 аж ахуйн нэгж байгууллагыг Зам тээврийн яамнаас шүүхэд өгнө гэсэн шийдвэрт хүрсэн ...” гэж /хх-182/ тусгагдсанаас үзэхэд талуудын хооронд нөхөн олговрыг суутгах эсэх асуудал хэлэлцэгдсэн улмаар хариуцагчийн биелүүлэх үүргийн хэмжээг тодотгож байсан эсэх, гэрээний нөхцөлийн талаар талууд дахин хэрхэн тохирч байсан талаар тодруулж, дүгнэлт хийх шаардлагатай байжээ.

Талууд гэрээ байгуулахдаа Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн тул ҮАГ-ын шаардлагын дагуу гэрээг шинэчлэн байгуулах талаар Засгийн газрын 2010.11.23-ны өдрийн 303 дугаар тогтоол гарсан боловч талууд гэрээг шинэчлээгүй, гэрээний хугацаа дууссан тул уг тогтоол ач холбогдлоо алдсан хэдий ч тухайн үеийн ам.долларын ханш, төсвөөс гаргасан 31.5 тэрбум төгрөгийг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хэрхэн төлөхөөр тохирсон, нэг автобусны үнийг ам.доллароор гэрээнд заасан боловч хэдэн төгрөгөөр худалдан авсан, гэрээний үнэд нөлөөлөх эсэх талаар буюу маргааны зүйлийн талаар шүүх хийвэл зохих дүгнэлтийг хийгээгүй байна. Учир нь хариуцагч автобусны үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр тухайн үед тусгаагүй, аж ахуйн нэгжүүдээс өгсөн 2.6 тэрбум төгрөг хасагдах ёстой гэж маргасан тул энэ талаар дүгнэлт хийх ёстой.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаав.

Төсвийн хөрөнгө оруулалт төлөвлөхийн өмнө төслийн үр дүнд бий болсон хөрөнгийг хэрхэн ашиглах талаарх санал, тооцоо судалгаа гарсан байх ёстой.

Тайлбар: УДШ-ийн дээрх тогтоолын дараа Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022.06.22-ны өдрийн 102/ШШ2022/02364 дүгээр шийдвэрээр[123] дараах үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Нийтийн тээврийн үйлчилгээний 2009, 2010 оны нөхөн олговор болох 7.5 тэрбум төгрөгийг хасаж тооцсоноос маргаан гарч, хариуцагчийн үүргийн хэмжээг тодорхой болголгүй, гэрээний хугацаа дуусгавар болжээ. Дээрх нөхөн олговор нь нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагын олох байсан орлого бөгөөд гэрээний үнийг төлөхөд шууд хамааралтай байсан гэж үзнэ. Түүнчлэн, үүрэг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээг өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцүүлэхийг шаардах эрхтэй ба энэ талаарх хариуцагчийн саналыг нэхэмжлэгч шийдвэрлэлгүй гэрээний хугацаа 2015.12.04-ний өдөр дуусжээ. Худалдах-худалдан авах гэрээний үүрэгт шаардлага гаргах хөөн хэлэлцэх хугацаа 3 жил бөгөөд 2015.12.04-ний өдрөөс 2018.12.04-ний өдрийг хүртэл шаардах эрхээ хэрэгжүүлэх байсан. Хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй.

2.4.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийг хариуцан шийдвэрлүүлэх үүрэг бүхий этгээд нь захиалагч болно.

Хэргийн мэдээлэл:	“Г” ХХК-ийн нэхэмжлэлтэй Увс аймгийн Засаг даргад холбогдох иргэний хэрэг
Нэхэмжлэлийн шаардлага:	Гэрээний үүрэгт 20 сая төгрөг гаргуулах тухай

Хэргийн үйл баримт: “Г” ХХК нь У-тай 2015.06.19-ний өдөр “Увс аймгийн Ахмадын сувиллын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. “Г” компани гэрээний дагуу барилгыг барьж гүйцэтгэн, 2015.12.03-ны өдрийн 53 тоот “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах тухай комиссын акт”-аар захиалагчид хүлээлгэн өгсөн. Гэрээний хугацаанд захиалагч ажлын хөлснөөс нийт 377.8 сая төгрөгийн санхүүжилт өгч, гэрээний үнийн дүнгийн 5 хувь буюу 20.0 сая төгрөгийг төлөөгүй байна.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Увс аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан. Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Гэрээний тусгай нөхцөлийн 32-т “Чанарын баталгаат хугацаа Барилгын тухай хуулийн дагуу 3 жил байна.”, 35, 45-д “Гүйцэтгэсэн ажлын баталгаа болох барьцаа хөрөнгийн хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байх бөгөөд эцсийн санхүүжилтээс саатуулан үлдээнэ. Барилгын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 3 жилийн хугацаанд

[123] https://shuukh.mn/single_case/120318?start_date=&end_date=&id=1&court_cat=1&bb=1

ажлын гологдол, зөрчил гараагүй нөхцөлд буцаан олгоно.” гэж зааж тохиролцсон байна.

Нэхэмжлэгчийн барьж гүйцэтгэсэн ахмадын сувиллын барилга нь ашиглалтад орсноос хойш хэвийн ажиллаж байгаа, барилгыг ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 3 жилийн хугацаанд ямар нэгэн ажлын гологдол, зөрчил гараагүй нь тогтоогджээ. Баталгаат хугацаа дууссан, барилгын чанарын талаар ямар нэгэн гологдол, зөрчил гараагүй тул үнийн дүнгийн 5 хувь болох 20.0 сая төгрөгийг хариуцагчаас шаардах эрхтэй.

Давж заалдах шатны шүүх “... улсын төсвөөс санхүүжилт дутуу орж ирсэн бол энэ талаар зохих хууль, журмын дагуу шаардлага гаргах, санхүүжилтийг хариуцан шийдвэрлүүлэх этгээд нь аймгийн Засаг дарга учир нэхэмжилсэн төлбөрийг хариуцагчаас гаргуулж шийдвэрлэсэн нь үндэслэлтэй ...” хэмээн дүгнэсэн нь хуульд нийцнэ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн гомдлыг хангахгүй орхив.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас эрх шилжүүлсний дагуу Увс аймгийн Засаг дарга төсөл хэрэгжүүлсэн байдаг. Төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх харилцааг боловсронгуй болгох нь зүйтэй.

ГУРАВ.ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

УДШ-ийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар 2020.01.01-ний өдрөөс 2025.04.26-ны өдрийн хугацаанд хэлэлцэн шийдвэрлэсэн төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хамаарах эрүүгийн хэргийг түүвэрлэн судлав. Тухайн хэрэг маргааныг шийдвэрлэсэн хяналтын шатны шүүхийн тогтоолын хууль зүйн дүгнэлтүүдээс төсвийн хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулсан анхдагч хуулийн төсөл боловсруулахад ач холбогдолтой гэж үзсэн хэсгийг авсан болно.

3.1.Тендер шалгаруулалтгүйгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, санхүүжилт шилжүүлсэн нь албан тушаалын гэмт хэрэг болно.

Хэргийн мэдээлэл:	Ж.О, Б.Ү, Р.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай
Эрүүгийн хуулийн зүйлчлэл:	Эрүүгийн хуулийн (2002 он) 263 дугаар зүйл.Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, 263.2

Хэргийн үйл баримт: Хөдөлмөрийн сайдын 2014.06.27-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/146 дугаар тушаалаар Баянзүрх дүүрэгт ахуйн үйлчилгээний

цэг байгуулах төсөл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Ж.О-т үүрэг болгосон. Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2014.07.10-ны өдрийн А/68 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө болох 1.3 тэрбум төгрөгийг хэлтсийн нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг нягтлан бодогч Б.Ү-д даалгасан.

“Ө Т Ю” ХХК-ийн захирал Л.У нь 2012.02.17-ны өдөр хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр Р.Б-д компанийн 25 хувийн хувьцааг, 2014.07.10-ны өдрийн итгэмжлэлээр компанийн эзэмшлийн Хаан банкны данснаас орлого, зарлагын гүйлгээ хийх, төлөөлж гарын үсэг зурах эрхийг шилжүүлжээ.

Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга Ж.О нь “Б” ХХК-ийн захирал С.О, “ӨТЮ” ХХК-ийн захирал Л.У нартай хамтран ажиллах гэрээ байгуулж, “ӨТЮ” ХХК-ийн харилцах дансанд нийт 1.1 тэрбум төгрөг, “Б” ХХК-ийн харилцах дансанд нийт 180 сая төгрөгийн санхүүжилт хийсэн байх бөгөөд эдгээр компаниуд нь Баянзүрх дүүргийн 2, 9, 11, 19, 22, 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт ахуйн үйлчилгээний цэг, худалдааны төв, халуун усны барилга зэрэг үл хөдлөх хөрөнгийг барьж гүйцэтгэсэн.

Гэм буруугийн тухай:

Ж.О, Р.Б, Б.Ү нь 1/. ТБОНӨХБАҮХАтХ-ийн 7.1.1-д нээлттэй тендер зарлах гэснийг;

2/. 2014 оны төсвийн хуваарьт “Ахуйн үйлчилгээний цэг байгуулах төсөл”-д 1,344 сая төгрөг төсөвлөгдсөн байхад Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2014.07.10-ны өдрийн А/68 тоот тушаалаар “Ахуйн үйлчилгээний цэг, Худалдааны төв байгуулах төсөл” гэж 804 сая төгрөгийн санхүүжилтийн зориулалтыг өөрчилж, Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”47.3-д “Энэ хуулийн 47.1.2, 47.1.6-д заасан орлогыг зөвхөн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулна” гэснийг;

3/. Төсвийн тухай хуулийн 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох”, 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, 41.2.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны гэрээ төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэснийг;

4/. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэснийг тус тус зөрчиж, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Хөдөлмөрийн сайдын 2014.06.27-ны өдрийн А/145 тоот тушаалаар Баянзүрх дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст эрх нь шилжсэн 1,344 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчээр нээлттэй сонгон шалгаруулалт зарлахгүйгээр “ӨТЮ” ХХК, “Б” ХХК-ийг шууд шалгаруулж, “ӨТЮ” ХХК-д давуу байдал бий болгож, 2014.07.17-ны өдөр 582 сая төгрөг, 2014.08.15-ны өдөр 381 сая төгрөг, 2014.09.15-ны өдөр 201 сая төгрөгийг нийт 1,164 сая төгрөгийг;

“Б” ХХК-д давуу байдал бий болгож 2014.08.05-ны өдөр 90 сая төгрөг, 2014.09.09-ний өдөр 90 сая төгрөг, нийт 180 сая төгрөгийг санхүүжилт хэлбэрээр олгосны улмаас Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст их хэмжээний буюу 1,344 сая төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийг гүйцэтгэсэн.

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Ж.О, Р.Б, Б.Ү нарыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263.2-т заасан “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас их хэмжээний хохирол учруулсан” гэмт хэрэгт гэм буруутайд тооцож, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, “ӨТЮ” ХХК-аас 582 сая төгрөг, шүүгдэгч Р.Б аас 194 сая төгрөг, “Б” ХХК-аас 90 сая төгрөг, шүүгдэгч Ж.О, Б.Ү тус бүрээс 239 сая төгрөгийг тус тус гаргуулж улсын орлогод оруулж, зарим хөрөнгийг хохиролд тооцон шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх “... хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр шүүгдэгч Ж.О, Р.Б, Б.Ү нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэснийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар шүүгдэгч Ж.О, Р.Б, Б.Ү нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, тэднийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлсүгэй” гэж, “...” ХХК-аас буюу иргэний хариуцагч Л.У-аас 833 сая төгрөг, шүүгдэгч Р.Б-аас 25 хувь буюу 291 сая төгрөг, шүүгдэгч Ж.О-ээс 20 сая төгрөг, шүүгдэгч Б.Ү-аас 20 сая төгрөг, бүгд 1,164 сая төгрөгийг, “...” ХХК-аас буюу иргэний хариуцагч С.О-ээс 160 сая төгрөг, шүүгдэгч Ж.О-ээс 10 сая төгрөг, шүүгдэгч Б.Ү-аас 10 сая төгрөг, бүгд 180 сая төгрөг буюу нийт 1,344 сая төгрөгийг гаргуулан улсын орлогод оруулсугай хэмээн өөрчилсөн.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Дээрх барилга, байгууламжийг барьж байгуулахдаа Барилгын тухай, Газрын тухай хууль тогтоомжийн зохих зүйл, хэсгийг зөрчсөн, Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн санд эрх зүйн харилцаа үүсээгүй газарт байрлалтай, энэ нь нийтийн эзэмшлийн газарт хамаарч байгаа, бусдын өмчлөлийн газартай давхацсан зэрэг

зөрчлүүд тогтоогдсон. Нэгэнт санхүүжилтээр шилжүүлэн авсан үнийн дүнгээс гүйцэтгэгч нар тодорхой хэмжээний материал, зардлын зарцуулалт хийж, үл хөдлөх хөрөнгийг барьсан, эдгээр нь биет байдлаараа хаягтаа оршин буй тул эдгээр үл хөдлөх хөрөнгийг одоогийн зах зээлийн ханшаар үнэлж, үнэлэгдсэн хэмжээгээр нь нийт хохирлын дүнгээс хасаж, бодитой хохирлыг тогтоох шаардлагатай.

Баянзүрх дүүргийн 2, 9, 11, 19, 22, 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдсан ахуй үйлчилгээний цэг, худалдааны төв, халуун усны барилгыг улсын комисс хүлээж аваагүй, үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгээгүй нь эдгээр эд хөрөнгийн үнэлгээг бууруулахаас бус огт үнэ цэнгүй болгож устаж үрэгдсэнд тооцох хэмжээнд нөлөөлөх нөхцөл байдал биш юм.

Ингэснээр уг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээг бодитой тооцож, шүүгдэгч нарын үйлдэлд эрх зүйн зөв дүгнэлт өгөх боломж бүрдэнэ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаав.

Тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан ч гэсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон бол гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс чөлөөлөгдөхгүй.

Тайлбар: УДШ-ийн дээрх тогтоолын дараа Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.11.29-ний өдрийн 2023/ШЦТ/1480 дүгээр тогтоолоор[124] нэр бүхий шүүгдэгчдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263.2 дахь хэсэгт заасан “Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг” үйлдсэн гэм буруутайд тооцож, Ж.О, Р.Б нарыг тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хугацаагаар хорих ялаар, Б.Ү-г тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 1 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар шийтгэж, “...” ХХК-аас 833 сая төгрөг, шүүгдэгч Р.Б-аас 25 хувь буюу (1,164 сая * 0.25) = 291 сая төгрөг, шүүгдэгч Ж.О-оос 20 сая төгрөг, шүүгдэгч Б.Ү-аас 20 сая төгрөг, нийт 1,164 сая төгрөгийг гаргуулах,

“...” ХХК-аас 160 сая төгрөг, шүүгдэгч .....-ээс 10 сая төгрөг, шүүгдэгч Б.-аас 10 сая төгрөг, нийт 180 сая төгрөг гаргуулан улсын орлогод оруулж шийдвэрлэсэн.[125]

3.2.Гэм буруутай этгээд зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан нөхцөлд гэм хорыг нөхөн төлнө.

[124] https://shuukh.mn/single_case/98857?start_date=&end_date=&id=1&court_cat=2&bb=1
[125] Анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрийн талаарх мэдээлэл “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан”-аас олдоогүй болно.

Хэргийн мэдээлэл:	Ч.З-т холбогдох эрүүгийн хэргийн тухай
Эрүүгийн хуулийн зүйлчлэл:	Эрүүгийн хуулийн (2015 он) 22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 22.1.1

Хэргийн үйл баримт: ОНХС-гийн хөрөнгөөр сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд 100 мянган км-ээс бага гүйлттэй, зөв талдаа жолооны хүрдтэй, 2008 онд үйлдвэрлэсэн суудлын автомашин худалдан авах тендер зарласан. Ч.З нь Дундговь аймгийн Хулд сумын Засаг даргаар ажиллаж байхдаа иргэн Л.Б-д давуу байдал бий болгож, 1999 онд үйлдвэрлэсэн, Монгол Улсад 2009 онд импортолсон, 193 мянган км гүйлттэй, буруу талдаа жолооны хүрдтэй, 24 сая төгрөгийн үнэ бүхий “Тоёота ланд круйзер-100” загварын автомашиныг “ЁХ” ХХК-ийн нэр дээр шууд гэрээ байгуулан зах зээлийн үнээс өндөр үнээр буюу 49.5 сая төгрөгөөр худалдан авч, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан.

Гэм буруугийн тухай: Шүүгдэгч Ч.З Дундговь аймгийн Хулд сумын засаг даргын албан тушаалын байдлаа урвуулан ашиглан бусдад давуу байдал бий болгосон буюу эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутай байна

Анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал: Дундговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Ч.З-ын үйлдлийг Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зүйлчилж, түүнд нийтийн албанд томилогдох эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 15 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 15 сая төгрөгөөр торгох ял шийтгэсэн[126]. Дундговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгов.

Хяналтын шатны шүүхийн хууль зүйн дүгнэлт: Хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоогдсон Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ч.З-ын үйлдсэн хэрэгт гомдол санал, нэхэмжлэх зүйлгүй тухай 2019.12.17-ны өдрийн 6/1534 тоот албан бичиг шүүхэд ирүүлснийг үндэслэн анхан шатны шүүх гэм хорын хохирлыг шийдвэрлээгүй орхигдуулсан нь буруу байна. Шүүгдэгч Ч.З-аас автомашины үнийн зөрүү 25.5 сая төгрөгийг гаргуулж, улсын төсөвт шилжүүлнэ.

Хяналтын шатны шүүхийн тогтоол: Шийтгэх тогтоол, магадлалд “... 25.5 сая төгрөгийг Ч.З-аас гаргуулж улсын төсөвт шилжүүлэх” нэмэлт оруулж, тогтоол, магадлалыг бусад хэсгийг хэвээр үлдээн, шүүгдэгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгов.

[126] Эрүүгийн хуулийн 2022.12.16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр торгох ялыг хассан.

Захиалагч тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, нөлөөлсөн нь тухайн гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл болжээ.